



unesco

---

ИРЭЭДҮЙГЭЭ  
Боловсролын  
ХАМТДААДАХИН  
НИЙГМИЙН ШИНЭ  
ТӨСӨӨЛӨХ НЬ  
гэрээ

---

БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙН ОЛОН УЛСЫН КОМИССООС

## ЮНЕСКО – боловсролын салбар дахь дэлхий нийтийг манлайлагч

Боловсрол нь хүний суурь эрх бөгөөд тогтвортой хөгжил болон энх тайвны үндэс суурь болдог учраас ЮНЕСКО-ийн гол тэргүүлэх чиглэл юм. ЮНЕСКО нь НҮБ-ын боловсролын асуудлаар мэргэшсэн төрөлжсөн байгууллага бөгөөд бүх суралцагчдад үйлчлэх үндэсний тогтолцооны тэсвэртэй уян хатан чанар, чадавхыг бэхжүүлэх, ахиц дэвшилд жолоодон хөтлөх дэлхий нийтийн болон бүс нутгийн манлайлаар ханган ажилладаг. ЮНЕСКО нь мөн хувирган өөрчлөх суралцахуйгаар дамжуулан дэлхий нийтийг хамарсан өнөө үеийн сорилтуудад хариу арга хэмжээ авах хүчин чармайлтыг удирдан чиглүүлэхийн хамт бүх үйлийнхээ хүрээнд жендэрийн тэгш байдал ба Африк тивд онцгой анхаарал хандуулдаг.

## Боловсролын Ирээдүй санаачилга

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссыг ЮНЕСКО-оос 2019 онд мэдлэг ба суралцахуй нь хүн төрөлхтөн болон гараг дэлхийн ирээдүйг хэрхэн тодорхойлж болох талаар эргэцүүлэн бодож, дахин төсөөлөх зорилгоор байгуулсан юм. Энэхүү санаачилга нь олон нийт, шинжээчдийг өргөн хүрээгээр татан оролцуулж, хоршин ажиллуулах бөгөөд улам бүр нарийн төвөгтэй, тодорхойгүй, эмзэг хэврэг болж буй дэлхий ертөнцөд боловсролыг эргэн харж шинээр ухаарах нь хэрхэн зайлшгүй хэрэгцээ шаардлагатай болох талаар дэлхий нийтийн мэтгэлцээн хэлэлцүүлгийг өрнүүлэн идэвхжүүлэхэд чиглэнэ.



Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (Фонтенуа, 75352 Парис хот 07 SP, Франц Улс) болон ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс (НҮБ-ын байр, Нэгдсэн Үндэстний гудамж 14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс) хамтран 2022 онд эрхлэн гаргав.

© ЮНЕСКО болон ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс 2022

ISBN 978-92-3-000181-0



нэхүү ном нь Creative Commons-ийн Зохиогчийн нэрийг дурьдах - Ижил нөхцөлөөр цааш дамжуулах (CC-BY-SA 3.0 IGO) лицензийн дагуу хэрэглэхэд нээлттэй байна. (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>). Номын агуулгыг ашигласанаар, хэрэглэгч нь ЮНЕСКО-ийн Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалтын нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрөх ёстой (<http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en>).

Номны англи нэр: *Reimagining our futures together: a new social contract for education.*

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (7, Фонтенуа талбай, 75352 Парис хот 07 SP, Франц Улс)-аас 2021 онд эрхлэн гаргав.

Энд ашигласан нэр, материалууд нь аль нэг улс орон, газар нутаг, хот дүүргийн болон хил хязгаарын тухай эрх зүйн байдлын талаар ЮНЕСКО-ийн үзэл бодлын илэрхийлэл биш болно.

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын гишүүд энэхүү хэвлэлд тусгагдсан баримтуудыг сонгох, танилцуулах, түүнд илэрхийлэгдсэн үзэл санааны төлөө үүрэг хариуцлага хүлээнэ. Эдгээр нь ЮНЕСКО-ийн үзэл баримтлал биш бөгөөд тус байгууллага үүрэг хүлээхгүй.

Англи хэл дээрх эхийг хянан тохиолдуулсан: Mary de Sousa

Орчуулсан: Нэрэндоогийн Нэргүй, "Тэгш таван ухаан" НҮТББ  
Чойжилсүрэнгийн Нямгэрэл, Монгол Улсын Их Сургууль

Хянан тохиолдуулсан: Самбуугийн Болдсайхан, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс  
Эрдэнэгийн Урангаа, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс

Хэвлэлийн загварыг: ЮНЕСКО

Монгол Улсад хэвлэв.

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын энэ ажлыг Шведийн Олон улсын Хөгжлийн Хамтын ажиллагааны Агентлаг (Sida), Францын Засгийн газар болон Банко Сантандер (Banco Santander) нар харамгүй өгөөмөр сэтгэлээр дэмжсэн.

# Т О В Ч Х У Р А А Н Г У Й

## Боловсролын нийгмийн шинэ гэрээ

Хүн төрөлхтөн бид болон эх Дэлхий маань аюул занал доор оршин байна. Цар тахал нь бидний эмзэг хэврэг болон харилцан уялдаа холбоотой байдлыг батлан харууллаа. Одоо бид явах замынхаа чиглэлийг өөрчилж, ирээдүйгээ дахин шинээр төсөөлөхийн тулд хамтдаа яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна. Боловсролын ирээдүйн Олон улсын Комиссоос гаргасан энэхүү илтгэлд боловсрол нь гүн гүнзгий өөрчлөлтийг авчрах чадалтайг хүлээн зөвшөөрсөн. Бид хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид бүрийн чанартай боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах хэмээх биелэгдээгүй амлалтаа биелүүлэхээс гадна хамтын тогтвортой ирээдүйд замчлах маршрут болох боловсролын хувирган өөрчлөх нөөц потенциалыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх гэсэн давхар сорилттой тулгарч байна. Үүний тулд ирээдүйг хувирган өөрчлөхийн зэрэгцээ шударга бус байдлыг засаж залруулж чадах боловсролын нийгмийн шинэ гэрээ хэрэгтэй байна.

Энэхүү нийгмийн шинэ гэрээ нь хүний эрхэд үндэслэсэн, ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн шударга ёс, амьдрал, хүний эрхэм чанар, соёлын олон янз байдлыг хүндэтгэх зарчимд суурилсан байх ёстой. Энэ гэрээ нь халамжийн, харилцан ойлголцлын, эв нэгдлийн ёс зүйг агуулсан байх ёстой. Мөн боловсролыг бүх нийтийн хичээл зүтгэл, нийтлэг сайн сайхан (common good) болгон бэхжүүлэх учиртай.

Хоёр жилийн турш бэлтгэгдэж, нэг сая орчим хүнийг хамарсан дэлхийн зөвлөлдөх үйл явцаар тэжээгдсэн энэхүү илтгэл нь бүх нийтийн энх тайван, шударга ёс, тогтвортой ирээдүйг цогцлооход бидэнд туслах боловсролын нийгмийн шинэ гэрээ байгуулахыг санал болгож, дэлхийн даяарх Засгийн газрууд, институциуд, байгууллагууд, иргэдийг уриалж буй юм.

Энд дурдсан алсын хараа, зарчим, саналууд нь ердөө л эхлэлийн цэг юм. Тэдгээрийг тайлбарлан орчуулах, хам нөхцөлд нийцүүлэн утгажуулахад хамтын хүчин чармайлт хэрэгтэй. Олон тооны эерэг голомтууд (bright spots) аль хэдийн бий болсон. Энэхүү илтгэлд тэдгээрийг тогтоон барьж, хөгжүүлэхийг хичээсэн болно. Энэ бол заавар ч биш, бюлпринт ч биш, харин амин чухал яриа хэлцлийн эхлэл юм.

**Ирээдүйг  
хувирган  
өөрчлөхийн зэрэгцээ  
шударга бус байдлыг  
засаж залруулахын тулд  
боловсролын нийгмийн  
шинэ гэрээ БИДЭНД  
ХЭРЭГТЭЙ.**



unesco

*“Дайн хийх сэдэл нь хүний оюун ухаанд үүсэж  
эхэлдэг тул энх тайвныг хамгаалах үзлийг хүний  
ухамсарт суулгах ёстой”*

---

ИРЭЭДҮЙГЭЭ  
Боловсролын  
ХАМТДААДАХИН  
НИЙГМИЙН ШИНЭ  
ТӨСӨӨЛӨХ НЬ  
гэрээ

---

БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙН ОЛОН УЛСЫН КОМИССООС

# Өмнөх үг

## Одри Азулей

ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал

Өнгөрсөн жил хагасын хугацаанд ямар нэгэн зүйл биднийг ойртуулж нэгтгэсэн бол энэ нь бидний өнөөгийн эмзэг хэврэг байдал ба ирээдүйнхээ талаар итгэл алдарсан тодорхойгүй байдлын мэдрэмж юм. Хүн төрөлхтөн явж ирсэн замнал чиглэлээ өөрчлөх, гараг дэлхийгээ цаашид тохиолдож болзошгүй үйл явцын тасалдалтууд (disruptions)-аас сэргийлж, аврах үйлд цаг алдалгүй шамдах шаардлагатай байгааг бид одоо урьд нь ойлгож байснаасаа илүү их мэдэх болсон. Гэхдээ энэ үйл нь урт хугацааны туршид тууштай үргэлжлэхээр мөн стратегийн сэтгэлгээтэй хосолсон байх ёстой.

Эдгээр биднийг айлгаж түгшээсэн сорилтуудыг шийдвэрлэхэд боловсрол амин чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэсэн хэдий ч цар тахал нь боловсрол ямар эмзэг хэврэг байгааг харууллаа: КОВИД-19 цар тахлын оргил үед дэлхий даяар сургуулиуд хаагдсаны улмаас 1.6 тэрбум суралцагчид суралцахуйн асуудалд өртсөн.

Бид аливаа зүйлийг алдахаас нааш түүний үнэ цэнийг мэддэггүй. Ийм учраас ЮНЕСКО нь Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссоос Холбооны Ардчилсан Бүгд Найрамдах Этиоп Улсын Ерөнхийлөгч, Эрхэмсэг хатагтай Сахле-Век Зевдегийн удирдлага дор бэлтгэсэн “Бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ» гэсэн энэхүү шинэ илтгэлийг сайшаан хүлээн авч байна.

ЮНЕСКО нь 75 жилийн өмнө үүсгэн байгуулагдсанаасаа хойш нийгмийн хувирган өөрчлөлтийн нэн чухал мөчүүдэд боловсролын үүрэг ролийг эргэн харах зорилгоор дэлхий нийтийн түвшний хэд хэдэн илтгэлийг захиалж гүйцэтгүүлсэн. Эдгээр нь Фаурегийн Комиссын 1972 онд гаргасан «Оршихуйн төлөө суралцахуй: Боловсролын ертөнц өнөөдөр ба маргааш» илтгэлээс эхэлж, 1996 онд Делорсын Комиссын «Суралцахуй: Түүнд эрхэмлэх үнэт эрдэм» илтгэлээр үргэлжилсэн. Энэ хоёр илтгэл хоёулаа боловсролын талаар гүн гүнзгий ухаарал өгч, хүчтэй нөлөөлөл үзүүлсэн хэдий ч сүүлийн жилүүдэд дэлхий ертөнц үндсээрээ өөрчлөгдөөд байна.

Өмнөх илтгэлүүдийн нэгэн адил Сахле-Век Комиссын энэхүү илтгэл нь энэ гараг дээрх бүх амьд зүйлсийн оршихуйг сайжруулахын төлөө боловсролыг чиглүүлэхэд шаардлагатай философийн үзэл баримтлал, зарчмуудын тухай асуудлыг өргөн хүрээнд авч хэлэлцсэн. Тус илтгэлийг хоёр жил гаруй хугацаанд боловсруулсан бөгөөд нэг сая гаруй хүнтэй хийсэн өргөн хүрээний хэлэлцүүлэг, зөвлөлдөөний үр дүнд суурилсан юм.

**Өмнөх үг**

Тус илтгэл нь бидэнд нэгэн зүйлийг сургаж байгаа нь: Хүмүүс бидний ирээдүй нь манай гарагийн ирээдүйгээс хамаарах бөгөөд аль аль нь аюул заналын эрсдэлд байгаа тул бид явж ирсэн замналаа яаралтай өөрчлөх үйлд шамдах хэрэгтэй байна. Энэхүү илтгэлд боловсролын нийгмийн шинэ гэрээг санал болгож байгаа бөгөөд энэ гэрээ нь бидний бие биетэйгээ, гараг дэлхийтэйгээ, мөн технологитой харьцах бүх харилцан хамаарлыг шинээр цогцлооход чиглэх юм.

Энэхүү нийгмийн шинэ гэрээ нь бидний өнгөрсөн үе дэх шударга бус байдлыг засч, ирээдүйг өөрчлөх боломж юм. Юуны өмнө энэ гэрээ нь багшлахуй ба суралцахуйг нийгмийн хамтын хичээл зүтгэл, улмаар нийтлэг сайн сайхан байдал гэж үзэж, амьдралынхаа туршид чанартай боловсрол эзэмших эрх дээр суурилдаг

Боловсролын талаарх энэхүү алсын харааг бодит үйл хэрэг болгох нь боломжгүй ажил биш юм. Ялангуяа, залуу үеийнхэнд итгэл найдвар бий. Гэсэн хэдий ч инклюзив оролцоо, үл алагчлах байдал, хүний эрх, энх тайван байдал нь бидний ирээдүйг тодорхойлдог болоход хотол дэлхийн бүтээлч сэтгэлгээ, оюун ухаан бидэнд шаардлагатай болно. Эцсийн дүндээ, үүнийг хийнэ үү хэмээн энэ илтгэл биднийг урин дуудаж байгаа юм. Зөвхөн энэ шалтгаанаар энэ илтгэлд бидний хүн нэг бүрд үнэ цэнтэй сургамжууд бий.



**Одри Азулей (Audrey Azoulay)**

Ерөнхий захирал

# Өмнөх үг

## Эрхэмсэг Ерөнхийлөгч Сахле-Вок Завуди

Боловсролын Ирээдүйн олон улсын комиссын дарга

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын Ерөнхийлөгч

Манай гарагийн ирээдүйг тухайн орон нутаг бүртээ ардчилсан байдлаар төсөөлөх ёстой. Бидний хүсэж буй ирээдүйг зөвхөн хүмүүсийн болон соёлын олон янз байдлыг ашиглан хамтын болон хувь хүний үйл ажиллагааны үр дүнд л бодит болгох боломжтой юм.

Хүн төрөлхтөн ганц дэлхийтэй, гэсэн хэдий ч бид түүнийхээ нөөцийг бүрэн дүүрэн хуваалцаж эсвэл тогтвортой арга барилаар ашиглахгүй байна. Дэлхийн янз бүрийн бүс нутгийн хооронд байж боломгүй тэгш бус байдал оршин байна. Бид охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдалд хүрэхэд хол хэвээрээ байна. Технологи биднийг холбох чадамжтай хэмээн амлаж буй хэдий ч асар том дижитал хуваагдал, ялангуяа Африкт байсаар байна. Хүмүүсийн мэдлэг олж авах, бүтээх чадамжид эрх мэдлийн асар их тэгш хэмгүй байдал оршоор байна.

Боловсрол бол эдгээр амь бөхтэй тэгш бус байдлыг арилгах гол арга зам юм. Бид мэддэг зүйлдээ тулгуурлан боловсролыг өөрчлөх хэрэгтэй. Анги, сургууль нь зайлшгүй шаардлагатай ч ирээдүйд тэдгээрийг өөрөөр бүтээн байгуулж, өөрөөр ажиллуулах хэрэгтэй болно. Боловсрол нь ажил хөдөлмөрийн өөрчлөгдөж буй шинж чанар, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах янз бүрийн арга замыг харгалзан XXI зууны ажлын байранд шаардлагатай ур чадварыг бий болгох ёстой. Цаашлаад, бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хамгаалахын тулд боловсролын санхүүжилтийг дэлхий нийтээрээ өргөжүүлэх ёстой.

Хүний эрхийг хүндэтгэх, боловсролыг нийтлэг сайн сайхан байдал гэж үзэх нь бидний хамтын ертөнц, харилцан уялдаатай ирээдүйг холбогч гол зангилаа болох ёстой. Энэхүү илтгэлд дурдсанчлан энэ хоёр түгээмэл зарчим нь хаана ч боловсролын үндэс суурь болох ёстой. Дэлхийн хаана ч чанартай боловсрол эзэмших эрх болон хувь хүмүүсийн хамтын ашиг тусын төлөө хамтран ажиллах нөөц чадварууд (capabilities)-ыг бий болгосон суралцахуй нь боловсролын цэцэглэн хөгжилт, олон янз ирээдүйг бий болгох үндэс суурь болдог. Хүний эрх, нийтлэг сайн сайхны төлөөх амлалт үүрэгтээ тууштай байснаар бид хүн төрөлхтний соёл, нийгмийн туршлагаас албан ба албан бус боловсролд авч ирсэн дэлхий ертөнцөд оршин тогтнох, түүний танин мэдэх янз бүрийн арга замуудыг сүлжин нэхсэн баялаг бүтээлийг, мөн хамтдаа хуваалцаж, цуглуулан эвлүүлэх боломжтой мэдлэгийг тэтгэн хадгалж, ашиг тусыг хүртэх боломжтой болно.

Энэхүү илтгэл нь ЮНЕСКО-оос 2019 онд байгуулагдсан Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын хамтын ажлын үр дүн юм. Манай багийн бүх гишүүд нь хүмүүсийн олон янз байдал, газарзүйн байршлын тархалтыг төлөөлөн ажилласан бөгөөд тэднийхээ хүлээсэн амлалт үүргийн биелэлт болон оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрөхийн сацуу, ЮНЕСКО-д суугаа Португалийн Элчин сайд, Комиссын судалгаа, төсөл боловсруулах хороог ахалсан Антонио Новоад онцгойлон талархал илэрхийлье. “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь” илтгэлд танилцуулсан саналууд нь тодорхой бус, нарийн төвөгтэй, найдваргүй байдал улам бүр нэмэгдэж буй дэлхий ертөнцөд бүтээлч байдал, няцашгүй зориг, итгэл найдвар арвин байдгийг харуулсан дэлхий нийтийн оролцоо, хамтын бүтээн байгуулалтын үйл явцаас үүдэлтэй юм. Тайланд дахин эргэцүүлэн бодох шаардлагатай дараах чухал сэдэвчилсэн асуудлуудын ирээдүйг нягтлан судлав. Үүнд тогтвортой байдал; мэдлэг; суралцахуй; багш болон багшлахуй; ажил, ур чадвар, цогц чадамж; иргэний харьяалал; ардчилал ба нийгмийн инклюзив оролцоо; нийтийн боловсрол; дээд боловсрол, судалгаа, инноваци зэрэг асуудлууд багтсан болно.

Комиссын өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хийсэн ажил нь дэлхийг хамарсан цар тахлын нөлөөгөөр тодорхойлогдсон бөгөөд олон тооны сургууль хаагдсанаар бүх насны хүүхэд, залуучууд, суралцагчдад учирсан сорилтуудыг комиссын гишүүд маш сайн мэдэж байсан. КОВИД-ын улмаас амьдрал нь тасалдсан сурагчид, багш нар болон тэдний сайн сайхан байдал, өсөлт хөгжил, хүнд хэцүү нөхцөлд үргэлжлүүлэн суралцах гайхалтай хүчин чармайлтад бид «Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь» илтгэлээ зориулж байна.

Энд дурдсан саналууд болон уриалан дуудсан нийтийн яриа хэлэлцээ, хамтын үйл нь хүн төрөлхтний болон гараг дэлхийн энх тайван, шударга, тогтвортой ирээдүйг бүрдүүлэхэд түлхэц болно гэдэгт бид найдаж байна.



**Эрхэмсэг Сахле-Век Завуди (H.E. Sahle-Work Zewde)**

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын дарга

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын Ерөнхийлөгч



# Боловсролын Ирээдүйн Олон улсын Комисс

**Эрхэмсэг Сахле-Век Завуди (Sahle-Work Zewde)** Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын Ерөнхийлөгч, Боловсролын Ирээдүйн олон улсын комиссын дарга

**Антонио Новоа (António Nóvoa)**, Лиссабоны Их Сургуулийн Боловсролын Хүрээлэнгийн профессор, Боловсролын Ирээдүйн Олон Улсын Комиссын судалгааны төсөл боловсруулах хорооны дарга

**Масанори Аояги (Masanori Aoyagi)**, Токиогийн Их Сургуулийн эмирит профессор

**Аржун Аппадурай (Arjun Appadurai)**, Нью-Йоркийн Их Сургуулийн Хэвлэл мэдээлэл, Соёл, Харилцаа холбооны эмирит профессор, Нью-Йорк дахь Бард төгсөлтийн төвийн Макс Вебер Глобал профессор.

**Патрик Авуа (Patrik Awuah)**, Гана улсын Ашеси Их Сургуулийн үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч

**Абдель Бассет Бен Хассен (Abdel Basset Ben Hassen)**, Тунис Улс дахь Арабын Хүний Эрхийн Хүрээлэнгийн ерөнхийлөгч

**Криволам Буарке (Cristova m Buarque)**, Бразилын Их Сургуулийн эмирит профессор

**Элиза Гуэрра (Elisa Guerra)**, Мексикийн Валле де Филадельфия коллежийн багш, үүсгэн байгуулагч

**Бадр Жафар (Badr Jafar)**, Арабын Нэгдсэн Эмират Улсын Crescent Enterprises компанийн гүйцэтгэх захирал

**Дох-Ён Ким (Doh-Yeon Kim)**, Сөүлийн Үндэсний Их Сургуулийн эмирит профессор, БНСУ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн сайд асан

**Жастин Ифу Лин (Justin Yifu Lin)**, Бээжингийн Их Сургуулийн Шинэ бүтцийн Эдийн Засгийн Хүрээлэнгийн декан, профессор

**Евгений Морозов (Evgeny Morozov)**, зохиолч

**Карен Мунди (Karen Mundy)**, ЮНЕСКО-ийн Олон Улсын Боловсролын Төлөвлөлтийн Хүрээлэн (ИЕР)-ийн захирал, Торонтогийн Их Сургуулийн Онтариогийн Боловсрол судлалын хүрээлэнгийн профессор (чөлөөнд байгаа)

**Фернандо М.Реймерс (Fernando M.Reimers)**, АНУ-ын Харвардын Боловсролын Ахисан түвшний Сургуулийн профессор

**Тарцила Ривера Зеа (Tarcila Rivera Zea)**, Перугийн уугуул иргэдийн соёлын CHIRAPAQ төвийн ерөнхийлөгч

**Серигне Мбайе Тиам (Serigne Mbaye Thiam)** Сенегал Улсын Ус, Ариун Цэврийн сайд

**Вайра Вике-Фрейберга (Vaira Vike-Freiberga)**, Латви Улсын Ерөнхийлөгч асан, Баку дахь Низами Ганжавийн Олон Улсын Төвийн хамтран даргалагч

**Маха Яхья (Maha Yahya)**, Ливан дахь Карнеги Ойрхи Дорнодын төвийн захирал

# ТАЛАРХАЛ

---

Энэхүү илтгэлийг олон тооны хувь хүмүүс, сүлжээд, байгууллагуудын үнэтэй хувь нэмэргүйгээр гаргах боломжгүй байсан.

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссоос бие даасан тайлан, суурь өгүүллүүд бичиж хувь нэмэр оруулсан бүх хүмүүст, түүнчлэн боловсролын ирээдүйн талаарх дэлхийн зөвлөлдөх уулзалтад оролцсон хувь хүмүүс, байгууллагууд, сүлжээнүүдэд талархал илэрхийлье (хувь нэмэр оруулагчдын жагсаалт, хувь нэмрийг хавсралтаас үзнэ үү).

Боловсрол, шинжилгээ судалгаа, инновацын салбарт дэлхийд тэргүүлэгч зүтгэлтнүүд болон стратегийн гол түншүүдийг төлөөлсөн Боловсролын Ирээдүйн Зөвлөхүүдийн Зөвлөл нь үнэлж баршгүй санал санаачилгаар хангаж байсан (хувь хүмүүс, байгууллагыг бүрэн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү).

Задлан шинжилгээ болон төслийг боловсруулах явцад ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газартай нягт хамтран ажиллаж, гар бичмэлийн анхны хувилбаруудыг хянаж үзсэн эксперт Трейси Бернс (Tracey Burns), Пол Комин (Paul Comyn), Питер Рональд ДеСоуза (Peter Ronald DeSouza), Инес Дюссель (Inés Dussel), Кери Фасер (Keri Facer), Хью Маклин (Hugh McLean), Эбрима Салл (Ebrima Sall), Франсуа Таддей (François Taddei), Малак Заалок (Malak Zaalouk), Хавьер Рогла Пуиг (Javier Roglà Puig) нарт онцгой талархал илэрхийлье.

Эцэст нь Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын зүгээс ЮНЕСКО-д, тэр дундаа түүнийг манлайлан ажилласан Боловсролын асуудал эрхэлсэн орлогч захирал, хатагтай Стефаниа Жианнинид (Stefania Giannini), түүнчлэн Суралцахуй ба Инновацын Ирээдүй багийн захирал Собхи Тавил (Sobhi Tawil) болон түүний багийнханд тус комиссын ажилд уйгагүй дэмжлэг үзүүлсэнд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. Багийн бүрэлдэхүүнд Аида Алхабши (Aida Alhabshi), Алехандра Кастанеда (Alejandra Castaneda), Катарина Серкейра (Catarina Cerqueira), Анетт Домитер (Anett Domiter), Кит Холмс (Keith Holmes), Ярослав Харкова (Iaroslava Kharkova), Стефани Магалар (Stephanie Magalage), Жек МакНейл (Jack McNeill), Фэнчун Миао (Fengchun Miao), Микела Пагано (Michela Pagano), Майя Принс (Maya Prince), Ноа В.Собе (Noah W. Sobe), Елена Тукан (Elena Toukan), Марк Вэст (Mark West) нар багтан ажилласан. Энэ баг нь улмаар Боловсролын Ирээдүй санаачилгад янз бүрийн арга замаар хувь нэмрээ оруулсан байгууллагынхаа олон хүмүүсээс дэмжлэг авч байсан.

# Гарчиг

<b>Өмнөх үг</b>	v
<i>Ерөнхий захирал Одри Азулей (Director-General Audrey Azoulay)</i>	
<b>Өмнөх үг</b>	vii
<i>Эрхэмсэг ерөнхийлөгч Сахле-Век Завуд (H.E. President Sahle-Work Zewde)</i>	
<b>Боловсролын Ирээдүйн Олон улсын Комисс</b>	ix
<b>Талархал</b>	x
<b>Гүйцэтгэлийн хураангуй</b>	1

## ТАНИЛЦУУЛГА 7

Эрсдэлд буй хүн төрөлхтөн, хүний эрх, амьд гарагийн оршин тогтнохуй	8
Боловсролын нийгмийн шинэ гэрээний хэрэгцээ	10
Боловсролын шалтгаант зорилгыг дахин тодорхойлох нь	12
Илтгэлийн зохион байгуулалт	15

## ХЭСЭГ I ӨМНӨХ АМЛАЛТУУД БОЛОН ТОДОРХОЙГҮЙ ИРЭЭДҮЙН ХООРОНД 17

### БҮЛЭГ 1 ИЛҮҮ ҮЛ АЛАГЧИЛСАН БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ 19

Боловсрол дахь суралцахуйн бүрэн дүүргэлтгүй, алагчилсан тэлэлт	20
Амь бөхтэй ядуурал ба өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал	25
Хасан гадуурхалтын сүлжээ/вэб	26

### БҮЛЭГ 2 ҮЙЛ ЯВЦЫН ТАСАЛДАЛТ БА ҮҮСЭЖ БУЙ ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТҮҮД 29

Аюул эрсдэлд буй гараг	30
Холбож БАС хувааж буй дижитал	35
Ардчиллын ухралт ба өсөн нэмэгдэж буй туйлшрал	40
Ажил хөдөлмөрийн тодорхойгүй ирээдүй	42

## ХЭСЭГ II

### БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ

48

#### **БҮЛЭГ 3 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БА ЭВ НЭГДЛИЙН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЗҮЙ 51**

Сурган хүмүүжүүлэх арга хандлагыг дахин төсөөлөх нь	53
Нас, үе шат бүр дэх сурган хүмүүжүүлэх аялалууд	59
Дээд боловсролын эрхэм зорилгыг шинэчлэх нь	63
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	64

#### **БҮЛЭГ 4 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БА ХУВЬСАН ХӨГЖИЖ БАЙДАГ НИЙТЛЭГ МЭДЛЭГ 67**

Нийтлэг мэдлэг дэх оролцоо	69
Дээд боловсролын идэвхжүүлэх үүрэг роль	81
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	83

#### **БҮЛЭГ 5 БАГШИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ АЖИЛ 85**

Багшлахуйг хоршин ажиллах мэргэжил болгон хувиргах нь	87
Амьдралд уягдсан багшийн хөгжлийн замнал	91
Багшлахуйг хувирган өөрчлөхийн төлөөх нийтийн эв нэгдэл	94
Багш нартай харьцах их сургуулиудын өнөөгийн харилцаа	96
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	98

#### **БҮЛЭГ 6 СУРГУУЛИЙГ ХАМГААЛАХ БА ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ НЬ 99**

Сургуулийн орлуулшгүй үүрэг роль	102
Сургуулийн хувирган өөрчлөлт зайлшгүй болох нь	103
Сургуулиас дээд боловсрол хүртэлх шилжилтүүд	109
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	110

#### **БҮЛЭГ 7 ӨӨР ӨӨР ЦАГ ХУГАЦАА, ОРОН ЗАЙН БОЛОВСРОЛ 113**

Инклюзив оролцоо ба тогтвортой байдлын төлөө боловсролын боломжуудыг удирдах нь	116
Боловсрол тохиож л байвал хэзээд тэлж өргөжнө	123
Боловсрол эзэмших эрхийг өргөтгөх нь	125
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	127

## ХЭСЭГ III

# БОЛОВСРОЛЫН НИЙГМИЙН ШИНЭ ГЭРЭЭГ ХУРДАСГАХ НЬ

128

### **БҮЛЭГ 8 ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА, ИННОВАЦИД УРИАЛСАН ДУУДЛАГА 129**

Боловсролын шинжилгээ судалгааны шинэ мөрийн хөтөлбөр	131
Мэдлэг, өгөгдөл, нотолгоог өргөжүүлэх нь	133
Боловсролын ирээдүйг шинэлэг болгох нь	136
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	140

### **БҮЛЭГ 9 ДЭЛХИЙ НИЙТИЙН ЭВ НЭГДЭЛ БОЛОН ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНД УРИАЛСАН ДУУДЛАГА 143**

Улам бүр тодорхой бус болж буй дэлхийн жаягт хариу үйлдэл үзүүлэх нь	145
Хамтын шалтгаант зорилго, үүрэг амлалт, хэм хэмжээ, стандартын төлөө	147
Мэдлэг бүтээх, нотлох баримт ашиглах чиглэлээр хамтран ажиллах	149
Боловсрол нь аюулд байгаа газар боловсролын санхүүжилт олгох нь	151
ЮНЕСКО-ийн үүрэг роль	152
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	153

## **ТӨГСГӨЛИЙН ҮГ БА ҮРГЭЛЖЛЭЛ 157**

### **Боловсролын ирээдүйг хамтдаа цогцлоох нь 157**

Нийгмийн шинэ гэрээг бүтээх саналууд	159
Үйлд уриалсан дуудлагууд	167
Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд	170
Үргэлжлүүлэх урилга	172

## **ХАВСРАЛТУУД**

### **Сонгогдсон эх сурвалжууд 175**

<i>Бие даасан тайлангууд</i>	176
<i>Суурь өгүүллүүд</i>	178
<i>Дэлхий нийтийн түвшний зөвлөлдөх уулзалтын саналууд</i>	180
<i>Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын нийтлэлүүд</i>	181

### **Боловсролын Ирээдүйн Олон улсын Комисс 182**

<i>Бүрэн эрх</i>	182
<i>Гишүүд</i>	182

### **Боловсролын Ирээдүй санаачилга 188**

### **Дэлхий нийтийн зөвлөлдөх үйлсэд хувь нэмэр оруулагчид 189**

# ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Манай дэлхий эргэлтийн цэг дээр байна. Мэдлэг ба суралцахуй нь шинэчлэл болон хувирган өөрчлөлтийн үндэс гэдгийг бид аль хэдийн мэддэг болсон. Гэвч дэлхий нийтийн тэнцвэрт бус байдал (disparity) болон бид яагаад, яаж, юуг, хаана, хэзээ сурдаг талаар дахин төсөөлөх тулгамдсан хэрэгцээ байгаа нь бидэнд энх тайван, шударга ёс, тогтвортой ирээдүйг бий болгоход туслах өөрийн амлалтаа боловсрол хараахан биелүүлээгүй байна гэсэн үг юм.

Өсөлт, хөгжлийг эрж хайхдаа хүмүүс бид байгаль орчноо дааж давшгүйгээр цөхрөөж, өөрсдийн оршин тогтнохуйдаа аюул занал учруулсан. Өнөөдөр амьдралын өндөр стандарт, алмайрч гайхахаар тэгш бус байдал хоёр зэрэгцэн оршиж байна. Улам бүр олон хүн нийгмийн амьдралд татагдан оролцож байгаа ч иргэний нийгэм болон ардчиллын үндэс суурь дэлхий дахинаа олон газарт ганхаж байна. Технологийн хурдацтай өөрчлөлтүүд бидний амьдралын олон талыг хувирган өөрчилж байна. Гэсэн хэдий ч эдгээр инновацууд нь үл алагчлах байдал (equity), инклюзив оролцоо (inclusion), ардчилсан оролцоо (democratic participation)-нд тохирч нийцэхэд чиглээгүй байна.

Өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхнийхээ өмнө эх дэлхийгээ хомсдол гачигдлын бус элбэг дэлбэг ертөнц байлгах, хүний эрхийг хүн бүр адил тэгш бүрэн дүүрэн эдэлдэг болгох хүнд хэцүү үүрэг даалгавар өнөөдөр хүн бүрийг хүлээж байна. Хойшлуулшгүй арга хэмжээ авах болон тодорхойгүй нөхцөлүүд үүсэхийг үл харгалзан **бидэнд итгэл найдвар дүүрэн байх шалтгаан бий**. Нэгэн төрөл зүйл болохынхоо хувьд бид хамтын түүхэндээ бидэнд хамтран ажиллах боломжийг олгодог мэдлэг болон арга хэрэгслийг хамгийн их хүртээмжтэйгээр ашиглаж болох тийм цэг дээр байна. Хамтдаа илүү сайн сайхан ирээдүйг цогцлоон бүтээхэд хүн төрөлхтнийг татан оролцуулах нөөц боломж урьд өмнө хэзээ ч ийм их байгаагүй билээ.

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссоос гаргасан энэхүү дэлхийн илтгэлд 2050 он ба түүнээс цааших хугацаанд харж буй бидний нийтлэг ертөнц, хамтын ирээдүйг төлөвшүүлэхэд боловсрол ямар үүрэг гүйцэтгэж чадах талаар асуултыг тавьсан. Дэвшүүлж буй саналууд нь дэлхий нийтийн оролцоо, хамтын бүтээн байгуулалтын хоёр жилийн үйл явцын үр дүнд бий болсон. Энэхүү үйл явц нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид гээд асар олон хүмүүс энэ нэг дэлхий дээр **бид холбогдсон байдаг** бөгөөд **бид хамтдаа ажиллах** нь зайлшгүй нэн чухал гэдгийг маш сайн ухамсарлаж байгааг харуулсан.

Олон хүмүүс эдгээр өөрчлөлтийг өөрсдөө хийхээр аль хэдийн оролцоод эхэлсэн байна. Энэхүү илтгэл нь суралцахуйн орон зайг хэрхэн дахин төсөөлөхөөс эхлээд сургалтын хөтөлбөрийг колоничлолоос ангижруулах, нийгэмшил ба сэтгэл хөдлөлийн суралцахуйн ач холбогдлыг чухалчлах, тэдгээрийг бодит амьдрал дээр харуулах мөн уур амьсгалын өөрчлөлт, КОВИД-19 мэтийн хямралууд, хуурамч мэдээ мэдээлэл болон дижитал хуваагдал зэрэг өсөн нэмэгдэж буй болгоомжлолын талаарх тэдний оруулсан хувь нэмрийг багтаасан.

Бидний амьдралын туршид суралцахуй (learning throughout life) ба багшлахуйг зохион байгуулах арга зам болох боловсрол нь хүний нийгмийг өөрчлөх үндсэн үүргээ аль хэдийнээс гүйцэтгэсээр ирсэн. Боловсрол нь биднийг дэлхий ертөнцтэй болон өөр хоорондоо холбогдох шинэ бололцоог нээж, яриа хэлэлцээ хийх, үйл ажиллагаа явуулах чадавхыг маань бэхжүүлдэг. **Гэвч энх тайван, шударга ёс, тогтвортой ирээдүйг бий болгохын тулд боловсрол өөрөө хувиран өөрчлөгдөх ёстой.**

## Боловсролын нийгмийн шинэ гэрээ

Боловсролыг нийгмийн гэрээ талаас нь авч үзвэл хамтдаа хуваалцаж болох ашиг тусын төлөө нийгмийн гишүүдийн дунд байгуулсан хамтран ажиллах далд хэлцэл гэж харж болно. Нийгмийн гэрээ нь албан ёсоор хуульчлагдсан хэм хэмжээ, амлалт үүрэг, зарчмуудыг тусгадаг, мөн соёлд шигтгэгдэн орсон байдаг тул ажил хэргийн хэлэлцээрээс илүү зүйл юм. **Эхлэлийн цэг нь боловсролын нийгмийн шалтгаант зорилгууд (purpose)-ын талаарх хамтдаа зорих алсын хараа юм.** Энэхүү гэрээ нь боловсролын тогтолцоонуудын бүтэц, түүнчлэн тэдгээрийг бүтээж бий болгох, хадгалан бэхжүүлэх, боловсронгуй болгон сайжруулахад чиглэсэн ажлын суурь болон зохион байгуулалтын зарчмуудаас бүрдэнэ.

XX зууны туршид нийтийн боловсрол (public education) нь үндсэндээ хүүхэд, залуучуудыг заавал сургуульд сургах хэлбэрээр үндэсний иргэншил, хөгжлийн хүчин чармайлтыг дэмжихэд чиглэгдэж байв. Гэсэн хэдий ч өнөөдөр бид хүн төрөлхтний ирээдүйд болон амьд гараг-эх дэлхийд өөрт нь ноцтой эрсдэлүүд тулгараад байгаа учраас тэдгээр нийтлэг сорилтуудыг даван туулахад бидэнд тусалж чадахаар боловсролын талаар эргэцүүлэн тунгааж, нэн яаралтай **дахин шинээр бүтээх ёстой болоод байна. Энэхүү дахин төсөөлөх үйл хийнэ гэдэг нь хамтын, харилцан хамааралтай ирээдүйг цогцлоохоор хамтдаа ажиллана гэсэн үг юм.** Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь хамтын хичээл зүтгэлийн эргэн тойронд биднийг нэгтгэж, нийгэм, эдийн засаг, хүрээлэл орчны шударга ёсонд тулгуурласан хүн бүрийн тогтвортой, амар амгалан ирээдүйг бүрдүүлэхэд хэрэгтэй мэдлэг, инновацаар хангах ёстой. Тус гэрээ нь энэхүү илтгэлийн нэгэн адил багш нарын гүйцэтгэх үүрэг ролийг ч тэргүүн эгнээнд тавих нь зүйтэй.

2050 он хүртэл боловсролын талаар асуух дараах гурван чухал асуулт байна: Бид юуг цаашид үргэлжлүүлэн хийх ёстой вэ? **Бид юунаас татгалзах ёстой вэ? Бид юуг цоо шинээр сэдэж, бүтээлчээр урлах хэрэгтэй вэ?**

## Суурь зарчмууд

Аливаа нийгмийн шинэ гэрээ нь инклюзив оролцоо, үл алагчлах байдал, хамтын ажиллагаа, эв нэгдэл түүнчлэн хамтын хариуцлага ба харилцан уялдаатай байдал гэсэн хүний эрхийг хангах өргөн хүрээний зарчмуудад суурилж, дараах хоёр үндсэн зарчмаар зохицуулагдах ёстой.

- **Амьдралынхаа туршид чанартай боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах.** Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд заасан боловсрол эзэмших эрх нь боловсролын тухай нийгмийн шинэ гэрээний үндэс суурь хэвээр байх ёстой бөгөөд амьдралын туршдаа чанартай боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах агуулгаар өргөжих учиртай. Энэ нь мэдээлэл, соёл,

шинжлэх ухааны түүнчлэн нийтлэг мэдлэг (knowledge commons) болон үе дамжин өвлөгдөж, тасралтгүй хувиран өөрчлөгдөж буй хүн төрөлхтний хамтын мэдлэгийн нөөцүүдийг хүртэх, түүнд хувь нэмэр оруулах эрхийг хамрах ёстой.

- **Боловсролыг нийтийн хичээл зүтгэл, нийтлэг сайн сайхан байдал болгон бэхжүүлэх.** Нийгмийн хамтын хичээл зүтгэл болох утгаараа боловсрол нь нийтлэг шалтгаант зорилгыг дэвшүүлж, хувь хүмүүс ба хамт олонд хамтдаа цэцэглэн хөгжих боломжийг олгодог. Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь зөвхөн боловсролын салбарыг төрийн санхүүжилтээр хангах төдийгүй боловсролын талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт хүн бүрийг оролцуулж, нийгмийг бүхэлд нь хамруулах амлалт үүргийг тусгасан байх ёстой. Хүн бүрийн оролцоонд онцгойлон анхаарч байгаа нь боловсролыг нийтлэг сайн сайхан байдал буюу хамтдаа сонгож, хамтдаа хүрдэг сайн сайхан аж байдал (shared well-being) болгож бэхжүүлж буй явдал юм.

Эдгээр суурь зарчмууд нь өнөөдрийг хүртэл боловсрол нь хүн төрөлхтнийг одоогийн түвшинд хүрэх боломжийг олгосон дүгнэлт дээр тулгуурладаг бөгөөд биднийг 2050 он болон түүнээс цааших цаг үед дөхөхийн хэрээр боловсрол нь хойч үеийнхэндээ ирээдүйгээ дахин төсөөлж, өөрсдийн ертөнцөө шинэчлэх боломж, эрх мэдлийг олгоход тусална.

### Өмнөх амлалтууд болон тодорхойгүй ирээдүйн хооронд

Өсөн тэлж буй нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн алдагдал, гараг дэлхийн хил хязгаараас давсан нөөцийн ашиглалт, ардчиллын ухралт, эх захгүй технологийн автоматжуулалт энэ бүгд нь бидний өнөөгийн түүхэн цаг үеийн онцлог шинж юм. Эдгээр давхацсан олон хямрал, сорилтууд нь бидний хувь хүний болон хамтын хүний эрх (individual human right and collective human right)-ийг хязгаарлаж, дэлхий дээрх амьдралын ихэнх хэсэгт хохирол гэмтэл учруулж байна. Хэдийгээр боловсролын системийн өргөжин тэлэлт нь олон хүнд боломжуудыг бий болгож байгаа ч асар олон хүмүүсийн суралцахуй нь чанар муутай хэвээр байна.

Ирээдүйгээ харахад үүнээс ч илүү бүдэг бараан дүр зураг тун амархан бууж байна. Хүний амьдрах орон зай багассан, эцэж сульдсан гараг дэлхийг төсөөлж болно. Ирээдүйн эрс тэс зураглал бүхий төсөөллүүдэд чанартай боловсрол нь элитүүдийн давуу эрх ямба болж байхад, асар олон хүмүүс зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг хүртэх боломжгүйгээс зовж шаналж амьдардаг ертөнц ч бас багтана. Сургалтын хөтөлбөрүүд нийцэлгүй болох хүртэл өнөөгийн боловсролын тэгш бус байдал дордсоор л байх уу? Эдгээр боломжит өөрчлөлтүүд бидний суурь хүмүүнлэг чанарт хэрхэн нөлөөлөх вэ?

Ямар ч чиг хандлага бол хувь тавилан биш юм. Ирээдүйн өөр олон хувилбарууд байх боломжтой бөгөөд хэд хэдэн гол салбарт хэсэгчилсэн хувирган өөрчлөлтийг ялган харж болно:

- Манай гараг аюулд өртөж байгаа ч нүүрстөрөгчгүйжүүлэх, эдийн засгийг ногоонжуулах ажил хийгдэж байна. Энд хүүхэд, залуучууд аль хэдийн манлайлан утга учиртай үйлд уриалж, хойшлуулшгүй нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж буй хүмүүсийг хатуу зэмлэж байна.
- Сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхий даяар ардчилсан засаглалаас ухарч, ижилсэлд-хөтлөгдсөн популист мэдрэмж, сэтгэлгээ (identity-driven populist sentiment) өсөн нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ дэлхий даяар газар авсан ялгаварлан гадуурхал, шударга бус байдлыг эсэргүүцэж буй иргэдийн оролцоо, идэвхи улам бүр цэцэглэн хөгжиж байна.



- Дижитал технологид хувирган өөрчлөлт хийх асар их нөөц потенциал байгаа ч бид тэдгээр олон амлалтыг хэрхэн хэрэгжүүлэхээ хараахан бодож олж чадаагүй байна.
- Хиймэл оюун ухаан, автоматжуулалт болон бүтцийн хувирган өөрчлөлтүүд нь дэлхийн өнцөг булан бүрд хөдөлмөр эрхлэлтийн ландшафтуудыг өөрчилж байгаа учраас хүн-төвтэй зохистой ажил хөдөлмөрийг бий болгох сорилтыг шийдвэрлэхэд улам хэцүү болж байна. Үүний зэрэгцээ, илүү олон хүн, хамт олон халамжийн ажлын үнэ цэнийг болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах олон тооны арга замыг хүлээн зөвшөөрч байна.

Шинээр гарч ирж буй үйл явцын эдгээр тасалдалт нь боловсролд далд учир холбогдол бүхий чухал үр дагавар авчирна. Эргээд, боловсрол тэдгээрт хэрхэн хариу үйлдэл үзүүлэх нь бид хамтдаа боловсролын салбарт юу хийхээс хамаарна.

Одоогийн байдлаар дэлхий даяар бидний боловсролыг зохион байгуулж буй арга замууд нь шударга, амар амгалан нийгэм, эрүүл гараг дэлхий, бүгдэд ашиг тустай хамтын ахиц дэвшлийг хангахад хангалттай байж чадахгүй байна. Үнэн хэрэгтээ бидний зарим бэрхшээл нь бид хэрхэн боловсрол эзэмшүүлж байгаагаас үүдэлтэй байдаг. **Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь** суралцахуй болон сурагчид, багш нар, мэдлэг, дэлхий ертөнц хоорондын харилцан хамаарлын талаар **өөрөөр бодох боломжийг бидэнд олгох ёстой.**

## Боловсролыг шинэчлэх саналууд

**Сурган хүмүүжүүлэх арга зүй нь хамтран ажиллах, хоршин ажиллах, эв нэгдэлтэй байх зарчимд суурилах ёстой.** Энэ нь сурагчдын хамтарч ажиллах болон дэлхийг энэрэх нинжин (empathy), нигүүлсэх ариун (compassion) сэтгэлээр хувирган өөрчлөх оюун ухаан, нийгэм, ёс суртахууны чадавхыг тэтгэх хэрэгтэй. Түүнчлэн өрөөсгөл хандлага (bias), мухардмал зан заншил (prejudice), хуваагдмал байдал (divisiveness)-аас ангид байх нь чухал юм. Үнэлгээнд сурган хүмүүжүүлэх эдгээр зорилгыг бүх сурагчийн утга учиртай өсөлт хөгжил болон тэдний суралцахуйг дэмжихэд чиглэдэг байхаар тусгах ёстой.

**Сургалтын хөтөлбөрүүд нь сурагчдад мэдлэг олж авах, бүтээхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тэдний шүүмжлэлт сэтгэлгээний, мөн мэдлэгээ хэрэглэх чадавхыг хөгжүүлдэг экологийн болон соёл хоорондын мөн судлагдахуун хоорондын суралцахуйг чухалчлах ёстой.**

Сургалтын хөтөлбөрүүд нь хүн төрөлхтний экологийн ойлголтыг агуулсан байх шаардлагатай бөгөөд энэ нь бидний цорын ганц орон гэр болсон амьд гараг эх Дэлхийтэйгээ хамааралтай байдаг харилцааг дахин тэнцвэржүүлэх хэрэгтэй. Худал хуурмагийг үнэнээс ялгах чадамжийг хөгжүүлдэг байгалийн ухаан, дижитал болон хүмүүнлэгийн ухааны мэдлэг боловсролоор дамжуулан буруу ташаа мэдээллийн тархалтыг няцаан эсэргүүцэх нь зүйтэй бөгөөд боловсролын агуулга, аргууд, бодлого дахь иргэний идэвхтэй байр суурь, ардчилсан оролцоог дэмжих нь зүйтэй юм.

**Багшлахуйг хоршин ажиллах хамтын хичээл зүтгэл болгож цаашид мэргэжлийн түвшинд хүргэхэд багш нар мэдлэг бүтээгч, боловсрол ба нийгмийн хувирган өөрчлөлтийн гол зүтгэлтэн гэдэг утгаараа энэ хамтын үйлдээ хүлээн зөвшөөрөгдөх ёстой.** Хорших ажиллагаа, багийн ажил нь багш нарын ажлын онцлог байвал зохино. Эргэцүүлэл, шинжилгээ судалгаа,

сурган хүмүүжүүлэх шинэ мэдлэг ба туршлагыг бүтээх нь багшлахуйн салшгүй хэсэг болох хэрэгтэй. Энэ нь тэдний бие даасан байдал, эрх чөлөөг дэмжиж, боловсролын ирээдүйн талаар олон нийтийн мэтгэлцээн, яриа хэлэлцээнд бүрэн хэмжээнд оролцох ёстой гэсэн үг юм.

**Сургуулиуд нь инклюзив оролцоо, үл алагчлах байдал болон хувийн ба хамтын сайн сайхан аж байдлыг дэмждэгийнхээ хувьд боловсролын хамгаалагдсан хотхонууд байх ёстой бөгөөд мөн илүү шударга, тэгш, тогтвортой ирээдүй рүү чиглэсэн дэлхийн хувирган өөрчлөлтийг сайн дэмжих зорилгоор дахин төсөөлөгдөж, шинээр төлөвлөгдсөн байх нь чухал юм.** Сургууль нь хүмүүсийн янз бүрийн бүлгүүдийг хамтад нь нэгтгэж, тэдний өмнө өөр хаана ч байхгүй тийм сорилтууд ба бололцоонуудыг нээж өгдөг газар болох учиртай. Сургуулийн архитектур, орон зай, цаг хугацаа, цагийн хуваарийг төлөвлөж, сурагчдын бүлгийг зохион байгуулахдаа хувь хүмүүст хамтдаа ажиллах боломжийг олгож, урамшуулан дэмждэг байхаар дахин дизайнчлах хэрэгтэй. Дижитал технологи нь сургуулиудыг орлох биш харин тэдгээрийг дэмжихэд чиглэсэн байх ёстой. Сургуулиуд хүний эрхийг хангах, тогтвортой байдалд хүрэх, нүүрстөрөгчийг саармагжуулах үйл хэрэгт үлгэр жишээ болох замаар бидний зорьж буй ирээдүйн загвар болох ёстой.

**Бид янз бүрийн соёл болон нийгмийн орон зайд амьдралын туршид нээгддэг боловсролын боломжуудыг эдэлж, тэдгээрийг өргөжүүлэх ёстой.** Амьдралын бүхий л цаг үед хүмүүст утга учиртай, чанартай боловсролын боломжууд байх учиртай. Бид суралцахуйн байгалийн, зохиомол, виртуал сургалтын талбаруудыг холбож, тус бүрийн хамгийн сайн нөөц потенциалыг хөшүүрэг болгон ашиглах хэрэгтэй. Гол үүрэг хариуцлагыг Засгийн газрууд үүрэх бөгөөд тэдний боловсролын төрийн санхүүжилт, эрх зүйн зохицуулалтын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Хүмүүсийн боловсрол эзэмших эрхийг насан туршид нь хангахын тулд мэдээлэл, соёл, шинжлэх ухаан, харилцаа холбооны эрхээр өргөжүүлэх нь чухал юм.

### Боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгах нь

Томоохон хэмжээний өөрчлөлт, шинэчлэл хийх бололцоо бий. Бид олон сая хувь хүний болон хамтын эр зориг, манлайлал, эсэргүүцэл, бүтээлч байдал, анхаарал халамж зэрэг үйлээр дамжуулан боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулах болно. Нийгмийн шинэ гэрээ нь ялгаварлан гадуурхал (discrimination), орхин гадуурхалт (marginalization), хасан гадуурхалт (exclusion)-ын сорилтуудыг даван туулж, ялан дийлэх хэрэгтэй. Арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, нас, иргэний харьяаллаас үл хамааран жендэрийн тэгш байдал, бүх хүний эрхийг хангахын төлөө бид өөрсдийгөө зориулах ёстой. Нийгмийн яриа хэлэлцээ хийх, хамтдаа сэтгэж, үйлдэхэд асар их амлалт үүрэг, хичээл зүтгэл хэрэгтэй.

**Судалгаа, инновацын уриалга.** Нийгмийн шинэ гэрээ байгуулахын тулд амьдралынхаа туршид сурч боловсрох (education throughout life) эрхийг хангахад анхаарал төвлөрүүлсэн дэлхий дахины хоршин ажиллах хамтын шинжилгээ судалгааны хөтөлбөр шаардлагатай. Энэхүү хөтөлбөр нь боловсрол эзэмших эрхэд төвлөрч, хөндлөн чиглэлийн суралцахуй, мэдлэгийн хил дамнасан солилцоо зэрэг олон төрлийн нотолгоо, мэдэхүйн арга замыг багтаасан байх ёстой. Багш нараас эхлээд сурагчид хүртэлх, эрдэмтэн судлаачид, судалгааны төвүүдээс эхлээд Засгийн газар,

иргэний нийгмийн байгууллагууд хүртэлх хүн бүрийн хувь нэмрийг талархан хүлээн авах нь зүйтэй.

**Дэлхий нийтийн эв нэгдэл, олон улсын хамтын ажиллагааны уриалга.** Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь төрийн болон төрийн бус бүх тоглогчдын хоорондох илүү шударга, үл алагчилсан тэгш хамтын ажиллагаанд тулгуурласан нийтлэг сайн сайхан байдал болгож боловсролыг дэмжихийн төлөө дэлхий нийтээрээ хоршин ажиллахаар хүлээсэн шинэ амлалт үүргийг шаардана. Боловсролд үзүүлэх Хойд-Өмнөдийн тусламжийн урсгалаас гадна Өмнөд-Өмнөд болон гурван талт хамтын ажиллагаагаар дамжуулан мэдлэг, баримт нотолгоог үүсгэн бий болгох ажлыг бэхжүүлэх ёстой. Олон улсын хамтын нийгэмлэг нь боловсролын нийгмийн шинэ гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хамтын шалтгаант зорилго, хэм хэмжээ, стандартад нийцүүлэн ажиллахад нь улс орнуудын төрийн болон төрийн бус тоглогчдод туслах гол үүрэг роль гүйцэтгэнэ. Ингэхдээ аливаа нийгэм, улс төрийн асуудлыг шийдвэрлэхдээ тухайн асуудалтай хамгийн ойрын байх бүтэц, эрх мэдлийн түвшинд нь шийдвэрлэх нь зүйтэй хэмээх “субсидиар” (subsidiarity) зарчмыг хүндэтгэж, орон нутгийн, үндэсний, бүс нутгийн хүчин чармайлтыг хөхиүлэн урамшуулах ёстой. Орогнол хүсэгчид, дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүс, цагаачдын боловсролын хэрэгцээг ялангуяа, олон улсын хамтын ажиллагаа, дэлхийн түвшний байгууллагуудын үйл ажиллагаагаар дэмжих шаардлагатай.

**Их сургуулиуд болон дээд боловсролын бусад байгууллагууд боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулах бүх чиглэлд идэвхтэй ажиллах ёстой.** Бүтээлч, шинийг санаачлагч, боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон бэхжүүлэхийн төлөө тууштай ажилладаг их дээд сургуулиуд нь судалгаа, шинжлэх ухааны дэвшлийг дэмжихээс эхлээд өөрсдийн хамтын нийгэмлэгт болон дэлхийн өнцөг булан бүрд байгаа боловсролын бусад байгууллага, хөтөлбөрүүдэд хувь нэмэр оруулагч түнш байх хүртэл боловсролын ирээдүйд гол үүрэг гүйцэтгэх болно.

**Боловсролын ирээдүйг бүтээхэд** хүүхэд, залуучууд, эцэг эхчүүд, багш нар, судлаачид, идэвхтнүүд, ажил олгогчид, соёл урлаг, шашны удирдагчид гээд **хүн бүр оролцох боломжтой байх нь нэн чухал.** Бидэнд тулж босох гүн гүнзгий, арвин баялаг, олон янзын соёлын өв уламжлал бий. Хүмүүс агуу хамтын хүч нэгдэл, оюун ухаан, бүтээлч нөөц чадавхтай байдаг. Бид одоо тогтворгүй байдалд хөтөлсөн замаараа үргэлжлүүлэн яваад байх уу эсвэл чиглэлээ эрс өөрчлөх үү гэсэн маш нухацтайгаар шийдэх сонголтын өмнө тулж ирээд байна.

Энэхүү илтгэл нь Бид юуг үргэлжлүүлэн хийх ёстой вэ? Бид юунаас татгалзаж, орхих ёстой вэ? Бид юуг бүтээлчээр дахин төсөөлөх хэрэгтэй вэ? гэсэн гурван чухал асуултад өгөх хариултыг санал болгож байна. Гэхдээ **энд байгаа саналууд нь зөвхөн эхлэл юм.** Энэхүү илтгэл нь блюпринт гэхээс илүүтэйгээр эргэцүүлэн бодох, шинээр төсөөлөх урилга юм. Эдгээр асуултыг олон нийт, улс орон, сургууль, боловсролын хөтөлбөр, бүх төрлийн системд, дэлхийн өнцөг булан бүрд хөндөн тавьж, хариулах шаардлагатай байна.

**Боловсролын нийгмийн шинэ гэрээ байгуулах нь бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлөх чухал алхам юм.**

# ТАНИЛЦУУЛГА

Бид тогтворгүй байдалд хөтөлсөн замаар үргэлжлүүлэн яваад байх уу эсвэл чиглэлээ эрс өөрчлөх үү гэсэн оршихуйн сонголттой тулгарч байна. Өнөөгийн замаар үргэлжлүүлнэ гэдэг нь хэт их тэгш бус байдал болон мөлжлөг, хүчирхийллийн олон хэлбэрийн эргүүлэг, нийгмийн эв нэгдэл болон хүний эрх чөлөөний алдагдал, байгаль орчны үргэлжилсэн сүйрэл, биологийн олон янз байдлын аюултай, магадгүй сүйрлийн хохирлыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Өнөөгийн замаар үргэлжлүүлнэ гэдэг нь манай нийгмийн технологийн болон дижитал өөрчлөлтийг дагалдаж буй эрсдэлийг урьдчилан харж, шийдвэрлэхгүй байх явдал юм.

Бид ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлж, түүнийг бодит болгох арга хэмжээ авах шаардлагатай байна. Мэдлэг болон суралцахуй нь шинэчлэл, өөрчлөлтийн үндэс мөн боловч дэлхий нийтийн тэгш бус байдал, түүнчлэн яагаад, яаж, юуг, хаана, хэзээ сурч мэдэхийг дахин төсөөлөх зайлшгүй шаардлага байгаа нь энх тайван, шударга ёс, мөн тогтвортой ирээдүйг бүрдүүлэхэд боловсрол бидэнд хангалттай тусалж чадахгүй байгааг харуулж байна.

Дэлхий ертөнц маань хомсдол, гачигдалгүй элбэг дэлбэг байх, мөн хүн бүр хүний эрхийг бүрэн дүүрэн эдэлдэг байх үүрэг хариуцлагыг бид өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхнээх өмнө хүлээдэг. Яаралтай арга хэмжээ авах, тодорхойгүй нөхцөлүүд үүсэхийг үл харгалзан бидэнд итгэл найдвар дүүрэн байх шалтгаан бий. Хүн төрөлхтөн гэдэг нэгэн төрөл зүйлийнхээ хувьд бид хамтын түүхэндээ мэдлэг болон хамтран ажиллах боломжийг олгодог хэрэгсэл хамгийн их хүртээмжтэй байгаа цэг дээр байна. Ирээдүйг хамтдаа бүтээхэд хүн бүрийг татан оролцуулах боломж урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр их байна.

Боловсрол буюу бидний амьдралынхаа туршид суралцахуй болон багшлахуйг зохион байгуулах арга замууд нь хүмүүний нийгмийг өөрчлөхөд үндсэн үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Боловсрол гэдэг нь бид мэдлэг дамжуулах, хамтран бүтээх үе дамжсан мөчлөгийг зохион байгуулах явдал юм. Энэ нь биднийг дэлхийтэй болон бусад хүмүүстэй холбож, шинэ бололцоог нээж, бидний яриа хэлэлцээ хийх, үйл гүйцэтгэх чадавхыг бэхжүүлдэг. Гэхдээ бидний хүсэж буй ирээдүйг бий болгохын тулд боловсрол өөрөө өөрчлөгдөх ёстой.

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссоос гаргасан энэхүү дэлхийн илтгэлд 2050 он болон түүнээс цааших хугацаанд бидний дэлхий ертөнц, хамтын ирээдүйг төлөвшүүлэхэд боловсрол ямар үүрэг гүйцэтгэх талаар асуусан. Энэхүү илтгэлд тусгагдсан саналууд нь дэлхий даяарх хоёр жилийн хамтын ажиллагаа, хамтын бүтээн байгуулалтын үйл явцын үр дүнд бий болсон бөгөөд бид энэ дэлхий дээр харилцан хамааралтай гэдгийг маш олон тооны хүмүүс буюу хүүхэд, залуус, насанд хүрэгчид маш сайн ухамсарлаж байгааг харуулсан. Дэлхийн асуудлууд бидэнд бүгдэд нь нөлөөлөхүйцээр бид бие биетэйгээ холбоотой байдаг. Бид олон янз байдал болон ялгаатай байдалд талархалтай хандахаас эхлэн хамтдаа ажиллах ёстой гэдгийг гүн бат ойлгож, нэгэн адил ухамсарласан олон хүн дэлхий даяар бий.

Ирээдүйг урьдчилан таамаглах нь хүмүүс бидний хувьд үргэлж хийдэг зүйл юм. Ирээдүйн талаарх санаа бодлууд нь боловсролын сэтгэлгээ, бодлого, практикт чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр нь сурагчид болон гэр бүлийн өдөр тутмын шийдвэр гаргахаас эхлээд боловсролын яамдын гаргасан боловсролын өөрчлөлтийн томоохон төлөвлөгөө хүртэл бүх зүйлийг тодорхойлдог.

ТЭНЭХҮҮ илтгэлд боловсролын талаар эрс өөрчлөлтөөс эхлээд гүн гүнзгий хямрал хүртэлх ирээдүйн олон хувилбарууд байгааг хүлээн зөвшөөрсөн. Боловсролын ирээдүйн талаар эргэцүүлэн бодох гол шалтгаан нь бидний өнөө цагийг өөрөөр дүрслэх, шинээр гарч ирж буй замналыг тодорхойлох, бидний өмнө нээгдэх эсвэл хаагдах бололцоонуудыг анхаарах боломжийг олгох явдал юм. Боломжит болон өөр ирээдүйн талаарх мөшгөх бүх судалгаа нь хэнд зориулсан, ямар ирээдүйг хүсэх вэ? гэсэн ёс зүй, үл алагчлах байдал, шударга ёсны талаар гүн гүнзгий асуултуудыг дэвшүүлж гаргадаг. Боловсрол нь зөвхөн гаднын хүчин зүйлийн нөлөөнд автдаггүй бөгөөд дэлхийн өнцөг булан бүрд боломжит ирээдүйг нээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул бид ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөхдөө зайлшгүй биш юм аа гэхэд боловсролын нийгмийн шинэ гэрээг шаардах нь зүй ёсны хэрэг юм.

Боломжит болон өөр ирээдүйн талаарх мөшгөх бүх судалгаа нь хэнд зориулсан, ямар ирээдүйг хүсэх вэ? гэсэн ёс зүй, үл алагчлах байдал, шударга ёсны талаар гүн гүнзгий асуултуудыг дэвшүүлж гаргадаг.

## Эрсдэлд буй хүн төрөлхтөн, хүний эрх, амьд гарагийн оршин тогтнохуй

Хүн бүрийн эрхэм чанар үнэ цэнтэй гэсэн үзэл санаа; бүх хүмүүс үндсэн эрхтэй гэсэн амлалт үүрэг; бидний цорын ганц гэр орон болох эх дэлхийн эсэн мэнд байдал бүгд эрсдэлд байна. Урагшлах замаа өөрчилж, өөр ирээдүйг төсөөлөхийн тулд бид бие биетэйгээ, амьд дэлхийтэй, технологитой харилцах харилцаагаа яаралтай дахин тэнцвэржүүлэх хэрэгтэй. Хүмүүний бус ертөнц (more-than-human world)-д хүний өөрийн эзлэх байр суурь, бидний харилцан хамаарал болон хийх үйлийн сонголтоо бид эргэн харж дахин сурах ёстой.

Бид давхацсан олон хямралтай нүүр тулж байна. Өргөжин тэлж буй нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн алдагдал, гараг дэлхийн хил хязгаараас давсан нөөцийн ашиглалт, ардчиллын ухралт, эх захгүй технологийн автоматжуулалт, хүчирхийлэл зэрэг нь өнөөгийн бидний түүхэн цаг үеийн онцлог шинж юм.

Парадоксын шинжтэй хөгжлийн чиг хандлага биднийг тогтворгүй ирээдүй рүү хөтөлж байна. Дэлхийн хэмжээнд ядуурлын түвшин буурсан ч улс хоорондын болон улс доторх тэгш бус байдал нэмэгдсээр байна. Амьдралын хамгийн өндөр түвшин нь түүхэн дэх хамгийн их тэгш бус байдалтай зэрэгцэн оршиж байна. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол нь дэлхий дээрх хүн төрөлхтөн болон бусад төрөл зүйлийн оршин тогтнолд заналхийлж байна. Илүү олон хүмүүс олон нийтийн амьдралд идэвхтэй оролцож байгаа ч иргэний нийгэм, ардчилал дэлхийн олон газарт доройтож байна. Технологи биднийг урьд урьдынхаас илүү нягт холбож байгаа ч

нийгмийн хуваагдал, хурцадмал байдалд хувь нэмэр оруулсаар байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахал бидний олон эмзэг байдлыг улам тодотгож өглөө. Эдгээр хямрал, сорилтууд нь бидний хувь хүний болон хамтын эрхийг хязгаарлаж байгаа бөгөөд тэдгээр нь ихэвчлэн хүний сонголт, үйл ажиллагааны үр дүн юм. Эдгээр нь ойрын ирээдүйгээ холын ирээдүйгээсээ урьтал болгож, цөөн хүний ашиг сонирхлыг олон хүний ашиг сонирхлоос давж гарах боломж олгодог бидний бүтээн байгуулалтад бий болсон нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцооноос үүдэлтэй юм.

Нөөцийн ашиглалтын тогтворгүй байдлаас хамааралтай эдийн засгийн загварууд нь уур амьсгал, байгаль орчны гамшгийг хурдасгаж байна. Богино хугацааны ашиг, хэт их хэрэглээг чухалчилдаг эдийн засгийн загварууд нь дэлхийн өнцөг булан бүр дэх бидний нийгмийн хэт их хувиа бодох үзэл, өрсөлдөөнч сэтгэлгээ, бусдыг энэрэх нинжин сэтгэлгүй байдал зэрэгтэй нягт холбоотой юм. Дэлхийн баялгийн эрчимтэй төвлөрөл, эдийн засгийн хэт тэгш бус байдал нь манай нийгмийн эв нэгдлийг алдагдуулж байна.

Улсын төрийн хил хязгаарыг мэддэггүй, хүндэтгэдэггүйгээс үүсэлтэй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хамтын ажиллагаа, эв нэгдлээ бэхжүүлэх шаардлагатай байгаа энэ цаг үед авторитаризм, гадуурхагч популизм, улс төрийн хэт туйлшрал ирчээ авч байгаа нь ардчилсан засаглалыг сорьж байна. Зөрчилдөөнийг энх тайвнаар шийдвэрлэх арга замыг урагш ахиулахад нийгмийн хүчин чармайлтыг дэмжих чиглэлээр олон арван жил ажилласан хэдий ч өнөөдөр дэлхийд нийгэм, улс төрийн туйлшрал улам бүр нэмэгдсээр байна. Үзэн ядсан үг хэллэг, хуурамч мэдээг хариуцлагагүй тараах, шашны фундаментализм, гадуурхагч үндсэрхэг үзлийг шинэ технологиор өргөжүүлсэн нь эцсийн дүндээ явцуу ашиг сонирхлын төлөө стратегийн хувьд ашиглагдаж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсан нийтлэг үнэт зүйлс дээр тулгуурласан дэлхийн дэг жаяг суларч байна. Авлига, увайгүй байдал, тэвчээргүй байдал, хэт их гадуурхал нэмэгдэж, мөн хүчирхийллийг хэвийн үзэгдэл мэт хүлээн авч буй нь манай дэлхий үнэт зүйлсийн хямралтай тулгарч буйг гэрчилж байна.

Глобалчлал хурдасч, албадан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөн зэргээс үүдэлтэй хүний хөдөлгөөн өсөн нэмэгдэж байгаа нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, хэт их гадуурхах, үл тэвчих, ялгаварлан гадуурхах үзлийн хүнлэг бус нөлөөг улам бүр хурцатгадаг. Хүний эрхэм чанарт халдсан хүчирхийллийн эдгээр хэлбэрүүд нь хамтран ажиллах, чөлөөлөх гэхээсээ илүүтэй дарангуйлах, хянах гэсэн эрх мэдлийн бүтцийн илэрхийлэл юм. Зэвсэгт мөргөлдөөн, эзлэн түрэмгийлэл, улс төрийн хэлмэгдүүлэлт нь амьдралыг сүйтгээд зогсохгүй хүний эрхэм чанар гэсэн ойлголтыг гутаадаг. Ихэнхдээ эрх ямба эдэлж, ноёрхогч тогтолцооны ашиг тусыг хүртдэг хүмүүс жендэр, арьсны өнгө, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлагаар ялгаварлан гадуурхаж, уугуул иргэд, эмэгтэйчүүд, дүрвэгсэд, цагаачид, феминистүүд, хүний эрхийн хамгаалагчид, байгаль орчны төлөө тэмцэгчид, эсвэл улс төрийн тэрс үзэлтнүүд гэх мэт аюул заналхийлэл учруулагч гэж өөрсдийн үзсэн бүлгүүдийг дарангуйлдаг.

Манай нийгмүүдийн дижитал хувирган өөрчлөлт нь бидний амьдралд урьд өмнө байгаагүй их хэмжээгээр нөлөөлж байна. Компьютер нь мэдлэгийг бий болгох, олж авах, түгээх, баталгаажуулах, ашиглах арга замыг хурдацтай өөрчилж байна. Үүний ихэнх нь мэдээллийг илүү хүртээмжтэй болгож, боловсролын шинэлэг, ирээдүйтэй гарцуудыг нээж байна. Гэвч тэр хэмжээгээр эрсдэл их. Тухайлбал, суралцахуй нь дижитал орон зайд нарийсах бас өргөжих боломж олгодог, технологи нь дарангуйлж мөн чөлөөлж чаддаг эрх мэдэл, хяналтын

шинэ хөшүүргийг бий болгодог. Нүүр царай таних технологи болон хиймэл оюун ухааны тусламжтайгаар хүний хувийн нууцыг хамгаалах бидний эрх аравхан жилийн өмнөхөөс төсөөлж ч байгаагүй арга замаар хумигдаж байна. Одоо өрнөж буй техникийн өөрчлөлтүүд нь биднийг хөгжин дэвшихэд тусалж, мэдэхүйн олон арга замын, оюуны болон бүтээлч эрх чөлөөний ирээдүйд заналхийлэхгүй байхын тулд бид сонор сэрэмжтэй байх хэрэгтэй.

Бидний амьдралын хэв маяг эх дэлхийтэйгээ болон түүний тэтгэж буй амьдралын элбэг дэлбэг байдалтай тэнцвэргүй болж байгаа нь бидний одоогийн болон ирээдүйн сайн сайхан аж байдал, цаашдын оршин тогтнолд заналхийлж байна. Технологи нь сайн тал руугаа ололт амжилт гаргах чадамжтай хэдий ч бид эргэцүүлж бодохгүйгээр түүнийг шууд хэрэглэж байгаа нь биднийг бие биеэс нь халгаатайгаар холдуулж, харилцаа холбоог тасалж, харилцан ойлголцлыг сааруулж байна. Мөн манай гарагийн болон технологийн эдгээр тэнцвэргүй байдал нь түүнтэй нэгэн адил аюултай гурав дахь гажилт-зөрөөг бий болгоход хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, тэгш бус байдлыг хөөргөн дэвэргэх хэлбэрээр бидний бие биетэйгээ тэнцвэргүй харьцах, итгэлцэл, сайн санааг дордуулах, “бусад”-ыг буруутган харлуулах, дэлхий нийтийн түвшинд өсөн нэмэгдэж буй сорилтуудыг илүү утга учиртай арга замаар даван туулах хүсэлгүй байх, хамтран ажиллаж тэмцэхээс татгалзах зэрэг хэлбэрээр илэрч байна.

Ирээдүйгээ төсөөлөхөд үүнээс ч илүү бүдэг бараан дур зураг дэндүү амархан бууж байна. Хүний амьдрах орон зай багассан, эцэж сульдсан гараг дэлхийг төсөөлж болохоор байна. Ирээдүйг хамгийн муугаар зурагласан төсөөлөлд, чанартай боловсрол нь элитүүдийн давуу эрх болж, ихэнх бүлэг хүмүүс анхдагч хэрэгцээт бараа, үйлчилгээг хүртэх боломжгүйгээс болж зовж шаналж амьдарч буй ертөнц ч бас багтана. Хичээлийн хөтөлбөрүүд улам бүр нийцэлгүй болж,

өнөөгийн боловсролын тэгш бус байдал цаг хугацаа өнгөрөх тусам улам дордох уу? Манай хүн төрөлхтөн улам бүр доройтсоор байх уу?

Өнөөдөр бидний хамтдаа хийх сонголтууд бидний хамтын ирээдүйг тодорхойлох болно.

Өнөөдөр бидний хамтдаа хийх сонголтууд бидний хамтын ирээдүйг тодорхойлох болно. Бид амьд үлдэх үү, эсвэл мөхөх үү, амар амгалан амьдрах уу эсвэл хүчирхийлэл бидний амьдралыг тодорхойлохыг зөвшөөрөх үү, бид дэлхийтэй

тогтвортой байдлаар холбогдох уу эсвэл үгүй юу, эдгээр асуултууд нь бидний өнөөдрийн хийж буй сонголт, шийдвэр, нийтлэг зорилгодоо хүрэх нөөц чадвараар гүн гүнзгий тодорхойлогдоно. Бид хамтдаа замналынхаа чиглэлийг өөрчилж чадна.

## Боловсролын нийгмийн шинэ гэрээний хэрэгцээ

Боловсрол бол нийгмийг шинэчлэх, өөрчлөх үндэс суурь бөгөөд байнга хувиран өөрчлөгдөж байдаг, тодорхой бус ертөнцийг залж удирдахад бидэнд туслах мэдлэгийг бүрдүүлж өгдөг билээ. Боловсролын хүч нь биднийг дэлхий болон бусад хүмүүстэй холбож, амьдарч буй орчноосоо давж сэтгэх, шинэ бололцоонуудыг нээж өгөх чадавхад нь оршдог. Энэ нь биднийг хамтын

хичээл зүтгэлийн хүрээнд нэгдэхэд тусалж, нийтлэг сорилтуудыг шийдвэрлэхэд шаардлагатай шинжлэх ухаан, мэдлэг, инновацыг өгдөг. Боловсрол нь бидний ирээдүйг нийгмийн хувьд илүү инклюзив оролцоотой, эдийн засгийн хувьд шударга, хүрээлэл орчны хувьд тогтвортой байлгахад туслах бидний ойлголтыг хөгжүүлж, нөөц чадварыг бий болгодог.

Хэдийгээр дутагдалтай талуудтай ч сургуулиуд ба боловсролын системүүд нь хувь хүний болон хамт олноороо урагшлах боломжуудыг бий болгож, чиглүүлж чаддаг гэдгийг дэлхийн өнцөг булан бүрд байгаа гэр бүл, олон нийт, засгийн газрууд сайн мэднэ. Хөгжлийн хүссэн үр дүнгүүдээ хүрэхийн төлөө ахиц дэвшил гаргах, ажил хийх ур чадвар, цогц чадамжийг бий болгох, ажил хэрэгч, ардчилсан иргэнийг дэмжих цор ганц нь биш боловч гол хүчин зүйл бол боловсрол гэдгийг засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд хүлээн зөвшөөрдөг. Хүн төрөлхтний сайн сайхан аж байдал, шударга ёс, энх тайван, хүрээлэл орчинтой тогтвортой харилцааг бий болгоход чиглэсэн цогц алсын хараа буюу Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийн тулгуур багана нь зүй ёсоор боловсрол юм.

Гэсэн хэдий ч дэлхий даяар боловсрол нь бидний хүсэл зорилгыг хангаж чадахгүй хэвээр байна. Дэлхий даяар хүртээмжтэй байдал ихээхэн өргөжин тэлж байгаа хэдий ч олон төрлийн хасан-гадуурхалт нь олон зуун сая хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн чанартай боловсрол эзэмших үндсэн эрхэд саад болсоор байна. Жендэр, үндэс угсаа, хэл, соёл, мэдэхүйн арга замаар ялгаварлан гадуурхах нь ихэвчлэн системчилсэн байдлаар үргэлжилсээр байна. Суралцахуйн нийцтэй байдлын хямрал нь боловсролын хүртээмжийн хомсдолыг улам бүр гүнзгийрүүлдэг бөгөөд ихэвчлэн албан сургалт нь хүүхэд, залуучууд болон тэдний нийгмийн хэрэгцээ, хүсэл эрмэлзэлд нийцдэггүй. Чанар муутай сургалт нь бүтээлч сэтгэлгээ, сониуч занг боомилдог. Боловсролын бүх түвшинд сурагчид суралцахуйд татагдан оролцохгүй байх, сургууль завсардах/ гарах зэрэг нь хүүхэд, залуучуудад утга учиртай суралцах болон бие даасан, чиг зорилготой мэдрэмж төрүүлэхэд өнөөгийн сургуулиар суралцах загвар хангалтгүй байгааг харуулж байна. Боловсрол хүртэж буй хүмүүс өнөөгийн болон ирээдүйд тулгарах бэрхшээлүүдэд бэлэн биш байна.

Цаашлаад, ихэнхдээ боловсролын систем өөрөө ялгаварлан гадуурхал, хасан гадуурхалт, тогтворгүй амьдралын хэв маяг гэх мэт бидний хамтын ирээдүйд заналхийлж буй нөхцөлүүдийг бий болгож, улам даамжруулж байдаг. Энэ нь жинхэнэ өөрчлөлтийг бий болгох боловсролын нөөц потенциалыг хязгаарладаг. Эдгээр Бид бүгдийн эдгээр алдаа дутагдал нь боловсролын салбарт бидний үйл ажиллагааг бүтэцчилж, удирдан чиглүүлэх хамтын шинэ алсын хараа, шинэчлэгдсэн зарчим, амлалт үүрэг шаардлагатай байгааг харуулж байна.

Боловсролын нийгмийн аливаа гэрээний эхлэлийн цэг нь боловсролын нийтийн шалтгаант зорилгын талаарх хамтын алсын хараа юм. Боловсролын нийгмийн гэрээ нь боловсролын системийг бүрдүүлдэг суурь болон зохион байгуулалтын зарчим, түүнчлэн тэдгээрийг бий болгох, үргэлжлүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр хийх хуваарилагдсан ажлаас бүрдэнэ.

XX зууны үед нийтийн боловсрол нь үндсэндээ үндэсний иргэнийг төлөвшүүлэх, хөгжлийн төлөө хүчин чармайлтыг дэмжихэд чиглэгдэж байв. Энэ нь гол төлөв хүүхэд, залуучуудыг заавал сургах хэлбэрээр явагдаж ирсэн. Харин өнөөдөр бидэнд тулгарч буй ноцтой эрсдэлүүдийг харгалзан бид бүгдийн нийтлэг бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд тусалж чадахаар



боловсролыг нэн даруй шинэчлэх ёстой. Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь хамтын хичээл зүтгэлийн хүрээнд нэгдэх, нийгэм, эдийн засаг, хүрээлэл орчны шударга ёсонд тулгуурласан хүн бүрийн тогтвортой, амар амгалан ирээдүйг бүрдүүлэхэд шаардлагатай мэдлэг, инновацаар хангахад туслах учиртай.

Нийгмийн шинэ гэрээг байгуулна гэдэг нь боловсрол, мэдлэг, суралцахуйн талаарх сэтгэлгээний хэвшмэл арга барилууд нь биднийг шинэ зам нээж, тэмүүлж буй ирээдүй рүүгээ урагшлахад хэрхэн саад болж байгааг судлахыг хэлнэ. Боловсролын хөгжлийн өнөөгийн загварыг зөвхөн өргөжүүлж хөгжүүлэх нь үр дүнтэй урагшлах арга зам биш бөгөөд бидэнд тулгарч буй бэрхшээлүүд нь зөвхөн хязгаарлагдмал нөөц, арга хэрэгслийн үр дагавар биш юм. Эдгээр сорилт бэрхшээлүүд нь бид ямар учраас, хэрхэн яаж сургах суурь үндэслэл болон суралцахуйг зохион байгуулж буй арга барилаас мөн үүдэлтэй.

## Боловсролын шалтгаант зорилгыг дахин тодорхойлох нь

Боловсролын системүүд нь урт хугацааны тогтвортой байдлаас илүү богино хугацааны давуу эрх, тав тухыг чухалчлах буруу ойлголтыг бий болгосон. Мөн хувь хүний амжилт, үндэсний өрсөлдөөн, эдийн засгийн хөгжлийн үнэ цэнийг чухалчилснаар, эв нэгдэл, харилцан хамаарлыг ойлгох, бие биеэ болон эх дэлхийгээ халамжлахад сөргөөр нөлөөлсөн.

Боловсрол нь хамтын хичээл зүтгэлийн хүрээнд биднийг нэгтгэж, нийгэм, эдийн засаг, хүрээлэл орчны шударга ёсонд тулгуурласан хүн бүрийн тогтвортой ирээдүйг бүрдүүлэхэд шаардлагатай мэдлэг, шинжлэх ухаан, инновацаар хангахад чиглэх ёстой бөгөөд биднийг хүрээлэл орчин, технологи, нийгмийн өөрчлөлтөд бэлтгэхийн зэрэгцээ өнгөрсөн үеийн шударга бус явдлыг засаж залруулах ёстой.

Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь (1) боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах, (2) боловсролыг нийтийн нийгмийн хичээл зүтгэл, нийтлэг сайн сайхны төлөө болгох амлалт үүрэгтээ тууштай байх гэсэн хоёр үндсэн зарчимд тулгуурласан байх ёстой.

### Амьдралын туршдаа чанартай боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах нь

Боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахад шаардлагатай яриа хэлэлцээ, үйл ажиллагаа нь хүний эрхийн төлөөх амлалт үүрэгтээ тууштай байх ёстой. 1948 онд бичигдсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүн төрөлхтөн гэх нэгэн гэр бүлийн гишүүдийн салшгүй эрхийг тодорхойлсон бөгөөд боловсролын шинэ ирээдүйг төсөөлөхөд хамгийн сайн луужин болж өгөх болно. Нийгэм, эдийн засаг, соёлын болон бусад бүх эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг боловсрол эзэмших эрх нь нийгмийн шинэ гэрээний чиглүүлэгч гэрэл, үндэс суурь нь хэвээр байх ёстой. Хүний эрхийн энэхүү линз нь орлого, жендэр, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл, соёл, бэлгийн чиг хандлага, улс төрийн харьяалал, хөгжлийн бэрхшээлээр биднийг ялгаварлан гадуурхах, орхигдуулах зорилгоор ашиглаж болох бусад шинж чанараас үл хамааран боловсролыг бүх нийтэд олгохыг шаарддаг.

Боловсрол эзэмших эрхэд амьдралын туршдаа чанартай боловсрол эзэмших эрхийг багтаах ёстой. Хүүхэд, залуучуудын сургуульд сурах эрх гэж эрт үеэс тайлбарлаж байсан бол цаашид суралцах эрх нь бүх насанд, амьдралын бүхий л салаа мөчирт хангагдах ёстой. Энэхүү өргөн хүрээний өнцгөөс харахад боловсрол эзэмших эрх нь мэдээлэл, соёл, шинжлэх ухааны эрхтэй нягт холбоотой бөгөөд хүний нөөц чадварыг бий болгох гүн гүнзгий амлалт үүргийг шаардана. Энэ нь бас нийтлэг мэдлэг, хүн төрөлхтний хуваалцаж, өргөжин тэлж буй мэдээлэл, мэдлэг, мэргэн ухааны нөөцийг хүртэж ашиглах, түүнд хувь нэмэр оруулах эрхтэй нягт холбоотой.

Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь хүний эрхийн төлөөх амлалт үүрэгтээ тууштай байх ёстой.

Уралдаан тэмцээн, яриа хэлэлцээ, мэтгэлцээний явцад бий болдог мэдлэгийн тасралтгүй мөчлөг нь үйлийг чиглүүлж зохицуулах, шинжлэх ухаанч үнэнийг бий болгох, инновацыг өдөөхөд тусалдаг зүйл юм. Энэ бол хүн төрөлхтний хамгийн үнэ цэнтэй, шавхагдашгүй нөөцийн нэг бөгөөд боловсролын чухал бүрдлүүдийн нэг юм. Нийтлэг мэдлэгийг олон хүн хүртэх тусам тэр хэмжээгээр өргөжин баяждаг билээ. Хэл, тоо тоолол, бичиг үсгийн системүүдийн хөгжил нь мэдлэгийн цаг хугацаа, орон зайн түгээлтэд тус дэм болсон. Энэ нь эргээд хүмүүний нийгэмд хамтын цэцэглэн хөгжил, соёл иргэншлийн бүтээн байгуулалтын ер бусын өндөрлөгт хүрэх боломжийг олгосон билээ. Нийтлэг мэдлэгийн бололцоо нь онолын хувьд хязгааргүй юм. Нийтлэг мэдлэгээр чөлөөлөгдөж бий болсон мэдлэгийн олон янз байдал, инноваци нь зээлэх, зээлдүүлэх, судлагдахуунуудын хил хязгаарыг огтолцуулан дамнасан туршилт хийх түүнчлэн хуучныг дахин тайлбарлах болон шинийг бүтээх замаар бий болдог.

Харамсалтай нь, үл алагчлагдсан байдлаар нийтлэг мэдлэгийг хүртэх, түүнд хувь нэмрээ оруулахад саад бэрхшээлүүд тулгардаг. Хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэгт ихээхэн цоорхой, гажуудал байгаа бөгөөд тэдгээрийг засаж залруулах шаардлагатай. Уугуул иргэдийн үзэл бодол, хэл яриа, мэдлэг нь аль эртнээс гадуурхагдсаар ирсэн. Мөн эмэгтэйчүүд, охид, нийгмийн цөөнх, бага орлоготой бүлгүүдийн төлөөлөл хавчигдаж байна. Нийтлэг мэдлэгийн зах зээлийн арилжаалалт болон оюуны өмчийн хэтэрхий хатуу хууль тогтоомжууд, түүнчлэн нийтлэг мэдлэгт менежмент хийдэг нийгэмлэг, системүүдийг зохих ёсоор зохицуулах, дэмжих механизмын дутагдлаас хаалт, хязгаарлалтууд үүсдэг. Бид зураач, зохиолч, эрдэмтэн, зохион бүтээгчдийн оюуны болон урлагийн өмчийн эрхийг хамгаалах ёстой ба үүний зэрэгцээ мэдлэгийг хэрэглэх, бүтээх нээлттэй, үл алагчилсан тэгш боломжуудыг хангах ёстой. Уугуул иргэд болон бусад орхигдон гадуурхагдсан бүлгүүд, тэдний мэдлэгийг хууль бусаар, зөвшөөрөлгүй эзэмших, ашиглахаас хамгаалахын тулд хамтын оюуны өмчийн эрхийг хүлээн зөвшөөрөх эрхэд суурилсан хандлагыг нийтлэг мэдлэгт хэрэглэх ёстой.

Амьдралын туршид боловсрол эзэмших эрхийн өргөжүүлэлт нь бартаа тотгорыг арилгаж нийтлэг мэдлэгийг мэдэхүй ба дэлхийд оршин тогтнох олон янзын арга замыг тусгасан, нээлттэй бөгөөд байнгын нөөц болохыг баталгаажуулах амлалт үүргийг шаардана.

**Боловсролыг нийтийн хичээл зүтгэл, нийтлэг сайн сайхан байдал болгож бэхжүүлэх нь**

Ас Нийгмийн хамтын хичээл зүтгэл гэдэг утгаараа боловсрол нь нийтлэг шалтгаант зорилгыг бий болгож, хувь хүн болон хамт олонд хамтдаа цэцэглэн хөгжих боломжийг олгодог. Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь боловсролын салбарт төсвөөс зохих ёсны, тогтвортой санхүүжилт олгохоос гадна боловсролын талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт хүн бүрийг хамруулах талаар нийгмийн амлалт үүргийг тусгасан байх ёстой. Хүн бүрийн оролцоонд онцлон анхаарч байгаа нь боловсролыг нийтлэг сайн сайхан байдал буюу хамтдаа сонгож, хамтдаа хүрдэг сайн сайхан аж байдлын нэг хэлбэр болгон бэхжүүлдэг явдал юм.

Боловсролыг нийтлэг сайн сайхан байдал гэж тодорхойлох нэн чухал хоёр шинж чанар байдаг. Нэгдүгээрт, боловсрол бол хүмүүс бусадтай болон эх дэлхийтэйгээ харилцах замаар нийтлэг ойлголттой болдог туршлага юм. Боловсролын байгууллагуудад багш, сурган хүмүүжүүлэгч, суралцагчид цугларч хувь хүний мөн хамт олны хамтын үйл ажиллагаанд нэгдэн оролцдог онцлогтой. Боловсрол нь хүмүүст хүн төрөлхтний мэдлэгийн өвийг ашиглах, түүнд хувь нэмэр оруулах боломжийг олгодог. Хамтдаа бүтээх хамтын үйл ажиллагаа болохынхоо тухайд боловсрол нь хувь хүний болон нийгмийн эрхэм чанар, чадавхыг бататгаж, хамтын шалтгаант зорилгыг бий болгож, хамтын үйлийн нөөц чадварыг хөгжүүлж, бидний нийтлэг хүн чанарыг бэхжүүлдэг. Иймд боловсролын байгууллагууд нь сурагчдын олон янз байдлыг аль болох ихээр хамруулж, бие биеэсээ суралцах боломжоор хангах нь нэн чухал юм.

Хоёрдугаарт, боловсролыг нийтлэг байдлаар зохицуулан засагладаг. Нийгмийн төслийн хувьд боловсрол нь өөрийн удирдлага, хяналтдаа олон янз оролцогчдыг багтаадаг бөгөөд бодлого, шийдвэр гаргах үйл явцад олон янзын дуу хоолой, харах өнцгүүдийг нэгтгэх шаардлагатай. Боловсролын бодлого, зохицуулалт, хяналт-шинжилгээнд илүү олон янзын төрийн бус оролцоо нэмэгдэж буй өнөөгийн чиг хандлага нь боловсролын салбар дахь дуу хоолой, ил тод байдал, хариуцлагыг нийтийн асуудал болгон нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаагийн илэрхийлэл юм. Багш нар, залуучуудын хөдөлгөөн, хамт олонд суурилсан бүлэг, сан, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоо, буяны үйлстэн, шашны байгууллага, нийгмийн хөдөлгөөнүүдийн оролцоо нь боловсролын үл алагчлах байдал, чанар, нийцийг бэхжүүлнэ. Төрийн бус оролцогчид нь ялгаварлан гадуурхахгүй байх, боломжийн тэгш байдал, нийгмийн шударга ёсны зарчмуудыг хамгаалахдаа боловсрол эзэмших эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Боловсролын нийтийн гэх шинж чанар нь боловсролын хангамжууд, санхүүжилт, менежментийг төрийн эрх бүхий байгууллага хариуцахаас хамаагүй өргөн утгатай юм. Нийтийн боловсрол гэдэг нь (1) боловсролыг нийтийн орон зайд бий болох, (2) нийтийн ашиг сонирхлыг дэмжих, (3) бүх нийтийн өмнө хариуцлага хүлээх боловсрол юм. Хэн зохион байгуулж байгаагаас үл хамааран бүх сургууль хүний эрхийг хангах, олон янз байдлыг эрхэмлэх, ялгаварлан гадуурхлыг эсэргүүцэх боловсрол олгох ёстой. Нийтийн боловсрол олон нийтийг хүмүүжүүлдэг гэдгийг мартаж болохгүй. Энэ нь бид ялгаатай байдал болон олон янз байдлаа эрхэмлэхийн зэрэгцээ нэг хүн төрөлхтөн, нэг дэлхийд хамаарах бидний нийтлэг байдлыг бэхжүүлдэг.

Боловсролын нийгэм дэх нийтийн хичээл зүтгэл, нийтлэг сайн сайхны төлөө гэсэн амлалт үүрэг нь орон нутаг, үндэсний, дэлхий нийтийн түвшинд боловсролын засаглалын хэлбэрүүд нь хүртээмжтэй, оролцоотой байх ёстой гэсэн үг юм. Засгийн газрууд боловсролыг ашгийн хэлбэрт оруулахаас хамгаалах, зохицуулах тал дээр улам бүр анхаарах шаардлагатай болж байна. Хүний эрхийн боловсролд хүрэхэд цаашид саад учруулдаг зах зээлийг зөвшөөрөх ёсгүй. Харин боловсрол нь нийтийн ашиг сонирхолд үйлчлэх ёстой.

Хэрэв нийгмийн шинэ гэрээ нь нийгэм, эдийн засаг, хүрээлэл орчны шударга, тогтвортой ирээдүйд хүрэх замыг бий болгоход туслах зорилготой л бол амьдралын туршдаа боловсрол эзэмших эрх болон боловсрол нь нийтийн сайн сайхан, нийтлэг сайн сайхан байдлын төлөөх амлалт үүргээр хүрээлэгдсэн байх ёстой. Эдгээр суурь зарчмууд нь сурган хүмүүжүүлэх арга зүй, сургалтын хөтөлбөрөөс эхлээд шинжилгээ судалгаа, олон улсын хамтын ажиллагаа хүртэлх боловсролын гол хэмжээснүүдийг шинэчлэх яриа хэлэлцээ, үйл ажиллагааг чиглүүлэхэд тусална.

## Илтгэлийн зохион байгуулалт

Энэхүү илтгэл хэд хэдэн бүлгээс бүрдсэн гурван хэсэгтэй бөгөөд тус бүр нь боловсролын нийгмийн шинэ гэрээ байгуулах санал болон яриа хэлэлцээ, үйлд удирдамж болгон баримтлах хэд хэдэн зарчмыг тусгасан болно. Зөвлөмжийг өөр өөр хам нөхцөлд хэрэгжүүлэх арга замыг санал болгож буй төгсгөлийн үгээр илтгэлийг дуусгасан. Илтгэл нь шаардлагатай тохиолдолд судалгааны нотлох баримтыг эш татсан боловч эшлэлийг текстэд дурдаагүй болно. Энэхүү санаачилгын нэг хэсэг болгон тусгайлан захиалсан суурь өгүүлүүдийг хавсралтад оруулсан болно.

Илтгэлийн “Өмнөх амлалтууд ба тодорхойгүй ирээдүйн хооронд” гэсэн Хэсэг I-д боловсролын хасан гадуурхалтыг засаж залруулах, тогтвортой ирээдүйн баталгааг хангахад тусалж чадах нийгмийн шинэ гэрээний хэрэгцээний тулгуур үндэс болох боловсрол дахь үл алагчлах байдал, нийц гэсэн дэлхий нийтийн түвшний давхар сорилтын талаар танилцуулна. Энэ хэсэг хоёр бүлгээс бүрдэнэ.

Бүлэг 1-д Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26-р зүйлд тусгагдсан боловсрол эзэмших эрхийн биелүүлж чадсан болон чадаагүй амлалтын тухай өгүүлнэ. Бүлэг 2-т үйл явцын гол тасалдалтууд ба үүсэн бий болж буй хувирган өөрчлөлтүүд, түүнчлэн хүрээлэл орчны өөрчлөлт, технологийн хурдатгал, засаглал ба нийгмийн хуваагдал, ажлын шинэ ертөнц гэсэн дөрвөн талбарын өргөн хүрээг хамарсан өөрчлөлтүүдийн огтлолцсон давхцалд анхаарлаа хандуулна. 2050 оныг харахад эдгээр тасалдалт, өөрчлөлтүүд нь боловсролд хэрхэн нөлөөлөх, энэ бүгдийг илүү сайн шийдвэрлэхийн тулд боловсрол өөрөө хэрхэн өөрчлөгдөж болох талаар энэ бүлэгт авч үзнэ.

Илтгэлийн “Боловсролыг шинэчлэх нь” гэсэн Хэсэг II нь сурган хүмүүжүүлэх ухаан, сургалтын хөтөлбөр, багшлахуй, сургууль, мөн амьдралын туршид болон янз бүрийн соёл, нийгмийн орчин дахь боловсролын боломжууд гэсэн таван үндсэн хэмжээсний дагуу боловсролыг дахин төсөөлөх, шинэчлэх асуудлыг хэлэлцэнэ. Эдгээр таван хэмжээс бүрийг яриа хэлэлцээ болон үйлийг удирдан чиглүүлэх зарчмуудыг багтаасан тусгай дэд хэсэгт авч үзсэн болно.

Бүлэг 3-т бусдыг энэрэх нинжин сэтгэлийг тэтгэх, ялгаатай байдал ба нигүүлсэх ариун сэтгэлийг хүндэтгэх, өөрсдийгөө болон гараг дэлхийг өөрчлөхийн тулд хувь хүмүүсийн хамтран ажиллах чадавхыг бий болгох хамтын ажиллагаа, эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх арга зүйг уриалсан. Бүлэг 4-т сурагчдад мэдлэг олж авах, бүтээхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тэдний шүүмжлэлт сэтгэлгээний, мөн мэдлэгээ хэрэглэх чадавхыг хөгжүүлдэг экологийн, соёл хоорондын болон судлагдахуун дундын сургалтын хөтөлбөрүүдийг сайшаасан. Бүлэг 5-д багш нарын хувирган өөрчлөх ажлын ач холбогдлыг онцолж, багшлахуйг хоршин ажиллах хамтын хичээл зүтгэл болгон цаашид мэргэжлийн түвшинд хүргэхийг зөвлөнө. Бүлэг 6-д сургуулийг

боловсрол, инклюзив оролцоо, үл алагчлах байдал, хувь хүний болон хамт олны сайн сайхан аж байдлыг дэмждэг нийгмийн талбар болгон хамгаалахын зэрэгцээ шударга, үл алагчилсан тэгш ирээдүйг бүтээхийн тулд өөрчлөх шаардлагатайг тайлбарласан. Бүлэг 7-д боловсролыг зөвхөн албан ёсны байгууллагуудад байдаггүй, харин ч нийгмийн олон орчин, амьдралын туршид хуримтлуулдаг гэдгийг хүлээн зөвшөөрч, боловсролын ач холбогдлыг өөр өөр цаг хугацаа, орон зайн хүрээнд хэлэлцэх болно.

Илтгэлийн “Боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгах нь” гэсэн Хэсэг III нь шинжилгээ судалгаа, дэлхий нийтийн эв нэгдэл, олон улсын хамтын ажиллагаанд уриалга гаргах замаар боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулж эхлэх санааг агуулсан.

Бүлэг 8-д амьдралын туршдаа сурч боловсрох эрхийг хангах талаар хамтарсан судалгааны мөрийн хөтөлбөрт уриалж, боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахад шаардагдах мэдлэгийг бий болгох, бүтээх, зөвшилцөхөд хүн бүр үүрэг роль гүйцэтгэх ёстойг харуулна. Бүлэг 9-д дэлхий нийтийн түвшинд эв нэгдэл, олон улсын хамтын ажиллагааг тууштай, зоримог, харилцан уялдаатай, 2050 он ба цаашдын алсын хараатайгаар бий болгож, бэхжүүлэх шинээр үүсэж буй хойшлуулшгүй хэрэгцээг хэлэлцэх болно.

Илтгэл нь дэвшүүлсэн үзэл санаа, саналуудыг төрөл бүрийн тохируулгат орчинд янз бүрийн арга замаар хөтөлбөр, нөөц, үйл ажиллагаанд хөрвүүлэх шаардлагатай гэж үзсэн төгсгөлийн үг ба үргэлжлүүлэх урилгаар төгсөнө. Ийм хувирган өөрчлөлт нь эдгээр үзэл санааг төлөвлөлт ба үйл болгон хөрвүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бусад хүмүүстэй хамтран бүтээх, яриа хэлэлцээ өрнүүлэх замаар бий болно. Боловсролын шинэчлэлийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд төрийн олон түвшний манлайлагчид, боловсролын захиргааны удирдлагууд, багш нар, сурагчид, гэр бүл, олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллах ёстой.

Явах, юуг ардаа үлдээх, юуг бүтээлчээр дахин төсөөлөх талаар хамтын, тасралтгүй дэлхий нийтийн түвшний яриа хэлэлцээг бэхжүүлэх явдал юм. Хүмүүний бус ертөнцөд оршин суугчид болох хүн төрөлхтөн бидний хувьд хамтдаа тулгарч буй хүнд асуудлуудыг ухамсарлах мөн зүгээр л хуучнаа хуулбарлан давталгүйгээр ирээдүйн зүг чигээ шинээр нээж олохыг бид шинэчлэл хэмээн үзэж байна. Шуудхан хэлэхэд, бид илүү хурдан, илүү өргөн цар хүрээтэй, илүү үр дүнтэй ажилласан ч гэлээ хуучнаа давтан хийсээр байвал энэ нь биднийг сүйрлийн ирмэг рүү түлхэх болно. Үүнийг сануулах хамгийн тод бөгөөд хамгийн чухал анхааруулах дохио бол уур амьсгал ба экосистемийн доройтол гэдгийг бид сайн мэднэ. Шинэчлэл гэдэг нь боловсролын тогтолцоогоо шинэ түвшинд гаргахын тулд

маш их хүчин чармайлтаар олж авсан мэдлэг, туршлагыг шүүж шигшиж үзэхийг хэлнэ. Энэ нь шинийг барьж байгуулах, илүү ирээдүйтэй арга замыг бүтээн цогцлооход бид мэдэж буй зүйлээ ашиглах, залруулах явдал юм.

**Энэхүү илтгэл нь уг зорилгод хүрэхийн тулд хийх яриа хэлэлцээ, үйл ажиллагааны уриалга бөгөөд санал болгож буй мөрийн хөтөлбөр юм.**

Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь байгуулагдаж эхлээд багагүй хугацаа өнгөрч байна. Одоо үүнийг бодит үйл хэрэг болгоход өргөн хүрээний, инклюзив оролцоотой, ардчилсан олон нийтийн яриа хэлэлцээ, дайчилга хэрэгтэй байна. Энэхүү илтгэл нь уг зорилгод хүрэхийн тулд хийх яриа хэлэлцээ, үйлд дуудсан уриалга бөгөөд санал болгож буй мөрийн хөтөлбөр юм.

# ХЭСЭГ I

## Өмнөх амлалтууд болон тодорхойгүй ирээдүйн хооронд

Боловсролын ирээдүйн талаар эргэцүүлэн бодохын тулд бид юуны өмнө боловсрол хаана байгааг болон өнөөгийн сорилтууд ба шинээр гарч ирж буй хувирган өөрчлөлтүүд нь ямар боломжит ирээдүй рүү биднийг чиглүүлж буйг судлах ёстой. Амьдралын бусад салбарын нэгэн адил боловсролын салбарт өнгөрсөн үе нь бидэнтэй маш их холбоотой байдаг. Бид урт хугацааны түүхэн чиг хандлагыг мөн эргэцүүлэн харах хэрэгтэй. Өчигдрийн хасан гадуурхалт, дутагдалтай талуудыг судалж үзэхэд боловсрол бидний хүлээлтэд хүрээгүйг илүү сайн ойлгох болно.

Энэхүү илтгэлийн эхний хэсэг нь үл алагчлах байдал, шударга ёс, тогтвортой байдлын талаар хүлээсэн норматив амлалт үүрэгт хамаарах дэлхий нийтийн хэмжээний боловсролын төлөв байдлын зураглалыг харуулсан бөгөөд эдгээр нөхцөл байдлын ирээдүйн хөгжлийн боломжит арга замуудыг авч үзсэн. Энэ хүрээнд боловсрол нь өмнөх амлалтууд болон тодорхойгүй ирээдүйн хооронд хурцадмал байдалд байгааг олж илрүүлсэн юм.

Энэ хэсгийн эхний бүлэгт сүүлийн 50 жилийн хугацаанд боловсролд гарсан ахиц дэвшилд анхаарлаа төвлөрүүлсэн болно. Энэ бүлэгт эдийн засгийн өсөлт, ядуурал, жендэрийн ялгаварлан гадуурхал зэрэг хүчин зүйлс нь боловсролын ололт амжилттай хэрхэн огтлолцож (мөн нөлөөлж) байгааг шинжлэн судалсан. Мөн өнгөрсөн үеийг үл тоомсорлон үгүйсгэж болохгүй, гэвч дараа нь ирээдүйд юу тохиолдох нь бидний өнөөдрийн болон ирэх гучин жилийн хугацаанд хийх сонголт, хэрэгжүүлэх үйлээр тодорхойлогдоно гэж учирлан нотолсон.

Энэ хэсгийн дараагийн бүлэгт хүрээлэл орчин, технологи, улс төр, ажил хөдөлмөрийн ирээдүй гэсэн дөрвөн үндсэн салбарт шинээр үүсэн гарч ирж буй хувирган өөрчлөлтүүдийг авч үзнэ. Ирээдүйг урьдчилан таамаглах боломжгүй ч аль хэдийн эхэлсэн эдгээр хувирган өөрчлөлтүүдийг үл тоомсорлох явдал нь хамгийн аюултай бөгөөд сүйрэлд хүргэх зам юм гэсэн дүгнэлттэй энэ санаачилгад татагдан оролцсон сая сая хүмүүс санал ихэд нийлж байна.

# Бүлэг 1

## Илүү үл алагчилсан боловсролын ирээдүйн төлөө



Үүнийг манай боловсролын систем хөхиүлэн дэмжих ёстой. Тэр нь нийтлэг сайн сайхны төлөө хамтдаа амьдрах, хамтдаа ажиллах нийгмийн зорилгыг тэтгэх учиртай. Бүлгийнхээ сайн, муу хувь заяаг бүх гишүүд нь шударгаар хуваалцдаг, ахиц дэвшил нь нэр хүндтэй барилга, машин, хувийн болон нийтийн эзэмшлийн бусад эд зүйл биш харин хүний сайн сайхан аж байдлаар хэмжигддэг нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч болж, бүтээлч үүрэг гүйцэтгэдэг болоход нь залуучуудаа бэлтгэх хэрэгтэй. Тиймээс манай боловсрол сурагчдад нийгмийнхээ төлөө гэх мэдрэмжийг төрүүлж, бидний ирээдүйд тохирсон үнэт зүйлсийг хүлээн авахад нь туслах ёстой. Жулиус Ньерере (Julius Nyerere), Бие даах чадварын боловсрол.

**Жулиус Ньерере (Julius Nyerere), Бие даах чадварын боловсрол, 1967**

Сүүлийн гучаас тавин жилийн хугацаанд бид боловсролын салбарт хэр хол явсан бэ? Боловсрол одоо хаана байна вэ? Бид алс холын ирээдүйг харж байгаа энэ үед урагшлах замаа хаана аль болох хурдан өөрчлөх ёстой вэ?

Энэ бүлэгт боловсролын салбар дахь өнгөрсөн хагас зууныг хоёр өнцгөөс авч үзсэн болно. Нэгдүгээрт, боловсролын индикаторууд дахь чиг хандлага нь цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж буйг нарийвчлан харууллаа. Ингэхдээ дундаж үзүүлэлтээс гадна аль болох өгөгдлүүдийг илүү нарийвчилсан утгаар нь буюу бүс нутаг, орлогын бүлэг, жендэр, насны бүлэг болон бусад хүчин зүйлээр хэсэглэн харуулахыг хичээлээ. Хоёрдугаарт, эдгээр болон бусад чиг хандлагын талаар илүү чанарын хэлэлцүүлгийг танилцуулсан бөгөөд ингэхдээ боловсролын үл алагчлах байдал, чанар болон зөрчил мөргөлдөөн, шилжилт хөдөлгөөн зэрэг зарим нэг хүчтэй тасалдалт үүсэхэд боловсролын хариу үйлдэл зүүлэх чадварт илүү анхаарал хандуулсан болно.

Өнөөдрийн хүртээмж, оролцоо, гаралтын үр дүнгийн цоорхой нь өчигдрийн хасагдаж гадуурхагдсан явдал, дарангуйлал мөлжлөг дээр суурилдаг.

Урт хугацааны статистикийн чиг хандлага нь юуг хэмжиж болох, юуг болохгүйгээрээ хязгаарлагддаг тул түүхийг хэсэгчлэн өгүүлдэг. Гэсэн хэдий ч тэдгээрийг цогцоор нь авч үзэх үед тэдгээр нь ирээдүйн магадлалт чиг хандлага, өөрчлөлтийн бололцоот замуудыг харуулдаг. Боловсролын боломжуудын хүртээмж, орхигдон гадуурхагдсан хүн амын инклюзив оролцоо, бичиг үсэгт тайлагдалт болон насан туршийн суралцахуйн тогтолцоог бий болгосон байдал зэрэг нь зарим нэг нийтлэг шинж чанартай байдаг боловч дэлхийн улс орнууд, бүс нутаг, орлогын бүлгүүдийн хооронд

болон тэдгээрийн дотор мэдэгдэхүйц ялгаатай байдаг. Мөн чиг хандлагын задлан шинжилгээ нь аль салбарт хамгийн их анхаарал хандуулж ирсэн болохыг, мөн аль салбарт шинэ бөгөөд яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай байгааг тодруулж өгдөг. Боломжтой байж болох боловсролын ирээдүйг түүхэн болон өнөөгийн сорилтуудын үүднээс харах нь бидэнд гарч ирж болзошгүй бусад ирээдүйн талаар бодоход тусалдаг.

Өнгөрсөн тавин жилийн ахиц дэвшил маш жигд бус байсан бөгөөд өнөөдрийн хүртээмж, оролцоо, дам үр дүнгийн цоорхой нь өчигдрийн хасан гадуурхалт, дарангуйлал мөлжлөг дээр суурилж байна. Маргаашийн ахиц дэвшил нь зөвхөн тэдгээрийг засахаас гадна эдгээр тэгш бус байдал, тэгш бус хэмийг бий болгосон төсөөлөл ба тавилд эргэлзэн нягтлахаас хамаарна. Жишээлбэл, жендэрийн тэгш байдлыг зөвхөн бие даасан зорилго төдийгүй боловсролын тогтвортой ирээдүйг хангах урьдчилсан нөхцөл гэж үзэх ёстой.

## Боловсрол дахь суралцахуйн бүрэн дүүргэлтгүй, алагчилсан тэлэлт

Боловсролыг хүний эрх хэмээн хүлээн зөвшөөрснөөс хойш дэлхий нийтийн хэмжээнд боловсролын хүртээмж нь олон төрлийн хэмжилтээр өргөжиж ирсэн нь сэтгэл хөдлөм гайхалтай явдал болсон. 1948 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлах үед дэлхийн хүн



ам 2.4 тэрбум байсан бөгөөд тэдний дөнгөж 45 хувь нь сургуульд хөл тавьсан байв. Өнөөдөр 8 тэрбум хүн амтай дэлхийн 95 гаруй хувь нь сургуульд явж байна. 2020 оны байдлаар хамрагдалт бага сургуульд 90%, бүрэн бус дунд боловсролд 85%, бүрэн дунд боловсролд 65%-ийг давсан байна. Үүний үр дүнд сүүлийн тавин жилийн хугацаанд дэлхий даяар сургуулийн гадна байгаа хүүхэд, өсвөр үеийнхний эзлэх хувь илт буурсан байна. Энэхүү хүртээмжийн өргөжилт нь хүн амын огцом өсөлтийн үед тохиолдсон нь бүр ч гайхалтай. 1970 онд дөрвөн хүүхэд тутмын нэгээс илүү нь бага сургуульд суралцадаггүй байсан бол 2020 онд 10 хүрэхгүй хувь болж буурсан байна. 1990 онд сургуульд сурдаггүй хүүхдүүдийн бараг гуравны хоёрыг эзэлж байсан охидын хувьд ахиц дэвшил хамгийн тод ажиглагдаж байна. Дэлхийн хэмжээнд бага боловсрол жендэрийн тэнцвэрт байдалд бараг хүрсэн бөгөөд доогуур орлоготой улс орнууд ба Сахараас урагших Африкийг эс тооцвол сургуулийн гадна байгаа хүн амын дунд охид пропорциональ бус их хувь эзлэхээ больсон.

Мөн дэлхий даяар, ялангуяа 2000 оноос хойш бүх бүс нутаг болон орлогоороо бүлгүүдэд ангилагдсан улс орнуудад сургуулийн өмнөх боловсрол дахь оролцоо мэдэгдэхүйц нэмэгдсэн. 1970 онд дэлхий нийтийн түвшинд оролцооны хувийн жин (participation rate) 15% гаруй байсан бол 2000 онд 35%-д хүрээд 2019 он гэхэд 60% болж дээшилсэн байна. Өндөр болон дунд орлоготой улс орнуудад оролцооны хувийн жин ойртож байгаа бөгөөд 2050 он гэхэд бараг бүх нийтээр нь сургуулийн өмнөх боловсролд хамруулахаар тооцоолж байна. Дэлхий даяар жендэрийн тэнцвэрт бус байдал (gender disparity) цаг хугацааны явцад багасаж, сургуулийн өмнөх боловсролын оролцоо жендэрийн тэнцвэрт байдал (gender parity)-д хүрсэн байна. Энэ нь сургуулийн өмнөх насны бүлгүүд бага ангид дэвшин орж, сургуульд амжилттай суралцахад илүү сайн бэлтгэгдэх учраас ирэх жилүүдэд бага боловсрол дахь жендэрийн тэнцвэрт байдлыг хангахад таатай сайн нөлөө үзүүлнэ.

Боловсрол дахь оролцоог өргөжүүлснээр 1990-2020 оны хооронд залуучууд болон насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийн жин (literacy rates) хөгжлийн түвшнөөс үл хамааран бүх улс оронд тогтвортой өсөхөд хүргэсэн. Дунджаас доогуур орлоготой болон дунд орлоготой улс орнуудын залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувийн жин нь дундаас дээгүүр орлоготой орнуудад ажиглагдаж буй 90%-д ойртож байна. Мөн сүүлийн гучин жилийн хугацаанд бүх улс оронд залуу эмэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын хувийн жин мэдэгдэхүйц сайжирсан нь жендэрийн зөрөө (gender gap)-г багасгасан. Одоо дээгүүр орлоготой болон дунд орлоготой улс орнуудад өсвөр үеийнхний бичиг үсэг тайлагдалтын хувийн жин дэх жендэрийн тэнцвэрт байдал ажиглагдаж байгаа бөгөөд бусад оронд тэнцвэрт байдал дахь жендэрийн зөрөө багасаж байна. Үүний нэгэн адил энэ нь өсвөр үеийнхэн насанд хүрэгчдийн амьдралд шилжихийн хэрээр насанд хүрэгчдийн бүх нийтээрээ бичиг үсэгт тайлагдсан байх ирээдүйг илэрхийлж байна.

Сүүлийн тавин жилийн хугацаанд дээд боловсролын оролцоо (participation) мөн мэдэгдэхүйц нэмэгдсэн. Дэлхий нийтийн хэмжээнд 1970 онд залуучууд ба насанд хүрэгчдийн оролцоо 10% байсан бол өнөөдөр 40%-д хүрчээ. Хамрагдалт (enrolment)-ын тооны өсөлт нь сүүлийн тавин жилийн хугацаанд дээд боловсролд эмэгтэйчүүдийн оролцооны өсөлтийг дагуулсан. 1970, 1980-аад онд дээд боловсролд эрэгтэйчүүд голчлон хамрагдаж байсан бол 1990 онд жендэрийн тэнцвэрт байдалд хүрч, түүнээс хойш эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс илүү хурдацтай өссөөр байна. Энэ чиг хандлага нь бага орлоготой улс орнуудаас бусад орлогын бүх бүлэгт хамаарах улс оронд, түүнчлэн

эмэгтэй сурагчдын 7%, эрэгтэй сурагчдын 10% нь оролцдог, Сахараас урагших Африкаас бусад бүх бүс нутагт ажиглагддаг. 1970 оноос хойших чиг хандлагад үндэслэсэн тооцооллоос харахад өндөр орлоготой орнууд 2034 он гэхэд хэдийнээ 100%-ийн оролцоотой болох боломжтой бол дунд орлоготой орнуудад энэ оролцоо 2050 он гэхэд 60%-80%-д хүрнэ. Нөгөө талдаа, дээд боловсролын оролцооны хувийн жин 2050 он гэхэд дундаас доогуур орлоготой улс оронд ердөө 35%-д хүрэх бол бага орлоготой улс оронд 15%-иас бага хувьтай байх болно.

Сүүлийн хэдэн арван жилд боловсролын боломжийг өргөжүүлэхэд ийм гайхамшигтай ахиц дэвшил гарсан хэдий ч өндөр чанартай боловсролын хүртээмж бүрэн бус, тэгш бус хэвээр байна. Боловсрол эзэмших боломжуудаас хасагдаж гадуурхагдах нь хурц асуудал хэвээр байна. Бага орлоготой орнуудын дөрвөн залуу тутмын нэг нь өнөөдөр бичиг үсэг тайлагдаагүй хэвээр байна. Тэр байтугай дунд орлоготой болон дээгүүр орлоготой орнуудад ч гэсэн иргэний болон эдийн засгийн оролцооны эрэлт хэрэгцээ улам бүр нарийн төвөгтэй болж байгаа энэ үед сургуульд сурч байгаа 15 настай хүүхдүүдийн дийлэнх хувь нь хамгийн энгийн түвшнээс давсан зүйлийг уншаад ойлгох чадваргүй байгааг Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ-ОЕСД)-ын Сурагчдын олон улсын үнэлгээний хөтөлбөр (PISA)-ийн судалгаа харуулсан байна. Гэсэн хэдий ч, нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолтоор ч гэсэн насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын хувийн жин дунджаас доогуур орлоготой орнуудад 75%-иас бага, харин бага орлоготой орнуудад 55%-иас бага зэрэг илүү байдаг. Түүнчлэн насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийн жин дэх жендэрийн зөрөө 1990 оноос хойш багассан ч ялангуяа ядуу хүмүүсийн хувьд энэ үзүүлэлт нь хэвээрээ байна. Бага орлоготой орнуудад 5 эмэгтэй тутмын 2-оос дээш нь бичиг үсэгт тайлагдаагүй байна. Өнөөдөр бага орлоготой орнуудын таван хүүхэд тутмын нэг, дэлхийн хэмжээнд арван хүүхэд тутмын нэг нь буюу 250 сая хүүхэд одоо ч гэсэн бага сургуульд явдаггүй байна. Унших, математик, байгалийн ухааны бичиг үсгийн суурь мэдлэгийн зөрөөнөөс гадна Боловсролын ололт амжилтыг үнэлж дүгнэх олон улсын холбоо болон ЭЗХАХБ-аас улс орнуудын дунд явуулсан судалгаанаас харахад иргэний нийгэм болон эдийн засгийн амьдралд оролцоход улам бүр чухал болж буй иргэний боловсрол, глобал цогц чадамж, нийгэмшил-сэтгэл хөдлөлийн цогц чадамжууд зэрэгт ижил төстэй зөрөөнүүд ажиглагдаж байна.

Дунд шатны боловсролын түвшинд нөхцөл байдал бүр ч хурц шинжтэй байна. Бага орлоготой орнуудын өсвөр үе, залуучуудын таван хүүхэд тутмын гурав нь өнөөгийн байдлаар ерөнхий боловсролын сургуульд суралцдаггүй бөгөөд 2030 онд бүх нийтийг үнэ төлбөргүй, үл алагчилсан, чанартай бага ба дунд боловсрол эзэмшүүлэх амлалт үүрэг авсан хэдий ч нөхцөл байдал ийм л байна. Тэнцвэрт бус байдлыг маш тодорхой тодорхойлсон. Өндөр орлоготой орнуудад бүрэн бус дунд боловсролын хамран сургалт нь бараг бүх нийтийг хамрах түвшинд (98%) хүрсэн байдаг бол бага орлоготой орнуудад өсвөр насныхны гуравны нэгээс илүү нь (охидын 40%, хөвгүүдийн 34%) бүрэн бус дунд боловсролд хамрагдаагүй байна. Бага орлоготой орнуудад охидын 35, хөвгүүдийн 45 хүрэхгүй хувь нь суралцаж байгаа бол өндөр орлоготой орнуудад охид ба хөвгүүдийн 90 гаруй хувь нь суралцаж байгаагаас харахад бүрэн дунд боловсрол дахь оролцооны тэнцвэрт бус байдал бүр ч тод харагдаж байна.

Хүртээмж, хамрагдалтаас гадна төгсөлт дэх чиг хандлага нь боловсролын үйлчилгээний хангамжийн чанар ба нийц дэх сорилтуудыг харуулж байна. Дэлхийн хэмжээнд бүрэн бус

дунд боловсролд хамрагдсан дөрвөн сурагч тутмын нэгээс илүү нь, бүрэн дунд боловсролд хамрагдсан хоёр сурагч тутмын нэгээс илүү нь хичээл судлах мөчлөгөө дуусгадаггүй. Дунджаас доогуур орлоготой орнуудын ахлах сургуулийн сурагчдын 60 орчим хувь нь, бага орлоготой орнуудын бараг 90 хувь нь дунд сургуулиа дүүргэхээс өмнө сургуулиа орхидог. Залуучуудын авьяас, чадавхын ийм огцом алдагдлыг хүлээн зөвшөөрч боломгүй юм. Сургуулиа эрт орхиж буй массыг хамарсан энэ том цар хүрээг суралцахуйн агуулгын нийцийн сул байдал, охидын нийгмийн онцлог хэрэгцээ болон ядуусын эдийн засгийн тодорхой шалтгаанд анхаарал хандуулдаггүй явдал, соёлын мэдрэмж ба нийцтэй байдлыг тооцдоггүй байдал мөн залуучуудын бодит байдалд тохироогүй сурган хүмүүжүүлэх аргууд, үйл явцууд зэрэг олон хүчин зүйлээр тайлбарлаж болно. Эдгээр нь олон хүний дэлхий нийтийн «суралцахуйн хямрал» гэж нэрлэдэг зүйлсээс ихэнхдээ анзаарагдалгүй үлддэг нэг хэсэг нь юм.

Хичээлийн чанар хангалтгүй байх нь сурагчид төгсөхөөс өмнө сургуулиа орхиход «түлхэж» буй гол хүчин зүйлүүдийн нэг юм. Хангалттай түвшний хүлээн зөвшөөрөл, бэлтгэл, дэмжлэг, нөөц, бие даасан байдал, мөн тасралтгүй хөгжих боломжуудаар хангагдсан тохиолдолд багш нар боловсролын чанарын хамгийн чухал хүчин зүйл болно. Зохих ёсны дэмжлэгтэйгээр багш нар сурагчдаа үр өгөөжтэй, соёлын онцлогт нийцсэн, үл алагчилсан суралцахуйн боломжуудаар хангаж чадна. Багшлахуйг мэргэжлийн түвшинд хүргэх нь сурагчдад иргэний нийгмийн болон эдийн засгийн оролцоонд зайлшгүй шаардлагатай өргөн хүрээний нөөц чадварыг бүрэн хөгжүүлэхэд нь туслахад маш чухал юм. Энэ нь авьяаслаг ажил горилогчдыг сонгон шалгаруулах, тэднийг өндөр чанартай, зохих ёсны анхан шатны бэлтгэлээр хангах, багшилж эхэлсэн эхний жилүүдэд болон мэргэжлийн тасралтгүй хөгжлийн явцад нь үр өгөөжтэйгөөр туслан дэмжих, мэргэжлийн хоршин ажиллах хамтын ур чадварыг хөхиүлэн дэмждэг сургуулийг суралцагч байгууллага болгохын тулд багшийн ажлын байрыг шинээр бүтэцчилэх, багшлахуй болон захиргааны удирдлагын чиглэлээр өсөн нэмэгдэж буй туршлагыг нь хүлээн зөвшөөрч урамшуулдаг байхаар багшийн ажил мэргэжлийн карьерын шатлалыг бий болгох, түүнчлэн мэргэжил ба боловсролын ирээдүйг тодорхойлоход багш нарын дуу хоолойг тооцдог байх зэрэг харилцан уялдаа бүхий хөгжлийн тасралтгүй байдлыг бий болгохыг шаардана. Мэргэжлийн хөгжлийн ийм тасралтгүй байдлыг бий болгоход эдгээр янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хооронд нь уялдуулан нийцүүлсэн хамтын манлайлал шаардлагатай. Багш нарын томилгоог улс төржүүлэх гэх мэт сурагчдын ашиг сонирхлоос ангид өөр ашиг сонирхолд нийцүүлэх, багш боловсролын хөтөлбөрүүдийг удирдаж буй байгууллагуудыг «мөнгөний үнээ» болгон ашиглах, багшийн карьерын бүтэц нь сурагчдын суралцахуйд үзүүлдэг багшийн нөлөөллийг хүлээн зөвшөөрдөггүй байх, багшлах эсвэл багш бэлтгэх сургалтын байгууллагын стандартгүй байх, багшийн мэргэжлийн материаллаг нөхцөл нь ижил түвшний бэлтгэл, ажил шаарддаг бусад мэргэжлээс хамаагүй доогуур байх, багш нарыг улс төрийн кампанит ажилд оролцохыг шаардаж мэргэжлийн байр суурийг нь доошлуулсан ажил гүйцэтгүүлж дарамт үзүүлэх, эсвэл өөрсдийнх нь хүсээгүй зүйлд албадсан санхүүгийн шимтгэл татвар авах, эсвэл эрх чөлөө, мэргэжлийн ижилсэл, хүний эрхийг нь зөрчих, тэр дундаа ажлын байранд бэлгийн дарамт үзүүлэх, эсвэл шашин шүтлэг, улс төрийн харьяалалд үнэнч байхыг албадах зэрэг соёлын олон хэм хэмжээ нь багшлахуйн мэргэжлийн байх чанарыг алдагдуулдаг.

Гэсэн хэдий ч сургуульд суралцах хүртээмж нэмэгдэж, багш нарын эрэлт хэрэгцээ өсөхийн хэрээр бага сургуулийн мэргэшсэн багш нарын эзлэх хувь дэлхийн хэмжээнд буурч байгаа нь

## Бага сургуулийн мэргэшсэн багш нарын эзлэх хувь дэлхийн хэмжээнд сэтгэл түгшихээр буурч байна.

сэтгэл түгшээж байна. Энэ нь дэлхийн хэд хэдэн бүс нутаг, ялангуяа Сахараас урагших Африкт ажиглагдаж байна. Сахараас урагших Африкт хамгийн бага түвшинд мэргэшсэн бага сургуулийн багшийн эзлэх хувь 2000 онд 85% байсан бол 2020 онд ойролцоогоор 65% болж буурсан байна. Урьд нь бага сургуулийн мэргэшсэн багш нарын эзлэх хувь өндөр байсан зарим бүсэд тухайлбал, Арабын бүс нутагт 2004 онд

98% байснаа 2020 онд 85% болсон бууралт ажиглагдаж байна. Сахараас урагших Африк дахь мэргэшсэн багш нарын эзлэх хувийн бууралт нь дунд боловсролын түвшинд бүр ч их байна. 2015 онд Сахараас урагших Африкийн дунд сургуулийн нийт багш нарын тал хувь нь хамгийн бага ур чадвартай байсан ба энэ нь өмнөх арван жилтэй харьцуулахад бараг 80%-иар буурсан байна.

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС) дахь залуучуудын оролцоо дэлхийн олон хэсэгт мөн доогуур хэвээр байна. 2000-2020 оны хооронд Төв Ази, Төв болон Зүүн Европ, түүнчлэн Зүүн Ази, Номхон далайн бүс нутагт 15-24 насны залуучуудын 15 хүртэлх хувь нь ТМБС-д хөтөлбөрт хамрагдаж, техникийн болон мэргэжлийн боловсролын хамрагдалтад тодорхой ахиц дэвшил гарч байна. Харин хамгийн бага орлоготой орнууд болон Сахараас урагших Африк, Өмнөд Ази зэрэг бүс нутагт ТМБС-д элсэгчдийн тоо бага хэвээр байгаа бөгөөд 15-24 насны хүмүүсийн дөнгөж 1 орчим хувийг эзэлж, зогсонги байдалтай байна. Мэргэжлийн ур чадварын хөгжил нь зөвхөн албан боловсрол, сургалтаар хязгаарлагдахгүй бөгөөд томоохон албан бус эдийн засагтай олон орны залуучууд уламжлалаа өвлөн суралцах эсвэл албан бус ур чадвараа хөгжүүлэх боломжтой гэдгийг санах нь зүйтэй. Гэсэн хэдий ч, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын мэдээллээс харахад дэлхийн хэмжээнд таван залуу (16-24) тутмын нэгээс илүү нь боловсрол, сургалтад хамрагдаагүй, ажил эрхлээгүй байгаа бөгөөд тэдний гуравны хоёр нь залуу эмэгтэйчүүд байна.

Эдгээр тоо баримтууд нь 1990 оноос хойш дэлхий дахинд хэд хэдэн удаа амлалт үүрэг хүлээсэн хэдий ч хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн сурч боловсрох түгээмэл эрхийг хангахад хамтдаа бүтэлгүйдсэнийг тодорхой харуулж байна. Энэ бүтэлгүйтэл нь ялангуяа охид ба эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, ядуу өрхөөс гаралтай хүмүүс, хөдөө орон нутгийн иргэд ба олон нийт, уугуул иргэд, цөөнхийн бүлгүүд, түүнчлэн хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөн, улс төрийн тогтворгүй байдлын үр дагаврыг амсаж буй хүмүүсийн хувьд үнэн бодит зүйл юм. Нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн хүчин зүйлсийн харилцан хамаарлаас үүдэлтэйгээр гадуурхагдсан нийгэмлэгүүд урьдын адилаар хасагдаж гадуурхагдсан хэвээр байна.

Хэрэв боловсрол ирээдүйг өөрчлөхөд туслах ёстой юм бол эхлээд өмнөх шударга бус байдлыг арилгах замаар илүү их инклюзив оролцоотой болох ёстой. Бодлого, стратеги нь гадуурхагдсан (marginalized) сурагчдыг, ялангуяа нийлмэл сул талууд (compounded disadvantages)-тай тулгардаг сурагчдыг дэмжих зорилготой бол эдгээр тэгш бус байдал, хасан гадуурхалт (exclusion)-ыг бүрдүүлж буй хүчин зүйлсийг тод томруун тодорхойлох ёстой.

## Амь бөхтэй ядуурал ба өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал

Ядуурал нь боловсролын боломжуудын хүртээмжийг тодорхойлдог гол тодорхойлогч хэвээр байна. Ядуурал нь эмэгтэй сурагчид болон хөгжлийн бэрхшээлтэй, тогтворгүй байдал ба зөрчил мөргөлдөөний нөхцөл байдалд байгаа, үндэс угсаа, хэл яриа, алслагдсан байршлын улмаас гадуурхагдсан суралцагчдын тэнцвэрт бус байдлыг улам хурцатгадаг нийлмэл хүчин зүйл юм.

Зүүн Ази, Номхон далайн орнууд, ялангуяа Хятад улсын эдийн засгийн хурдацтай өсөлт болон өндөр ба дундаас дээгүүр орлоготой орнуудын эдийн засгийн тогтвортой өсөлтөөс шалтгаалан 1990-2020 оны хооронд дэлхийн эдийн засаг 2.5 дахин өссөн. Харин дундаас доогуур болон бага орлоготой улс оронд 2020 онд дэлхийн хүн амын тал хувь нь амьдарч байсан хэдий ч тэд дэлхийн нийт үйлдвэрлэлийн аравны нэгийг л бүрдүүлж байна. Энэ нь сүүлийн гучин жилийн хугацаанд бүс нутгуудын эдийн засгийн өсөлтийн хурдац ихээхэн ялгаатай байсны үр дүн юм. 1990 онд Хятад болон Сахараас урагших Африкийн эдийн засаг нь бараг ижил хэмжээгээр дэлхийн эдийн засгийн 2% ба 1.5%-ийг тус тус эзэлж байв. Харин 30 жилийн дараа Хятад улс дэлхийн ДНБ-ий 16 хувийг бүрдүүлж байгаа бол Сахараас урагших Африк ердөө 2 хувийг бүрдүүлж байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт нь хувь хүний орлого нэмэгдэж, амьдралын нөхцөл сайжирч, дэлхий нийтийн түвшинд ядуурлын хувийн жин буурахад хүргэсэн. Дэлхийн банкны мэдээллээс харахад 1990-2020 оны хооронд дэлхийн нэг хүнд ногдох жилийн орлого 75%-иар өссөн байна. 1990 онд дэлхийн хүн амын гуравны нэгээс илүүг ядуу гэж тооцож байсан бол өнөөдөр дэлхийн ядуурлын хувийн жин 10%-д хүрэхгүй байна. Гэсэн хэдий ч бага орлоготой орнуудын эдийн засгийн өсөлтийн хурд буурч байгаа нь ядуурлыг бууруулахад ахиц гаргахуйд болон орлогын тэгш бус байдлыг багасгах итгэл найдварт саад болж байна. Дэлхий дахинд ядуурлын үндсийг таслах сорилт хэвээр байсаар байна. Үнэхээр сүүлийн 30 жилийн хугацаанд дэлхий дахинд ядуурал буурсан хэдий ч дэлхийн хэмжээнд 690 орчим сая хүн өдөрт хоёр хүрэхгүй ам .доллаар амь зогоон ядуу амьдарч байна. Дэлхийн банкны мэдээгээр дэлхийн хүн амын дөрөвний нэг нь буюу 1.8 тэрбум хүн өдөрт 3.20 ам.доллар ба түүнээс бага орлогоор амьдарч байна. Нэн ядуурал нь Сахараас урагших Африкт голчлон төвлөрч, хөдөө орон нутагт зонхилдог бөгөөд эмэгтэйчүүдэд пропорциональ бусаар нөлөөлдөг. Ядуу хүмүүсийн гуравны хоёр нь 25 хүртэлх насны хүүхэд залуучууд байна.

1980-аад оноос хойш хөгжиж буй болон дунд орлоготой орнуудын эдийн засгийн хурдацтай өсөлт нь улс орнуудын хоорондын тэгш бус байдлыг аажмаар бууруулахад хүргэсэн. Гэсэн хэдий ч үүнтэй зэрэгцэн улс орнуудын дотоодод тэгш бус байдал харилцан адилгүй хурдтайгаар нэмэгдэв. 1980-аад оноос хойш Хятад, Энэтхэг, Хойд Америк, ОХУ-д орлогын тэгш бус байдал огцом нэмэгдсэн бол Европт харьцангуй бага зэргийн өсөлт ажиглагдсан. Харин Арабын улс орнууд, Сахараас урагших Африкт, мөн Бразилд тэгш бус байдал өндөр байсаар ирсэн бөгөөд одоо ч энэ байдал хадгалагдсаар байна. 2018 оны Дэлхийн тэгш бус байдлын тайланд дурдсанаар Сахараас урагших Африк болон Арабын орнууд, Бразил, Энэтхэг зэрэг орнуудын нийт орлогын талаас илүү хувийг хүн амын 10% хувийг эзэлдэг маш өндөр орлоготой хүмүүс эзэгнэдэг байна. Бараг бүх улс оронд хөрөнгө төрийн өмчөөс хувийн өмчид шилжсэн. Эдийн

засаг тэлсэн хэдий ч засгийн газрууд ядуурсан нь орлогыг дахин хуваарилах, тэгш бус байдлыг бууруулах боломжуудыг хязгаарлаж байна.

Баялгийн тэгш бус байдлын боловсролд үзүүлэх ач холбогдол олон талтай. Тэгш бус байдал нь нийгмийн хөгжил цэцэглэл, сайн засаглалд зайлшгүй чухал нийгмийн эв нэгдлийг алдагдуулж, ядуу хүмүүсийг нийгмээс хасагдан гадуурхагдахад хүргэдэг. Тэгш бус байдал нь янз бүрийн тодорхой нөхцөл байдал бүрд төрсөн хүүхдүүдийн боловсролд маш ялгаатай түвшний дэмжлэг үзүүлэхэд хүргэдэг бөгөөд энэ нь сургуулиудад үл алагчилсан тэгш боломжийг бүрдүүлж, тэдэнд тохирсон дэмжлэг үзүүлэхэд хүндрэл учруулдаг. Сургуулиуд нь сурагчдын амьдралын нөхцөл байдлаас үл хамааран бүх хүүхдэд боловсролын тэгш боломжууд олгох нь илүү шударга, үл алагчилсан ирээдүйн урьдач нөхцөл болдог.

Гэтэл энэ нь илүү тэгш бус нийгэмд илүү хэцүү сорилт болдог. Үнэн хэрэгтээ хэт тэгш бус байдал нь боловсролын салбарт авлига үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь үр өгөөжтэй хяналт тавих чадавхгүй газарт урагшлах гэсэн хяналтгүй хүсэл эрмэлзэл нь хууль бус дөт зам болж хувирахад хүргэдэг. Транспэрэнси Интернэшнл байгууллагын 2013 оны дэлхийн авлигын тайланд боловсролын салбар дахь авлига нь хэрхэн худалдан авалт, нийлүүлэлтэд зориулагдсан нөөцийг өөр тийш нь шилжүүлэх, дүн болон элсэлтийн төлөө хээл хахууль өгөх, төрөл садан ба танил талаа ажилд авах, тэдэнд тэтгэлэг олгох, эрдэм шинжилгээний бүтээлээс хулгайлах, шинжилгээ судалгаанд улс төрийн болон аж ахуйн байгууллагаас зүй бусаар нөлөөлөх зэрэг олон хэлбэрээр илэрч болохыг тодорхойлсон. Нийгэм болон институцийн итгэлцэл сулрах нь боловсролын үнэ цэн ба шударга зарчимч байдлын талаарх итгэлцлийг сулруулж, хамгийн чухал нь авлигыг аль бага наснаасаа нийгмийн хэм хэмжээ гэж хүлээн зөвшөөрөхөд хүргэж болзошгүй юм.

## Хасан гадуурхалтын сүлжээ

Боловсролоос хасагдан гадуурхагдахад хүргэдэг ялгаварлан гадуурхлын бусад хүчин зүйлтэй ядуурал, орлогын тэгш бус байдал нь огтлолцдог. Жишээлбэл, жендэрийн ялгаварлан гадуурхал нь харилцан огтлолцож давхцдаг ядуурал, уугуул иргэдийн ижилслийн өвөрмөц онцлог, хөгжлийн бэрхшээл зэрэг бусад хүчин зүйлтэй үлэмж хэмжээгээр хосолж, охидын цаашид сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй улам орхигдон гадуурхагдахад хүргэдэг. Түүнээс гадна ихэнх орлогын бүлгүүд болон бүс нутгийн сургуулийн элсэлтэд жендэрийн тэнцвэрт байдал хангагдаж байгаа ч хамгийн бага орлоготой орнууд болон Сахараас урагших Африкт байдал өөр байна. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн (ЮСХ) мэдээллээс үзэхэд Сахараас урагших Африкт сургуулийн гадна байгаа бага сургуулийн насны 100 эрэгтэй хүүхэд тутамд боловсролоос хасагдаж үлдсэн 123 охин ногдож байна. Охидын хасагдан гадуурхагдалт нь бүрэн бус дунд ба бүрэн дунд боловсролд бүр ч тод илэрдэг. Хамгийн бага орлоготой 9 оронд хамгийн ядуу өрхийн охидыг хөвгүүдтэй харьцуулахад дунджаар 2 жилээр бага хугацаагаар сургуульд суралцдаг байна. Энэхүү жендэрийн тэнцвэрт байдлын алдагдал, ялангуяа дунд боловсрол дахь энэ алдагдал нь охидыг бүхий л амьдралынх нь туршид боловсролтой байлгахын тулд илүү их зүйл хийх хэрэгтэй байгааг харуулж байна. Эндээс харахад анхан шатны хүртээмжийн асуудлыг шийдэх нь хангалтгүй юм. Охидыг дунд боловсролын мөчлөгийг бүрэн дуустал суралцах боломжоор хангах нь сургуулийн хүлээх үүрэг хариуцлагаас давсан зүйл юм. Ийм боломжоор

хангах явдал нь дэлхий даяар охидод тулгардаг сорилтуудад, ялангуяа тэд бэлгийн бойжилтын насандаа эрт гэрлэлт, эрт болон хүсээгүй жирэмслэлт, гэрийн ажил, сарын тэмдгийн үеийн эрүүл мэнд, гутаан доромжлол зэрэг нийгэм, эдийн засгийн асуудалд хамаарна.

Боловсролын системд инклюзив оролцооны бодлого байхгүй тохиолдолд хөгжлийн бэрхшээл нь бүх бүс нутаг ба улс орны орлогын бүлгүүдийн боловсролын хүртээмжид нөлөөлдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмшихэд нь учирч буй саад бэрхшээлүүд нь ядуурлаас хамааран ихээхэн хэмжээгээр нэмэгддэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дийлэнх нь ядуу буурай орнуудад амьдарч байна. Бүх насныхны хувьд дунд болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийн түвшин нь бага ба дунд орлоготой орнуудад баян орнуудтай харьцуулахад илүү өндөр байдаг. Ядуурал нь хөгжлийн бэрхшээлийн шалтгаан ба үр дагаврын аль аль нь болдог бөгөөд боловсролын системүүд нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурч боловсрох эрхийг аль болох дээд хэмжээгээр дэмжиж, хамгийн бага хязгаарлалттай боловсролын орчинд хамруулах үүрэгтэй.

Дэлхий дээрх урт хугацаагаар сургууль завсардсан хүн амын тал хувь нь мөргөлдөөний улмаас сургууль завсардсан байдаг. Хүчирхийллийн мөргөлдөөн нь сургууль ажиллуулах, сургуульд суралцахад аюултай болгодог бөгөөд хүн амыг бүхэлд нь нүүлгэн шилжүүлэхэд хүргэдэг. Боловсролын байгууллага, ажилтнууд болон сурагчид нь хүн хулгайлах, хүчиндэх, зэвсэгт хүчинд элсүүлэх зэрэг гэмт хэргийн золиос болж болзошгүй.

Уугуул иргэд болон үндэстний цөөнхийн хүүхэд, залуучууд бүх түвшинд чанартай боловсрол эзэмших боломжийг нь хязгаарладаг хэд хэдэн саад бэрхшээлтэй тулгардаг. Эдийн засаг, хэл яриа, газарзүйн саад бэрхшээлээс гадна арьс өнгө, ялгаварлан гадуурхал, соёлын нийцэлгүй байх зэрэг хүчин зүйл нь уугуул иргэдийн хүүхэд, залуучуудын дундах алдагдлын хувийн жин (attrition rate) өндөр байхад хүргэдэг. Ерөнхийдөө албан боловсрол нь уугуул иргэдийн мэдлэг ба суралцахуйн тогтолцоог таньж, хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд хөдөө орон нутаг, хотын аль алинд амьдарч буй уугуул иргэдийн бодит байдал, хүсэл эрмэлзэлд нь нийцсэн хариу үйлдэл үзүүлдэггүй.

Түүхийн хувьд боловсрол нь хүүхдийн соёл, шашны эрхийг зөрчихөд бас ашиглагдаж ирсэн бөгөөд тухайлбал, уугуул хүмүүс, үндэстний цөөнхийг нийтлэг нийгэмд уусгах ба шашны сургаал, үзэл санаанд итгүүлэх хэрэгсэл эсвэл үндэстний цөөнхөөс гаралтай хүүхдүүдийн суурь эрхийг зөрчиж, тэдний шашин, соёлын ижилслийн өвөрмөц онцлогийг устгах хэрэгсэл болгон тус тус ашиглаж ирсэн. Боловсролоор өөрчилдөг энэ өвийг уугуул түмний хүүхдүүд ба гэр бүлийн эсрэг зэвсэг болгон ашиглах нь үргэлжилсээр байгаа тул тэд системийн ялгаварлан гадуурхал, үл тоомсорлолыг урьдын адил амссаар байна. Жишээлбэл, алслагдсан нутгийн уугуул иргэд болон цөөнхийн бүлгүүдийн хүүхдүүд ихэвчлэн сургуулиа үргэлжлүүлэхийн тулд орон нутгаа орхиж, оюутны болон сургуулийн дотуур байранд амьдардаг нь тэднийг гэр бүл, хамт олон, соёлын дэмжлэгээс хөндийрүүлдэг.

Эдийн засгийн глобалчлал нь сурагчид юуг, яаж сурахад улам бүр нөлөөлж байна. Энэ нь XXI зуунд ажил, хөдөлмөр эрхлэхэд хүүхэд, залуучууд юу мэдэх ёстой вэ гэсэн хүлээлтийг өөрчилсөн. Ажил хөдөлмөрт бэлтгэх нь боловсролын чухал зорилго юм. Гэсэн хэдий ч боловсролын зорилгыг хэт явцуу тодорхойлох нь тухайлбал, сурагчдын болон тэдний гэр бүлийн боломжууд ба бодит



амьдралтай нийцэхгүй байх нь урьдчилан тооцоолоогүй алдаанд хүргэдэг. Мэдэхүйн илүү өргөн цар хүрээтэй арга хандлага нь янз бүрийн хам нөхцөл, соёл, тухайн тодорхой нөхцөл байдал бүрд мэдлэг бүтээх, хэрэглэх, түгээх арга замуудын олон янз байдгийг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр нь зөвхөн бичиг үсэг, тоо тооллын суурь ур чадвараас гадна дэлхий нийт, орон нутаг, өвөг дээдэс, соёл, шинжлэх ухаан, оюун санааны хүлээн зөвшөөрөгдсөн янз бүрийн соёлын талаарх мэдлэгийн баялаг өв уламжлал дээр тулгуурладаг.

## Боловсролын үл алагчлах байдал нь хүн төрөлхтний мэдлэг ба өөрийгөө илэрхийлэх олон хэлбэрийг хамрах ёстой.

Энэ нь тухайлбал, сургуулийн гадна үлдсэн гэх хүмүүсийн тоонд багтаж болох уугуул иргэд болон цөөнхийн хэлтэй, угсаатны олон янз сурагчдын хувьд бодит үнэн юм. Боловсролын үл алагчлах байдал нь хүмүүний мэдлэг ба өөрийгөө илэрхийлэх олон хэлбэрийг хамрах ёстой. Суралцахуйн томоохон хэмжээний үнэлгээ нь төрөлх эх хэлний цогц чадамжийг ихэнхдээ тооцож үздэггүй бөгөөд энэ нь цөөнх болон уугуул сурагчдыг цаашдаа боловсролын үйлчилгээнээс орхигдон гадуурхагдах, мөн сургуулиа эрт орхиход хүргэдэг. Жишээлбэл, Олон улсын унших чадварын судалгааны хөтөлбөр (Programme in International Reading Literacy Study-PIRLS)-ийн үр дүнгээс харахад гэртээ шалгалтын төстийн хэлээр ярих магадлал багатай 4-р ангийн сурагчид бусад сурагчидтай харьцуулахад унших чадварын хамгийн доод түвшинд үнэлэгдсэн байна. Бид нийгэм, эдийн засгийн хөгжлийн цор ганц төсөөлөл-алсын харааг тулгахаас илүүтэй олон амьд бодит байдлыг агуулсан ертөнцийг хүлээн авах ёстой. Хувь хүний болон хамтын эрхийг бүрэн хэрэгжүүлэх баталгаа нь хүмүүний олон янз байдал бүхий нөөц потенциалыг жинхэнэ утгаар нь үнэлэхийг шаарддаг.

Хэрэв хүний эрх нь боловсролын нийгмийн шинэ гэрээг чиглүүлэх ёстой юм бол сурагчдын, ялангуяа үүсэл гарал, шашин шүтлэг, соёлын болон жендэрийн цөөнх, системтэйгээр гадуурхагдсан хүн амын дундах өөрийн гэсэн соёл, оюун санаа, нийгэм, хэл ярианы ижилслийн өвөрмөц мэдрэмжийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах ёстой. Сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, сургалтын байгууллагын арга хандлагад ижилслийн онцлог шинж чанарыг зохих ёсоор хүлээн зөвшөөрөх нь сурагчийг тогтоон барихад болон тэдний сэтгэцийн эрүүл мэнд, өөрийгөө үнэлэх үнэлэмж, хамт олны сайн сайхан аж байдалд шууд нөлөөлдөг.

Өөр бусад шийдлүүд нь тохирч нийцэхгүй байгаа хүмүүст хүрэхийн тулд янз бүрийн арга хэрэгсэл, арга хэмжээ шаардлагатай болно. Гэвч эдгээр хүчин чармайлт нь уур амьсгалын өөрчлөлт, дэлхий нийтийг хамарсан цар тахал, аюулгүй байдал алдагдсаны улмаас үүссэн бодит байдалд болон өнөөгийн нийгэм ба боловсролд үүсээд буй үйл явцын тасалдалтын энэ үед улам хэцүү болж байна. 2020 онд зөвхөн КОВИД-19 тахлын үед боловсролын байгууллагууд хаагдсаны улмаас дэлхийн хэмжээнд 1.6 тэрбум хүүхэд, залуучууд хохирчээ. Сургуулиуд дахин нээгдсэн ч олон сая сурагч, ялангуяа ядуу өрхүүд ба гадуурхагдсан бүлгийн сурагчид буцаж ирэхгүй. Боловсрол эзэмших боломж дахь тэгш бус байдал улам бүр хүндэрч байна.

Шинээр гарч ирж буй нийгмийн хувирган өөрчлөлтүүд ба алсдаа ирж болзошгүй үйл явцын эрс ондоо тасалдалтуудыг харгалзан боловсролын нийгмийн шинэ гэрээг хойшлуулшгүйгээр байгуулах нь чухал юм. Энэ нь хүрээлэл орчны хувьд тогтвортой, нийгмийн хувьд шударга, инклюзив оролцоотой хамтын ирээдүйг бий болгоход туслахын зэрэгцээ боловсрол ба нийгмээс хасагдан гадуурхагдахыг мөнхжүүлсээр ирсэн тэгш бус байдлын өнөөгийн сүлжээнд чиглэсэн байх ёстой.



## Бүлэг 2

# Үйл явцын тасалдалт ба үүсэж буй хувирган өөрчлөлтүүд



ҮМиний амьдралын хамгийн чухал сургамжуудын нэг бол өнөөгийн байдал тогтонги хадгалагдана, үйл явдлын хэвээр үргэлжилнэ, ирээдүйг урьдчилан таамаглаж болно гэдэгт итгэхээ больсон явдал гэдгийг энд онцлон хэлмээр байна. Урьдчилан таамаглаагүй богинохон, гэнэтийн тэсрэлтүүд бидний хувь хүний, иргэний, улс үндэстний, хүн төрөлхтний амьдралыг заримдаа аз жаргалтайгаар, заримдаа аз жаргалгүйгээр, донсолгож эсвэл хувирган өөрчилдөг.

Эдгар Морин (**Edgar Morin**), *Амьдралын нэг зууны сургамж, 2021*

Энэ зууны дунд үеийн түүхэн он цаг болох 2050 он руу дөхөж яваа үед гэр бүл, олон нийт, улс орон, бүс нутгууд хоорондын асар их ялгаатай байдлыг тооцсон дэлхий ертөнц ямар байх тухай бидний хүлээлтээс бидэнд хэрэгтэй боловсролын төрөл нь ихээхэн шалтгаална.

Энэ бүлэгт хүрээлэл орчин, бидний технологитой хэрхэн харьцан амьдарч буй байдал, засаглалын тогтолцоо, ажил хөдөлмөрийн ертөнц гэсэн хоорондоо харилцан уялдаатай дөрвөн салбарын ирээдүйн талаар гэхдээ тэдгээрт чухал нөлөө үзүүлнэ гэж таамаглаж буй үйл явцын тасалдлуудад анхаарлаа төвлөрүүлэн авч үзэх болно.

Хийх ажил тодорхойгүй байгааг үл харгалзан хувирган өөрчлөлтийн шилжилтийг урьдчилан тааварлах явдал нь ойрын хэдэн арван жил болон цаашдаа ч боловсролыг хүн төрөлхтний хэрэгцээ шаардлагад хэрхэн илүү нийцүүлэх талаар өөр шинэ хувилбаруудыг төлөвлөж, бий болгох үндэс суурь болдог.

## Аюул эрсдэлд буй гараг

2050 он хүртэлх хэдэн арван жил, ялангуяа 2020-иод он нь хүн төрөлхтний болон дэлхий дээрх бусад бүх амьдралын хэлбэрүүдийн ирээдүйд чухал ач холбогдолтой байх болно гэсэн шинжлэх ухаанч зөвшилцөл бий болсон. Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулахын тулд бидний хийх эсвэл үл хийх алхмууд нь 2030, 2040-өөд онд ямар ирээдүй хүлээж буйг тодорхойлох бөгөөд энэ нь хэдэн зуун мянга, бүр сая сая жилийн турш нөлөө үзүүлсээр байх болно. Эх дэлхийд бидний учруулж буй өөрчлөлтийн хүрээ, хурд нь түүхэнд урьд өмнө байгаагүй бөгөөд геологийн хувьд урьд өмнө маш цөөхөн тохиолдсон зүйл юм. Агаар мандлын химийн найрлага нь хөхтөн амьтдын бүх эрин үед ажиглагдсан хамгийн эрс тэс өөрчлөлтийн үеийнхээс арав дахин хурдан өөрчлөгдөж байна гэж тооцоолсон. 125,000 жилийн өмнө эхэлсэн сүүлчийн мөстлөгийн үеэс хойш дэлхий одоо урьд өмнө байгаагүйгээр халж байна. Мөн аль хэдийн явагдаж эхэлсэн уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар нь бидний ахуй амьдралд хэдийнээ шингэсэн тул ирэх гуч орчим жилд дэлхий дээрх амьдралыг ч тодорхойлох болно. Бид уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, сааруулж, буцаах ёстой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх болон түүний төлөөх боловсролыг эдгээр гурван зорилготой уялдуулах хэрэгтэй.

2015 оны Парисын уур амьсгалын хэлэлцээрт гарын үсэг зурсан нь аж үйлдвэрийн эрин үеэс эхлэн улам бүр ихсэж байгаа CO<sub>2</sub> (нүүрстөрөгчийн давхар исэл), метан зэрэг хүлэмжийн хийн дэлхийн хэмжээн дэх ялгаралтыг тогтворжуулах, бууруулах чиглэлээр ажиллах дэлхий нийтийн түүхэн амлалт үүрэг болсон. Дэлхийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 2 хэмээс хэтрүүлэхгүй (болж өгвөл 1.5 хэмээс илүүгүй) дулаан байлгахад засгийн газрууд туслахаа амласан. Хэдийгээр чулуужсан түлшийг шатаахыг багасгах амлалт үүрэг авсан ч ялгаралт нэмэгдсээр байна. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын комиссын 2021 оны тайлан нь дэлхийн дулаарлын хурд хэдхэн жилийн өмнө таамаглаж байснаас ч илүү байгааг харуулж байна. Бид дэлхийн хэмжээнд хүлэмжийн хийн гаралтыг эрс бууруулах нь бүү хэл тогтвортой байлгаж чадахгүй гэдгээ нотолсон. Энэхүү гар хумхин идэвхгүй суухын нөлөөлөл нь бидний эргэн тойронд илэрч байгаа бөгөөд хүч тамир алдагдуулсан халуун, олон удаагийн давтамжтайгаар удаан үргэлжилсэн ган гачиг, үер, гал түймэр, хурдсаж буй мөхөл

зэрэг нь хэвийн үзэгдэл болж сүйрэлд хүргэж байгаа нь тэрхүү нөлөөллийн ихэнх хэсэг юм. Байнгын сэрэмжлүүлгийг үл харгалзан орчин үеийн ертөнцийг эрчим хүчээр хангахын тулд нүүрстөрөгчийг олборлох, шатаах зэрэг хүний үйл ажиллагааны үр дагаврыг хэт олон хүмүүс ойлгоогүй хэвээр байна. Хүний үйл ажиллагаанаас болж уур амьсгалын өөрчлөлтүүд явагдаж, энэ нь манай гарагийн халуун орны шүрэн хадны тал хувийг устгаж, 10 их наяд тонн мөс хайлах, далай илүү хүчиллэг болох шалтгаан болсон. Уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн муу үр дагавраас урьдчилан сэргийлэхийн тулд нүүрстөрөгч тэг ялгаруулалтыг 2050 он хүртэл хүлээх боломжтой мэт санагдаж байсан бол сүүлийн үеийн шинжлэх ухааны судалгаанаас үзэхэд энэ эцсийн хугацаа илүү ойрхон байгааг харуулж байна. Дараагийн хэдэн жилд буюу өргөн удам замыг туулсан Дэлхийн түүхийн ердөө л нано секундэд тохиолдох зүйл нь биднийг улам бүр тогтворгүй, аюул дагуулсан уур амьсгалтай, хар дарсан зүүд мэт, эсвэл уур амьсгал өөрчлөгдөх ч гэсэн бага зэрэг ширүүн, хүмүүст харьцангуй элэгсэг хэвээрээ байх замд оруулж магадгүй юм.

Тухайн нөхцөл байдлыг хойшлуулшгүй шийдвэрлэх хэрэгцээ нэмэгдэж байгааг дэлхий дахинд гэр орон, бизнесийн ба мөргөлийн газар, сургуулиудад улам бүр хүлээн зөвшөөрөх болсон. Бидний цаг үеийн эгзэгтэй байдлыг хүлээн зөвшөөрөн засаж залруулах утга учиртай арга хэмжээ авахаас татгалзсан хүмүүсийг хатуу зэмлэж, тэднээс хамгийн хүчтэй арга хэмжээ авахыг хүүхэд залуучууд шаардаж байгаа нь мэдээж ойлгомжтой. Энэхүү илтгэлийг танилцуулсан зөвлөлдөх уулзалтууд, залуучуудтай болон тэдний фокус бүлэгтэй хийсэн ярилцлага, мөн залуучуудын дунд явуулсан судалгаагаар уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэл орчны сүйрэлд ихээхэн анхаарал хандуулж байгаа нь илт харагдаж байна.

### Гарагийн хил хязгаарыг давах нь

Дэлхийн агаар мандал, далай тэнгисийн дулаарал нь эх дэлхийг сүйрлийн ирмэг рүү түлхэж буй нөөцийн ашиглалттай гар гараасаа хөтлөлцөн явагдаж байна. 1950-2020 оны хооронд дэлхийн хүн ам гурав дахин нэмэгдэж, 2.5 тэрбум хүнээс бараг 8 тэрбум болж өссөн нь төрөлт нэмэгдэж, дундаж наслалт уртассаны үр дүн юм. Дэлхийн дундаж хүн (average person) 2020 онд 1920 онтой харьцуулахад хоёр дахин урт насалсан нь нийгэм, шинжлэх ухааны олон ололт амжилтыг харуулсан гайхалтай амжилт юм. Таамаглаж байсанчлан хүн амын энэхүү огцом өсөлтийн хэрээр хэрэгцээ ч мөн адил хэмжээгээр нэмэгдэж байна. Мөн дэлхийн хүн ам өсөлтийн хурдац сүүлийн зууныхаас бага байгаа хэдий ч хүн амын тоо өссөөр байна. Одоогийн тооцооллоор дэлхийн хүн амын өсөлт 2050 онд 9.7 тэрбум болж, 2100 онд 11 тэрбум орчимд хүрэх төлөвтэй байна.

Энэхүү өсөлт нь хэрэглээ болон аж үйлдвэрийн үйл ажиллагааны өсөлтийн хурдацтай зэрэгцэн нөөцийн асар их хэрэгцээ үүсгэж, хүрээлэл орчныг доройтуулж байна. 1950 оноос хойш хүний усны хэрэглээ хоёр дахин, хүнсний үйлдвэрлэл ба хэрэглээ 2.5 дахин, модны хэрэглээ гурав дахин нэмэгджээ. 2050 он гэхэд хүнсний хэрэгцээ дахин 35%-иар, усны хэрэгцээ 20%-30%-иар, эрчим хүчний хэрэгцээ 50%-иар өснө гэсэн тооцоо бий.

Өнөөдөр материаллаг үйлдвэрлэл, хэрэглээ, хог хаягдлын хувьд бид гараг дэлхийн хил хязгаарыг хол давжээ. Зарим тооцооллоор, хүн төрөлхтний өнөөгийн экологийн ул мөр нь биднийг тээж, хог хаягдлыг шингээхэд 1.6 гараг дэлхий шаардагдахаар байна. Энэ нь бидний

нөөцийн хэрэглээ өссөөр байгаа тул нэг жилийн дотор хэрэглэж байгаа зүйлээ нөхөн сэргээхэд манай гарагт нэг жил найман сар шаардлагатай гэсэн үг юм. 2050 онд бид нөөцөө нөхөхөд шаардагдах хэмжээнээс нь дөрөв дахин их хэмжээгээр ашиглаж, хойч үедээ асар их хомсдолд орсон гарагийг үлдээх болно.

**Нарийвчлалгүй тоо, соёлын инклюзив оролцоогүй холболт, баталгаагүй мэдээлэл, тодорхой шалтгаант зорилгогүй боловсрол дахь дижитал технологи зэрэг нь хүсүүштэй зүйл биш юм.**

Бидний хэрэглээ, нөөцийн ашиглалтын дагалдах бүтээгдэхүүн болох бохирдол нь хүрээлэл орчноос үүдэлтэй өвчин, нас баралтын хамгийн том шалтгаан болж байгаа бөгөөд энэ нь ДОХ, хумхаа, сүрьеэ, дайн байлдаанаас болж амиа алдагсдын нийлбэрээс хавьгүй илүү буюу жил бүр 9 сая хүн нас барах шалтгаан болдог гэсэн тооцоо бий. Энэ нь дэлхий дээрх нийгмийн эрүүл мэндийн хамгийн том хямрал гэж тооцогддог төдийгүй суралцахуйн бэрхшээлүүд, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой байдаг. Олон тооны хам нөхцөлд агаарын бохирдлын аюултай түвшингээс шалтгаалж зөвхөн сургуульдаа ирэх, буцах нь хүний эрүүл мэндэд аюултай байж болох бөгөөд боловсролын олон байгууллагад хэвийн

ажиллагаатай агаар шүүгч, зохих шаардлага хангасан бохир усны цэвэрлэх байгууламж, цэвэр ус дутагдаж байна. Суралцахуйн бусад байгууламж, төхөөрөмжүүд нь химийн хог хаягдал болон бусад төрлийн хорт бохирдол ихтэй газруудад байрлаж байна.

Бид маргааш гэхэд утааг тэг хэмжээнд хүргэж, 100% цэвэр эрчим хүчний системтэй болсон ч ойн хомсдол, хэт их загас агнуур, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, уул уурхай, хог хаягдал зэрэг аль хэдийнээ бидний ахуй амьдралд нэвтэрсэн тогтворгүй үйл ажиллагааны экологийн хор хөнөөл бүхий үр дагавруудтай тулгарсаар байх болно. Ар араасаа цуварсан үр дагаврууд нь одоо л харагдаж эхэлж байна. Дэлхийн биосфер нь хүн амыг өөртөө багтаасан, ихээхэн дарамтыг тэсвэрлэх чадвартай нэгдмэл систем боловч бид экосистемдээ улам их ачаалал өгөх тусам эргэлт буцалтгүй эвдрэлд хүргэж болзошгүй зөрлөгт ойтсоор байна.

Хүн төрөлхтөн үүнд буруутай ч бүх хүмүүс тэнцүү хариуцлага хүлээхгүй. Манай гарагийн эрх дархтай бүлгүүд болон чинээлэг бүс нутаг бусдаас илүү их нөөцийг ашиглаж, илүү их нүүрстөрөгч шатаадаг. Бид хамтдаа замналынхаа чиглэлийг өөрчлөхөөр ажиллахдаа нийгмийн шударга ёс нь экологийн шударга ёсыг агуулдаг мөн эсрэгээрээ байх зарчмыг дагах ёстой. Манай гарагт эдгээр хэт их ачааллыг учруулахад хамгийн бага буруутай хүмүүс шударга бусаар хариуцлага хүлээхийг бид зогсоох ёстой.

### **Боловсрол уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө**

Одоогийн байдлаар уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн тогтворгүй байдал нь боловсролд шууд болон шууд бусаар нөлөөлж байна. Цаг агаарын эрс тэс үзэгдэл, үүнтэй холбоотой байгалийн гамшиг эрчимжиж байгаа нь боловсролын хүртээмжид саад учруулж, бүр үгүйсгэж ч чаддаг. Хүүхэд, залуучууд, насанд хүрсэн суралцагчдыг боловсролын зохих байгууламжаас алслагдсан газар нутаг руу ч нүүлгэн шилжүүлж болно. Сургуулийн барилгуудыг хоргодох байр болон бусад үйлчилгээ үзүүлэхээр өөрчилж эсвэл өөр зориулалтаар ч ашиглаж болно. Сургууль,

их дээд сургуулиудын үйл ажиллагаа хэвийн явагдах ч нүүлгэн шилжүүлэлтийн улмаас үүсэх багш нарын хомсдол нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн нийтлэг үр дагавар юм.

Температурын өсөлт нь боловсролд онцгой эрсдэл учруулдаг. Халуун нь суралцахуй, танин мэдэхүйд сөргөөр нөлөөлдгийг, мөн дэлхийн ихэнх сургууль, орон байранд температурыг бууруулж, уур амьсгалыг хянахад хангалттай тохиромжтой материал, архитектурын шийдэл, технологи одоогоор байхгүй байгааг нэлээд судалгаа харуулж байна. Энэ нь хэт халуун уур амьсгалтай улс орон болон ихэнх нь баян чинээлэг, зөвхөн үе үе температурын огцом өсөлттэй байдаг улс орнуудын тухайд бодит үнэн юм. Хүлэмжийн хийн ялгаралт эрс өөрчлөгдөхгүй бол 2070 он гэхэд дэлхийн нийт хүн амын гуравны нэг нь хүн амьдрахад тохиромжгүй халуунд тооцогдох бүс нутагт амьдрах хэтийн төлөвтэй байгааг сүүлийн үеийн төлөвлөлтүүд харуулж байна. Дэлхий даяар сурагчид нь цар хүрээ, хэм, давтамж нь нэмэгдэх магадлалтай хэт халалтын түвшин болон цаг агаарын бусад эрс тэс үзэгдлийн улмаас сургуульд явах нь тасалдаж, гэртээ үлдэх зааварчилгаанд аль хэдийнээ дасаж байна.

Сурагч, багш, сургуулийн хамт олонд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлт, бохирдлын шууд нөлөөнөөс гадна тэдний амьжиргаа, сайн сайхан аж байдалд үзүүлэх шууд бус нөлөөллүүд бий. Хүнсний аюулгүй байдал, өвчний тархалт, эдийн засгийн хүндрэл улам бүр нэмэгдэж байгаа нь боловсрол эзэмших эрхийг хангахад шинэ сорилтуудыг бий болгож байна. Эдгээр нөхцөлд ч гэсэн үүсэх үр дагаврууд нь жигд бус гэдгийг бид мэднэ.

Уур амьсгалын өөрчлөлт нь ялангуяа нэн ядуу, гадуурхагдсан, амь зуулга нь хөдөө аж ахуйгаас хамааралтай хүмүүсийн дунд жендэрийн тэгш бус байдлыг нэмэгдүүлж байгааг баримтууд харуулж байна. Нөөц хомс газар тэгш бус хуваарилалт явагдах хандлагатай байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эмэгтэйчүүд, охидыг нүүлгэн шилжүүлэхэд ядууралд өртөх магадлал хамаагүй өндөр байдаг. Тэд боловсролоор дамжуулан өмнөх ажил амьдралдаа эргэн ирж, сэргээх боломж нь эрэгтэйчүүдээс доогуур байдаг. Уур амьсгалын өөрчлөлт нь эрэгтэйчүүдийн гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлж, эмэгтэйчүүд дээр ирэх гэр бүлийн ачааллыг нэмэгдүүлдэг. Зарим хам нөхцөлд охидын цаашдын боловсролын бололцоог зогсоож эрт гэрлүүлэх нь гэр бүлээ тэтгэх чөөн хэдэн сонголтуудын нэг юм. Үүний зэрэгцээ уур амьсгалын шударга ёсны төлөөх өөрчлөлтийн зуучлагчид болох эмэгтэйчүүд нь эх хүн, багш, ажилтан, шийдвэр гаргагч, нийгмийн гишүүн, удирдагчийн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд дасан зохицох, сааруулах хөдөлгөөнд ихэвчлэн тэргүүн эгнээнд байдаг.

Уугуул нутгийн эмэгтэйчүүд ойн тогтвортой менежмент, ус түгээх, хуримтлуулах, биологийн олон янз байдал, ургацын тэсвэртэй чанар, үр хадгалах, сонгох зэрэг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход хувь нэмэр оруулах мэдлэгийг эзэмшдэг боловч тэдний оруулсан хувь нэмрийг үл тоомсорлодог.

Уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй хүмүүсийн дуу хоолой дэлхий нийтийн хэмжээнд болон улс орон, орон нутагт явагддаг олон нийтийн хэлэлцүүлэгт дутмаг байна. Үүнээс гадна боловсролын хамгийн чухал үйлчлүүлэгчид болох сурагч, багш, гэр бүлүүд нь уур амьсгалын өөрчлөлт, түүний боловсролд үзүүлэх нөлөөллийн талаарх хэлэлцүүлэгт ихэвчлэн илтэд оролцохгүй байна. Тэд уур амьсгалын өөрчлөлтөд боловсрол хэрхэн хариу үйлдэл

үзүүлэхийг тодорхойлоход тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой. Иргэдийн оролцоот арга хандлагын хэрэгцээ нь боловсролын бодлого, төлөвлөлтөөс гадна хүний хүчин зүйлээс үүдэлтэй гараг дэлхий болон боловсролын хувирган өөрчлөлтийн талаарх шинжилгээ судалгаа, мэдлэгийн үйлдвэрлэлд ч хамаатай.

Одоогийн байдлаар эзэмшсэн, дүүргэсэн боловсролын түвшин нь амьдралын тогтворгүй хэв маяг, зан үйлтэй хамааралтай байна. Уур амьсгалын өөрчлөлтийг хамгийн их хурдасгаж байгаа хүчин зүйл нь дэлхийн хамгийн боловсролтой улс орнууд, ард түмэн байна. Бид боловсрол нь энх тайван, шударга ёс, хүний эрхэд хүрэх арга замуудыг бий болгоно гэж найдаж ирсэн хэдий ч тогтвортой байдлын замыг нээж, чадавхыг бий болгохыг одоо л боловсролоос хүсэж, үнэхээр шаардаж эхэлж байгаа бөгөөд энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Хэрэв боловсролтой байна гэдэг нь тогтворгүй амьдрах гэсэн үг юм бол бид боловсрол юу хийх ёстойг, боловсролтой байх нь юу гэсэн үг болохыг тодорхойлох ойлголт төсөөлөлдөө дахин тохируулга хийх хэрэгтэй.

### Итгэж найдахын шалтгаан

Хэтэрхий удаан хугацаанд боловсрол өөрөө эдийн засгийн өсөлтөд чиглэсэн орчин үеийн хөгжлийн парадигмд суурилсаар ирсэн. Гэхдээ амьд Дэлхий дээрх бидний амьдрах арга ухааныг дахин тэнцвэржүүлж, дэлхийн харилцан хамааралтай системүүд, тэдгээрийн хил хязгаарыг хүлээн зөвшөөрч чадахуйц ухааралд үндэслэсэн, экологид баримжаалсан шинэ боловсрол руу шилжиж байгаа анхны шинж тэмдгүүд бий болсон. Жил бүрийн дөрөвдүгээр сард “Эх дэлхийн өдөр”-ийг тэмдэглэдэг нь хүн төрөлхтний түүхэн дэх шашны бус дэлхийн хамгийн том баяруудын нэг болжээ. Уур амьсгалын хөдөлгөөн нь хүүхдүүдийг ирээдүйнхээ талаарх өөрсдийн алсын хараа-хүсэл мөрөөдлөө сонсгож, түүнийгээ үйл хэрэг болгох идэвхтэй оролцогч болоход түлхэц өгсөн. Тэдний үйлдэл бол ирээдүйн өөр төрлийн сургуулилт юм.

Үүнээс гадна тогтвортой хөгжлийг боловсролын чиглүүлэгч шалтгаант зорилго, сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах зарчим болгон чанаржуулж байна.

2050 онд хүн төрөлхтний эко ухамсарт, мөн эх дэлхийтэй зохицон амьдрах арга барилд гүнзгий хувирган өөрчлөлт орсон байхыг бид үгүйсгэж чадахгүй.

Сурагчдад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах нөөц чадваруудыг хөгжүүлэхэд туслах шинэчилсэн, илүү үр дүнтэй арга барил хэрэгтэй байна.

Хүрээлэл орчны боловсролын ач холбогдлыг олон арван жилийн турш хүлээн зөвшөөрч, олон засгийн газрын бодлогын бичиг баримтад тусгагдсан хэдий ч бодлого ба хэрэгжилт хооронд асар их зөрөөтэй, бодлого ба үр дүн хооронд бүр ч их зөрөөтэй байна. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын үр өгөөжтэй байдлын талаарх судалгаанаас үзэхэд ихэнх нь сурагчдад үр дүнтэй үйл ажиллагаанд татан оролцуулахад шаардлагатай өргөн хүрээтэй цогц чадамжийг төлөвшүүлэлгүй гагцхүү шинжлэх ухаан талаас заахад чиглэдэг байна. Сурагчдад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг сааруулах нөөц чадваруудыг хөгжүүлэхэд туслах шинэчилсэн, илүү үр дүнтэй арга барил

хэрэгтэй байна. Хэрхэн илүү гүн гүнзгий суралцах, иргэний цогц чадамжийг хөгжүүлэх талаар одоо байгаа мэдлэг, амьдрах болон ажиллах ур чадварыг хөгжүүлэх сүүлийн үеийн судалгаанд тулгуурласан стратеги баримтлах нь зүйтэй.

## Холбож бас хувааж буй дижитал орчин

Бидний түүхэн энэ цаг үе нь нийгэмд явагдаж байгаа технологийн хувирган өөрчлөлтийн хурдцаараа ялгагдаж, дижитал хувьсгал, биотехнологи, мэдрэл судлалын шинжлэх ухааны дэвшлээр тодорхойлогдож байна. Технологийн инноваци нь бидний амьдрах, сурах арга барилыг өөрчилсөн бөгөөд цаашид ч өөрчлөх нь дамжиггүй юм.

Дижитал технологи, хэрэгсэл, платформыг хүний эрхийг дэмжих, хүний нөөц чадварыг нэмэгдүүлэх, энх тайван, шударга ёс, тогтвортой байдал руу тэмүүлэх хамтын үйл ажиллагааг хөнгөвчлөх чиглэлд эргүүлж болно. Дижитал бичиг үсэг болон хүртээмж бол XXI зууны үндсэн эрх гэдэг нь илэрхий бөгөөд эдгээр эрхийг эдлэхгүйгээр иргэний болон эдийн засгийн харилцаанд оролцоход улам хэцүү болж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нэг эмзэглүүлсэн зүйл бол сургуулиуд хаагдсан үед дижитал орчинд холбогдож, ажиллах ур чадвартай хүмүүс алсаас үргэлжлүүлэн суралцаж (мөн тухай бүрд бусад чухал мэдээллээс ашиг тус хүртэх), харин ийм боломж, ур чадваргүй хүмүүс суралцах боломжоо алдаж, танхимын сургалтын бусад ашиг тусыг хүртэх боломжгүй болсон явдал юм. Энэхүү дижитал хуваагдлын үр дүнд улс орон хооронд болон улс дотроо боловсролын боломж, дам үр дүнгийн зөрөө нэмэгдэж байна. Хамгийн эхний захиалгат даалгавар бол энэ ялгааг арилгах, сурагч болон багш нарын дижитал бичиг үсгийн боловсролыг XXI зууны хамгийн чухал мэдлэгийн нэг гэж үзэх явдал юм.

Гэсэн хэдий ч дэлхийг илүү инклюзив оролцоотой, тогтвортой байлгахын тулд хүмүүний нөөц чадварыг дээшлүүлэхэд технологийг зориуд, идэвхтэй ашиглах шаардлагатай байна. Технологи нь бидний эрхийг зөрчиж, бидний нөөц чадавхыг хязгаарлаж, бүр бууруулж ч байсан урт түүхтэй. Шинэ бүтээн байгуулалт болгоныг “шидэт саваа” болгон яаран нэвтрүүлэх нь амжилтад хүргэх нь ховор. Илүү сайн үр дүн өгөх зүйл бол үе шаттай сайжруулалтыг эрэлхийлсэн хөгжүүлэлтүүд бөгөөд эрсдэл байхыг хүлээн зөвшөөрсөн технологийн туршилтыг дэмждэг, энгийн бас бүгдэд тохирох шийдэл байдаггүй гэдгийг ойлгох соёл юм.

Компьютерын тусламжтайгаар дамжуулах, хадгалах, анализ хийхэд зориулж тоон дараалал болгон хувиргасан бүх зүйл буюу дижитал нь хүний үйл ажиллагааны өргөн хүрээг хамардаг. Дэд бүтцийн нэг хэлбэр (холбогч элемент) болохын хувьд дижитал нь биднийг “холбоход” их зүйлийг хийдэг боловч интернэтийн хүртээмж, хамтын болон хувь хүнд чиглэсэн зорилгод хүрэхийн тулд технологийг ашиглахад шаардагдах ур чадвар, цогц чадамжийн хувьд “дижитал хуваагдал” оршсон хэвээр байна.

Дижиталчлал болон дижитал технологи хоёр нь угаас зөрчилтэй байдаг. Дижитал технологиуд нь хэд хэдэн логик үндэслэлтэй байдаг бөгөөд зарим нь асар их чөлөөт нөөц потенциалтай, бусад нь асар их нөлөөлөл, эрсдэлтэй байдаг. Энэ утгаараа “дижитал хувьсгал” нь хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хувьсгал гэх мэт бусад технологийн агуу өөрчлөлтийн мөчүүдээс ялгарах

зүйлгүй юм. Хамтын томоохон ололтууд нь тэгш бус байдал болон хасагдан-гадуурхагдалтын санаа зовоосон өсөлттэй хамт ирдэг. Иймээс хүний эрх, тэгш боломжийг хангахын тулд эдгээр холилдсон үр дагаврыг технологийн хөгжлийг инженерчлэх замаар залж удирдах явдал нь гол сорилт болдог.

Технологи нь төвийг сахисан, идэвхгүй зүйл биш бөгөөд дэлхий ертөнц, түүнчлэн хүний ойлголт, үйл хөдлөлийг хуваагдалд хүргэж, шинэ хэлбэрт оруулах замаар үйл ба шийдвэр гаргалтыг зохицуулж чаддаг.

Дижитал технологийн зарим шинж чанарууд нь мэдлэг, мэдээлэл солилцоход тусалдаг шиг тодорхой хэдэн шинж чанарууд нь мэдлэгийн олон янз байдал, соёлын инклюзив оролцоот байдал, ил тод байдал, оюуны эрх чөлөөнд ихээхэн аюул учруулж болзошгүй юм. Одоогийн байдлаар алгоритмын зам хувилбарууд (algorithmic pathways), платформын империализм (platform imperialism), дижитал дэд бүтцийн засаглалын хэв маяг (patterns of governance of digital infrastructures) нь боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон тогтвортой байлгахад хүнд сорилтуудыг бий болгож байна. Тэдгээрээс үүдэлтэй асуудлууд нь боловсролын тухай, ялангуяа боловсролыг дижитал болгох, шинээр хосолмол эсвэл дан виртуал боловсролын загвар гарч ирж болзошгүй талаарх орчин үеийн мэтгэлцээний гол төв болж байна.

Хэдэн арван жилийн туршид боловсролын ертөнц нь дижитал технологитой олон төрлийн, түр зуурын болон шинэ тутам үүссэн харилцан холбоонд татагдан орсон. Компьютерыг дэлхий даяар олон анги танхим, гэрт ашиглаж; Гар утсыг боловсролын янз бүрийн тохируулгат орчинд ашиглах нь ихсэж байгаа бөгөөд тэр нь ядмаг муухан тохируулгат орчин буюу ялангуяа хувийн компьютер ашиглах боломжгүй Сахараас урагших Африкт чухал үүрэг гүйцэтгэдэг. Интернет, цахим шуудан, мобайл дата, дүрс болон дуун дамжуулалт, хорших ажиллагаа, сургалтын олон боловсронгуй хэрэгслүүд нь боловсролын асар их боломж, бололцоог бий болгосон.

Үргэлжилж буй эдгээр өөрчлөлтүүд нь сурч боловсрох эрх түүнчлэн хэл, өв уламжлал, хүсэл тэмүүлэлтэй холбоотой соёлын эрхүүдэд чухал нөлөө үзүүлж байна. Мөн мэдээлэл, өгөгдөл, мэдлэг олж авах эрх, ардчилсан оролцооны эрх зэрэгт ихээхэн нөлөөлдөг. Дижиталчлалын авчирсан хэсэгчилсэн хувирган өөрчлөлтүүдийг харахад хувийн нууцыг хадгалах эрх, өөрийн шалтгаант зорилгоо биелүүлэх эрх зэрэг хүний эрхэм чанарын үндсэн зарчмууд хөндөгдөж эхэлж байна.

Мэдээлэл харилцааны технологийн дэвшил нь суралцахууд юуг чухалчилдаг, суралцах үйл явц хэрхэн бий болдог, боловсролын систем хэрхэн зохион байгуулагдаж байгааг өөрчлөн хувиргасаар байна. Дижитал технологиуд нь мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдлэг дээр ажиллах зардлыг эрс багасгасан. Мөн илүү олон хүмүүст эдгээр үйл явцад оролцоход хялбар болгож өгсөн. Иргэдийн болон нээлттэй шинжлэх ухааны төслүүд бол дижитал технологи нь цуглуулсан, анализ хийсэн мэдээллийн хэмжээ, энэ ажилд оролцож буй хүмүүсийн тоо, олон янз байдлыг өргөжүүлэхэд хэрхэн тусалж болдгийн гайхалтай жишээ юм. Өгөгдлийг бий болгох, дамжуулах, ашиглах, мөн дижитал үйл явцаар дамжуулан өгөгдлийг үүсгэж болно гэсэн мэдлэг нь шинжлэх ухааны дэвшил, тусгай мэргэшлийн хөгжлийн арга зам, түүнчлэн дэлхий дахины олон нийтэд мэдээлэл ба мэдлэгийн хүртээмжтэй болон хүртээмжгүй байдлыг өөрчилсөн. Үүний зэрэгцээ компьютерын тусламжтай мэдээлэл цуглуулах, анализ хийхэд хялбар болсон нь үндэслэл гаргах, утга агуулгыг илэрхийлэх зэрэг мэдээлэл боловсруулалтын өөр хэлбэрүүдийг



хурдан халж, ач холбогдолтой ч тоолоход хүндрэлтэй байж болох хувийн туршлага мэтийн бусад төрлийн мэдээллээс илүүтэйгээр тоон өгөгдлийн санг чухалчлах үр дагаварт хүргэх болсон.

Мянган, мянган жилийн түүхт томоохон бодит номын сангуудаас илүү халаасанд багтах гар утсан дээрээ текст болон график мэдээллийг шууд авах боломжтой ертөнцөд дасан зохицож байгаа энэ үед боловсрол нь мэдлэгийг түгээх, дамжуулахаас хальж, түүний оронд мэдлэг нь суралцагчдыг чадавхжуулдаг, мөн сурагчид мэдлэгээ хариуцлагатай ашигладаг байх боломжоор хангах ёстой. Боловсролд тулгарч буй үндсэн сорилт бол хүмүүсийг хэдхэн товшилт эсвэл товчлуур дарахад л нэвтэрч болох далай их мэдээллийг ойлгох арга хэрэгслээр хангах явдал юм.

### Дижитал мэдлэг ба түүний хасан гадуурхалт

Дижитал технологиуд нь Сэргэн мандалтын дараах барууны орнуудад өвөрмөц онцгой бөгөөд улам бүр зонхилох болсон мэдлэгийн урсгалыг тулгаж, уугуул иргэдийн ер бусын хосгүй мэдлэгийг зах хязгаар луу шахсан. Загасчид, далайчид, аялагчдын цаг уурын болон навигацийн мэдлэг нь технологиор тоноглогдсон одон орон судлаачид, цаг уур судлаачид, цаг уурын мэргэжилтнүүдийн гаргаж авсан мэдээлэлд шахагдаж байна. Үүний нэгэн адил, олон зууны туршид уламжлагдан ирсэн тариаланчид, анчид, цуглуулагчид, малчдын мэдлэг нь агрономчид, ойн мэргэжилтнүүд, мэргэжлийн байгаль хамгаалагчид, эмийн компаниуд, хоол тэжээлийн мэргэжилтнүүдийн хэрэглэж буй техникийн магадлан шинжилгээ болон технологид шахагдаж байна. Технологийн бус мэдэхүйн аргуудын энэхүү үгүйсгэл нь хүн төрөлхтнийг хүн байх, байгаль, хүрээлэл орчин, сансар судлалын талаарх өргөн хүрээтэй, олон талт мэдлэгийн архиваас салгасан юм. Хүн төрөлхтний соёлын олон янз байдлын ДНХ-ийг бүрдүүлдэг энэхүү мэдлэгийг хүлээн зөвшөөрч, буцааж ашиглах, сэргээхийн тулд багш, сурган хүмүүжүүлэгчид их зүйлийг хийж чадна. Харин эргээд харахад сурган хүмүүжүүлэх шинжлэх ухаан нь албан бус, уугуул, амархан олддоггүй мэдлэгийг ихэвчлэн няцааж эсвэл сэжиглэн хардаж байдаг шинжээчийн цогц чадамжтай болсон байна.

Дижиталчлалын амжилт, ялалтад аюул занал учруулж буй мэдлэгийн хамгийн үнэ цэнтэй хэлбэрүүдийн нэг бол нийгэм өөрөө юм. Хуваалцах, холболт, харилцааны талаар сайрхаж байдаг хэдий ч ашиг олоход тулгуурласан ихэнх дижитал мэдлэг нь хэрэглэгч, худалдан авагч эсвэл ажиглагч гэсэн хувь хүмүүсийн тусгаарлалтад тулгуурладаг бөгөөд ганцаардал, хувиа хичээсэн байдал, нарциссизмыг дэндүү амархан хөгжүүлдэг. Дижитал мэдлэг, төхөөрөмж, платформ, мэдээлэл нэвтрүүлэх чадавх нь улс орнуудын хооронд болон улс орон дотроо маш тэгш бус тархсан байдаг тул мэдлэгийн эртний, хоцрогдсон, богино настай, дахин давтагдашгүй хэлбэрийг үнэлж, түүнд итгэж найдаж буй хүмүүсийг үл тоомсорлодог.

Тухайлан үзвэл, тодорхойлолт ёсоор “дижитал хуваагдал” нь өөрийн хүрээнээс гадуур ажилладаг хүнийг, мөн энэ хүрээний хэмжилт, хадгалалт, анализ хийх арга техникээс зайлсхийдэг бүх зүйлсийг үл тоомсорлодог учраас оршсоор байдаг. Энэ талаас нь авч үзвэл үүнийг “платформын эзлэн түрэмгийлэл” гэж нэрлэж болно. Энэхүү шийдэл нь энгийн хялбар, хүртээмжтэй дижиталчлал биш юм.

Энэ нь дижитал технологийг нийтлэг сайн сайхныг дэмжихийн төлөө түүний хүрээнээс гадуур үлдсэн зүйлсийг хүндэтгэн, шинээр хүлээн зөвшөөрөхтэй хослуулан ашиглах илүү нарийн нийлмэл, олон нийтийг татан оролцуулах явдал юм.

2050 он гэхэд улам бүр газар аван дэлгэрч болзошгүй дижитализмын сөрөг талуудыг сөрөн зогсох чадавхыг бид бүгдээрээ дэмжин тэтгэх ёстой, ялангуяа мэдлэгийн тоон, алгоритмын болон "шийдвэрлэгч" тодорхойлолтуудад анхаарлаа хандуулах ёстой. Гэхдээ эдгээр хандлагыг эсэргүүцнэ гэдэг өөрөө дижиталчлалыг эсэргүүцнэ гэсэн үг биш юм.

Нарийвчлалгүй тоо, соёлын инклюзив оролцоогүй холболт, баталгаагүй мэдээлэл, тодорхой шалтгаант зорилгогүй боловсрол дахь дижитал технологи зэрэг нь хүсүүштэй зүйл биш юм.

КОВИД 19-ийн эринд бид дижитал технологи нь нийгмийн эрүүл мэнд, нийтийн боловсролд зайлшгүй шаардлагатай болохыг олж харсан: алсын зайны боловсрол, холбоо барих болон вакцины хяналт, вирусийн талаарх найдвартай мэдээлэл зэрэгт зайлшгүй шаардлагатай хэрэгсэл юм. Гэсэн хэдий ч нарийвчлалгүй тоо, соёлын инклюзив оролцоогүй холболт, баталгаагүй мэдээлэл, тодорхой шалтгаант зорилгогүй боловсрол дахь дижитал технологи зэрэг нь хүний хөгжлийн хүсүүштэй хэмжүүр бас тусламж дэмжлэг биш юм.

Үүнийг дижитал хувьсгалын талаарх олон тайлбарыг дагалддаг амжилтын өнгө аясыг үл харгалзан дижитал технологийн олгож буй гүн гүнзгий хувиран өөрчлөх боломжийг бүрэн ашиглаж чадаагүй гэж бас тайлбарлаж болно. Одоогийн байдлаар дижитал платформууд нь бизнесийн томоохон зорилгод хүрэх шалтгаант зорилгоор ашиглагддаг. Тэдний дизайнчдын нийгэмлэг нь эмэгтэйчүүд, хэл, үндэс угсаа, арьс өнгөний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг эрх нь бүрэн хэрэгждэггүй бүлгүүдийг байнга хасаж гадуурхдаг бөгөөд энэ нь хүн төрөлхтнийг бүхэлд нь төлөөлөх боломжгүй буруу ташаа мэдээлэл, өрөөсгөл хандлагыг түгээдэг талтай. Гэвч энэ нь өнөөгийн хүчирхэг дижитал технологийн хувь тавилан байх ёсгүй. Дижитал технологи нь бидний одоогоор бий болгосон арилжааны хэв загвараас илүүтэйгээр хүмүүст боломж, эрх мэдэл олгож, холбох илүү их зүйлийг хийж чадна.

Илүү уян хатан дижитал орчныг бий болгохын тулд дижитал дэд бүтцийн суурь болдог зарим хэсгийг бизнесийн загваруудаас болон одоогийн эерэг хөгжил, шинээр бий болгож болох нийтлэг сайн сайхныг хязгаарлаж буй авторитар зохицуулалтаас тус тус салгах шаардлагатай болно.

### Суралцагч хүмүүнийг хакердах нь

Биотехнологи болон мэдрэл судлалын шинжлэх ухааны хөгжил нь урьд өмнө төсөөлж байгаагүйгээр хүний инженерчлэлийг хөгжүүлэх нөөц потенциалтай. Хүний генийн бүтэц, нейрхимид нөлөөлж буй технологийн хөгжил нь тогтвортой, шударга, амар амгалан ирээдүйг дэмжихийн тулд зохистой ёс зүйн засаглал, нийтийн хүрээн дэх няхуур хэлэлцүүлэг улам бүр чухал байх болно.

Мэдрэл судлалын шинжлэх ухааны шинэ хэрэгслүүд нь хүний тархины үйл ажиллагааг зан үйлээр дамжуулан дүгнэхийн оронд хүний тархи хэрхэн ажилладгийг шууд судлах боломжийг судлаачдад олгосон. Гэвч орчин үеийн тархины бичлэгийн ихэнх аргууд нь бодит амьдрал дахь боловсролын хам нөхцөл, харилцан үйлчлэлээс хол, өндөр хяналттай орчин нөхцөлд явагддаг. Өнөөдөр түгээмэл хэрэглэгддэг судалгааны нэг төрөл бол суралцахуйн янз бүрийн үйл ажиллагааны явцад (хэл ойлгох, математик үндэслэл гаргах гэх мэт) сонгон идэвхэждэг тархины хэсгүүдийг тодорхойлох явдал юм. Гэсэн хэдий ч энэ нь өнөөг хүртэл сургалтыг хэрхэн дизайнчлан төлөвлөх талаар маш бага зүйл илрүүлж байгаа бөгөөд нэмэлт тайлбар судалгаа шаардлагатай.

Гэтэл тархийг суралцах үйл гүйцэтгэхэд илүү тохиромжтой болон тохиромжгүй нөхцөлд байж болох биологийн эрхтэн гэж үздэг судалгааны үр дүнд үнэ цэнтэй, гүн гүнзгий ойлголтууд хуримтлагдсаар байна. Бие махбодын эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг болох тархины эрүүл мэндийн ач холбогдол нь суралцахуй болон хүний эрүүл мэнд хоорондын харилцан хамаарлыг бэхжүүлж, боловсрол эзэмших эрх болон эрүүл байх эрх зэрэг бусад эрхийн хоорондох уялдаа холбоог улам бодитой болгож өгдөг.

Хүний тархины нейропластик шинж чанарыг илтгэх нотолгоо нэмэгдэж байгаа нь хүний амьдралын туршид тархи бие махбодын хувьд өөрчлөгддөг гэсэн үг юм. Хүний амьдралын эхний жилүүд нь хөгжлийн чухал үед тооцогдсон хэвээр байгаа хэдий ч бидний тархи бүх насанд суралцах, “дахин шинэчлэгдэж солигдох” чадвартай байдаг бөгөөд зарим химийн бодисууд хүний тархины дахин шинэчлэгдэн солигдох үйл явцыг хөнгөвчлөх, тухайлбал, тархины гэмтлийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг бид ойлгодог болсон. Суралцахуйн мөн чанарт нэвтэрч буй эдгээр гүн гүнзгий ойлголтууд нь насанд хүрэгчдийн боловсрол, суралцахуйд нөлөөлөх нөөц потенциалтай байдаг.

Хүний амьдралын эхний жилүүд нь хөгжлийн чухал үед тооцогдсон хэвээр байгаа хэдий ч бидний тархи бүх насанд суралцах, “дахин шинэчлэгдэж солигдох” чадвартай байдаг

Тархины нейропластик чанар нь хүний хүрээлэл орчин, техникийн өөрчлөлтөд дасан зохицох чадварт чухал нөлөө үзүүлдэг. Энэхүү илтгэлд дурдсанчлан, зөвхөн хүүхэд гэлтгүй бүх насны хүмүүс гэмтэж сүйдсэн гараг дээр амьдарч сурахаас өөр аргагүй болно. Дэлхий даяар улам олон хүн дижитал болон дэлгэцэд суурилсан уншлагад хамрагдаж байгаа тул нейропластик чанар бас чухал үүрэг гүйцэтгэдэг. Анхаарал сарнихад хялбар байх, удаан хугацаанд анхаарал төвлөрүүлэх нь хүндрэлтэй байх, мөн хүснэгт хэлбэрээр унших, “гүйлгэж унших” арга нэмэгдэх зэрэг олон чухал санаа зовоосон асуудлууд гарч ирж байна. Тархи өөрт өгөгдсөн даалгавраа биелүүлэх чадамжаа нэмэгдүүлэхийн тулд хэрхэн өөрийгөө сайжруулдаг, дасан зохицдог тухай бидний одоогийн ойлголт нь шугаман уншлага (linear reading) өөрөө маш нарийн нийлмэл мэдрэлийн ажил гэдгийг сануулж байна. Энэ талаар хүн төрөлхтөнд хамаатай соёлын болон биологийн ач холбогдлыг хүмүүний олон соёл аман хэлбэрээс бичгийн хэлбэрт шилжсэн шилжилтийг судалсан олон эрдэмтэд онцлон тэмдэглэсэн байдаг. Нэг ёсондоо, хүмүүс бид өөрсдийгөө “хакердаж (hacking)” багагүй хугацаа өнгөрчээ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бид одоо өмнө маань байгаа унших шинэ технологиудад дасан зохицох болно гэж олон хүн шударгаар зөв таамаглаж байна. Боловсролын ирээдүйн тухайд бол дижитал эсвэл хэвлэмэл уншлагын аль

нэгийг сонгох биш харин олон талт бичиг үсгийн мэдлэгийг бий болгох хүчин чармайлтын төлөө сонголт хийх ёстой болж, багш нар сурагчдаа шугаман болон хүснэгтийн уншлагын аль алинд нь туршлагажих баталгаагаар хангах ёстой. Хэвлэмэл болон дижитал мэдээлэл нь текстийн нэмэлт хэлбэр бөгөөд хоёуланд нь зайлшгүй шаардлагатай гэж үзэх нь зүйтэй юм.

Мэдрэл судлалын шинжлэх ухаан болон биотехнологийн салбарт шинээр гарч ирж буй эдгээр хөгжлийг зөв удирдах нь нээлттэй өгөгдөл, нээлттэй шинжлэх ухаан, түүнчлэн өгөгдөл, мэдээлэлтэй холбогдох эрх, хувийн нууцыг хамгаалах эрх зэрэг боловсрол эзэмших эрхийн талаарх өргөн хүрээний ойлголцлоос тус тус хамаарна.

## Ардчиллын ухралт ба өсөн нэмэгдэж буй туйлшрал

Шүүмжлэлт сэтгэлгээ, инноваци, хувь хүний болон хамтын шалтгаант зорилгыг хэрэгжүүлэх нь хүний эрхийг дээдэлсэн оролцоотой, ардчилсан тохируулгат орчинд л цэцэглэн хөгждөг. Гэвч сүүлийн 10 жилийн хугацаанд ардчилсан засаглал мэдэгдэхүйц ухарч, мөн ижилслийн өвөрмөц шинжид тулгуурласан гадуурхагч популист хандлага өсөж байгааг дэлхий гэрчилж байна. Ийм хандлага нь хана хэрэм нурж, хил хязгаар үгүй болохыг харсан, мөн хүмүүс, бараа бүтээгдэхүүн, санаа бодлын шилжилт хөдөлгөөн нь орчин үеийн түүхэнд хэзээ ч байгаагүйгээр өргөжиж буй глобалчлагдсан дэлхийн дэг жаягаас үлдэж хоцорсон хүмүүсийн сэтгэл ханамжгүй байдлаас төрдөг. Үүнийг мөргөлдөөн, эдийн засгийн хүндрэл, уур амьсгалын өөрчлөлтийн дарамтаас үүдсэн хүн амын шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлт нь улам бүр нэмэгдүүлсээр байна.

Дэлхий даяарх ардчиллын төлөв байдлыг судалж, хянадаг байгууллагууд эдгээр өөрчлөлтийн үр нөлөөг янз бүрээр тайлбарладаг. “Экономист” сэтгүүл бүрэн ардчиллаас алдаатай ардчилал руу шилжих тухай өгүүлсэн байдаг. Freedom House буюу Эрх чөлөөний Ордон чөлөөт улс төрийн тогтолцооноос хэсэгчилсэн чөлөөт тогтолцоо руу шилжих хөдөлгөөн гэж хардаг бол В.Дем сонгуулийн ардчиллаас сонгуулийн нэг хүнд эрх мэдэл төвлөрүүлэх руу шилжих шилжилт гэж тайлбарладаг. Нэршлийг нь эс тооцвол эдгээрийн нийтлэг зүйл бол олон хүний хувьд ардчилал өнгөрсөн үеийнхээс илүү хэврэг мэт байгаад оршиж буй юм.

Иргэдийн яриа хэлцлийг тасалдуулах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдаж буй зөрчил нь иргэний оролцоонд суурилсан боловсролд ихээхэн хор уршиг авчирдаг.

Үүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд популист манлайлагчдын өсөлт болон үндсэрхэг үзлээр илэрч буй уугуул хүн амыг дээдлэх үзлийн өсөлтөөс эхлээд зориудаар төөрөгдүүлсэн “хуурамч мэдээ”-г тухайн бодит цаг үед нь түгээх чадавхтай сошиал медиагийн хүч чадал, нийгмийн зан үйлд нөлөөлөхийн тулд мэдээллийг гуйвуулах, мессежийг тухайн товлосон бичил зорилтот бүлэгт зориулан бэлтгэх хүртэл багтана. Түүнчлэн элитүүдийн ихэмсэг зан, дэлхий дээрх өөрсдийн байр суурь, улам бүр тодорхойгүй болж буй ирээдүйнхээ талаар тэдний өсөн нэмэгдэж буй санаа зовнил нь ч нөлөөлж байна.

Дэлхий улам бүр хуваагдаж, туйлширч олон ардчилсан институциуд бүслэлтэд орж байна. Ардчилал амлалтаа биелүүлээгүй гэж үзэж байгаа хүмүүс болон аль хэдийн хэрээс хэтэрсэн гэж үзэж буй хүмүүс тэднийг эсэргүүцэж байна. Дээрэнгүй үзэл суртал, шовинизм (дээрэнгүй үзэл) хүчээ авч, олон талт ижилсэл, яриа хэлэлцээ, ойлголцолд хор хохирол учруулж байна. Айдас, өрөөсгөл харалган үзэл, ялгаварлан гадуурхлыг ашиглан засагладаг авторитар засгийн газрууд иргэний, нийгмийн, хүний, байгаль орчны эрхийг хязгаарлан багасгаж, шахан үгүйсгэж байна. Иргэдийн яриа хэлцлийг тасалдуулах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдаж буй зөрчил нь орон нутаг, үндэсний болон дэлхий нийтийн түвшинд хүний эрх, иргэншил, иргэний оролцоонд суурилсан боловсролд ихээхэн хор уршигтай үр дагавар авчирдаг.

Үүний зэрэгцээ олон талбарт иргэдийн хөдөлгөөний идэвхжил улам бүр нэмэгдэж байна. Эсэргүүцлийн хөдөлгөөнүүд нь оролцоонд суурилсан ардчилсан улс төрийг уян хатан байх шинэ ирээдүй рүү чиглүүлж байна. Эдгээр хөдөлгөөнүүд нь ихэвчлэн залуучуудаар удирдуулсан экологийн хөдөлгөөнөөс эхлээд цөөнхийн хүний үндсэн эрхийг хориглосон дэглэмийн эсрэг иргэдийн тэмцэл хүртэлх өргөн хүрээг хамардаг. Тэдгээр нь ардчилсан эрхийг сэргээж, хууль дүрмийг хүндэтгэх дэлхий дахины эрэлт шаардлагуудыг агуулсан байна. Энэхүү хөдөлгөөнд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг “Black Lives Matter” хөдөлгөөн, жендэрт суурилсан дарамт, хүчирхийллийг эсэргүүцсэн “#metoo” хөдөлгөөн, мөн сургалтын хөтөлбөр, боловсролын байгууллагуудыг колоницлолоос ангижруулах уриалга зэрэг багтана.

Эдгээр хөдөлгөөнүүдийн ач холбогдлыг ирээдүйн сургалтын хөтөлбөрүүдээр шүүн тунгаах хэрэгтэй. Боловсрол нь бат бөх ардчилсан иргэдийн төлөвшил, зөвлөлдөх орон зай, оролцооны үйл явц, хоршин ажиллах практик туршлага, халамж тусламжийн харилцаа болон хамтын ирээдүйг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үүрэгтэй.

КОВИД-19 тахлын улмаас үүссэн дэлхийн эрүүл мэндийн хямрал нь олон нийт нэгдэж байгаа хэд хэдэн жишээн дээр эв нэгдэл сэргэж буйг харуулж, энэхүү иргэний оролцоо, идэвхжилд түлхэц үзүүлж, шуурхай байх мэдрэмжийг өгсөн. Нийгмийн эрүүл мэнд болон бусад онцгой байдалд нийгмийн тусламжгүйгээр, өөртөө хариуцлага хүлээхгүйгээр, харилцан анхаарал халамжгүйгээр даван туулах боломжгүй гэдгийг олон засгийн газар ойлгож нийгэм аврагдсан.

Үүний хажуугаар цар тахал нь ардчиллын ухралтыг улам хүндрүүлсэн. Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээ өргөжиж, тандалтын технологийн хэрэглээ нэмэгдсэн, олон нийтийн цугларалт, хөдөлгөөний эрх чөлөөг хязгаарласан, энгийн иргэд оршин суудаг бүс нутагт цэргийн хүчээ байршуулсан, сонгуулийн хуанли тасалдсан гэх мэт болон бусад нөлөөллийг бид харсан. Нийгмийн эрүүл мэндийг хангах үндэслэл ямар ч байсан, олон түмнийг хамарсан онцгой байдлын нөхцөлд юу болж байгаа нь засаглалыг тодорхойлох илэрхийлэл гэдгийг санах нь зүйтэй.

Эдгээр улс төрийн хувирал өөрчлөлтүүдийн үл мэдэгдэх замнал нь боловсролд олон үр дагавартай, наад зах нь хэдэн арван жилийн турш бидэнтэй хамт байх болно, учир нь үйл явцын эдгээр тасалдалт нь боловсролын мөрийн хөтөлбөрүүдийг тодорхойлох мөн боловсролын хүртээмж, сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүйтэй холбоотой болж байгаа зүйлс нь эргээд дэлхий даяарх улс төрийн хувирган өөрчлөлтүүдийг тодорхойлох болно.

Сошиал медиагийн хэмнэлээр зарим талаараа суларсан, тэвчээр муутай улс төрийн нийгэмлэгүүд хэрхэн хэлбэржин төлөвшиж буй үеийн эргэлтийн цэгт дэлхий ертөнц ирээд байна. Бид бие биеэ сонсож чадахгүй үед нийгмийн амьдрал маш ихээр хумигддаг. Боловсрол нь сурагчдын идэвхтэй иргэн, ардчилсан оролцооны чадавхыг хөгжүүлэхээс гадна бусдыг халамжлах, хүндлэх чадварт тэднийг дадлагажуулж, энэ чадвараа бэхжүүлэхэд нь тусалдаг.

## Ажил хөдөлмөрийн тодорхойгүй ирээдүй

Ирээдүйд боловсрол нь хэрхэн хувь хүн, олон нийт, нийгмийг утга учиртай ажил хөдөлмөр, эдийн засгийн сайн сайхан аж байдалд хамгийн сайнаар дэмжих вэ?

ОУХБ-ны Ирээдүйн Ажлын Глобал Комиссын 2019 оны зөвлөмж нь хүн төвтэй ажил хөдөлмөрийн ирээдүйн баталгааг хангахад чиглэсэн эхлэлийн чухал цэг юм. Энэхүү мөрийн хөтөлбөр нь эдийн засаг, нийгмийн бодлого, бизнесийн практикийн төвд хүмүүс, тэдний хийж буй ажлыг тавьдаг.

Өнөөдөр ажилгүйдэл байж боломгүй өндөр хэвээр байна. Олон тэрбум хүн найдваргүй, албан бус хөдөлмөр эрхэлдэг. Цалинтай ажил эрхэлдэг 300 сая гаруй ажилчид нэн ядуу амьдарч, сая сая эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд орчин үеийн боолчлолын нөхцөлд амьдарч байна. Ажлын байрны аюулгүй байдал болон дарамт шахалтад хариу үзүүлэхэд ахиц дэвшил гаргах хэрэгцээ байсан хэвээр байна. Дэлхийн ихэнх хэсэгт ажиллах хүчний оролцоо, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн олговрын хувьд жендэрийн зөрөө их байсаар байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 1990 оноос хойш дэлхийн бараг бүх бүс нутагт болон орлогын түвшингүүдэд аажмаар буурч байна. Энэ нь ялангуяа, залуучуудын (15-24) оролцоонд хамаатай бөгөөд энэ индикаторын үзүүлэлт 1990 онд 50% байсан бол өнөөдөр 33% хүртэл буурчээ. Энэ нь сүүлийн гучин жилийн хугацаанд дунд болон дээд боловсролын түвшин дээшилсэнтэй холбоотой ч өнөөдөр таван залуу тутмын нэг нь ажил эрхлэлт, боловсрол, сургалтад хамрагдаагүй байна. Мөн дөрвөн залуу тутмын нэг нь хагас ажилгүйдэлд байна.

Жендэрээс шалтгаалаад хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо ба боломжууд ихээхэн зөрөөтэй байдаг. Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцоо тогтмол нэмэгдэж цаг хугацааны явцад жендэрийн зөрөөг багасгаж байгаа ч нэлээн бага түвшний цэгээс эхэлсэн учир ялгаа нь маш өргөн хүрээтэй хэвээр байна. 2019 онд ажиллах хүчний оролцоо эмэгтэйчүүдийн хувьд 50%-иас доош байсан бол эрэгтэйчүүдийнх 75%-д дөхөж байна. Боловсролд хамрагдалтын өсөлт нь эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлдөг бөгөөд амьжиргааны түвшин дээшлэх нь эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлийг сайн дураараа орхиход хүргэж болно. Гэвч олон тооны нотлох баримтууд нь эмэгтэйчүүдийн ажлын байрны чанар муу байгааг харуулж байна. Цалингүй болон гэр орны хөдөлмөр нь цалинтай хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд байнгын саад болж байна.

Жендэрийн асар их ялгаа байсаар байгаагийн нэг үзүүлэлт бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ажил мэргэжлээр ялгаварлан тусгаарлах явдал юм. Ерөнхийдөө албан ёсоор “ажил” гэж тооцогддог, “бүтээмж” гэж хэмжигддэг зүйл нь асар их чухал хөдөлмөрийг үл үзэгдэгч болгодог.

Үүнд ихэвчлэн нийгэмд чухал ач холбогдолтой боловч “эмэгтэйчүүдийнх” гэж үздэг ихэвчлэн гэрт хийдэг ажил багтдаг. Тухайлбал, асарч халамжлах, хүүхэд асрах, өвчтэй хүмүүсийг асрах, цэвэрлэгээ хийх, хоол хийх, бусдад бие, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх гэх мэт. Энэ ажлыг албан ёсны болгоход эдгээр мэргэжлүүд ихэвчлэн бага цалинтай, бага статустай байдаг.

Ажил хөдөлмөрийн чанарыг сайжруулж, эдийн засгийн аюулгүй байдлаа өөрсдийн хүссэн арга замаараа хэрэгжүүлэх хувь хүмүүсийн сонголт, эрх чөлөөг ялангуяа, ойрын ирээдүйд КОВИД-19 цар тахлаас болж үүссэн үйл явцын тасалдалтыг харгалзан өргөжүүлэх нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал хэвээр байна. Энэхүү дэлхийн нийтийн хямрал нь ажлын ертөнцийг тасалдуулж, одоо ч анхаарлын төвд байгаа бөгөөд олон хүний таамаглаж буйгаар урт хугацааны сөрөг үр дагаварт хүргэсэн. Ажлын байр хаагдаж, ажлын цагийн алдагдал дэлхий даяар сая сая хүмүүст нөлөөлсөн. Одоогийн ОУХБ-ын тооцоолсноор 150 сая орчим ажлын байр алга болсон байж магадгүй юм.

Жендэрийн зөрөөг арилгах болон дэлхий нийтийн тэгш бус байдлын улмаас учирсан хохирлыг арилгахад КОВИД-19 нь маш том саад болсон. Гэрээсээ ажиллах шилжилт нь эмэгтэй мэргэжилтнүүдэд таатай/ашигтай байх болов уу гэсэн горьдлоготой байсан ч яг эсрэгээрээ болсон. Орлогын түвшнээс үл хамааран бүх бүс нутаг болон ихэнх улс орнуудад эмэгтэйчүүд ажил эрхлэлтийн алдагдалд эрэгтэйчүүдээс хамаагүй их өртөж байна.

Жендэрийн зөрөөг  
арилгах болон дэлхий  
нийтийн тэгш бус  
байдлын улмаас учирсан  
хохирлыг арилгахад  
КОВИД-19 нь маш том  
саад болсон.

Ажил хөдөлмөрийн ирээдүйг харахад сорилт бэрхшээл бүхий дүр зураг гарч ирнэ. Хиймэл оюун ухаан, автоматжуулалт, робот техник гэх мэт технологийн дэвшил нь шинэ ажлын байр бий болгох боловч үүний зэрэгцээ олон хүнийг ажилгүй болгох бөгөөд энэ үйл явцад ажлын байраа алдсан хүмүүс шинэ боломжуудыг ашиглахад хамгийн бага бэлтгэлтэй байж магадгүй юм.

Тогтвортой үйл ажиллагаа, цэвэр технологи нэвтрүүлэхийн зэрэгцээ бид эдийн засгаа ногоон болгосноор олон сая ажлын байр бий болох боловч улс орнууд нүүрстөрөгчийн болон байгалийн нөөцийн эрчимжүүлсэн үйлдвэрүүдээ багасгахын хэрээр бусад ажлын байр алга болно. Платформд суурилсан эдийн засаг нь XIX зууны ажлын дадал зуршил болон ирээдүй хойч үеийн “дигитал өдрийн ажилчид (digital day labourers)-ыг бүтээж чадна. Өнөөдрийн хөгжүүлсэн үр чадвар нь маргаашийн ажлын байрны шаардлагад нийцэхгүй байх магадлалтай бөгөөд ихэнх нь хуучирна. Эдгээр шилжилтүүд нь хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийг шууд мэдэрч буй хүмүүст үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийн тулд боловсрол болон сургалтын системд нэмэлт шаардлагуудыг тавих болно.

### Боловсрол, үр чадварын хөгжүүлэлт ба сургуулиас ажилд шилжих шилжилт

Эдгээр өдөр тутмын сорилтууд, сүүлийн үеийн саад бэрхшээлүүд бүгд боловсрол болон сургалтын ертөнцөд нөлөөлсөн. Сургууль болон бусад боловсролын байгууллагууд нь эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэсэн орчин нөхцөлд эдийн засгийн сайн сайхан аж байдлаа дээшлүүлэх

арга замыг эрэлхийлдэг хувь хүнийг бэлтгэх, дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь албан ба албан бус эдийн засагт, эсвэл жишээлбэл, гэрийн ажил, асрамжийн ажил болон хөдөлмөрийн бусад хэлбэрт амжилт, үр дүнд хүрэхэд хүргэдэг эсэхээс үл хамааран боловсрол нь эдийн засгийн тэгш боломжийг олгох, хүмүүст утга учиртай ажил, мэргэжил эзэмшихэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж бид үзэж байна.

Үүний зэрэгцээ, ажлын байрны чанар буурч, газар авсан ажилгүйдэлд хүргэсэн, мөн одоо ч энэ нь үргэлжилсээр байгаа бусад салбарын бодлогын дутагдалтай байдлыг боловсрол нөхөж чадахгүй. Боловсрол бол энэ хольцын нэг хэсэг боловч макро эдийн засаг, аж үйлдвэр, хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь ялангуяа ойрын хугацаанд чанартай ажлын байр бий болгоход илүү үр дүнтэй хөшүүрэг болдог. Боловсрол эзэмшилт, залуучуудын ажилгүйдэл заримдаа зэрэгцэн өсдөг. Хагас ажилгүйдэл, өөрийн хүсэл эрмэлзэл, ур чадвар, нөөц чадварт тохирсон ажил олж чадахгүй байх нь дэлхийн хамгийн баян улс орнуудын их дээд сургууль төгсөгчдийн дунд ч байсаар байгаа бөгөөд өсөн нэмэгдэж буй дэлхий нийтийн асуудал юм. Энэхүү үл нийцэх байдал нь дэврэмтгий байдаг: өндөр боловсролтой хүн ам зохих ажилд ур чадвар, цогц чадамжаа ашиглаж чадахгүй байх нь бухимдал, үймээн самуун, заримдаа улс төр, иргэний мөргөлдөөн үүсгэдэг болохыг нийгмийн ухааны эрдэмтэд нотолсон.

Сургуулиас ажил руу шилжих үед гардаг ур чадварын зөрөөг багасгах боломжгүй. Суралцахуй нь ажлын ертөнцөд чухал хамааралтай байх ёстой. Залуучуудад боловсрол эзэмшсэний дараа хөдөлмөрийн зах зээлтэй интеграцид орж, олон нийт, нийгэмдээ өөрсдийн нөөц потенциалынхаа хэрээр хувь нэмрээ оруулахад тэдэнд хүчтэй дэмжлэг хэрэгтэй. Сурагчдад ажил хөдөлмөрийн ертөнц, олон төрлийн ажил мэргэжлийг таниулах баталгааг хангахын тулд үйлдвэрлэлийн болон олон нийтийн нийгэмлэгүүдийн удирдагчид, дунд ба дээд боловсролын үйл ажиллагаанд илүү сайн татагдан оролцох ёстой. Боловсролын байгууллагууд зөвхөн мэргэжлийн чиг баримжаа олгох бус, харин насан туршийн суралцахуйн боломжоор нь дамжуулан сурган хүмүүжүүлэгчдэд мэргэжил, ажил хөдөлмөрийн ертөнц дэх өөрчлөлтөд хөл нийлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ёстой. Дунд эсвэл дээд боловсролоор дамжуулан ТМБС-ын хангамж нь ажилд-суурилсан суралцах боломжуудыг интеграцчилах ёстой. Энэ нь суралцагчдад бодит туршлага өгөхөөс гадна боловсрол ба суралцахуйн чанар болон нийцийг сайжруулах боломжтой. Сурах арга замууд нь ирээдүйн суралцах боломжуудыг хаахгүйгээр мэргэжлийн хичээлийн сонголтуудад хандах боломжоор хангах нь бас чухал юм.

**Боловсрол нь хүмүүст урт хугацаанд үргэлжлэх нийгэм, эдийн засгийн сайн сайхан аж байдлыг өөртөө, гэр бүл, нийгэмдээ бий болгоход чиглэгдэх ёстой.**

Боловсрол дангаараа ажиллах хүчний эрэлтийг бий болгодоггүй. Мөн технологийн болон бусад бүтцийн өөрчлөлттэй холбоотой үүссэн ажилгүйдэл (structural unemployment)-ийн асуудлыг ч шийдэж чадахгүй. Сүүлийн жилүүдэд ТМБС болон ур чадварын хөгжилд нөлөөлсөн “нийлүүлэлтийн талын” олон тооны өөрчлөлт шинэчлэл нь өөрөө ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлээгүй.

Гэхдээ боловсрол нь хүмүүсийг шинийг санаачлах, мэдлэгээ хэрэглэх, асуудал шийдвэрлэх, нарийн нийлмэл ажлуудыг гүйцэтгэх чадвартай болгодог. Тухайлбал, боловсролын дээд түвшний сургуульд суралцах нь нарийн мэдлэг, танин мэдэхүйн ур



чадвартай хүмүүсийг төрүүлэхийн зэрэгцээ мэдлэг, ур чадвараа ашиглах боломж олдоно гэсэн хүлээлтийг бий болгодог. Ажлын байрт зориулсан боловсрол эсвэл бизнес эрхлэх ур чадварыг хөгжүүлэх боловсролд онцгой анхаарал хандуулах нь зохисгүй юм. Боловсрол нь хүмүүст урт хугацаанд үргэлжлэх нийгэм, эдийн засгийн сайн сайхан аж байдлыг өөртөө, гэр бүл, нийгэмдээ бий болгоход чиглэгдэх ёстой.

Технологитой зүй зохистой харьцан амьдарч сурах нь ирээдүйн ажил хөдөлмөрийн хувьд маш чухал юм. Ногоон эдийн засаг, нүүрстөрөгч саармаг ирээдүйд бэлтгэх хамгийн сайн стратегийн нэг бол шинээр гарч ирж буй ажил мэргэжил, салбар, эсвэл нүүрстөрөгч багатай эдийн засгийн төлөө хувирган өөрчлөлт хийж буй салбаруудад шаардлагатай “ногоон ур чадвар” олгоход зориулсан мэргэшлүүд, тусгай хөтөлбөрүүд, сургалтын хөтөлбөрүүдээр хангах явдал юм. Өөр нэг чухал алхам бол суралцах орчныг бүрэн ногоон болгох явдал юм. Сурагчдад нүүрстөрөгч ялгаруулдаггүй боловсролын системийг бий болгоход манлайлах боломжийг олгох нь тэднийг ногоон эдийн засагт чухал ач холбогдолтой ажил хөдөлмөрт бэлтгэх ирээдүйтэй стратегийн нэг юм.

### Боловсролын зэргийн өөрчлөгдөж буй ирээдүй

Диплом нь боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн огтлолцол дээр байдаг. Сургууль, их дээд сургууль, ТМБС-ын хөтөлбөрийн гол үүрэг бол ур чадвар, цогц чадамж, мэдлэгийг эзэмшсэн эсэхийг баталгаажуулан гэрчлэх явдал юм. Хувь хүн сурч мэдсэнээ, бүр албан бус боловсролын арга замаар болон амьдралын орчноос суралцсан ч гэсэн хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулах үндсэн эрхтэй гэсэн ойлголт нэмэгдэж байна.

Зөвхөн мэргэшилд анхаарлаа төвлөрүүлэх нь хангалтгүй юм. Суралцахуйн гаралтын дам үр дүнгүүдийн талаар бодох нь чухал ч боловсролын цөм болох нийгмийн үйл явц, харилцан үйлдлийг мартаж болохгүй. Мэргэшсэн байдал гэдэг нь үргэлж боловсролын шалтгаант зорилго, үйл ажиллагаанд итгэх итгэлийн үнэ цэнийг нотлох нийгмийн итгэлцлийн ачаар хэн нэгний хийж, ажиллаж чадах зүйлд өгсөн зөвхөн “итгэмжлэл” юм.

Мэргэжлийн карьер ба хөдөлмөр эрхлэлт улам бүр түгээмэл, уян хатан болж өөрчлөгдөхийн хэрээр бид хүмүүст харилцан уялдаа холбоо бүхий ажил мэргэжлүүдийн хооронд шилжих боломжийг хэрхэн сайн олгож чадах талаар илүү их судалгаа хийх шаардлагатай байна. Засгийн газар, сурган хүмүүжүүлэгчид, ажил олгогчид болон өргөн олон нийт өөрсдийн нийгмээ тэтгэн хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжил, ажил хөдөлмөрийн төрлүүдийг тодорхойлохдоо хамтдаа ажиллах хэрэгцээ улам бүр нэмэгдэх болно. Хөдөлмөрийн зах зээлийн шилжилт, ажил мэргэжлийн болон ажлын байрны ур чадварын хэрэгцээ өөрчлөгдөж байгааг хянаж, анализ хийдэг системүүд улам боловсронгуй болж, боловсрол болон сургалтын системүүд энэ мэдээллийг илүү сайн ашиглаж, хөтөлбөрөө тохируулж, ажил хөдөлмөрийн ертөнцөд тохирох сургалтын хувилбаруудыг санал болгох шаардлагатай байна. Байгууллагууд мэргэшил, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хандах өөрсдийн арга хандлагаа илүү шинийг эрэлхийлсэн, дэвшилттэй болгох хэрэгтэй.

## Хөдөлмөрийн зах зээлийн бүтцийн хувирган өөрчлөлт

Технологийн болон хүрээлэл орчны өөрчлөлтийн хажуугаар эдийн засгийн бүтцийн олон хүчин зүйлүүд хөдөлмөрийн зах зээлийг өөрчилж байна. Бид “халтуур”, бие даасан чөлөөт, гэрээт ажилчдын эдийн засгийн өсөлтийг харж байна. Мөн ирээдүйд дэлхий даяар олон тэрбум хүний хувьд албан бус эдийн засгийн ач холбогдол нь өсөх магадлалтай байна. Хөдөлмөр эрхлэлтийн ийм шинэ загварууд нь одоо байгаа ажилчдын дахин ур чадваржих, ур чадвараа дээшлүүлэх өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг улам бүр нэмэгдүүлнэ. Боловсрол болон сургалтын систем нь сургалтын уян хатан хувилбаруудыг үргэлжлүүлэн санал болгож байх ёстой, ингэснээр боловсролын байгууллага, хөтөлбөрүүд нь илүү өргөн хүрээний, суралцагчдад хэрэгтэй зүйлээ хэрэгтэй газартаа хэрэгтэй үедээ сурах боломжтой болно.

Хүн ам зүйн өөрчлөлт нь ажил хөдөлмөрийн ирээдүйн гол хүчин зүйл бөгөөд 2050 он гэхэд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлэх магадлалтай. Зарим бүс нутагт залуучуудын өсөлт хурдацтай нэмэгдэж байгаа нь залуучуудын ажилгүйдэл, шилжилт хөдөлгөөний дарамтыг улам хурцатгаж байна. Бусад бүс нутагт хүн амын хөгшрөлт, нийгмийн хамгаалал болон бусад халамжийн тогтолцоонд нэмэлт дарамтууд нүүрлэх болно.

Одоогийн байдлаар олон улсын хамтын нийгэмлэг нийт хүн амын эдийн засгийн үр өгөөжтэй гэж үздэг 15-64 насныхантай харьцуулж, хүүхэд, ахмад настнуудыг дэмжих арга хэрэгслээр хангадаг “хамааралтай байдлын харьцаа (dependency ratio)”-ны тооцооллыг ашигладаг. 2050 он гэхэд хамааралтай байдлын харьцаа Европ, Хойд Америкт огцом өсөх ба Ази, Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад дунд зэрэг нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь ажил эрхэлдэг жижиг бүлгүүд ажил хийдэггүй томоохон бүлгүүдийн (ялангуяа тэтгэвэр авагчид) хэрэгцээг хангах болно гэсэн үг юм. Үүний зэрэгцээ Африкийн бүс нутгийн хүн амын тал хувь нь 25-аас доош насныхан байх тул нийт хамааралтай байдлын харьцаа нь буурах төлөвтэй байна.

Залуучуудын болон өндөр настнуудын эзлэх хувь нэмэгдэж буй хүн ам зүйн эдгээр өөрчлөлтүүд нь ажил, боловсрол, сургалтын системд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна. ТМБС болон насанд хүрэгчдийн боловсролын боломжуудыг өргөжүүлэх, насан туршийн суралцахуйг сэргээх хандлага үүнтэй холбоотой. Хүний наслалт уртсаж магадгүй бөгөөд үүнийг дагаад ядаж зарим хүмүүсийн тэтгэврийн насыг уртасгаж магадгүй юм. Хэрэв ахмадууд идэвхтэй, оролцоотой байж чадвал ур чадвар, туршлагаараа нийгэм, эдийн засгаа баяжуулах болно. Залуучуудад өөрсдийн нөөц потенциалгаа бүрэн дүүрэн ашиглах, шинээр гарч ирж буй боломжуудаас хүртэх боломж, эрх мэдэл олгох нь тэднийг маргаашийн өөрчлөлтийн итгэмжлэгдсэн зуучлагч буюу гүйцэтгэгчид (agents of change) болгоно. Энэ нь хүмүүсийн нөөц чадварт хөрөнгө оруулалт хийж, тэдэнд ур чадвар эзэмших, дахин ур чадваржих, ур чадвараа дээшлүүлэх боломжийг олгож, амьдралынхаа туршид тулгарах янз бүрийн шилжилтийг даван туулахад нь дэмжлэг үзүүлнэ гэсэн үг.

Эдгээр хувирган өөрчлөлтүүд явагдахын хэрээр боловсролд тавигдах шаардлага өөрчлөгдөнө, заримыг нь загварчилж болохуйц (зарим бүс нутагт бага сургуулийн анги танхимыг өргөтгөх, илүү олон багш хөлслөх хэрэгцээ гэх мэт) бол бусад нь харилцан уялдаатай хүчин зүйлсийн нарийн нийлмэл байдал, боломжит хувирган өөрчлөлтүүдийн үл мэдэгдэх замнал зэргээс хамаарч загварчлах боломжгүй юм. Ийм учраас боловсрол, сургалтын байгууллагууд орон нутагтайгаа уялдаа холбоогоо чангатгаж, зангуу байгууллага (anchor institutions) болох ёстой. Орон нутгийн бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллах нь сургууль, байгууллагуудад орон нутгийнхаа сургалтын хэрэгцээг илүү сайн ойлгож, хангах боломжийг олгоно.

## Ирээдүйд ямар ажил өндрөөр үнэлэгдэх вэ?

Бид 2050 он руу дөхөх тусам хүн төрөлхтний түүхэнд өвөрмөц нөхцөл байдлыг илэрхийлэх боломжит хувилбар гарч ирж байна: дэлхийн ажилчдын ур чадварын түвшнээс үл хамааран технологийн дэвшлийн улмаас албан ёсны эдийн засаг дахь ажлын байр үгүй болж магадгүй юм. Зөвхөн цөөнх нь албан ёсны ажил эрхэлдэг нийгэмд боловсрол хэрхэн ажиллах вэ? Хүмүүс албан ёсны ажилгүйгээр амьдрахад ямар шинэ боловсрол хэрэгтэй вэ?

Хүний нийгэм хувь хүний хөдөлмөрийг үнэлдэг болсон. Олон мянган жилийн тэртээгээс хүнд хүчир хөдөлмөр эрхлэлтгүй алтан цаг үеийг мөрөөддөг байлаа. Гэхдээ өнөөдөр урьд өмнө хэзээ ч байгаагүй чөлөөт цагаа зохицуулахад асуудалгүй байх шиг байна. Олон арван жилийн турш ядуу буурай орнуудад тохиолдож байсан шиг одоо чинээлэг орнуудад их хэмжээний ажилгүйдлийн шинж тэмдэг үзэгдэж байна. Маш их зүйлийг дахин бодож үзэх шаардлагатай болж байна. Хүний бүтээмжтэй, бүтээлч сэтгэлгээг нийгэмд болон хувь хүнд хэрэгтэй бусад чиглэлд хэрхэн хамгийн сайн байхаар чиглүүлэх вэ?

Хүмүүс албан ёсны ажилгүйгээр амьдрахад ямар шинэ боловсрол хэрэгтэй вэ?

Аз болоход, ийм гэнэтийн тохиолдлын талаарх сайн саналуудын зарим нь зохистой ажлын байр бий болгох боловсролын хүчин чармайлтад бас сайнаар нөлөөлдөг. Ажил хөдөлмөр болон дэлхийн ирээдүйн талаарх тодорхойгүй байдлын олон давхарга нь суралцагчдын утга учир бий болгох чадамжид тэргүүлэх ач холбогдол өгөх ёстойг харуулж байна.

Бид эхний ээлжид үнэ цэнийг бий болгох гэдэг нь юу гэсэн үг вэ гэдгийг сайтар бодож үзэх хэрэгтэй болов уу. Ажил хөдөлмөрийн болон боловсролын ирээдүйн талаар бодохдоо бид, боловсролыг хэт болон дутуу үнэлдэг өргөн тархсан зөрчилтэй зуршлаа үргэлжлүүлэх үү эсвэл боловсрол нь юуг сайн хийж чадах вэ гэдэгт анхаарлаа хандуулах уу гэсэн нэгэн сонголттой тулгардаг.

Ирээдүйд бидний юуг, хэрхэн үнэлж эрхэмлэх нь бидний амьжиргааг залгуулж ирсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аж үйлдвэрийн дараах эдийн засагт хүн төрөлхтний мэддэг байсан зүйлээс тэс өөр байдлаар өөрчлөгдөж магадгүй юм.

Эдийн засгийн аюулгүй байдал нь зөвхөн албан ёсны эдийн засагт оролцоноор хангагддаггүй. Мөн бид айл өрхүүдэд хийж буй халамжийн ажил, нийтлэг сайн сайхан байдлын нөөцөөр хангах, засгийн газраас олгодог дэд бүтцийг (материаллаг болон зохицуулалтын аль алиныг нь) авч үзэх ёстой. Хэдийгээр манай уламжлалт сегментчилсэн хандлагууд болон хатуу тогтсон ашиг сонирхол нь үүнийг хязгаарлаж байгаа ч эдийн засгийн аюулгүй байдлыг юу дэмжиж байгааг ойлгох өргөн хүрээтэй хандлага 2050 онд энгийн зүйл болж магадгүй юм.

Боловсрол нь албан ёсны, цалинтай хөдөлмөрийн ертөнцийг бүхэлд нь авч үзэх, цаашлаад илүү өргөн хүрээнд авч үзэх үед хувь хүн, тэдний гэр бүл, нийгэмд урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлдэг. Хөдөлмөр эрхлэлтийн ирээдүй тодорхойгүй байгаа нөхцөлд түүний уян хатан байдлыг боловсролын ирээдүйн нийгмийн шинэ гэрээнд тусгасан байх ёстой.

# Хэсэг II

## Боловсролын шинэчлэл

1921 онд Францын Кале хотод болсон “Боловсролын шинэ нөхөрлөл”-ийн анхдугаар конгрест дэлхийн өнцөг булан бүрээс сурган хүмүүжүүлэгчид цугларч чуулсан бөгөөд энэ нөхөрлөл нь дараагийн хорин жилийн хугацаанд өргөжин хөгжиж, ЮНЕСКО-г байгуулах, түүний боловсролын чиг үүргийг тодорхойлоход тус дэм болсон юм. Тэд анхны уулзалтаараа “Шинэ эриний шинэ боловсрол” бий болсныг зарласан.

Энэхүү илтгэлийн зорилго нь түүнээс дутахааргүй зоримог хүсэл тэмүүлэл (амбиц)-тэй. Энэ илтгэл нь зүгээр нэг дахин шинээр эхлүүлэх ээлжит дуудлага биш юм. Харин бидэнд сурган хүмүүжүүлэх шинэ арга зүй, сургалтын хөтөлбөрт хандах шинэ арга хандлага, багш нарын хүлээх шинэ чиг үүрэг, сургуулийн талаарх шинэ алсын хараа, боловсролын цаг хугацаа, орон зайг хүлээн зөвшөөрөх шинэ үнэлэмж хэрэгтэй байна. Гэхдээ энэ нь бидэнд хэдийнээ бий болсон зүйлсээсээ салж ангижирна гэсэн үг биш юм. Үүний оронд бид сурган хүмүүжүүлэх ухаан болон боловсролын шилдэг уламжлалуудаа судлан энэ өвийг шинээр авч үзэж, хүн төрөлхтөн болон амьд гарагийн харилцан уялдаатай ирээдүйг тодорхойлоход бидэнд тусалж чадах найдвар төрүүлэхүйц шинэ элементүүдийг нэмэх ёстой.

Өнгөрсөн зуунд болон түүнээс хойших хугацаанд нийгэм ба гэр бүлүүд нь хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх амлалт өгөхдөө сургуульд заавал сургахад гол итгэл найдвараа тавьж ирсэн. Мөн дэлхий даяар сургуулиудыг гайхмаар ижил төстэй байдлаар зохион байгуулах болсон. Хэдийгээр эдгээр шинж чанарууд нь янз бүрийн бүс нутаг ба соёлд өөр өөр тохиргоотой байсан боловч дэлхий даяар тархан давамгайлж, өмнөх эрин үеийг тодорхойлж байсан боловсролын туршлагуудын олон янз байдлыг үгүй хийж тэгшитгэсэн юм. XIX, XX зуунд байгуулагдсан боловсролын нийгмийн гэрээ нь суралцахуйн зохион байгуулалтын дараах зарчмуудаар дамжин хэрэгжсэн юм. Нэгдүгээрт, боловсролыг ангиуд болгон зохион байгуулсан сургуулийн бүтэц ба анги танхимд явагддаг багш нарын хичээлд үндэслэгдсэн сурган хүмүүжүүлэх төсөл гэж үзэж ирсэн бөгөөд энэ нь хамтын суралцахуйн орчинтой хэдий ч хувь хүний амжилтыг чухалчлан үздэг. Хоёрдугаарт, боловсролыг хичээлүүдийн торон сүлжээ хэлбэрээр боловсруулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгож байсан. Гуравдугаарт, багшлахуй нь ихэвчлэн тухайн судлагдахууны хүрээнд үр өгөөжтэй суралцахуйг найруулан зохион байгуулах нь нэг

багшийн мэргэжлийн цогц чадамжид тулгуурласан ганц хүний практик гэж ойлгогдож ирсэн. Дөрөвдүгээрт, сургуулиудыг тухайн хам нөхцөлөөс үл хамааран архитектур, зохион байгуулалт, процедурын хувьд ижил төстэй загвараар байгуулдаг байв. Тавдугаарт, гэр бүл, хамт олноосоо харьцангуй хол зайд үйл ажиллагаа явуулдаг боловсролын төрөлжсөн байгууллагуудад ижил насны сурагчдад багшлахуйг зохион байгуулж, хүүхэд, залуучуудыг насанд хүрэгчдийн ирээдүйн амьдралд бэлэн болсон гэж үзсэнээр боловсролыг дуусгавар болгож ирсэн.

Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь боловсролыг төр, түмний хичээл зүтгэл, нийгмийн хамтын үүрэг амлалт, хүний хамгийн чухал эрхийн нэг, төр ба иргэдийн нэн чухал үүрэг хариуцлагын нэг болгон тус тус бэхжүүлэх ёстой. Эргээд боловсролын гол үүргүүдийн нэг бол хүний эрхийг эрхэмлэж, түүний хэрэгжилтийг урагшлуулдаг иргэдийг төлөвшүүлэх явдал юм. Энэ нь сурагчдыг бие даасан, ёс зүйтэй сэтгэгч, хэрэгжүүлэгч болох нөөц чадварт хөтөлнө. Ингэснээр тэднийг бусадтай хамтран ажиллах эв дүй, хүсэл бодлын эрх чөлөө, хариуцлага, энэрэх нинжин сэтгэл, шүүмжлэлт бүтээлч сэтгэлгээгээр зэвсэглэхийн зэрэгцээ тэдний нийгэмшлийн болон сэтгэл хөдлөлийн хүрээний бүх ур чадвар дадлыг хөгжүүлнэ гэсэн үг юм. Боловсролыг ийм амбиц бүхий алсын хараатай нийцүүлэхийн тулд суралцахуйг зохион байгуулах шинэ арга замуудыг бий болгох шаардлагатай байна. Бие биетэйгээ болон эх Дэлхийтэй хамтран амар амгаланг тогтооход хүн төрөлхтөнд туслах гол хүчин зүйлийн нэг нь боловсрол хэмээн үзэж болно. Энэхүү илтгэлийн Хэсэг II-т хүмүүн бидний бие биедээ санаа тавин халамжлах, хамтран ажиллах чадавхыг нэмэгдүүлдэг боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэд ахиц гаргах, боловсролыг нийтлэг сайн сайхан, хамтын хичээл зүтгэл болгон бэхжүүлэх чиглэлээр нийгмийн шинэ гэрээг хэрэгжүүлэх арга замуудыг санал болгосон болно.

Эдгээр таван бүлэгт дэвшүүлж буй яриа хэлэлцээ ба үйлийг чиглүүлж буй зарчмууд нь сүүлийн хоёр жилийн хугацаанд тус Комиссоос явуулсан, ялангуяа залуучуудын оруулсан хувь нэмрийг онцгойлон анхаарч үзсэн дэлхий нийтийг хамарсан зөвлөлдөх уулзалтуудын үр дүн юм. Гэхдээ эдгээр удирдамжийн шинжтэй зарчмууд нь эрдэм шинжилгээний болон мэргэжлийн нийгэмлэгийн аль алиных нь олон арван жилийн судалгаа, эргэцүүллийн үр дүнд бий болсон боловсрол дахь гүн бат үндэслэлтэй шинжлэх ухааны мэдлэгийн баазаас үүдэлтэй.

Эдгээр чиглүүлэгч зарчмыг хөгжлийн бодлого, практик үйл болгон хувиргах үйл хэрэг нь энэхүү илтгэлийг уншсан бүх хүмүүсийн гарт байна. Суралцагч, иргэн, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх бүрд амьдарч байгаа орон нутагтаа ажиллаж, боловсролын практик үйлээ, байгууллагаа, тогтолцоогоо өдрөөс өдөрт хувирган өөрчлөхийн тулд хол, ойрын бусад хүмүүстэй холбогдох нөөц потенциал, бололцоонууд байгаа. Хорших ажиллагаа, түншлэлийн энэ олон том, жижиг үйл үйлдэл нь эцсийн дүндээ ирээдүйг өөрчлөх хүч юм. Тус Комиссоос уг илтгэлийг гаргахад баримталсан гол чиглэл нь энэхүү хувирган өөрчлөлтийн талаарх үзэл санаа, зарчмуудын талаарх хэлэлцүүлгийг улам өргөжүүлэх явдал юм. Илтгэл бэлтгэх нь хоршин ажилласан хамтын хичээл зүтгэлийн оролдлого байлаа. Түүний үзэл санааг хэрэгжүүлэх нь бүр ондоо зүйл байх болно.

## Бүлэг 3

# Хамтын ажиллагааны ба эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй



Жинхэнэ боловсрол нь боловсрол эзэмшиж буй хүмүүсийн шалтгаант зорилго, эрч хүчийг эзэмдэж татсан байх ёстой. Ийм оролцоог хангахын тулд багш нар халамж, итгэлцлийн харилцааг бий болгох шаардлагатай бөгөөд ийм харилцааны хүрээнд сурагчид болон багш нар боловсролын зорилтуудаа хамтдаа бүтээж чадна.

**Нел Ноддинг (Nel Noddings)**, *Боловсролын философи.*

**Боловсролын нийгмийн шинэ гэрээнд сурган хүмүүжүүлэх зүй нь дэлхийг хувирган өөрчлөх итгэлцлээр хамтдаа ажиллах чадавхыг цогцлоодог сурагч ба багш нарын хамтын ажиллагаа, эв нэгдэлд үндэслэсэн байх ёстой.**

Ирээдүйг хамтдаа дахин төсөөлөх нь хамтын ажиллагаа, эв нэгдлийг тэтгэн дэмжсэн сурган хүмүүжүүлэх арга зүйг шаардана. Бидний хэрхэн суралцах нь юуг, яагаад сурч байгаагаар тодорхойлогдох ёстой. Хүний эрхийг багшлах болон урагш ахиулахаар өгсөн үндсэн амлалт үүрэг нь суралцагчийн эрхийг хүндэтгэх ёстой гэсэн үг юм. Жендэр, шашин шүтлэг, арьсны өнгө, бэлгийн баримжаа, нийгмийн анги давхарга, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа гэх мэт ялгаатай олон байдлын бүх чиглэлээр хүмүүст бие биеэсээ суралцах, бие биеэ үнэлж хүндлэх боломжийг бид бий болгох ёстой. Хүний эрхэм чанарыг хүндэлнэ гэдэг нь юуг, эсвэл яаж бодохыг заах биш, харин өөрийнхөөрөө сэтгэж сургана гэсэн утгатай. Энэ нь сурагчдад шалтгаант зорилгоо ухамсарлан өөрийн мэдрэмжээ нээн илрүүлэх, тэдний хувьд цэцэглэн хөгжих амьдрал гэж юу болохыг тодорхойлох боломжийг бүрдүүлнэ гэсэн үг юм. Үүний зэрэгцээ, бид бүгдэд ийм амьдралыг хамтдаа цогцлоох боломжтой дэлхийг бүтээх хэрэгтэй бөгөөд ийм дэлхийг бүтээх чадавхыг бий болгоход хамтран ажиллах нь чухал байна.

Хамтын ажиллагааны болон эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй нь ялгаварлан гадуурхахгүй байх, олон янз байдлыг хүндэтгэх, хохирогчдод учирсан хохирлыг арилгах шударга ёс (репаратив шударга ёс-reparative justice)-ны нийтлэг зарчимд суурилж, анхаарал халамж тавих, харилцан тус болох (reciprocity) ёс зүйг эрхэмлэх ёстой. Эдгээр нь оролцоонд суурилсан, хоршин ажиллах, асуудал-дэвшүүлэх болон судлагдахуун хоорондын, үе удам хоорондын, соёл хоорондын суралцахуйг зайлшгүй шаарддаг. Ийм сурган хүмүүжүүлэх зүй нь нийтлэг мэдлэгээр тэжээгдэн түүнд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нас ба боловсролын түвшин бүрийн дахин давтагдашгүй боломжуудыг хүлээн зөвшөөрч, бүхий л амьдралынх нь туршид хадгалагддаг.

Идэвхтэй суралцахуй нь ухагдахууны болон үйлдлийн мэдлэгийг хөгжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Ийм суралцахуйд мэдлэгийг ургуулан хөгжүүлэхийн тулд танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн үйлд татан оролцуулах хэрэгцээ, мэдлэгийг үйл болгон хувиргах чадамж, үйлдэл гүйцэтгэх бэлэн байдлыг тус тус хүлээн зөвшөөрдөг. Сурган хүмүүжүүлэх арга барил нь үе үеийнхний туршлага, эргэцүүлэл, судалгаан дээр суурилдаг бөгөөд эдгээрийг өнөөгийн болон ирээдүйн хойшлуулшгүй чухал хэрэгцээнд нийцүүлэн байнга шинэчилж байх шаардлагатай. Суралцахуйн хүчирхэг сэдэлжүүлэгч нь жинхэнэ бодит байдал (бидний сурсан зүйл нь бидний амьдарч буй ертөнцтэй ямар харилцан хамааралтай байгааг ойлгох) болон нийцтэй байдал (бидний сурсан зүйл ба бидний үнэт зүйлс хоорондын уялдаа холбоог ойлгох) юм. Төсөлд- болон асуудалд-суурилсан суралцахуй нь жинхэнэ бодит байдал (authenticity) ба нийцтэй байдал (relevancy)-д тохирсон суралцахуйн олон боломжийг олгодог бөгөөд бидний мэдэх, ойлгох дотоод хүсэл сонирхлыг тогшиж сэрээдэг.

Энэ бүлгийн эхний хагаст хамтын ажиллагааны болон эв нэгдэлд суурилсан сурган хүмүүжүүлэх зүйн боломжит арга хандлагуудыг тодруулж онцолсон. Эдгээрт хорших ажиллагаа, судлагдахуун хоорондын интеграц, асуудал-дэвшүүлэх аргазүй, олон янз байдлыг үнэт эрдэнэ хэмээн үзэж, хамгаалж хадгалахыг дэмждэг; сурагчдыг мухардмал зан заншил, хуваагдмал байдлаас салахад урьдаг; шударга бус байдлын шархыг эдгээдэг; мөн утга учиртай үнэлгээг сурган хүмүүжүүлэх давуу тал болгон ашигладаг арга хандлагууд багтана. Эдгээр арга хандлага нь музей, номын сан, зуслан, олон нийтийн төв болон бусад арга хэлбэрээр албан бус болон амьдралын орчноос

суралцаж боловсрол эзэмшиж болох бүхий л тохируулга бүхий орчинд хэрэглэгдэж болно. Энэ бүлгийн дараагийн хэсэгт эдгээр сурган хүмүүжүүлэх тэргүүлэх чиглэлийг амьдралын үе шат бүр дэх албан боловсролын өвөрмөц онцгой хэрэгцээнд болон боломжуудад хэрэглэх талаар тухайлбал, бага насны хүүхдийн үндэс суурийг дэмжих болон бага насных нь туршид хөгжүүлэх хорших ажиллагааг дэмжих; өсвөр үеийнхэн, залуучуудын өвөрмөц онцгой чадавхыг нээж илрүүлэх, дээд боловсролын эрхэм зорилгыг шинэчлэх чиглэлийг авч үзнэ. Бүлгийн төгсгөлд 2050 он хүртэл ашиг сонирхол нь хөндөгдөх, ялангуяа сурган хүмүүжүүлэгчид болон боловсролын салбарын менежерүүд, төлөвлөгчидтэй хийх яриа хэлэлцээ ба үйл ажиллагаанд удирдлага болгон баримтлах үндсэн зарчмуудыг дүгнэнэ. Эдгээрт өргөн цар хүрээ бүхий дэлхий ертөнцтэй гүн гүнзгий холбоо тогтоох, хорших ажиллагааг тэтгэн дэмжих, ёс зүйн үндэс суурийг бий болгох, бусдыг энэрэх нинжин сэтгэлийг хөгжүүлэх, суралцахуйг дэмжсэн үнэлгээг ашиглах зэрэг багтана.

## Сурган хүмүүжүүлэх арга хандлагыг дахин төсөөлөх нь

Сурган хүмүүжүүлэнэ гэдэг нь хүн хоорондын харилцаа юм. Багш, суралцагч хоёулаа сурган хүмүүжүүлэх нүүр тулах уулзалт (pedagogical encounters)-ын явцад бие биеэсээ суралцаж өөрчлөгддөг. Нэгэн зэрэг явагдах хувь хүний ба хамтын хувирган өөрчлөлтүүд хоорондын бүтээмжтэй харилцан нөлөөлөл (productive tension) нь сурган хүмүүжүүлэх нүүр тулсан уулзалтыг тодорхойлдог. Бидний дотоод амьдрал нь бидний хүрээлэл орчинд нөлөөлөхийн зэрэгцээ эргээд энэ гадаад орчны гүн гүнзгий нөлөөлөл доор байдаг.

Сурагч, багш, мэдлэг нь сонгодог сурган хүмүүжүүлэх гурвалжинг бүрдүүлдэг. Багшлахуй ба суралцахуй нь нийтлэг мэдлэгээр тэжээгддэг бөгөөд түүнд хувь нэмэр оруулдаг. Сурган хүмүүжүүлэх нүүр тулсан уулзалтаар дамжуулан боловсрол нь биднийг хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэгийн нийтлэг өвтэй холбож, мөн түүнийг баяжуулах боломжуудыг олгодог.

Энэ гурвалжинг өнөөгийн дэлхий ертөнцөд илүү өргөн агуулгаар төсөөлөх хэрэгтэй байна. Бидэнд дэлхийгээс суралцах, түүнтэй хамт суралцах, түүнийг сайжруулахад тусалдаг сурган хүмүүжүүлэх ухаан хэрэгтэй байна. Ийм сурган хүмүүжүүлэх ухаан нь хүн бүрийн эрхэм чанар болон сэтгэлгээний эрх (right to conscience) ба сэтгэлгээний эрх чөлөө (freedom of thought)-ний агуу ололт амжилтаас үргэлжлүүлэн суралцахыг уриалж, харин хүний бусдаас онцгойрох үзэл (human exceptionalism) ба өмчирхөн эзэгнэх хувийн үзэл (possessive individualism)-ээс ангижрахыг шаарддаг. Эдгээр нь харилцаа ба ойлголцлын харилцан тэгш байх, анхааран халамжлах ёс зүйд суурилсан байх ёстой бөгөөд хувь хүмүүс, бүлгүүд, төрөл зүйлүүд хоорондын харилцан хамаарлыг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ. Энэ бүгд нь биднийг бие биетэйгээ болон эх дэлхийтэйгээ холбогддог системийн нарийн нийлмэл харилцан хамаарлын ач холбогдлыг ойлгоход бидэнд тус дэм өгөх ёстой.

Багш нар, сурагчид хамтдаа мэдлэгийн эрэл хайгуулчдын болон бүтээн байгуулагчдын нийгэмлэгийг бүрдүүлэх хэрэгтэй.



Багш нар, сурагчид хамтдаа хүн төрөлхтний нийтлэг мэдлэгээр тэжээгдэн түүнд хувь нэмэр оруулдаг мэдлэгийн эрэл хайгуулчдын болон бүтээн байгуулагчдын нийгэмлэгийг бүрдүүлэх хэрэгтэй. Энэ нь юу байгаа, юуг бүтээж болох талаар эргэцүүлэн бодож, багш, сурагч гэлтгүй хүн бүр өөрийгөө бусадтай хамтран мэдлэг бүтээх чадвартай гэж үзэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал юм.

Сурган хүмүүжүүлэх бүх цаад санааны ард утга учир ба шалтгаант зорилгын асуултууд байдаг. Тухайлбал, багш нар сурагчдад ямар үйл, харилцан үйлдлийг санал болгож байна вэ, ямар шалтгаант зорилгоор? Сурагчид өөрсдийн сурах хүчин чармайлтдаа ямар утга учрыг өгдөг вэ?

Хувирган өөрчлөлтийн нүүр тулах сурган хүмүүжүүлэх уулзалтууд нь ангийнхан, үе тэнгийнхэн, хамт олны гишүүдтэй яриа хэлэлцээ хийх боломж олгодог. Багш нар багшлах урлаг, шинжлэх ухаан, эв дүйг эзэмшиж, сурагчдад тэдний мэддэг болон үл мэддэг зүйлсийг шинжлэн судлах, зохион бүтээх, тэдгээртэй харилцах боломжуудаар хангаж, сониуч зан, сонирхлыг өдөөхөд үр дүнтэй ашигладаг. Дараах хэсгүүдэд боловсролын нийгмийн шинэ гэрээг сурган хүмүүжүүлэх нүүр тулах уулзалтууд болгон хөрвүүлэх ирээдүйтэй стратегиудыг танилцуулна.

### **Судлагдахуун хоорондын асуудалд-баримжаалсан хоршин суралцахуй**

Ирээдүй нь сурагчдад урьд өмнө байгаагүй шинэ асуудлууд ба боломжуудыг олгох болно. Суралцагчдын асуудлыг-танин мэдэх, асуудал-шийдвэрлэх, асуудал-дэвшүүлэх чадавхыг зориудаар хөгжүүлснээр дэлхий ертөнцийн өөрчлөлт үргэлжилсээр байх болно гэсэн ойлголтыг сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх ухаанд суулгаж болно. Асуудал-дэвшүүлэх боловсрол нь сурагчдыг нээлт, хорших ажиллагаа шаарддаг төслүүд, санаачилгууд, үйл ажиллагаанд татан оролцуулдаг. Ойлгомжтой тодорхой зорилго, зорилтуудтай тулгарах үед сурагчид судлагдахууны явцуу хил хязгаараас хальж, хэрэгжих боломжтой, уран сэтгэмж бүхий шийдлүүд олох ёстой. Суралцах явцад тулгарч буй асуудал ба төслүүдэд анхаарлаа төвлөрүүлэх нь сурагчдын хувийн туршлагыг нь бэхжүүлж, ертөнцийг тогтонги гэхээсээ илүү өөрчлөгддөг гэж харахад тусалж, мэдлэг ба ажигч гярхай (discernment) байх чадварыг бий болгож, сурагчдын бичиг үсгийн болон утга учиртайгаар илэрхийлэх чадварыг хөгжүүлдэг.

2030 оны Тогтвортой хөгжлийн мөрийн хөтөлбөр нь сурагчдад тулгарч буй асуудлуудад чиглүүлсэн арга хандлагуудын өргөн хүрээг авч үзэх хэрэгцээг хүлээн зөвшөөрдөг. ТХЗ 4.7 нь тухайлбал, сурагчдыг улам бүр харилцан хамааралтай болж буй дэлхий ертөнцөд тогтвортой ирээдүйг бий болгох мэдлэг, цогц чадамжуудыг эзэмшсэн байх шаардлагатай дэлхийн иргэд гэж тодорхойлсон. 2050 он болон түүнээс хойших хугацаанд эдгээр чадавхыг тэтгэн хөгжүүлэх нь улам чухал болж байна. ТХЗ-ууд нь өөрөө сурагчдад бүхий л зорилгодоо хүрэх нөөц чадваруудыг хөгжүүлэхэд тусалдаг асуудал ба төсөлд суурилсан судлагдахуун хоорондын суралцахуйг шинээр бүтэцчилэх үйлийн хүрээг санал болгосон.

Хамтын асуудал ба төслүүдэд анхаарлаа хандуулна гэдэг нь судлахуй (study), эрэл хайгуул, хамтын бүтээн байгуулалт (co-construction)-ад тэргүүлэх ач холбогдол өгнө гэсэн үг. Хувь хүний мэдлэг, чадавх нь бусадтай холбогдох үед эрх мэдлийг хэрхэн хуваалцдаг, түүнчлэн мэдлэг нь өөрөө ямар олон янз байдалтай, сүлжилдсэн чиглэлүүдтэй байдгийг тодруулж ойлгох замаар өргөжин тэлдэг.

Төсөл- болон асуудалд-суурилсан арга хандлага нь мэдлэгийн хэрэгцээг бууруулдаггүй, харин мэдлэгийг динамик хөдөлгөөн ба хэрэглээний амьд багц дотор байршуулдаг.

Боловсролын хамгийн үр өгөөжтэй олон хэлбэр нь тухайн судлагдахууны ердийн хил хязгаараас хальсан, санаа бодлын байнгын урсгалаар баяжигдсан орчинд явагддаг. Гаргагч ертөнцийн асуудлууд болон нууцууд нь тухайн судлагдахууны хил хязгаараар хязгаарлагддаггүй учраас сурган хүмүүжүүлэх ухаан нь судлагдахуун хоорондын харилцан хамаарлыг тусгах ёстой. Гэвч тухайн асуудлыг шийдвэрлэх олон арга зам байдаг тул харилцан хамаарал, эв нэгдлийн үнэт зүйл, зарчмуудыг төлөвшүүлдэг сурган хүмүүжүүлэх арга хандлагыг сонгох нь чухал юм. Үйлчлэх суралцахуй (service learning) ба олон нийтийн оролцоо нь анги танхимын болон олон нийтийн хоорондох ханыг зөөлрүүлж, сурагчдын төсөөлөл, таамаглалыг сорьж, тэднийг өөрсдийнх нь туршлагаас илүү өргөн хүрээний систем, үйл явц, туршлагатай холбож өгдөг. Сурагчид, энэ арга хандлагын дагуу суралцахдаа, ялангуяа материаллаг талын янз бүрийн сорилттой тулгардаг хүмүүст үйлчлэхдээ патернализмын үзэл (paternalism)-ээс ангид даруу төлөв байдлаар үйлчилж сурах нь амин чухал юм. Үйлчлэх суралцахуй нь хамгийн давуу эрх ямба, нэр хүндтэй хүмүүсээр хязгаарлагдахгүй байх ёстой бөгөөд бүх суралцагч өөрсдийн нийгэмлэг дэх сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх харилцан ярианы явцад өөрийн хувь нэмрээ оруулж чадна. Үйлчлэх суралцахуй нь хамгийн тохиромжтой эсвэл хувийн ашиг сонирхолд нийцсэн шийдлүүдэд талтай хандахаас илүүтэйгээр асуудлыг шийдвэрлэх сурган хүмүүжүүлэх арга зүйд эв нэгдлийг гол зарчим болгон ашиглах нөөц боломж олгодог.

### **Олон янз байдал ба олон ургалч үзлийг эрхэмлэн дээдэлж, тогтвортой хадгалах нь**

Ирээдүйг хамтдаа дахин төсөөлнө гэдэг нь олон янз байдал, олон ургалч үзлийг бэхжүүлж, хүмүүний ертөнцийн нийтлэг чанарыг баяжуулж чанаржуулсан нийгмийг урьдчилан харах явдал юм. Амьдарч буй орон зайн хил хязгаараасаа гарах боломжийг бидэнд олгодог, үл мэдэх тодорхойгүй байдалд хань түшиг болж биднийг дагалддаг тийм боловсрол бидэнд хэрэгтэй байна.

Эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй нь боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд, залуучууд болон арьс өнгө, жендэрийн ижилслийн онцлог, нийгмийн давхарга, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, яс үндэс зэргээс шалтгаалсан үл тэвчих явдал (bigotry)-тай нүүр тулдаг хүмүүсийн боловсролын хүртээмж дэх ялгаварлан гадуурхал, ялгаварлан тусгаарлалт (segregation)-ын бүх хэлбэр байхгүй байх инклюзив оролцоотой, соёл-хоорондын (Intercultural education) боловсролд суурилсан байх ёстой. Хүн бүрийн олон янз байх бодит байдалд тулгуурладаг инклюзив оролцооны эрх нь хүний эрхийн хамгийн чухал эрхүүдийн нэг юм. Сурган хүмүүжүүлэх зүй нь сурагчдыг боловсролын нийгэмлэгт талархалтайгаар хүлээн авч, бусад хүний эрхэм чанарыг хүндэтгэх, инклюзив оролцоотой байлгах ур чадварыг хөгжүүлэхэд нь тэдэнд туслах ёстой. Инклюзив оролцоог хангаагүй сурган хүмүүжүүлэх зүй нь боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон хувиргах хичээл зүтгэлийг сулруулж, бүх хүний эрхэм чанар, хүний эрхийг дээдэлдэг дэлхий ертөнцийг бий болгох бололцоог алдагдуулдаг.

Эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй нь дэлхий дахинд арьс өнгө, хүйсийн үгүйсгэл, колоничлол, дарангуйлагч дэглэмээс үүдэлтэй системчилсэн хасан гадуурхалт байгааг мөн тэдгээрийг устган арилгах ёстойг хүлээн зөвшөөрөх ёстой.

Суралцахуй нь өөрөө олон янз байдал, ялгаатай байдал ба олон ургалч үзлийг эхлэлийн цэг хэмээн үнэлж, сурагчдад үл тэвчих явдал болон ялгаварлан гадуурхахтай шууд тэмцэх боломжийг олгох ёстой. Дэлхийд нүүрлэн тулгарч буй нарийн төвөгтэй, олон талт сорилтуудыг даван туулах

бүх шийдлийг ямар ч ард түмэн эсвэл хөгжлийн ямар ч үзэл санаа дангаараа гаргаж чадахгүй. Эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй нь дэлхий дахинд арьс өнгө, хүйсийн үгүйсгэл, колоничлол, дарангуйлагч дэглэмээс үүдэлтэй системчилсэн хасан гадуурхалт байгааг мөн тэдгээрийг устган арилгах ёстойг хүлээн зөвшөөрөх ёстой. Янз бүрийн соёл, мэдлэг судлал (epistemology) болон амьдрал ба ертөнцийг үзэх янз бүрийн арга барилыг үнэлэхгүйгээр эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүйг бий болгох боломжгүй юм. Эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх ухаан нь эдгээр ялгааг бодит цаг хугацааных нь горимд дайчлан хөгжүүлдэг.

Сонголтот эсвэл албадан нүүлгэн шилжүүлэлт (displacement)-ийн улмаас дэлхий даяар хүмүүсийн шилжилт хөдөлгөөн (mobility) нэмэгдэж байгаа нь хүмүүсийн соёл, арьс өнгөний олон янз байдлыг анги танхим болон боловсролын тохируулгат

орчинд шууд авчирч, сурган хүмүүжүүлэх шинэ бодит байдлыг бий болгож байна. Янз бүрийн боловсролын түүх, хэл яриа, соёл бүхий сурагчидтай шинэ орчинд багш нар ажиллаж байна. Хүндэтгэлтэй хандах, инклюзив оролцоог хангах, харьяалал хамааралтай байлгах, амар амгаланг тогтоох, зөрчилдөөнийг хувиргах сурган хүмүүжүүлэх зүй нь тэднээс зөвхөн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх эсвэл тэвчихээс давсан илүү их зүйлийг шаардана. Тэд сурагчдыг бие биетэйгээ мөр зэрэгцэн сууж, хамтдаа ажиллахад нь туслан дэмжих ёстой. Залуу хүмүүст өөрийнхөө өнгөрсөн, одоо, ирээдүйгээ ойлгох, тэдгээрийг холбон авч үзэх, тэгш бус байдлын талаар өөртөө төлөвшсөн туршлагаа задлан шинжлэх, хасан гадуурхалт ба орхин гадуурхалтыг эсэргүүцэх боломжийг олгодог боловсрол нь тэднийг тодорхойгүй ирээдүйд бэлтгэх хамгийн сайн аргуудын нэг юм.

Дэлхий олон соёлт, олон ёс зүйт нийгмүүдээр баялаг бөгөөд боловсрол нь соёл хоорондын иргэншлийг дэмжих ёстой. Боловсрол нь олон янз байдлын үнэ цэнийг үнэлж сурахаас гадна янз бүрийн бүлгүүд, мэдлэгийн систем, практик туршлагатай харьцах хөндлөн чиглэлийн, ардчилсан яриа хэлэлцээ хийхэд шаардлагатай ур чадвар, үнэт зүйлс, орчин нөхцөлийг дэмжих нь чухал юм. Соёл хоорондын иргэншлийн үндэс нь тухайн хүний соёлын ижилслийн онцлогийг хүлээн зөвшөөрөх явдал юм. Өөрийгөө хэн бэ гэдгийг мэдэх нь бусдыг хүндлэхийн эхлэл юм. Соёл хоорондын боловсролыг соёлын цөөнх, уугуул иргэд болон бусад орхигдон гадуурхагдсан бүлгүүдийг нийгмийн зонхилж буй бүлэгт уусгах арга хэрэгсэл болгон ашиглах ёсгүй бөгөөд харин нийгэмд илүү тэнцвэртэй, ардчилсан боломж, эрх мэдлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэгдэх ёстой. Бидэнд харилцан бие биеэ нөхөх, харилцаа нь тэгш байх, хүндэтгэх үндсэн дээр харилцан баяжигддаг мэдлэг, туршлага, шийдлийн солилцоог бий болгодог сурган хүмүүжүүлэх арга зүй хэрэгтэй байна.

Бид ялгаатай байдлаараа дамжуулан бие биеэ сургаж, сурсан зүйл маань хамтын хам нөхцөлөөс үүдэн утга учиртай болдог. Нийтлэг орон зайн доторх ялгааг харгалзан үздэг “сурган хүмүүжүүлэх зүйн хувьд ялгаатай байдлыг харгалзах”-ыг хиймэл оюун ухаанаар тодорхойлогддог нийтийн болон хамтын орон зай, харилцан хамаарлаас суралцагчдыг хөндийрүүлж, хам нөхцөлгүй болгодог хэт хувьчилсан суралцахуй (hyper-personalized learning)-гаас ялгаж үзэх нь чухал юм. Бидний ялгаатай байдлыг илүү харилцан ойлголцол болгож нэгтгэх хэрэгтэй.

Сурган хүмүүжүүлэх үйл явц нь ямагт шинээр үүсэж байдаг, дотооддоо нэг төрлийн бус, үргэлжид бүтээн байгуулагдаж байдаг орон зай-цаг хугацаанд явагддаг. Нэг номын хоёр ижил хувь байж болох ч унших хоёр ижил арга гэж байдаггүй. Хоёр ижил хичээлийн төлөвлөгөө эсвэл сургалтын хөтөлбөрийн нэгж ижил байж болох ч багшлах ижил арга гэж байхгүй. Энэхүү санаа “дэлхий боловсролын үйлдвэрлэл (global education industry)”-д эрчээ авч буй боловсролын технологи (ed tech)-ийн зарим чиг хандлагад болгоомжтой байхыг сануулж байна. Бидэнд хиймэл оюун ухааныг ашигладаг мөн багшлахуй, суралцахуй эсвэл үнэлэлт дүгнэлтэд зориулсан бэлэн арга замуудаар хангах болно гэж амладаг автоматжуулсан системүүдийн газар сайгүй өсөн нэмэгдэж буй хэрэглээний эсрэг хүний хүчин зүйлсийг нэмэгдүүлсэн тэнцвэржүүлэлт хэрэгтэй. Автоматжуулсан системүүдийг ашигласан тохиолдолд эдгээр арга техникийн хязгаарлагдмал талууд, түүнчлэн одоо байгаа эрх мэдлийн бүтцийг бэхжүүлэх эрсдэл болон бусдаас өөрөөр “гүйцэтгэж” суралцаг хүмүүсийг орхин гадуурхах асуудал дагуулж болзошгүйг урьдчилан таамаглаж анхаарч үзэх ёстой. Технологиор товчлох (short-cuts) боломжгүй байдаг хүлээц тэвчээртэйгээр сургаж, суралцах шаардлагатай бусдыг энэрэх нинжин сэтгэл, ёс зүй, эв нэгдэл, хамтын бүтээл, шударга ёс зэрэг эрсдэлтэй (risk-taking) практик туршлагад бид эрч хүчээ төвлөрүүлэх хэрэгтэй. Гүн гүнзгий хүмүүнлэг чанартай эдгээр үйлдлийг хүмүүс бүхнээс илүү дэмждэг.

### Хуваагдмал байдлаас ангид байхад суралцах нь

Хамтын ажиллагааны болон эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй нь олон янз байдлыг хүлээн авах, тууштай хадгалахаас илүү зүйлийг шаарддаг. Эдгээр нь өрөөсгөл хандлага (bias), мухардмал зан заншил (prejudice), хуваагдмал байдал (divisiveness)-аас ангид байхыг шаарддаг. Үнэн хэрэгтээ мэдлэг бол дамжуулахаар савласан “бэлэн бүтээгдэхүүн” биш юм. Сурган хүмүүжүүлэх зүй нь мэдлэгийг зүгээр нэг дамжуулж сурталчлахаас илүүтэйгээр түүхийн хувьд хэрхэн үүсэж бүрэлдсэн, харилцан ярианы хэлбэрээр хэрхэн боловсорч бүтээгдсэнийг тайлбарлан таниулж чаддаг.

Соёлын нөөц бол бидний мэдлэгтэй харьцах харилцааны гол хэсэг юм. Боловсролын бодлого нь жендэр, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, оршин суугаа газар, үндэстэн, харьяаллын баримт бичгийн статус, хөгжлийн бэрхшээл, бэлгийн баримжаа эсвэл нийгмийн гарал үүслээр алагчлагдсан байдлыг шийдвэрлэхэд улам бүр чиглэж байна. Гэсэн хэдий ч боловсролд болон нийтлэг мэдлэг дэх хамтын дурсамжууд, хүсэл эрмэлзэл, соёлын уламжлалууд, уугуул иргэдийн мэдлэгийн талаар дуугүй байх болон хасан гадуурхах явдалд бага анхаарал хандуулж байна. Бүтээгдэж бэхжээд давамгайлах болсон тогтсон мэдлэгийг шүүмжлэлтэйгээр шинжлэн судалж сурах нь эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх ухааны гол цөм юм. Бид татгалзаж, салж сурах ёстой.

Соёлын нөөц бол бидний  
мэдлэгтэй харьцах  
харилцааны гол хэсэг юм.

Хамтдаа цуглаж, бие биеийнхээ өмнө нь мэдэж байгаагүй бодит байдлуудыг олж мэдэх, тогтсон мэдлэгт шүүмжлэлтэй хандах нь хэцүү бөгөөд бүр аюултай ч байж болно. Боловсролын хүрээлэл орчин нь бүхэлдээ суралцагчдын туршилт хийх, зориглон хүчээ сорих, алдаж бүтэлгүйтэх, бүтээж байгуулахыг хөхиүлэн дэмждэг, тэр ч битгий хэл нуугдаж хоргодоход ч аюулгүй газар байх ёстой. Сурган хүмүүжүүлэх зүй нь уран сэтгэмж, бүтээлч сэтгэлгээг идэвхжүүлж, алдаа гаргах, түүнээс суралцах эрхийг багтаасан оюуны эрх чөлөөг дэмжих ёстой. Энэхүү, заримдаа эмх замбараагүй гэхээр суралцах ажлыг зөвшөөрдөг, идэвхжүүлдэг орчин нь жинхэнэ үнэний ойлголт, бусдыг энэрэх нинжин сэтгэл, ёс зүйн үйлийн хүрээ болон ойлголцол ба харах өнцгийн ялгааг үнэлэх чадварыг хөгжүүлэхэд маш чухал юм. Сурган хүмүүжүүлэгчид нь сурагчид шинэ санаа, хүнд хэцүү мэдлэгтэй тэмцэлдэх үед нь тэд шүүмжлэлд эмзэглэхгүй, түүнээс айх айдасгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллах ёстой.

### **Шударга бус байдлын шархыг эдгээж сурах нь**

Мэдэх нь мэдрэмжтэй нягт холбоотой. Хүний оюун ухаан нь ухамсар, сэтгэл хөдлөлтэй шууд холбоотой байдаг. Энэхүү харилцан уялдаа холбоог хүлээн зөвшөөрсөн үед боловсролын бололцооны асар том талбарууд нээгдэнэ. Бид аливаа нэг төрлийн болон моносоёлын алсын хараа ба үнэт зүйлсийн эсрэг зогсож, мэдэх, мэдрэх бусад арга замууд, амьдрах янз бүрийн арга ухаан, мэдлэгийн ялгаатай ойлголтуудыг цогцоор нь үнэлж чадна. Сурган хүмүүжүүлэх ухааныг колоничлолоос ангижруулах зорилтуудад мэдлэгийн онолын таамаглалууд ба хэтийн төлөвүүд хоорондын конструктив, хэвтээ буюу хөндлөн холбоо харилцаагаар дамжуулан хүрч болно.

Репаратив шударга ёс болон эв нэгдэлд боловсрол чухал ач холбогдолтой болохыг бид бас урьдчилан харж байна. Эв санааны нэгдэл нь эвлэлдэж нэгдсэн нийгмийг байгуулахад амин чухал ач холбогдолтой байсаар ирсэн бөгөөд сүүлийн үед албан болон бусад хэлбэрийн суралцахуйн аль **алиных** нь сурган хүмүүжүүлэх зүйн чухал чиглэл болоод байна. Эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүй нь хамтын ухамсар ба үйлийн хэрэгцээг бий болгосноор дарангуйлагч дэглэмийг даван туулахад тусалсан. Боловсролын ажил нь бусдыг ойлгож түүнд татагдах сэтгэл (sympathy), бусдыг энэрэх нинжин сэтгэл (empathy), нигүүлсэх ариун сэтгэл (compassion)-ээр дамжуулан өргөн хүрээний эв нэгдэлд анхаарлаа төвлөрүүлж шударга бус байдлын шархыг эдгээх бололцоог бий болгож чадна. Бусдад анхаарал тавьж, тэдний мэдэрч буйг хамтдаа мэдрэх чадамжууд болох энэрэх нинжин сэтгэл нь ёс зүйтэй хамтдаа шударга ёсны салшгүй хэсэг юм. Өнгөрсөн шударга бус явдлыг эдгээж сурах нь хамтын ажиллагааны болон эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүйн чухал бүрэлдэхүүн хэсэг байх ёстой.

### **Утга учиртай үнэлгээг бэхжүүлэх нь**

Хамгийн суурь түвшинд авч үзвэл үнэлгээ нь сурагчдын суралцах явцад гарч буй ахиц дэвшил, тулгарч буй сорилтын талаар системтэй эмпирик ажиглалт хийдэг хэвийн бодит үйл явц юм. Үнэлгээгээр сурагчдыг кодлох, стандартчилах болон бүлэглэн ангилах, хөдөлгөөний урсгалыг зохицуулах үедээ болгоомжтой байх хэрэгтэй. Үнэлгээний бүх шийдвэр нь багц таамаглал дээр суурилдаг бөгөөд эдгээр нь мөрдөгдөж буй сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүйн байж болох баримжаа, таамагтай нийцэж байх ёстой.

Хамтын ажиллагааны болон эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх ухааны үүднээс авч үзэхэд сурган хүмүүжүүлэгчид хэмжилт хийх боломжтой болон боломжгүй сурган хүмүүжүүлэх зорилгуудыг нарийвчлан тодорхойлох ёстой. Маш чухал олон мэдлэгийг хэмжиж, тоолж болдоггүй. Гэхдээ ямар нэг зүйлийг тоолж болохгүй гэж хэлэх нь утга учиртай ахиц дэвшил хэзээ ч ажиглагдахгүй гэсэн үг биш юм. Жишээлбэл, хэлэлцээ хийж зөвшилцөх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, туршилт хийх үйл явцуудад сурагчдын бүлгийг залан удирдаж, энэ үйл явцын туршид өөр өөр үзэл бодлыг сонсох, бүтээлч шүүмжлэл гаргах, хүлээн авах чадавхаа нэмэгдүүлж, бие биедээ хувь нэмэр оруулах өргөн боломжуудаар хангагдаж байгаа үед хамтын ажиллагааны зорилго нь эмпирик байдлаар ажиглагдаж болно.

Үнэлгээний олон онол байдаг бөгөөд ойрын хэдэн арван жилд мэтгэлцээн үргэлжилсээр байх болно. Сорилго (test), үнэлгээ, хуваарь/шкал бүр сурган хүмүүжүүлэх ул мөр үлдээдэг гэдгийг сурган хүмүүжүүлэгчид болон бодлого боловсруулагчид санаж байх ёстой. Сургууль, багш нарын сурган хүмүүжүүлэх сонголтыг хязгаарлаж, өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжиж, хамтран ажиллах, хамтын бүтээн байгуулалт хийх боломжуудыг багасгадаг тул өндөр-амлалттай сорилгын дэглэмд бага насны сурагчдыг шахахад чиглэсэн дарамт шахалтыг эсэргүүцэх ёстой. Өрсөлдөөний зарим элемент нь сурагчдыг бие даан болон хамтаараа илүү өндөр түвшинд хүрэхэд түлхэц болдог нь үнэн. Гэвч багш нар ихэвчлэн холоос ирүүлсэн, үл мэдэгдэх жишиг үзүүлэлтүүд (benchmarks) бүхий гаднын дарамт шахалтад хариу үйлдэл үзүүлэхийн оронд сурган хүмүүжүүлэх тодорхой зорилгод ашиглахын тулд өрсөлдөөнт үйл ажиллагааг хэзээ ашиглах боломжтойг тодорхойлох эрх чөлөөтэй байх ёстой.

Хэмжилт болон үнэлгээ нь боловсролын үр нөлөөг ойлгоход чухал ач холбогдолтой боловч индикаторууд нь тохиромжтой, утга учиртай, сайтар бодож боловсруулсан байх ёстой. "Сүүдрийн боловсрол" гэж нэрлэгддэг хувийн сургалт дэлхий нийтийн хэмжээнд өргөжин тэлж байгаа нь боловсролын амжилтын хязгаарлагдмал хэмжүүрт (ихэвчлэн богино хугацааны эргэн санахуй, танин мэдэхүйн бага түвшний ур чадварыг чухалчилдаг) явцууран төвлөрч, сурагчдыг хувь хүний болон нийгмийн хувьд илүү баялаг шалтгаант зорилгуудад хүрсэн байхаар бэлтгэхэд шаардлагатай сургалтын хөтөлбөрийг хэрхэн багасгаж байгаагийн тод жишээ юм. Ирээдүйг харахад боловсролын салбарт өсөн нэмэгдэж буй өрсөлдөөний таагүй нөлөөллүүдийг буцаах болон өндөр-амлалттай сорилгуудад явцууран төвлөрч байгаад зайлшгүй анхаарал хандуулах шаардлага байгаа нь тодорхой байна.

## Нас, үе шат бүр дэх сурган хүмүүжүүлэх аяллууд

Оролцооны болон хамтран ажиллах сурган хүмүүжүүлэх зүй нь бүх түвшний боловсрол, түүнчлэн албан болон амьдралын орчноос суралцах боловсролын бүх тохируулгат орчинд нийцдэг. Эдгээр сурган хүмүүжүүлэх зүй нь амьдралын аль ч үе шатанд тохиолдож болох боловч хорших болон хамтран бүтээх үйл ажиллагааны боломжууд нь хүний өсөлт, хөгжлийн янз бүрийн үе шатуудаас хамааран өөр өөр байдаг. Дэлхий нийтийн хэмжээнд боловсролыг ихэвчлэн бага насны, бага, дунд, дээд боловсрол гэсэн түвшингээр ангилдаг. Хүний оюун ухаан, сонирхол, суралцах арга

барил нь маш олон янз байдалтай байдаг хэдий ч, мөн хүн шугаман байдлаар хөгждөггүй ч тэдний хөгжилд нь тохирсон суралцахуйг дэмждэг, суралцагчид хоорондын ялгааг хүндэтгэдэг, суралцахуй үйл явцыг нь хувийн болгон хувиргадаг оновчтой олон аргууд байдаг. Боловсрол нь янз бүрийн үе шатуудыг дамждаг гэсэн нийтлэг ойлголт нь боловсролыг шалтгаант зорилгодоо сэтгэл хангалуун, хүн бүрд хүртээмжтэй аялал гэж илэрхийлдэг. Илтгэлийн энэ бүлгийн үлдсэн хэсэгт амьдралын мөчлөгийн түвшин, үе шат бүрд гарч ирдэг сурган хүмүүжүүлэх дилемма, бололцоог нарийвчлан авч үзэхийн зэрэгцээ оролцоо ба хоршин ажиллах сурган хүмүүжүүлэх зүйг хэрхэн ашиглаж болох талаар анхаарлаа хандуулсан болно.

### **Бага насны хүүхдийн хөгжлийн үндэс суурийг дэмжих нь**

Бага насны хүүхдүүд нь ертөнцийг шинэчлэх арга замуудыг туулж гарах чадамжтай байж чаддаг. Аливааг хүүхэд шиг шинээр харж чаддаг хүн цөөхөн байдаг. Бусдын туршлагыг анхааралтай ажигладаг, бас үл мэдэгдэх тэгсэн хэр нь боломжоор дүүрэн ертөнцийн учрыг олохыг хүсдэг сониуч зангаараа хүүхдүүд бүх насны хүмүүст үлгэр жишээ болдог. Шилжилтийн энэ үе шатанд тод илэрдэг шинэ зүйл рүү тэмүүлдэг энэхүү нөөц потенциалд анхаарал хандуулах нь бага насны хүүхдийн боловсрол, үнэн хэрэгтээ боловсролын бүх орчны тохиргоог тодорхойлох ёстой.

Бага насны хүүхдийн чанартай боловсрол нь нийгэм бүрийн тэргүүлэх чиглэл байх ёстой. Хүний амьдралын эхний жилүүд нь бие бялдар, танин мэдэхүйн, нийгэмшил ба сэтгэл хөдлөлийн онцгой өсөлтийг бий болгодог тархины үлэмж уян хатан чанар бүхий хөгжлийн үе юм. Боловсролын олон тооны томоохон судалгаа бага насны хүүхдийн боловсрол нь ирээдүйн цаашдын бүх сурч боловсрох, цэцэглэн хөгжих гол үндэс суурь болохын ач холбогдлыг харуулж байна.

Хамтын ажиллагаа, харилцан хамааралд чиглэсэн сурган хүмүүжүүлэх үйлийн баримжаа нь бага насны хүүхдийн боловсролд ихээхэн нуугдмал далд байдаг. Энэ үе шатанд хүмүүсийн ойр дотно харилцаа, эрэл хайгуул, тоглоомыг онцлон анхаарах хэрэгтэй. Хөгжлийн анхдагч хүчин зүйлүүд нь хожим бий болсон чадамжууд, зан чанартай ижил байх албагүй гэдгийг санах нь чухал. Шинжлэх ухааны хамгийн сайн эрэл хайгуулын зарим нь жишээлбэл, шавж сонирхох энгийн хоббиноос үүдэлтэй байж болох юм. Уран сэтгэмжтэй дүрд тоглох нь гойд нарийн бичиг үсгийн хүчирхэг суурь болж чадна. Бага насны сурган хүмүүжүүлэгчдийн хэлснээр, хөнгөн хийсвэр тоглоом мэт харагддаг зүйл бол өөрийгөө болон ертөнцийг ойлгох туйлын нухацтай бизнес юм.

Манай гарагийн өмнө тулгарч буй хүрээлэл орчны, уур амьсгалын өөрчлөлтийн сорилтууд нь бага насны хүүхдийн боловсролд олон үр дагавар үзүүлж байна. Ихэнх суралцахуйн орчинд хувь хүүхдэд-төвлөрсөн (individual child-centred) сурган хүмүүжүүлэх арга зүй давамгайлж байгаа ч бүх хүний нэгэн адил хүүхэд бол хүмүүний бус ертөнцийн нэг хэсэг гэдгийг тусгахын тулд эдгээр хандлагыг эргэж харах шаардлагатай. Бага насны хүүхдийн боловсрол нь хүүхдийн газар нутаг болон оршихуйн бусад амьд зүйлстэй харилцах харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдүүдийг ирээдүйн ертөнцөд сайн сайхан амьдрахад нь хамгийн сайн дэмжлэг үзүүлэхийн тулд бид шүүмжлэл, сорилт, шинэ бололцоонд баримжаалсан бага насны хүүхдийн сурган хүмүүжүүлэх арга зүйг дэмжих ёстой.



Боловсролын энэ түвшинд гэр бүл, сургууль хоорондын холбоо хамгийн хүчтэй байдаг. Хүүхдийн бие бялдар, нийгэмшил-сэтгэл хөдлөл, танин мэдэхүйн хөгжлийг сайжруулахад гэр бүл гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэдэнд зохих дэмжлэг шаардлагатай байдаг. Хүний суралцах үйл явц нь хүрээлэл орчинтойгоо тасралтгүй харьцах харилцан үйлдлээр дамжин явагддаг гэдгийг бид мэднэ. Төрөлх хэл (эсвэл хэлүүд)-ээрээ харилцах суралцахуйн оновчтой орчин нь нялх балчир болон бага насны хүүхдүүдэд хангалттай сэдэл өдөөлтийг өгдөг. Хамтдаа ном уншиж, өдөр тутмын харилцаанд баялаг үгсийн санг ашиглах нь боловсролын суурь бүрэлдэхүүн хэсэг болох бичиг үсгийн ур чадварыг хөгжүүлэхэд тусалдаг. Хүүхдийг зурагт, таблет эсвэл бусад электрон төхөөрөмжтэй холбох нь тэдэнд хэрэгтэй олон талт үйлчлэл бүхий нийгэмшлийн туршлагын муу орлуулалт болно. Засгийн газар болон бизнес эрхлэгчид хүүхэд асрах чөлөөний бодлогоо бэхжүүлж хэрэгжүүлэх хэрэгтэй. Номын сан, музей, олон нийтийн төв, цэцэрлэгт хүрээлэнгүүдийг сайн санхүүжүүлж, төрийн нэн чухал үйлчилгээ гэж үзэж байгаа үед эцэг эх, гэр бүлд үзүүлэх дэмжлэг болон бага насны хүүхдийн боловсрол нэлээд ахицтайгаар урагшилсан байдаг. “Хүүхдийг өсгөхөд тосгон шаардлагатай” гэсэн зүйр үгийг хэтрүүлэн хэрэглэсний улмаас утгагүй мэт улиг болсон ч зарим талаараа “бага насны хүүхдийн боловсрол бол бид хамтарч байж амжилтад хүрдэг зүйл” гэсэн түүний цөм санаатай маш олон хүмүүс санал нийлдэг.

Харамсалтай нь олон нийгэмд бага насны хүүхдийн боловсролыг бага боловсролтой адил олон нийтийн үүрэг хариуцлага гэж хүлээн зөвшөөрдөггүй. Бага насны хүүхдийн төвүүд хүрэлцээгүй эсвэл шаардлага хангаагүй байдаг. Энэ түвшний сурган хүмүүжүүлэгчдийг зөвхөн бие бялдрын халамж тусламж үзүүлэх нь чухал юм шиг үздэгээс тэдний цалин, хөлс маш бага байдаг. Үүний үр дүнд тэгш бус байдлын хамгийн томоохон хэлбэрүүд бага насны хүүхдүүдэд үүсдэг. Учир нь өндөр боловсролтой, нөөц бололцоо ихтэй гэр бүлүүд хүүхдүүддээ чанартай боловсрол олгодог бол ийм боломжгүй хүмүүс нь ихэвчлэн хангалтгүй санхүүжилттэй, бага цалинтай, доогуур түвшинд бэлтгэгдсэн сурган хүмүүжүүлэгчидтэй, шаардлага бүрэн хангаагүй олон нийтийн төвүүдэд найдах хэрэгтэй болдог. Засгийн газрууд төрсөн цагаас нь эхлэн бүх хүүхдийн суралцах, өсөх, хөгжих хэрэгцээг хангахын тулд бага насны хүүхдийн чанартай боловсролыг төрийн хүрэлцээтэй, тогтвортой санхүүжилтээр хангах ёстой.

Бидний нийгмийг хуваадаг архагшсан тэгш бус байдал болон мухардмал зан заншлыг шууд зааварлуулахаас илүүтэйгээр эрт, ихэвчлэн ажиглалтаар олж авдаг. Жишээлбэл, бага насны хүүхдийн сурган хүмүүжүүлэгчдийн дунджаар 2 хүрэхгүй хувийг л эрэгтэйчүүд төлөөлдөг хэвээр байвал хөвгүүд бага насны болон эмзэг бүлгийнхнийг халамжлах эрмэлзэл хэрэггүй хэмээн шууд тусган ойлгож авна. Хэрэв гэр бүлийн болон өвөг дээдсийн эх хэл нь бүр багаас сургаж зүгшрүүлээгүй бол хүүхдүүд гэр бүлийн гишүүдтэйгээ тогтоох энэхүү нандин холбоогоо алдаж, орон зай, цаг хугацааны туршид өв уламжлалаа мэдэх, түүнтэй харьцах соёлын арга барилаа ч бас алдах эрсдэлтэй. Сургуулийг уусгах, хэлмэгдүүлэх арга хэрэгсэл болгон ашигладаг олон нийгэмд дарангуйлагч байгууллагуудыг засаж залруулах, хаах нэн их шаардлагатай тооцоо гарсан. Бага насны хүүхдийн боловсрол дахь ирээдүйн санаачилгууд нь соёл иргэншлээс хөндийрөх, мухардмал зан заншлыг үе уламжлан үргэлжлүүлэхээс зайлсхийх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Бага насны хүүхдийн сурган хүмүүжүүлэх ухаан нь хувь хүний болон хамтын соёлын ижилслийн өвөрмөц байдлыг төлөвшүүлж бэхжүүлж, олон янз байдлыг хүндлэхэд суурилсан соёл хоорондын яриа хэлэлцээг дэмжих ёстой.



## Хүүхэд бүрийн төлөө хоршин ажиллах боловсрол

1990-2020 оны хооронд дэлхий даяар бага боловсролын хүртээмж ихээхэн өргөжсөн боловч оролцоот болон хоршин ажиллах сурган хүмүүжүүлэх зүйг бүрэн ашиглаж, суралцахуйн бүх хүрээнд чанарыг бэхжүүлэхийн тулд хийх зүйл их байна.

Харамсалтай нь дэндүү олон сургууль болон нийгэмд бага насны хүүхдүүд анги ахихад тоглох, эрэл хайгуул хийх, хамтран ажиллах, холбоо сүлбээ тогтоох боломжууд багасахын хэрээр тэдний төрөлхийн сониуч, юмны учрыг олохыг хүсдэг эрэл хайгуулч зан чанар нь улам бүр багасаж байна. Урлаг, шинжлэх ухааны салбарт шинээр эзэмшсэн ойлголт, ур чадварын хувийн туршлагын үнэ цэнийг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ анхан шатны түвшинд тусгаарлагдсан орчинд хувийн бие даасан ажилдаа хэт их цаг зарцуулах нь хамтран бүтээн байгуулах, хамтран ажиллах, асуудал-шийдвэрлэх гол боломжуудыг хязгаарлаж байгаа нь маргаангүй.

Гэсэн хэдий ч сургууль болон албан боловсролын байгууллагуудын дотор болон гадна аль алинд нь хамтарч болон хоршиж ажиллах сурган хүмүүжүүлэх санаачилгын жишээ улам бүр нэмэгдсээр байна. Зарим бүс нутагт орон нутгийн сургуулиуд нь боловсролын шинэ бололцоонуудыг урьдчилан харах, соёлын нөөцийн санг ашиглан орон нутгийн хойшлуулшгүй хэрэгцээ шаардлагад хариу үйлдэл үзүүлэхэд чиглэсэн орон нутгийн иргэдийн бүтээлч хариу үйлдлийг төлөөлж чаддаг. Бусад хам нөхцөлд сургуулиудтай түншлэн ажилладаг, заримдаа “албан бус” гэгдэх боловсролын хөтөлбөрүүд нь орон нутгийн ахмадууд, олон нийтийг манлайлагчид, мэдлэгийг хадгалагчидтай холбогдох хоршин ажиллах боловсрол (collaborative education) ба соёлын харилцан ойлголцолд хүрэх боломжуудыг түшин тулж бэхжүүлдэг.

## Өсвөр үе, залуучуудын нөөц потенциалыг өдөөж асаах нь

Өнөөдөр дэлхий даяар залуучууд олон янзын бодит байдалтай нүүр тулж байна. Тэдгээрт боловсрол эзэмших эрхээ олж авах, хүчирхийллээс хамгаалах, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, эрт гэрлэх болон гэр бүлийн амьжиргаанд оролцох ачаалал дарамт нэмэгдэж байгаа зэрэг эрсдэлүүд багтана. Бусад зарим нь улам нэмэгдэж буй нийгмээс тусгаарлагдсан байдал, сэтгэцийн эрүүл мэндийн сорилтууд, ижилсэл ба шалтгаант зорилгын хямралтай тулгарч байна. Харилцан адилгүй түвшинд сүүлийн хэдэн арван жилийн туршид боловсрол нь нийгмийн эрүүл харилцан үйлдэл, үе тэнгийнхний харилцаа, одоогийн болон ирээдүйн хичээл зүтгэлийн шалтгаант зорилгын мэдрэмжийг бий болгосноор амьдралын энэ үе шатанд тулгарч буй сорилтуудыг зөөлрүүлэхэд тусалсан. Гэвч бусад тохиолдолд боловсролын академик түвшний дарамт, нийгмээс тасарч хөндийрөх явдал нэмэгдсэнээр сорилт бэрхшээлүүд улам гүнзгийрэн хүндэрч байна.

Хэдхэн жил эсвэл хэдэн сарын хугацаанд мэдрэл, бие махбодын ихээхэн өөрчлөлтүүд гарч ирдэг гэдэг утгаараа залуу насны үеийг бага настай харьцуулж болох юм. Залуучууд оюуны чадавхдаа мэдэгдэхүйц үсрэлт хийдэг ч насанд хүрсэн хүнийхээ бүрэн хариуцлагыг хүлээхэд бэлэн эсэх, эсвэл ирээдүйд бэлтгэхэд анхаарлаа төвлөрүүлж байгаа эсэхээс хамааран соёлын хүлээлт, философи өөр өөр байж болно. Боловсрол нь хоёуланд нь зэрэг хийх боломж олгож, тэднийг сорьж, тэгэнгээ дэлхий ертөнцтэй утга учиртай харилцах арга замуудад татан оролцуулах хангалттай боломжуудаар дэмжиж чадна.

Амьдралын энэ үе шатанд залуучууд ихэвчлэн өөрсдийн сонирхлыг тодруулж, авьяас чадвараа эрэлхийлж, өөрийнх нь дуудлагыг юунаас ч илүү хайж илрүүлж чадах ажил мэргэжлээ тодорхойлдог. Онол ба практик хоорондын, мөн эцэс төгсгөлгүй мэт санагдах бэлтгэл ба утга учиртай туршилт дадлага хоорондын хуваагдлыг холбох, шалтгаант зорилгын хүчтэй мэдрэмжийг бий болгох нь энэ үе шатны сурган хүмүүжүүлэх чухал зорилгууд юм. Ихэнхдээ шударга ёсны хүчтэй мэдрэмжээр тодорхойлогддог өсвөр насныхан насанд хүрэгчдийн хоёр нүүр гарган хуурамч дүр эсгэхийг маш соргогоор мэддэг. Энэ үүднээс залуучуудыг угаасаа сэтгэл санаа зовоосон ярвигтай, тэрслүү, нийгмийн сайн сайханд аюултай гэж тэднийг гутаах хаяг зүүсэн учир дутагдалтай яриа хөөрөө нь хор хөнөөлтэй бөгөөд ялангуяа, үе хоорондын хорших ажиллагааны боломжууд болон энэхүү чухал хэр нь заримдаа хэцүү байдаг шилжилтийн дэмжлэг туслалцааг хязгаарладаг. Хэрвээ бололцоо талаас нь харвал дунд боловсролын ховорт тооцогдох цөөн хэдэн загвар залуучуудын гайхалтай нөөц потенциалыг хангалттай хэмжээнд нээж өгч байгаа нь ойлгомжтой болно.

Гэсэн хэдий ч найдвар төрүүлэхүйц ирээдүйг дахин төсөөлөх ажил аль хэдийн хийгдэж эхэлсэн. Залуучуудын манлайлсан хөдөлгөөн, байгууллагууд асуудалд улам бүр өөрөөр хандаж байна. “Ирээдүйн төлөөх баасан гараг”, “Наран мандах хөдөлгөөн” болон дэлхий даяарх ижил төстэй олон мянган хүчин чармайлтууд нь өөр төрлийн ирээдүйн бэлтгэл сургуулилт юм. Латин Америк болон Өмнөд Азийн хэд хэдэн оронд хот төвтэй загварыг өргөжүүлэхийн оронд орхигдон гадуурхагдсан хөдөөгийн залуучуудыг эхлэлийн цэг болгон авдаг боловсролын систем ба сурган хүмүүжүүлэх зүйг хөгжүүлэн залуучууд, өсвөр үеийнхэнд уугуул болон өвөг дээдсийн зан үйлээр бахархах мэдрэмжийг сэргээж байна. Эдгээр болон бусад олон жишээнүүд нь хөгжиж цэцэглэсэн чинээлэг, үл алагчилсан шударга ирээдүйн илүү өргөн орон зайг бүтээхэд залуучуудыг дэмжих боловсролын чадавхын бодит илэрхийлэл юм.

Залуучуудын манлайлсан хөдөлгөөн, байгууллагууд асуудалд улам бүр өөрөөр хандаж байна.

## Дээд боловсролын эрхэм зорилгыг шинэчлэх нь

Боловсрол нь мэдлэг үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэхийн хамтаар их сургуулийн эрхэм зорилгын цөм хэсэг боловч сүүлийн хэдэн арван жилд дээд боловсролыг зохион байгуулах, магадлан итгэмжилж, санхүүжүүлж буй арга замуудын үр дүнд олон газар боловсрол анхаарлын гадна үлдэж орхигдсон. Зарим тохируулгат орчинд профессоруудыг шууд үр дүнгээр үнэлж байгаа нь багшлах, дагалдуулан сургах, чадавхыг бэхжүүлэх, олон нийттэй хоршиж ажиллах харилцааг тэтгэхэд тэдний оруулсан хувь нэмрийн чанар, нийц, үнэ цэнээс илүүтэйгээр дан ганц хувь хүний гаргасан бүтээмжээр үнэлж байгаагийн шинж тэмдэг юм.

Олон их сургуульд сурган хүмүүжүүлэх ухаан арын эгнээнд шилжсэн. Энэ замаар явсаар ирээдүйн их, дээд сургуулиуд нь бусад байгууллагууд эсвэл хиймэл оюун ухаан шингэсэн боловсронгуй технологиор тоноглогдсон тусгай төвүүдэд багшлах ажлыг даалгаж магадгүй юм. Үе дамжсан (intergenerational) боловсролын эрхэм зорилго төвд нь байдаг, мөн мэдлэг ба шинжилгээ

судалгаатай үргэлж холбоотой байдаг их сургуулийн шинэчлэлийн тийм ирээдүйг төсөөлөх боломжтой. Техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагууд заримдаа энэ дүүжингийн нөгөө талтай буюу багшлахуй нь ихэвчлэн сургалт, техникээр хязгаарлагддаг, харин нийгэмшил, ёс зүй, үзэл баримтлалын гүн гүнзгий асуултууд нь тэдний эрх хэмжээнээс гадуур үлдэхтэй тулгардаг. Бидний хувь хүний болон хамтын ирээдүйд чухал ач холбогдолтой бүтээмжийн нөөц чадварыг хөгжүүлэх, ашиглах явдлыг гүн гүнзгий ойлголт, мэргэшсэн ур чадвар, эргэцүүлэн бодох хандлагыг хөгжүүлэх сурган хүмүүжүүлэх баялаг талбар гэж харах ёстой.

Дээд боловсролын эрхэм зорилгыг шинэчлэхийн тулд бага, дунд боловсролтой нягт уялдуулан холбох мөн уламжлалт лекц, түүнийг дамжуулах загвараас давж гарсан сурган хүмүүжүүлэх өөр стратеги хэрэгжүүлэх шаардлагатай байна. Сурагч хоорондын хамтын ажиллагаа, шинжилгээ судалгааны төслийн боловсруулалт, асуудал-шийдвэрлэлт, бие даасан судалгаа, семинарын яриа хэлэлцээ, бодит талбар дээрх судалгаа (field study), боловсруулж бичих, үйлийн шинжилгээ (action research), нийтийг татан оролцуулсан төсөл болон бусад сурган хүмүүжүүлэх олон арга хэлбэрийг дээд боловсролд нэвтрүүлэх шаардлагатай. Сурган хүмүүжүүлэх ухааныг нүүрний эгнээнд буцааж авчрахын тулд профессоруудын багшлах ажилд илүү их үнэ цэн өгч, тэдний сурган хүмүүжүүлэх суралцахуй ба өсөлтийг зайшгүй дэмжих шаардлагатай байна.

Хүндэтгэл, энэрэх нинжин сэтгэл, тэгш байдал, эв нэгдэл зэрэг үнэт зүйлс нь ирээдүйд их сургууль, коллеж, техникийн институтийн эрхэм зорилгын гол цөм байх ёстой. Дээд боловсрол нь оюутнуудад ёс зүйг тэтгэн төлөвшүүлж, тэднийг иргэний болон хүрээлэл орчны хариуцлагаа ухамсарласан илүү сайн, илүү чадварлаг иргэн болоход нь тусалж дэмжих ёстой. Дээд боловсрол нь нийгэмшил-соёлд ч бас нийцсэн байх ёстой. Соёлын олон янз байдлыг талархан үнэлэх, хүний эрхийг хамгаалах амлалт үүргээ хэрэгжүүлэх, мөн угсаатан төвт үзэл болон арьс өнгө, хүйс ба жендэр, анги давхаргын бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхлыг үл тэвчих нь боловсролын гол зорилтууд байх ёстой. Ийм үнэт зүйл, зарчмуудын хэрэгжилтийг урагш ахиулдаг дээд боловсрол нь лекцийн танхим, виртуал орон зайн хязгаараас давж гардаг. Энэ нь хүмүүст өөртөө илүү сайн зан чанарууд төлөвшүүлэх, хүчирхэг үнэт зүйлсийн тогтолцоог бэхжүүлэх, өөрийг нь хүрээлж буй орчныг хувирган өөрчлөх боломжийг олгодог тул агуулгын хувьд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Энэ бүлэгт боловсролын нийгмийн шинэ гэрээнд сурган хүмүүжүүлэх ажлыг хамтын ажиллагаа ба эв нэгдлийн зарчмын дагуу зохион байгуулж, дэлхий ертөнцийг хувирган өөрчлөхийн төлөө сурагчид хамтдаа ажиллах чадавхыг бий болгохыг санал болгосон. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг урагш ахиулахад хэрэгтэй яриа хэлэлцээ, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх дараах дөрвөн зарчим байна.

- **Сурган хүмүүжүүлэх ухаан нь харилцан уялдаа холбоо, харилцан хамаарал дээр тогтох ёстой.** Багш, сурагч, мэдлэг хоорондын харилцаа холбоо нь илүү өргөн хүрээтэй хам нөхцөлд явагддаг. Бүх суралцагч тэрхүү хам нөхцөлтэй холбоотой байдаг бөгөөд суралцахуйн бүх үйл явц нь тэр хам нөхцөлд бас түүнтэй хамт явагддаг. Сурагчид бусдын үйлдэл өөрт нь хэрхэн нөлөөлж, өөрийнх нь үйлдэл бусдад хэрхэн нөлөөлж байгааг сурч мэдэх хэрэгтэй бөгөөд ийм

учраас л анги танхим, сургууль нь сурагчдыг өөрөөсөө ялгаатай бусад хүмүүстэй харилцах боломжийг олгох ёстой.

- **Хамтын ажиллагаа ба хорших ажиллагааг ялгаатай түвшин болон насныханд тохирсон арга замаар зааж, дадлагажуулах ёстой.** Хамтрах болон хорших ажиллагаа нь суралцагч нийгэмлэгийг тодорхойлогч шинж чанар болсон үед боловсрол нь өөрсдийгөө болон дэлхийг хувирган өөрчлөхөд шаардагдах хувь хүмүүсийн хамтдаа ажиллах чадавхыг бий болгодог. Энэ нь бага насны хүүхдийн боловсролд чухал байдгийн адил мөн насанд хүрэгчдийн боловсрол ба суралцахууд ч нэгэн адил чухал юм.
- **Эв нэгдэл, энэрэх нинжин сэтгэл, ёс зүй, нигүүлсэх ариун сэтгэл нь бидний хэрхэн суралцаж байгаа арга барилд шингэсэн байх ёстой.** Бид хүн төрөлхтний соёлын нөөцийн олон янз байдлыг бүрэн дүүрнээр нь боловсролд талархан хүлээн авч, олон янз байдал ба олон ургалч үзлийг эрхэмлэхээс эхлээд тэдгээрийг тэтгэн дэмжих, хадгалан хамгаалах хүртэл өргөжүүлэн тэлэх ёстой. Багшлахуй нь өрөөсгөл хандлага, мухардмал зан заншил, хуваагдмал байдлаас зайлсхийж сургахад төвлөрөх нь зүйтэй. Энэрэх нинжин сэтгэл буюу бусдад санаа тавьж тэднийг ойлгох, тэдэнтэй хамтдаа мэдрэх, нэгдсэн байр суурьт хүрч хамтын шийдвэр гаргах чадамж нь эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх арга зүйг бий болгоход нэн чухал шаардлагатай.
- **Үнэлгээ нь эдгээр чиглэлд нийцэж, сурагчдын өсөлт хөгжилт ба суралцахуйг утга учиртай байлгах нь чухал юм.** Шалгалт, сорилго болон үнэлгээний бусад хэрэгсэл нь боловсролын шалтгаант зорилго, зориулалтад нийцсэн байх ёстой. Нухацтай суралцахуйн үлэмж их хэсгийг хялбархан хэмжиж, тоолох боломжгүй юм. Сурагчдын сурах үйл ажиллагааг дэмжсэн багшийн удирдлагатай форматив үнэлгээг нэн тэргүүнд тавих ёстой. Бид өрсөлдөөнтэй, өндөр-амлалттай стандартчилалдсан үнэлгээний ач холбогдлыг бууруулах ёстой.

2050 онд хамтын ажиллагаа, эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүйг нийтийн, хүн бүрд хүртээмжтэй болгохын тулд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон дэлхий нийтийн түвшинд бид бүгд хамтдаа ажиллах хэрэгтэй байна.

## Бүлэг 4

# Сургалтын хөтөлбөр ба хувьсан хөгжиж байдаг нийтлэг мэдлэг



Хүмүүс боловсрол гэж үнэн хэрэгтэй юу байдгийг мэдэхгүй байгаа нь жинхэнэ хүндрэл юм. Боловсролын үнэ цэнийг бид хөрөнгийн биржийн зах зээл дээрх газар эсвэл хувьцааны үнэ цэнийг үнэлдэг шиг үнэлдэг. Бид сурагчдад зөвхөн илүү их мөнгө олох боломжтой боловсрол олгохыг эрмэлзэж байна. Боловсролтой хүмүүсийн зан чанарыг сайжруулах талаар бид бараг боддоггүй. Бид охидод мөнгө олох шаардлагагүй гэж хэлдэг; тэгвэл тэд яагаад боловсролтой байх ёстой гэж? Ийм үзэл бодол байсаар байгаа цагт бид боловсролын жинхэнэ үнэ цэнийг мэдэх найдвар байхгүй.

**Махатма Ганди (Mahatma Gandhi)**, « Үндэсний Жинхэнэ боловсрол», 1907 он.

**Боловсролын нийгмийн шинэ гэрээнд сургалтын хөтөлбөр нь нийтлэг мэдлэгийн баялгаас урган гарч, сурагчдад мэдлэг олж авах, үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тэднийг шүүмжлэлт сэтгэлгээтэй, мөн мэдлэгээ хэрэглэх чадавхтай болоход нь тусалдаг экологийн, соёл хоорондын болон судлагдахуун (шинжлэх ухааны салбар) дамнанас суралцахуйг урам зоригтойгоор хүлээн авах ёстой.**

Боловсрол ба түүний төлжүүлэн төлөвшүүлж буй мэдлэг, нөөц чадварууд, үнэт зүйлсийн хооронд шинэ холбоо тогтоогдох ёстой. Энэ нь сурагчдад амар амгалан, шударга, тогтвортой дэлхий ертөнцийг цогцлоох боломжийг олгодог нөөц чадварууд, мэдлэгийг шалгах, болон эдгээр чадавхыг хөгжүүлэхэд нь тэдэнд туслах зориулалттай сургалтын хөтөлбөрийн явж ирсэн чиг замыг эргэн харж шалгах аас эхэлнэ. Боловсролын нийгмийн шинэ гэрээг хамтдаа байгуулахын тулд бид сургалтын хөтөлбөрийг хичээлүүдийн торон сүлжээс гэхээс илүү том зүйл гэж бодох хэрэгтэй. Сургалтын хөтөлбөрийн асуултууд нь цогц чадамжийг төлөвшүүлэхтэй, мөн хүн төрөлхтний нийтлэг өвийн нэг хэсэг болох мэдлэгийг эзэмших болон шинэ мэдлэг, шинэ ертөнцийг хамтдаа бүтээх гэсэн боловсролд үргэлж хамаатай байдаг амин чухал хоёр үйл явцтай уялдаж томъёологдсон байх шаардлагатай.

### Юуг сурах ёстой, юуг сураагүй байх ёстой вэ?

Юуг, яаж сурах ба сургах тухай өгүүлсэн олон тооны арга хандлага, онол байдаг. Суралцахуйн дизайныг хүүхэд-төвтэй буюу субъект-төвтэй, суралцагч-төвтэй эсвэл багш-төвтэй гэж томъёолж болно. Мэдлэгийг академик болон хэрэглээний, шинжлэх ухааны болон хүмүүнлэгийн, ерөнхий болон тусгай гэж ангилж болно. Хэдийгээр арга хандлага бүрд санал болгох тодорхой зүйл байдаг ч мэдлэг ба ертөнцийн харилцан үйлчлэлийн өсөн нэмэгдэж буй нарийн нийлмэл байдлыг тусгасан шинэ парадигмууд, хэтийн чиглэлүүд хэрэгтэй болдог. Сурган хүмүүжүүлэгчид юуг сурах ёстой, юуг сураагүй байх ёстой вэ гэсэн асуулыг тавьж, үүний хамт мэдлэг эзэмшилтэд анхаарах ёстой. Энэ нь экологийн хямралтай холбоотойгоор хөгжлийн гол чиг хандлага, эдийн засгийн өсөлтийн парадигмыг эргэн харж дахин ухаарах шаардлагатай байгаа эгзэгтэй үед бүр ч онцгой чухал асуулт юм.

Энэ бүлэг нь нийтлэг мэдлэгийг бүх хүн төрөлхтний залгамжлан үлдэх өв хэмээн дахин ухаарах ёстой гэсэн товч хэлэлцүүлгээр эхэлж улмаар мэдэх, ойлгох олон янзын арга замуудыг багтаан өргөжүүлэх гэсэн асуултуудыг авч үзнэ. Энд мэдлэгийг онцолж байгаа нь агуулга давамгайлах ёстой гэсэн үг биш юм. Мэдлэг хэрхэн үүсэн бий болж, хэрэглэгдэж, дахин шалгагдаж байснаараа үргэлж хувьсан хөгжиж байдаг. Энэхүү бүлэг нь хүн төрөлхтний өмнө тулгарч буй сорилтууд, нарийн төвөгтэй эргэлзээ төрүүлсэн асуултуудыг шийдвэрлэхэд хэрэгтэй мэдлэгийг цаашид үүсгэн хуримтлуулах, ашиглах өргөн хүрээний нөөц чадваруудыг бий болгоход чиглэсэн хамтын хүчин чармайлтаа эрчимжүүлэхийг нийтэд уриалж байна.

Боловсрол нь юу мэдэхийг, бас яаж мэдэхийн аль алиныг нь төвөггүй хослуулж чадна. Агуулгын эзэмшилт нь хэрэглээ, ур чадвар эсвэл нөөц чадварууд хөгжүүлэхтэй уралдах шаардлагагүй юм. Үүний оронд суурь мэдлэг ба ур чадвар нь хоорондоо сүлжигдэж, бие биеэ нөхөж чаддаг байх хэрэгтэй. Хэдэн арван жилийн турш сургалтын хөтөлбөрийн талаарх маргаан агуулгын мэдлэг ба цогц чадамжийн хооронд эргэлдэж байна. Төсөлд-суурилсан болон асуудалд-суурилсан арга хандлагаар олж авсан зүйлээсээ татгалзахгүйгээр, тухайлбал, орчин үеийн тулгамдсан

асуудлуудыг нягт шинжлэх, сургалтын хөтөлбөрийг сурагчдад нийцтэй байлгах гэх мэт хүчирхэг мэдлэгийн хандлагыг дэмжих шинэ динамикийг тохируулах цаг болжээ.

Энэ бүлэгт нийтлэг мэдлэг ба сургалтын хөтөлбөрийн хоорондын харилцан үйлчлэлийг авч үзсэн бөгөөд ингэхдээ бичиг үсэг, тоо тоолол, шинжлэн судлах эрэл хайгуул, урлаг, иргэншил зэрэг нөөц чадваруудын эргэн тойрон дахь мэдлэгүүдийн хооронд угаасаа байдаг салшгүй уялдаа холбоог ойлгохын чухлыг нотлон харуулна. Энэ бүлэг нь 2050 он хүртэл нийтлэг мэдлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, шинжлэн судлах эрэл хайгуул, хүний эрхийг нэн тэргүүнд тавих зэрэг сургалтын хөтөлбөр боловсруулагчид болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд ижил ашиг сонирхол бүхий яриа хэлэлцээ, үйлд удирдлага болгох зарчмуудаар төгсөнө.

## Нийтлэг мэдлэг дэх оролцоо

Сургалтын хөтөлбөр нь мэдлэгийг хүн бүр түүнийг өмчлөх эрхтэй хүмүүний агуу ололт амжилт гэж үзэх ёстой. Үүний зэрэгцээ, сургалтын хөтөлбөрүүд нь нийтлэг мэдлэгийг шударга ёсны тусгалаар харахад түүнд залруулж тохируулах шаардлагатай, гэж орхих, авч өвлөх ихээхэн зүйлс хадгалагдсан байдгийг харгалзан үзэх нь зүйтэй юм. Мэдлэг хэзээ ч бүрэн гүйцэт байдаггүй бөгөөд сурган хүмүүжүүлэгчид мэдлэгийг цаашид хамтран бүтээх үйлсэд сурагчдыг уриалж, оролцох боломжийг олгох учиртай. Боловсролын хэт олон хэлбэрийн хүрээнд мэдлэг дамжуулалт нь бүх хүн төрөлхтөн, бидний хамтын сайн сайхан аж байдлыг баяжуулахаасаа илүүтэйгээр бидний өмнө саад бэрхшээлийг бий болгож, тэгш бус байдлыг үүсгэж байв. Мэдлэгтэй харьцахдаа зориудаар, бодолтойгоор оролцохыг урьтал болгодог боловсрол нь мэдлэг (эпистемик), танин мэдэхүй, репаратив шударга ёсыг цогцлооход тусалдаг.

Бид мэдлэгийн ноёрхлыг эсэргүүцэж, хүн төрөлхтний мэдлэг судлал (epistemology)-ийн хөгжлийн чиглэлүүдийн олон янз байдлыг бүрэн хамруулах замаар л бий болох бүтээлч байдал, хил заагуудын огтлолцол, туршилтууд явагдах боломжуудыг тэтгэн урамшуулах ёстой. Уламжлагдан ирсэн мухардмал зан заншил, дур зоргоороо эрэмбэлсэн шатлал, мөлжлөгийн үзэл хэлбэрүүд үгүйсгэгдэх ёстой. Дэлхийг дахин шинээр зохион бүтээхэд үе үеийнхэн өөр өөрийн хувь нэмрээ оруулдаг учраас боловсрол нь нийтлэг мэдлэг дээр тулгуурлан хүмүүсийн чадамжийг сайжруулж чадна. Сургалтын хөтөлбөрүүд нь бидний мэдлэгтэй харьцах, харилцан үйлчлэх чадавхыг хөгжүүлж, шинэчлэн сайжруулж байх учиртай. Жишээлбэл, бичиг үсэг, тоо тоолол, шинжлэн судлах эрэл хайгуул нь хүмүүст өөрсдийн ертөнцөө мэдэрч ойлгох, түүнд хувь нэмрээ оруулах боломжийг олгоход маш чухал ач холбогдолтой бөгөөд тэдгээрийг өнцөг булан бүрд өргөжүүлж, гүнзгийрүүлэх ёстой.

Нээлттэй болон нийтлэг сургалтын хөтөлбөрийг дизайнчлахын нэг хэсэг нь шинжлэх ухаан (disciplinary)-ы болон судлагдахуун (subject)-ы хил хязгаарыг хөдөлгөөнгүй бэхлэгдсэн эсвэл хэт хязгаарлалттай байлгадаг дарамтыг эсэргүүцэх явдал юм. Үүний оронд дэлхий ертөнцийн нарийн нийлмэл байдал, мэдлэгийн тогтолцооны түүхэн чанарын талаар эргэцүүлэн бодоход хүч энерги зарцуулах нь дээр юм. Олон талт, трансверсаль байдлын талаарх энэхүү үзэл хандлагыг боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах нь шинэлэг, бүтээмжтэй чиглэлд мэдлэгийн бат бөх суурийг бий болгоход бидэнд тусална.

Энэ бүх чухал ажлын хүрээнд сургалтын хөтөлбөр нь хэзээ ч “эцэслэсэн мэдлэг (completed knowledge)”-ээс бүрддэггүй, харин янз бүрийн үеийнхнийг холбосон, соёлын өвөө өвлүүлэн үлдээсэн, эргэн харах, шинэчлэх орон зай гаргаж өгдөг мэдлэгээр түүнийг бүрдүүлдэг гэдгийг санах хэрэгтэй. Үүнийг ухамсарлах нь биднийг бүх судлагдахууныг түүхэн хөгжлийн өнцгөөс харж, үе хоорондын учир шалтгааны хэлэлцүүлгийн нэг хэсэг болгон заахад хөтлөх ёстой бөгөөд ингэснээр сурагчид суралцах явцдаа судлагдахуунаа хам нөхцөлжүүлж, шинэ утга учрыг олох болно.

### **Боловсролын ирээдүйд хандсан сургалтын хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд**

Бид боловсролын талаарх явцуу үзэл бодлоосоо илүү том шалтгаант зорилго бүхий нухацтай үйлд татагдан оролцох учиртай. Сургалтын хөтөлбөрийн арга хандлага нь танин мэдэхүйн айг асуудал-шийдвэрлэх ур чадвар, шинийг санаачлах, бүтээлч сэтгэлгээтэй холбохоос гадна нийгэмшлийн, сэтгэл хөдлөлийн суралцахуй болон өөрийгөө танин мэдэхүйг тус тус агуулсан байх ёстой. Энд дэвшүүлсэн сургалтын хөтөлбөрүүдтэй харилцах хэлбэрүүд нь холбож нэгтгэх болон чөлөөтэй нээлттэй болгоход чиглэсэн. Сургалтын хөтөлбөрийн доор дурдсан тэргүүлэх чиглэлүүд нь инклюзив оролцоо, жендэрийн тэгш байдлыг дэмжих, шударга бус байдлыг арилгах, бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлөхөд шаардлагатай тэгш бус байдлын эсрэг өргөн хүрээний хүчин чармайлтыг хөхийлэн дэмжихэд зориулагдсан юм.

### **Гэмтэн сүйдэж буй гарагийн төлөөх сургалтын хөтөлбөр**

Ачаалал дарамт нь улам бүр нэмэгдэж буй гараг Дэлхий дээрээ бид хэрхэн хамтдаа сайхан амьдрах вэ? Боловсрол нь сурагчдыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах, буцаахад бэлтгэх замаар уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэл орчны сүйрэлд хариу арга хэмжээ авахад туслах шаардлагатай. Бид гараг Дэлхийнхээ нэг хэсэг болох хүмүүний эзлэх орон зайг огт өөр өнцгөөс харж, зарчмын шинэ үзэл бодлыг нэвтрүүлэхийн тулд сургалтын хөтөлбөрийн талаар дахин эргэцүүлэн бодож, дахин өөрөөр төсөөлөх ёстой. Сурагчид гараг Дэлхийнхээ хил хязгаарын дотор амьдрах, ирээдүй хойч үеийнхэн эсвэл бид бүгд нэг хэсэг нь болж байдаг байгалийн экосистемдээ хохирол учруулахгүй байхын тулд хүрээлэл орчны тогтвортой байдлыг хангах зайлшгүй асуудлыг бүх хичээлээр үзэж судлах ёстой. Хүний үйл ажиллагааны улмаас гэмтэн сүйдэж буй гараг дээрээ хүндэтгэлтэй, хариуцлагатай амьдрах урлагийг судлагдахуун бүхэнд нэвчүүлэх учиртай. Бид цаашид хүн төрөлхтнийг онцгойлон авч үзэх үзэл (exceptionalism)-ийг эсвэл гараг ертөнцийг бидний хувьд “гадаад” буюу танин мэдэх гаднын объект гэх үзлийг дэлгэрүүлэх боломжгүй. Үүний оронд бид харилцан уялдаатай, бүгдэд нь хуваарилагдсан эрх мэдэл, үйл ажиллагааг сэдэлжүүлэн идэвхжүүлэх ёстой. Энэ нь бид байгаль ертөнцтэйгөө хамт амьдарч, суралцдаг гэдгээ хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Боловсролын сургалтын хөтөлбөрт амьд ертөнцийн талаар хэрхэн авч үзэж хэлэлцэж байгаагаа өөрчлөх нь түүнтэй харилцах харилцаагаа тэнцвэржүүлэх нэг чухал стратеги юм. Гэтэл нөгөө талаас, сурагчдыг зөвхөн байгаль хамгаалагч байхад сургадаг сургалтын хөтөлбөр хангалтгүй байна. Эдгээр арга хандлага нь хүмүүний оршихуй ба түүний хүрээлэл орчин хоорондын хуваагдлыг урьдын адил хэвээр нь байлгасаар байх болно.



Уур амьсгалын өөрчлөлтийн боловсролд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна. Үр өгөөжтэй, зохимжтой уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол нь жендэрийн мэдрэмжийг тооцож, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг цаг хугацаа, газарзүйн хувьд огтлолцуулан цогцоор нь авч үздэг арга хандлагыг ашигладаг бөгөөд шүүмжлэлт сэтгэлгээ, иргэдийн идэвхтэй оролцоог тэтгэн дэмждэг. Энэ нь дэлхийн өнөөгийн үйлдвэрлэл, хэрэглээний түвшин тогтворгүй байгааг зөвшөөрч, чинээлэг орнууд уур амьсгалын өөрчлөлтөд хувь нэмрээ оруулахад пропорциональ бус үүрэг роль гүйцэтгэж байгааг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд үүний гол нөлөөллийн хүндрэл, үр дагаврыг ихэнхдээ ядуу буурай орнууд үүрч байна. Мөн уугуул иргэдийн тоо томшгүй олон нийгэмлэг дэх хүмүүс болон хүмүүний бус ертөнцүүд хоорондоо эв найртайгаар зохицож, зэрэгцэн оршиж ирсэн харилцааг тасалдуулсан колоничлолын болон аж үйлдвэрлэлийн өв болгон үлдээсэн зүйлийг хүлээн зөвшөөрдөг. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол нь сурагчдад шударга, тогтвортой байдлын хувилбаруудыг авч үзэх болон орон нутгийнхаа олон нийттэй хамтарч, цаашлаад эв санааны нэгдэлтэй байгаагийн бэлэг тэмдэг болгож шаардлагатай арга хэмжээнүүд авах боломж, эрх мэдлийг олгох ёстой.

Сургалтын хөтөлбөрүүд нь бид гэмтэн сүйдэж буй амьд гарагтайгаа хэрхэн холбогдож байгаагаа эргэн харж, дахин шинээр суралцах, тухайлбал, биологийн төрөл зүйлийн асар их хэмжээний алдагдал нь бүхэл бүтэн экосистемийг сүйрүүлж, уур амьсгалын эргэлт буцалтгүй өөрчлөлтөд хүргэсэн хүний бардам зангаасаа ангижрах боломжийг олгох ёстой. Бид байгаль ертөнцтэй гүн гүнзгий холбоотой байж, биосферийг боловсролын орон зай хэмээн хүлээн авах замаар сургалтын хөтөлбөрийг “онгон байгальд нь буцаах” талаар авч үзэж болно. Гараг дэлхийтэйгээ зохицон амьдрахад чухал ач холбогдолтой практик мэдлэгийн талаар тухайлбал, залуучууд болон олон нийтийн манлайлсан олон тооны хөдөлгөөнд оролцож байгаа газарт үе үеийнхний хооронд явагдах яриа хэлэлцүүлгийг сургалтын хөтөлбөрт оруулж, бид хөтөлбөрөө дахин шинээр төсөөлж болно.

Сургалтын хөтөлбөрүүд нь бид гэмтэн сүйдэж буй амьд гарагтайгаа хэрхэн холбогдож байгаагаа эргэн харж, дахин шинээр суралцах боломжийг олгох ёстой.

Феминист үзэл бодол, уугуул иргэдийн дуу хоолой нь энэ чухал мөчийг залж удирдахад ихээхэн хувь нэмэр оруулж чадна. Уугуул ард түмний мэдлэгийн системүүд нь сурагчид бол байгалийн нэг хэсэг болохыг мөн хүн төрөлхтнийг олон мянган жилийн туршид гараг дэлхийтэй зохицон амьдрах боломжийг олгосон үнэт зүйлс, дадал зуршил, оюун санааны ухамсраас суралцаж чадна гэсэн тэдний мэдрэмжийг өсгөдөг. Амьд оршихуй бүр тогтвортой экосистемд өөрийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд харилцан хамтдаа оршин тогтнох болон сайн сайхан аж төрж, амьдрахад шаардагдах хэмжээнээс илүү ихийг ч, бас дутуу багийг ч авахгүйгээр зохицон амьдрах чадавхыг хүмүүс боловсролоор дамжуулан сурч болно. Феминист үзэл бодол нь хүн төрөлхтний байгальтайгаа харьцах харилцааны ихэнх хэсгийг эзэлж буй харгис хэрцгий хандлага, мөлжлөгийн үндэс суурь болдог дайсагнасан байр суурийг эсэргүүцдэг. Дэлхий дээрх байнга өсөн нэмэгдэж буй хэрэглээ ба ноёрхол дээр суурилсан эдийн засгийн загварууд нь хуурмаг дүр зургийг мөнхжүүлдэг. Нийгмийн сайн сайхан аж байдал, экологийн тогтвортой байдлын зохистой тэнцвэрт байдалд хүрэхийн тулд бид эх дэлхийдээ багтан амьдарч сурах ёстой эдийн засгийн үр өгөөжийн босгууд бас байдаг.

Нийгмийн шударга ёс нь экологийн шударга ёстой салшгүй холбоотой. Бид бие биеэ анхааран халамжилж сурахгүйгээр амьд гарагаа анхааран халамжилж сурах боломжгүй. Анхаарал халамж нь зөвхөн сэтгэл хөдлөл, хандлагатай холбоотой төдийгүй танин мэдэхүйн гол бүрэлдэхүүн хэсэгтэй. Сургалтын хөтөлбөр нь гарагийг судалдаг шинжлэх ухаан, техникийн арга хандлагууд хэрхэн үйлдвэрлэгдэж бүтээгддэг, Дэлхий болон орчлон ертөнцийг хэрхэн баримтжуулж, дүрслэн харуулж, ойлгодог, мөн энэ гэмтэн сүйдэж буй гараг дээр амьдрах практик нь танин мэдэхүй, мэдлэгийн практиктай хэрхэн холбогдож сүлжигддэг талаарх гүн гүнзгий бүрэн дүүрэн мэдлэгийг агуулсан байх ёстой. Мэдээллийн арга хэрэгслүүд түүнчлэн хувь хүний болон хамтын төслүүдийн давуу болон хязгаарлагдмал талуудын асуудлаар ярилцаж хэлэлцэх нь дэлхий дээр цогц амьдрал үүсэх бололцоог өмгөөлөн хамгаалахад болон хамтын ухамсар, идэвхийг дайчлан нэмэгдүүлэхэд нийцсэн сургалтын хөтөлбөрүүдийг тэтгэн дэмжихэд чухал ач холбогдолтой юм.

Анхааран халамжлах ёс зүй нь бидэнд өөрсдийгөө нөөц чадвартай ч эмзэг байдаг харилцан холбоотой хүмүүс гэдгээ ойлгох боломжийг олгодог. Энэ нь биднийг бусдад болон гараг Дэлхийд хэрхэн нөлөөлж байгаагаа эргэцүүлэн бодоход хүргэдэг. Сургалтын хөтөлбөрүүд нь гэр бүлийн болон нийгмийн амьдрал дахь асран халамжлах жендэрийн тэнцвэргүй уламжлалт байдлыг арилгахын тулд жендэрийн илэрхийлэл (gender expression)-ээс үл хамааран хүн бүрийг халамжлах ёс зүйг төлөвшүүлэх нь чухал юм. Нөхөн үржихүйн мэдлэг нь хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, өвчтэй болон тусламж сувилгаа хэрэгтэй хүмүүсийг асрах, гэр бүлээ авч явах, нийгэмд нэн чухал ач холбогдолтой гэр бүлийн бие махбодын болон сэтгэл зүйн хэрэгцээг хангах зэрэг нь хүн төрөлхтний нийтлэг мэдлэгт хамаарах бөгөөд бидний хүмүүстэй харилцах харилцаанд болон манай гэмтэн сүйдэж буй эмзэг гарагийг эдгээн эмчлэх, тордон халамжлах арга барилд хамаарах нь дамжиггүй. Бидэнд харилцан хамааралтай ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх боломжийг олгох сургалтын хөтөлбөрт анхаарал халамжийн тухай (caring-about) юуны төлөө халамжлах (caring-for), яаж халамжлах, халамжлуулах (care-giving and care-receiving) талаар оруулах нь зүйтэй.

### **Мэдэхүй ба мэдрэхүйг интеграцчилах нь**

Сургалтын хөтөлбөрүүд нь сурагчдыг хөгшин залуу гэлтгүй боловсролын тохируулга бүхий орчинд суралцаж, юмны учрыг олох гэсэн сониуч зантай, суралцах хүсэл эрмэлзлээр цангасан өөрийгөө бүрэн дүүрэн илэрхийлж, хэрэгжүүлж чадах хүн гэж үзэх ёстой. Сурагчид боловсролын эдгээр орчинд өөрсдийн сэтгэл хөдлөл, айдас, найдваргүй байдал, өөртөө итгэх итгэл, хүсэл тэмүүлэл тээж ирдэг. Хүмүүсийг бүхэл бүтэн оршихуй болгон сургадаг сургалтын хөтөлбөрүүд нь тэдний дэлхий ертөнцтэй харилцах нийгэмшил, сэтгэл хөдлөлийн харилцан үйлчлэлийг дэмжиж, түүнийг сайжруулахын тулд бусадтай хамтран ажиллах чадварыг нь нэмэгдүүлдэг.

Мэдэхүй ба мэдрэхүй нь танин мэдэхүйн нэгэн ижил үйл явцын тодорхой хэсэг гэдгийг мэдрэл судлалын шинжлэх ухаан харуулж байгаа бөгөөд эдгээр нь бие даасан, тусгаарлагдсан нөхцөлд бус харин бусадтай шууд, өргөн хүрээтэй харилцаа холбоо тогтоох үед явагддаг. Тухайлбал, сүүлийн 10-аад жилийн хугацаанд нийгэмшлийн болон сэтгэл хөдлөлийн суралцахуйг боловсролын практикт нэвтрүүлэхийн тулд дэлхийн зарим хэсэгт боловсролын ихээхэн ажил хийгдсэн. Сургалтын хөтөлбөрийн нийгэмшил, сэтгэл хөдлөлийн суралцахуйн хамгийн шилдэг арга хандлагууд нь сурагчдын хувь хүний шинж чанарын нийгэмшил, сэтгэл хөдлөл, танин

мэдэхүй болон ёс суртахууны айг хамардаг. Эдгээр нь хувь хүний хөгжлийн траекторыг нийгмийн өргөн хүрээний нэгдэл нягтралд үзүүлэх үр дагавартай нь холбож өгдөг. Бусдад энэрэх нинжин сэтгэлээр хандах, хоршин ажиллах, мухардмал зан заншил, өрөөсгөл хандлагыг давж гарах, зөрчилдөөнийг зөөлрүүлэн залж удирдах чадварт суралцах нь нийгэм бүрд, ялангуяа олон жилийн туршид хагарал хуваагдалтай тэмцэж буй нийгэмд үнэ цэнтэй юм.

Нийгэмшлийн болон сэтгэл хөдлөлийн суралцахуйн практик нь нэг төрлийн бус байдаг бөгөөд харгалзах хам нөхцөлд нь нийцүүлж тохируулах хэрэгтэй. Эдгээр нь ухаалгаар дизайнчилсан суралцахуйн туршлага, багш нартай тогтоосон харилцаа холбоо, үе тэнгийнхний эерэг сайн туршлага, үе үеийнхний харилцан ойлголцол, олон нийтийн оролцоог шаарддаг. Анхаарал төвлөрүүлэх (mindfulness), бусдыг нигүүлсэх ариун сэтгэл, шүүмжлэлт эрэл хайгуул энэ бүгд нь нийгэмшил болон сэтгэл хөдлөлийн хүчирхэг суралцахуйд тус дэм болдог. Гэсэн хэдий ч ийм суралцахуй нь багш нарт нэмэлт эрэл хэрэгцээг үүсгэдэг бөгөөд энэ ажлыг гүйцэтгүүлэхийн тулд тэдэнд тусламж дэмжлэг шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Бид 2050 оныг хүртэл нийгэмшил, сэтгэл хөдлөлийн боловсролд богино хугацаанд өөрчлөлт гаргах хөрөнгө оруулалт хийх боломжгүй. Учир нь энэ нь хүний бүтээлч байдал, ёс суртахуун, шүүн тунгаах эрүүл ухаан болон ирээдүйн сорилтуудыг шийдвэрлэх үйл ажиллагааны үндэс суурь юм.

Суралцагчдыг өөрсдийгөө бүрэн дүүрэн илэрхийлж чадах хувь хүн гэж үзэж хандах нь амьдралынх бүхий л үе шатанд тэдний бие махбодын хэрэгцээ, чадавхыг хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг. Эрүүл ирээдүй нь бүх төрлийн чадамж, жендэр болон гарал үүслийн онцлогийг өөртөө багтаасан хөдөлгөөний үндсэн ур чадварыг хөгжүүлэх биеийн тамирын чанартай боловсролыг шаарддаг. Биеийн тамирын чанартай боловсрол нь батлан даах, өөртөө итгэлтэй байх, зохицуулах, хянах, багаар ажиллах, бие махбодын хүрээлэл орчны шаардлагад хариу үйлдэл үзүүлэх болон аман ба аман бус харилцаа холбоо тогтоох чадварт нь түлхэц өгч хөгжлийг нь хурдасгадаг. Биеийн тамирын боловсролыг зөвхөн бие бялдрын хувьд хамгийн чадварлаг хүмүүсийн онцгой эрэл хайгуул гэж үзэх ёсгүй бөгөөд өрсөлдөөн ба харьцуулалтад хэт найдах нь өргөн хүрээний оролцоог үгүйсгэдэг. Энэ нь сурагч бүр эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг эдлэх, хамтын үйл ажиллагаагаар дамжуулан өөрийгөө бусдын оронд тавьж, тэдэнтэй хүндэтгэлтэй харьцан чаддаг болгон хөгжүүлэх явдал насан туршдаа хамтран ажиллаж суралцахад хувь нэмэр оруулах үнэт зүйлийн үндэс суурь болох ёстой.

Үүний нэгэн адил нас насанд нь тохирсон, соёлын мэдрэмжийн онцлогийг тооцсон бүхэл бүтэн (holistic) байдлаар хүний бэлгийн амьдралд хандах боловсролын арга хандлагыг баримтлах нь нийгэмшил, сэтгэл хөдлөлийн бичиг үсэгт тайлагдахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, улмаар хүндлэл, зөвшилцлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж, биеийн өсөлт бойжилтын үеүд дэх бие махбодын болон сэтгэл хөдлөлийн үйл явцын талаарх ойлголтыг бий болгож, хүндэтгэлтэй харилцаа ба тэгш байдлыг дэмждэг. Дэлхийн олон хэсэгт охидууд бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн хор хохирлын улмаас өөрсдийгөө хасагдан гадуурхагдаж байгаага мэдрэх явдал үргэлжилсээр байгаа бөгөөд ялангуяа, өсвөр насны охидууд дунд сургуульд үргэлжлүүлэн

Бусдад энэрэх нинжин сэтгэлээр хандах, хоршин ажиллах, мухардмал зан заншил болон өрөөсгөл хандлагыг давж гарах, зөрчилдөөнийг зөөлрүүлэн залж удирдах чадварт суралцах нь нийгэм бүрт үнэ цэнэтэй.

суралцахад нь саад болж буй хам нөхцөлүүдтэй тулгарч байгаа нь бодит үнэн тул ирээдүйг урьдчилан таамаглах бололцоогүй болгож байна. Эх, хүүхдийн эрүүл мэнд, эндэгдэл, сайн сайхан аж байдал нь бэлгийн иж бүрэн, цогц боловсролтой нягт холбоотой. Эрүүл мэнд, сайн сайхан аж байдлын өргөн боломж бүхий хэлбэрүүдийн зэрэгцээ тэгш байдал, хүндэтгэл, өөртөө итгэх итгэлийн үнэт зүйлсийг үндэслэл болгосон боловсрол нь аль ч нийгэмд шударга, үл алагчилсан хүмүүс хоорондын харилцааны чадавхыг нэмэгдүүлдэг.

### **Бичиг үсгийн тайлагдалтыг өргөжүүлж, олон хэлтэй ирээдүйг бий болгох нь**

Бидний хэл ярианы болон хэлтэй харилцах чадавх нь хүний мөн чанар, мэдлэг, дэлхий дээр оршихуйн цөм болж, ойлголцлын шинэ өндөрлөгт хүрэхийн тулд бусад хүмүүсийн сурсан зүйлтэй холбогдон харилцах, түүнд тулгуурлах боломжийг бидэнд олгосон. Хэл бол нийтлэг мэдлэг оршин байхын өөрийнх нь эх үндэс юм. Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд боловсрол нь үе үеийнхэнд өмнөхөөсөө илүү уншиж, бичих чадвартай болох боломж олгосон. Гэсэн хэдий ч оролцоо (participation), инклюзив оролцоог (inclusion) өргөжүүлэхийн тулд аман ба бичгийн бүх хэлбэрээр түүх өгүүлэх, урлаг сонирхох гэх мэт хэвлэл мэдээллийн олон янзын хэрэгслийн тусламжтайгаар хүмүүсийн ойлгох, илэрхийлэх чадавхыг улам хүчитгэн бэхжүүлэхийн зэрэгцээ бичиг үсэгт тайлагдах ирээдүйг зөвхөн унших, бичихээр хязгаарлахгүйгээр түүнээс давуулж алсыг харах ёстой.

Мэдээжийн хэрэг, бичих ба ярих нь хүн төрөлхтний туршлагаа тэмдэглэж, шинэ залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх цорын ганц арга зам биш тул дүрслэл, биеийн хэл нь сургалтын хөтөлбөрт илүү тов тодорхой орох ёстой. Гэвч аман болон бичгийн мэдлэг нь хүн төрөлхтний түүхэнд маргашгүй чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ялангуяа, бичих нь хүний мэдлэгийн технологи болохынхоо хувьд бичээснүүдийг эргэлтэд оруулах, тархан зөөвөрлөгдөх, мэдлэг болгон хувиргаж хуримтлуулах бололцоог өргөжүүлж, олон ялгаатай соёлд хүний туршлагыг кодлон хадгалах боломжийг олгосон. Энэ мэдлэг нь ирээдүй хойч үеийнхэнд өвлөгдөхгүйгээр алдагдаж үрэгдэх ёсгүй.

Бичиг үсэг нь цаашдын суралцахуй болон нийгмийн амьдралын бололцоотой шууд холбоотой. Гэвч энэ нь “асаах/унтраах” зориулалттай унтраалга биш бөгөөд бид бүхий л амьдралынхаа туршид хэлээр дамжуулан харилцах, ойлголцох чадамжуудаа тасралтгүй бэхжүүлж чаддаг. Бичиг үсгийн боловсролын ирээдүй нь гүн гүнзгий, өргөн хүрээнд, шүүмжтэйгээр унших, аман болон бичгийн хэлээр ойлгомжтой тодорхой, үр өгөөжтэй харилцах түүнчлэн бусдыг анхааралтай, энэрэх нинжин сэтгэлийн үүднээс зааг ялгааг тогтоохуйц ажигч гярхай байдлаар сонсох чадамжуудыг хөгжүүлж чадна. Жишээлбэл, сурагчдын бие даан унших болон бүх хичээлийн хүнд, нарийн нийлмэл бичвэрүүдийг эрж хайх чадавх ба авьяас сонирхлыг тэтгэсэн дэмжлэг нь нийтлэг мэдлэгтэй илүү үл алагчлагдан харилцан үйлчилсний үрээр тэдэнд ирээдүйн боломжит хувилбаруудын маш өргөн цар хүрээтэй үүд хаалгыг нээж өгдөг. Бичиг үсгийн боловсрол нь анги танхим, сургуулийн хүрээнээс хальж нийгэм даяараа хүлээсэн амлалт үүргийн хэрэгжилт болж чадна. Жишээлбэл, Энэтхэгийн зарим хэвлэл мэдээллийн сүлжээнд саяхнаас эхэлсэн ижил-хэлний хадмал орчуулгыг стандарт практик болгох оролдлого нь хүмүүсийн ялангуяа, сургуульд байхдаа унших, бичих үндсэн ур чадвар зээмшсэн ч цаашдын дадлага, өөртөө итгэх итгэл шаарддаг хүмүүсийн унших ур чадварыг илүү өргөн утгаар бэхжүүлж байгааг харуулж байна.

Сургалтын хөтөлбөрүүд нь гадаад хэл, уугуул хэл, дохионы хэл зэргийг заах замаар тухайн үндэсний нэг хэлээс олон хэл рүү шилжиж байгааг харуулж байна. Энэ бол тогтвортойгоор, өргөн хүрээнд дэмжих шаардлагатай шилжилт юм. Мөн хүүхэд, залуучууд, насанд хүрсэн суралцагчид төрөлх эх хэл болон өвөг дээдсийнхээ хэлээр дээд зэргийн чанартай боловсрол эзэмших боломжтой байх нь чухал юм. Энэ нь багшлахуй ба суралцахуйн үр дүнтэй байдал (efficacy)-ын хувьд хэнд ч ойлгомжтой боловч дэлхийн даяараа боловсролын тогтолцоог олон янз байдлыг хүндэтгэн тогтвортойгоор дэмждэг болоход чиглүүлэх, түүнийг хүндлэх суурийг бий болгох утгаараа чухал ач холбогдолтой юм. Олон тооны тохируулгат орчинд сурагчдын соёлын ижилслийн онцлогийг дэмжих, нийгмийн амьдралд бүрэн оролцох боломжийг олгохын тулд хоёр болон олон хэлтэй боловсролын бодлого зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ нь цөөнхийн уугуул хэлийг дэмжихээс гадна түүнчлэн сурагчдад давамгайлж буй буюу олонхын хэлний мэдлэгийг эзэмших үндэс суурийг бий болгоход чиглэнэ.

Олон хэлний боловсрол нь дэлхий нийтийн яриа хөөрөө, ажил хэрэг, соёлын арга хэмжээнд оролцох цаашдын боломжийг бий болгодог. Харилцан хамаарал улам бүр нэмэгдсээр байгаа энэ ертөнцөд өөр өөр хэл сурах нь илтэд үнэ цэнтэй бөгөөд үүний хувь хүнд болон бүгдэд хүргэх ашиг тус нь зөвхөн харилцаа холбоогоор хязгаарлагдахгүй. Олон хэлт үзэл (plurilingualism) нь бид бүгдээрээ өөр өөр тэмдэглэгээний системүүдийн хооронд идэвхтэй орчуулагч болж, утгын тогтсон хэв маягт илүү бие даасан байдал, шүүмжлэлтэй хандахыг бидэнд үүрэг болгодог. Хэл бол зөвхөн харилцааны хэрэгсэл биш бөгөөд хэл нь ертөнцийг үзэх үзлүүд, ойлголцлын ер бусын хосгүй арга замуудыг тээж байдаг. Хэлний олон янз байдал нь хүн төрөлхтний нийтлэг мэдлэгийн гол шинж чанар бөгөөд түүнийг тогтвортой байлгахад боловсрол чухал үүрэгтэй.

Хэлний олон янз байдал  
нь хүн төрөлхтний  
нийтлэг мэдлэгийн  
ялгагдах гол шинж нь юм

## Тоо тооллыг баяжуулах

Хүмүүст математикийн мэдлэг, ур чадвараа тухайн нөхцөл байдлын өргөн хүрээнд ашиглах шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгаа тул тоо тооллын мэдлэг нь ирээдүйн боловсролд чухал ач холбогдолтой юм. Тоо тоолол нь зүй тогтлыг ажиглах, олонлогийг ангилах ба цэгцлэх, тоолох, хэмжих, тоо хэмжээг харьцуулах, тэдгээрийн хоорондын хамаарлыг тодорхойлох хүний чадавхын үр жимс юм. Аравтын бутархай, хоёртын систем зэрэг тооллын системүүд нь орчин үеийн харилцаа холбоо, гүйлгээ, тооцоолон бодох, таамаглал тооцооллын үндэс суурь болдог. Тоо тоолол нь нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үндсэн үйлдлийг эзэмшсэн байхын зэрэгцээ тэдгээрийг янз бүрийн хам нөхцөл, болон асуудалд ашиглахыг шаарддаг. Тухайлбал, энд санхүүгийн эрүүл байдлын хяналт ба төлөвлөлт, эрүүл мэндийн эрсдэл ба өвчлөлийн тохиолдлууд, хөдөө аж ахуйн ургац ба оролтын нөөцүүд, бохирдол ба байгаль орчны чанарын босго хэмжээ, орон нутгийн аж ахуйн нэгж, олон нийтийн банк гэх мэт хязгааргүй олон жишээ татаж болно. Тоо тооллыг хам нөхцөлтэй нь холбож ойлгох үед математик чадамжууд нь цаг хугацааны явцад гарч буй өөрчлөлтийг ойлгох, ирээдүйн талаар төсөл, төлөвлөгөө боловсруулах, харилцаа холбоог ойлгох, чиг хандлагыг утга учиртай хэтийн төлөвт оруулах зэргээр хүмүүн бидний чадавхыг хүчтэй нээж өгдөг.

Тоо тооллын мэдлэг нь бүх хүмүүст хамаатай бөгөөд соёлын онцлогийг тооцсон тоо тооллын сургалтын хөтөлбөрүүд нь албан боловсрол руу чиглэсэн нийгэмшил, сэтгэл хөдлөлийн гүүрийг бүтээж чадна. Жишээлбэл, Арктикийн Норвегийн уугуул оршин суугчдын уламжлалт сүлжих аргыг сурагчдад салангид бүхэл тооны бүтцийг ойлгохоос үржүүлэх ба алгебрын хувьсагчид зэрэг илүү нарийн төвөгтэй үйлдлүүд рүү шилжүүлэхэд ашигласан. Үүний нэгэн адил Канадын сургуулийн Зөвлөлүүд алгебр, пропорциональ, орон зайн сэтгэлгээ зэрэг математикийн ойлголтуудыг хэлхэж гоёл чимэглэл урлах (beading), сагс урлах, моказин гутал урлах ур ухаантай холбож өгөхийн тулд уугуул уран бүтээлчид, сурган хүмүүжүүлэгчдийг татан оролцуулсан. Математикийн мэдлэгийг сурагчдын соёлын мэдлэгтэй холбох нь гэр бүлийн орчин, сургуулийн орчин хоорондын холбоогүй байдлыг даван туулахад шаардлагатай нийгэмшил-сэтгэл хөдлөлийн хэмжигдэхүүнийг хэрэгжүүлэхэд тусалдаг. Энэ нь бас математикийг “барууны” гэсэн худал ойлголтыг няцааж, инуит (Inuit) математик, маори (Maori) математик гэх мэт угсаатны математикийн олон систем өргөн цар хүрээнд удаан хугацааны туршид оршиж байсныг сануулдаг.

### Хүмүүнлэгийн ухаанд тулгуурлахуй нь

Хүний нийгэм, соёлын талаарх мэдлэг ба судалгаань сурагчдад тулгарч буй асуудлуудаа шийдвэрлэх өргөн хүрээний арга хандлагад суралцахад нь чухал ач холбогдолтой байдаг. Хүмүүнлэгийн өв уламжлал нь янз бүрийн дүр төрхөөрөө манай дэлхийн хамтын бүтээн байгуулалтыг амин чухал талаас нь авч үзэж, дэлхийн нийтлэг мэдлэгт ихээхэн хувь нэмэр оруулсан. Үүний зэрэгцээ бидний мэддэг зүйл маань хэсэгчлэгдсэн, гажуудсан гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Хүн байх гэдэг нь юу гэсэн үг болохыг шинэчлэн тогтоохын тулд бид бие биетэйгээ болон амьд гараг ба технологитой харилцах харилцаагаа дахин тэнцвэржүүлэх шаардлагатай. Хүмүүнлэгийн шинжлэх ухаан нь үүнд дасан зохицох хэрэгтэй бөгөөд системчилсэн судалгааны талбар болохын хувьд эргээд биднийг дасан зохицоход маань тусалж чадна.

Жишээлбэл, түүхийг үр өгөөжтэй багшлах үед нийгмийн өөрчлөлт, нийгмийн тогтолцоо, тэр дундаа ялгаварлан гадуурхал, давуу эрх дархын талаар үнэлж баршгүй хэтийн чиглэлийг бий болгож чадна. Аливаа зүйл байгаагаасаа өөр байж болно гэсэн түүхэн тохиолдлын талаарх ойлголт нь ирээдүйн бололцоог урьдчилан таамаглахад үнэ цэнтэй юм. Гэсэн ч энэ нөөц потенциалыг чөлөөлж нээхийн тулд түүх нь он цагийн хэлхээсийг сонирхохоос илүү цааш урагшлахдаа эхний ээлжид нотлох баримт гэж юу болох, бид хүмүүний болон хүмүүний бус туршлагаудыг хэрхэн ойлгож буй талаар эхлээд өөрийн гэсэн бодолтой болж, хэлэлцүүлэгт оролцох ёстой.

Боловсролыг хүмүүнлэгийн ухаантай холбох, явцын дунд эргэн харж дахин холбох шинэ арга замуудыг хайж олох нь ардчиллын ирээдүйд асар чухал юм. Философи, түүх, утга зохиол, урлаг нь биднийг шалтгаант зорилго, шүүмжлэлт эрэл хайгуулын үнэ цэн, бусдыг энэрэх нинжин сэтгэл, ёс зүй, төсөөлөлтэй холбож өгдөг. Эдгээр хүмүүнлэг бүх арга хандлагууд нь сурагчдын “ирээдүйн талаарх бичиг үсгийн боловсрол (futures literacy)” буюу ирээдүй нь тэдний харж, хийж буй зүйлд ямар үүрэг гүйцэтгэхийг ойлгох чадамжийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. “Ирээдүйн бичиг үсэгт” тайлагдах нь ирээдүйг илүү үр өгөөжтэй, үр ашигтай ашиглах боломж, эрх мэдэлтэй болж, өөрчлөлт явагдахын хэрээр илүү сайн бэлтгэх, сэргээн босгох, зохион бүтээх чадвартай болох явдал юм. Үүнийг нийтлэг орон зайд албан боловсролын болон түүнээс гадуурх аль ч хэлбэрээр

нь хүмүүнлэгийн ухааныг бэхжүүлэх замаар дэмжих болно. Нийтлэг хүн төрөлхтөн, дундын гараг ертөнц, шударга ёсны төлөөх хамтын хүсэл эрмэлзлийн үүднээс боловсролыг хүмүүнлэгийн шинжлэх ухаантай хамтад нь дахин холбон авч үзэх нь маш чухал ажил юм.

## Шинжлэн судлах эрэл хайгуул ба ойлголт

Материаллаг ертөнцийг ойлгох хүсэл маань хүмүүс бидний эрэл хайгуул хийх, суралцах чадавхын тусгал байдаг. Шинжлэн судлах эрэл хайгуулын мөн чанар болох ажиглах, асуулт тавих, урьдчилан таамаглах, шалгах, онолдох, маргалдах, ойлголтыг нягтлах нь хүний оюун санаанаас урган гардаг үйлүүд юм. Орчин үеийн шинжлэх ухааны үндэс нь аливаа соёл, нийгэмд бичигдсэн түүхийн хамгийн эртний үе шатуудаас улбаатай. Түүний үр жимсийг анагаах ухаанаас эхлээд технологи хүртэл бидний бие махбодын болон материаллаг амьдралын бүхий л салаа мөчирт эдлэн хэрэглэдэг. Хүмүүнлэгийн үнэт зүйлсийг агуулсан, хүний хөгжлийг бүхэлд нь дуртай хүлээн авсан өргөн хэмжээний сургалтын хөтөлбөрийн хүрээнд шинжлэх ухааны бичиг үсэг (literacy)-ийн мэдлэг ба мөшгөх судалгаа (investigation)-нд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй

Хүн төрөлхтний түүхэнд шинжлэх ухаан нь үнэн бол хамтын хичээл зүтгэлийн үрээр бий болсон дүрэм журам, хэлэлцээрийн үр дүн гэсэн үзлийг суурь ололт амжилт болгосон мэдлэгийн чухал практик байсаар ирсэн. Гэсэн хэдий ч шинжлэх ухаан нь заримдаа шинжлэх ухааны нээлт эсвэл туршилтын нөлөөлөл зэрэг ёс зүйн асуултаас дээгүүр байр суурь эзэлдэг тусгайлсан салбар болж өргөжсөн. Энэ байдал нь хэдэн зууны туршид шинжлэх ухаанд тааламжтай хандан итгэдэг байсан итгэлийг алдагдуулсан мэтгэлцээн, асуултуудыг бий болгосон. Сургалтын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны аргууд, нээлтүүд, ёс зүйг харилцан уялдаанд нь авч үзэх ёстой.

Хэт харьцангуйн үзэл (relativism) хүрээгээ тэлж, янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төөрөгдөл (mistruths) өргөн тархаж байгаа нь бат үнэмшилтэй, өндөр хариу үйлдэл (reflexive)-тэй шинжлэх ухааны бичиг үсэгт тайлагдахыг шаардаж байна. Коронавирусын цар тахал, дэлхийн дулаарал зэрэг томоохон хямралын үед гарч буй онцолсон ташаа болон худал мэдээний тархалт нь шинжлэх ухааны бичиг үсэгт тайлагдахын ач холбогдлыг огцом нэмэгдүүлж байна. Шинжлэх ухааны мэдлэгийг үгүйсгэж, “баримт”-ыг буруугаар илэрхийлж тайлбарлах нь хардлага, үл итгэх байдал, айдас, үзэн ядалтыг өдөөж хөөрөгдсөн бодит үр дагаварт хүргэж байна. Сургалтын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны үнэнийг сахин хамгаалах, нарийн нийлмэл, олон өнгө аястай үнэнийг ажигч гярхайгаар ялган таних, чин үнэнчээр мөшгөн судлах чадавхыг эзэмшүүлэх амлалт үүргийг тэтгэн дэмжих ёстой.

Сургалтын хөтөлбөрүүд нь шинжлэх ухааны үнэнийг сахин хамгаалах, нарийн нийлмэл, олон өнгө аястай үнэнийг ажигч гярхайгаар ялган таних, чин үнэнчээр мөшгөн судлах чадавхыг тэтгэн дэмжих ёстой.

Дэлхий нийтийн нийтлэг мэдлэг нь хүн бүр хүмүүний сайн сайхан аж байдалд хувь нэмэр оруулах үнэн зөв мэдлэгийг авах эрхтэй байхыг шаарддаг. Энэхүү зарчим нь оюун ухааныг хөгжүүлэхэд ихээхэн нөлөөтэй мэдээ мэдээлэл, ухагдахуунд тулгуурладаг сургалтын хөтөлбөрт онцгой ач холбогдолтой юм. Жишээлбэл, уул уурхай, газрын тосны томоохон үйлдвэрлэлтэй зарим бүс нутаг эсвэл улс орнуудын засгийн газруудад байгалийн ухааны албан ёсны сургалтын



хөтөлбөрүүд дэх нөөцийн олборлолтын экологийн үр дагаврын тухай агуулгыг аль болох бага байлгах талаар ихээхэн дарамт ирдэг. Ийм ташаа мэдээлэлтэй бид боловсролын боломжит бүхий л арга хэрэгслээр тэмцэх нь чухал юм. Дэлхий даяар шинжлэх ухааны бичиг үсэгт тайлагдахын ач холбогдлыг сурталчлах, ялангуяа эрхээ хасуулсан, орхигдон гадуурхагдсан хүн амын дунд шинэ хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Өнөөгийн ертөнцөд урьд өмнө байгаагүй их хэмжээний мэдээлэл эргэлдэж байна. Шинжлэх ухааны бичиг үсгийн мэдлэг, арга барил, хатуу зарчимч байдал, эмпирик хандлага, ёс зүй зэрэг нь сургалтын хөтөлбөрийн чухал бөгөөд хойш тавьж болшгүй асуудал юм.

### Дижитал ертөнцөд зориулсан ур чадвар

Холбогдсон технологиуд (connected technologies) нь амьдрал, суралцахуй, ажил хөдөлмөрийн байнга өргөжиж буй олон талбар дахь оролцооны үндэс суурь болдог. Технологийн бүх нийтийн хүртээмжийг дэмжихийн зэрэгцээ боловсролын систем нь суралцагчдад технологийг утга учиртайгаар ашиглахад шаардагдах дижитал ур чадвар, цогц чадамжийг хөгжүүлэхийн төлөө тууштай хичээж байна. Эдгээр чадамжид “уугуул” эсвэл “байгалийн” гэх зүйл байхгүй. Эдгээр нь албан бус болон бие даан суралцах янз бүрийн арга хэлбэрийн хамт боловсролын зориудын оролцоо тусламжтайгаар цаг хугацааны явцад бүтээгдэж, боловсронгуй болдог.

Дижитал боловсрол нь ихэвчлэн функциональ ур чадвар, техникийн ноу-хаутай холбоотой байдаг ч энэ нь дижитал нийгэм, дижитал эдийн засгийн улс төрд хамаарах ойлголтууд, хандлага, байр суурийн багц болох “чухал дижитал бичиг үсэг (critical digital literacy)”-ийн мэдлэгийг хамрах ёстой. Энэхүү боловсрол нь юуны өмнө сурагчид дижитал буюу тоон технологийн улс төрийн бодлогын өвөрмөц талуудыг задлан шинжилж, тодорхой үр дүнгүүдэд хүрэхийн тулд тэдгээрийг чадварлаг удирдах чадамжтай болгохыг чухалчилдаг. Суралцагчид дижитал орон зай дахь тоглогчдын сэдэл тэмүүллийг ялган таньж, тэд ямар арга замаар хувь хүмүүс болон бүлгийн гишүүд илүү том дижитал экосистемийн нэг хэсэг болж байгааг олж харж сурах хэрэгтэй. Өнөөдөр холбогдсон технологиуд нь тэдгээрийг хэзээ ч ашигладаггүй, хардаггүй хүмүүст ч гүн гүнзгий нөлөө үзүүлж магадгүй юм.

Сургалтын хөтөлбөрүүд нь багш, сурагчдыг технологи дээр хамтдаа ажиллахад дэмжлэг үзүүлж, түүнийг хэрхэн ашиглаж байгааг, ямар шалтгаант зорилгоор ашиглаж байгааг тодорхойлоход туслах ёстой.

Технологийн талаарх боловсрол нь технологитой өөртэй нь зайлшгүй холбогдсон байдаг. Технологийг ойлгох, түүнийг сайн сайхны төлөө ашиглахад шаардагдах ур чадварын багц, шүүмжлэлт үзэл бодол нь шинэ технологийн хөгжлийн хурдад харгалзаад байнга өөрчлөгдөж байх болно. Гэвч энэ нь хамгийн сүүлийн үеийн технологийн дэвшилд нийцэж тохирч байхын тулд боловсрол нэг чиглэлийн хөдөлгөөнтэй байна гэсэн үг биш юм. Боловсрол нь технологийн инновацууд болон нийгмийн дижитал хувирган өөрчлөлтийг удирдахад нэмэлт үүрэг гүйцэтгэх ёстой. Сургалтын хөтөлбөрүүд нь багш, сурагчдыг технологи дээр хамтдаа ажиллахад дэмжлэг үзүүлж, түүнийг хэрхэн ашиглаж байгааг, ямар шалтгаант зорилгоор ашиглаж байгааг тодорхойлоход туслах ёстой.



## Урлагийн боловсролоор дамжуулан төсөөлөл, шүүмжит үнэлгээ, бололцоог бий болгох нь

Хөгжим, жүжиг, бүжиг, дизайн, дүрслэх урлаг, утга зохиол, яруу найраг гэх мэт урлагийн боловсрол нь сурагчдын нарийн нийлмэл ур чадвар эзэмших чадавхыг ихээхэн өргөжүүлж, сургалтын хөтөлбөрийн хүрээнд нийгэмшил, сэтгэл хөдлөлийн суралцахуйг дэмжих боломжтой. Энэ нь бусдын туршлагад хандах хүмүүс бидний чадамжийг бусдыг энэрэх нинжин сэтгэл эсвэл аман бус утгын нууцыг тайлах уншлагаар дамжуулан сайжруулж чадна.

Урлаг нь заримдаа бүрхэг бүдэг байдаг тодорхой үнэнийг ил гарган харуулж, ертөнцийг үзэх янз бүрийн үзэл бодол, тайлбарыг алдаршуулах тодорхой арга замыг гаргаж тавьдаг. Уран сайхны илэрхийллийн олон хэлбэр нь нарийн ширийн зүйлийг шингээж, амьдралын хоёрдмол утгатай тэмцдэг бөгөөд сурагчид жижиг ялгаа нь том үр дагаварт хүргэж болохыг мэдэж авдаг. Урлагийн туршлага нь ихэвчлэн үл мэдэгдэх зүйлд бууж өгөхийг шаарддаг бөгөөд тухайн тодорхой нөхцөл байдал, боломжоос хамааран бүх зүйл өөрчлөгддөг гэдгийг сурагчид сурч авч чаддаг. Мөн урлаг нь бидэнд хэлэх, харуулах, мэдрэх ёстой зүйлээ хэлж, үзүүлж, мэдэрч сурахад тусалж, урлагийн болон түүний хил хязгаараас хальсан мэдэхүй, оршихуй, харилцаа холбоотой байх цар хүрээг улам тэлж гүнзгийрүүлэхэд тусалдаг.

Урлагаар дамжуулан өөрийгөө бүтээлчээр илэрхийлэхийг өдөөсөн сургалтын хөтөлбөрүүд нь ирээдүйг тодорхойлох асар их нөөц потенциалыг агуулж байдаг. Уран бүтээл нь ертөнцийг ойлгож мэдрэх, соёлын шүүмжид оролцох, улс төрийн арга хэмжээ авах шинэ хэл, арга хэрэгслээр хангаж өгдөг. Сургалтын хөтөлбөрүүд нь соёлын өв болон бидний хамтын ижилслийн өвөрмөц байдлын хүчирхэг бэлгэдлүүд, урын сан, эшлэл лавлагаа зэрэгт шүүмжлэлтэй хандах, бүтээлч үйл хэрэгт татагдан оролцох хандлагыг төлжүүлэн төлөвшүүлж чадна.

## Хүний эрх, идэвхтэй иргэн байх, ардчилсан оролцоонд сургах нь

Хүний эрхийн боловсрол нь өөрийнхөө нөөц талааа бүрэн дайчилж ашигласан тохиолдолд хүн бүрийг хүлээн зөвшөөрөх, хөгжин цэцэглэх боломж нь хангагддаг ёс суртахууны ертөнцөд нэвтрэх гол цэг ба харилцан ойлголцох нийтлэг хэлийг санал болгож, хувирган өөрчлөх үүрэг гүйцэтгэж чадна. Хүний эрхийн боловсрол нь суралцагчдын бие даан шийдвэр гаргаж, түүнийхээ үр дүнг үнэлэх эрх чөлөө ба чадвар (learners'agency)-ыг дэмжих боломжтой. Тэгш бус байдалд дүн шинжилгээ хийх ур чадварыг хөгжүүлэх, шүүмжлэлт ухамсрыг төлөвшүүлэх нь иргэдийн оролцоог дэмжих чухал арга зам бөгөөд энэ чиглэлд хүний эрхийн боловсрол нь иргэний боловсролыг тууштай дэмждэг.

Хүний эрхийн боловсрол нь үндэсний боловсролын тогтолцооны нийт үр өгөөжийг дээшлүүлж, улмаар эдийн засаг, нийгэм, улс төрийн тогтвортой, шударга хөгжлийг дэмждэг. Хүний үндсэн эрх, эрхэм чанар, эрх чөлөөний талаар бүх нийтийг гэгээрүүлэх замаар боловсрол өөрөө тэгш байдлын амлалтууд бүрэн дүүрэн биелдэг талбар болох ёстой. Хүний эрхийн болон иргэний боловсрол нь энх тайвны боловсролтой гүн гүнзгий нягт холбоотой. Олон тооны хам нөхцөлд хүчирхийлэл нь хүмүүсийн бие биетэйгээ харилцах гол арга зам болж байна. Хүн амынх нь бүхэл бүтэн бүлэг тухайлбал, эмэгтэйчүүд, хүүхдүүд ялгаварлан гадуурхагдаж, үг хэлний доромжлол, бие махбодын

хүчирхийлэлд өртөж, тэдний амьдрах, цэцэглэн хөгжих бололцоо нь эрс хязгаарлагдаж байна. Хамгаалах хууль тогтоомжууд, халамжийн байгууллагуудтай хамтран хүний эрхийн боловсрол нь санал зөрөлдөөнийг зөвшилцөл, дипломат арга замаар шийдвэрлэх боломжтой амар амгалан нийгмийг цогцлооход тусалж чадна.

Боловсрол нь нийтээрээ даган мөрдөх нийтлэг үйлийн хүрээнд хүмүүсийг хийж буй ажлаа эргэцүүлэн бодох, задлан шинжлэх, дүгнэж цэгнэхэд сургах замаар иргэний, нийгмийн, улс төрийн тогтвортой үйлүүд гүйцэтгэх чадавхыг бий болгодог. Сургалтын хөтөлбөр нь эвсэл бий болгох, мөн идэвхтэй үйл ажиллагаа, эв нэгдлийн томоохон түүх, замналтай холбоо тогтооход төвлөрсөн үед л хүмүүс харилцах явцдаа болон хамт олноороо шийдвэр гаргаж, түүнийхээ үр дүнг үнэлэх эрх чөлөө, чадвар (relational and collective agency) хүчтэй дэмжигддэг. Боловсрол нь нийтлэг орон зайд өрнөж буй урт хугацаанд үргэлжлэх бодол сэтгэлгээ, яриа хэлэлцээ, мэтгэлцээнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн болон хувирган өөрчлөлтийн үйлийг дэмждэг. Хүний эрхийн боловсрол нь хүн байх нь юу гэсэн үг вэ гэсэн мэтгэлцээн, дилемма (ацан шалаа)-г дэмжих ёстой бөгөөд гараг дээрх амьдралын ялгаатай хэлбэрүүдийг хадгалах ёс зүйн асуултуудыг хайж судлах ёстой.

Мөн улс төрийн шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээ ба ухуулга сурталчилгаа, шударга бус байдал ба хүний эрхийн зөрчлийн хяналт-шинжилгээ, түүнчлэн жендэр, арьс өнгө, уугуул иргэдийн ижилслийн өвөрмөц онцлог, хэл, шашин шүтлэг, нас, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа эсвэл иргэний статусаар ялгаварлан гадуурхаж буй харилцаанууд ба эрх мэдлийн бүтцүүдийг асуух, илчлэх, тэдгээрийн эсрэг зогсоход шаардлагатай ур чадвар, чадамжийг дэмжихэд чиглэх ёстой. Тиймээс боловсролын систем ба нийгмийн хөдөлгөөнүүдийн хоорондын яриа хэлэлцээ нь энэ асуудлын үндэс суурь нь юм.

Жендэрийн тэгш бус байдлыг шийдвэрлэхэд сургалтын хөтөлбөр бас чухал үүрэгтэй. Эрчүүдэд нийгмийн дийлэнх эрх ямба ба эрх мэдлийг олгодог үзэл суртлын тогтолцоо болох патриарх үзэл (patriarchy)-ийн өргөн тархсан нөлөө нь нийгэм ба сургууль дахь хүүхэд, залуучуудад илгээж буй мессеж ба сэтгэлгээний хэв маягт нөлөөлсөөр байна. Жендэрийн дарангуйлагч үүрэг роль, жендэрийн ялгаварлан гадуурхал нь нийгэм дэх хүн бүрд хортой. Тэгш байдлын суурь зарчмуудад хүн бага наснаасаа суралцах ёстой. Хөвгүүд жендэрийн тэгш байдлыг дэмжигч байхын тулд үүнд аль болохоор эрт суралцах хэрэгтэй бөгөөд эгч дүүс, эмэгтэй үе тэнгийнхнээсээ үл ялих ч болов давуу тал олгож болзошгүй айл өрхийн болон нийгмийн тэгш бус тогтолцоог үргэлжлүүлэн өвлөх ёсгүй. Охид, эгч нар нь гэр бүлдээ илүү үүрэг хариуцлага хүлээдэг, гэрийн ажилд илүү их хувь нэмэр оруулдаг гэсэн хүлээлт нь тэдний сургуулийн оролцоонд сөргөөр нөлөөлөхөөс гадна тэдний үнэт зүйлс, бусдад захирагдах үнэ цэнийн талаарх далд мессежийг өгч байдаг. Жендэрийн тэгш байдлын зарчмууд нь хүүхдүүдийн гэр, анги, сургуулийн хашаа, олон нийт зэрэг тэдний нийгэмшиж, сурч, амьдарч буй бүх орчинд мөрдөгддөг байх ёстой. Тэгш байдлыг дэмжих нь хүн бүрийн дэмжлэгийг шаарддаг хамтын хичээл зүтгэл юм.

Үүнтэй нэгэн адил утгаар сургалтын хөтөлбөрүүд нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг зогсож, уугуул ард түмэн, африк гаралтай угсаатнууд, үндэстний цөөнх зэрэг манай нийгэмд зэрэгцэн оршдог олон янз соёл, хэл ярианы гарал үүсэлтэй бүлгүүдийн талаарх хэвшмэл, ялгаварлан гадуурхсан дүрслэл, өгүүлэмжийг эсэргүүцэхэд чиглэх ёстой.

## Дээд боловсролын идэвхжүүлэх үүрэг роль

Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь боловсрол нь зөвхөн нийтлэг мэдлэгээс олж авах төдийгүй түүний цаашдын өсөлт ба илүү инклюзив оролцоотой байдлыг дэмжих арга замуудыг дахин төсөөлөхийг шаардана. Энэ нь нийтлэг мэдлэгийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг дээд боловсролоос илүү өөр хаана ч тод илрэхгүй. Одоогоор дээд боловсрол хөгжлийн олон жилийн түүхэндээ тодорхойгүй байдлын хамгийн аугаа том үеийн нэгийг туулж байна. Их сургуулиуд мэдлэг ба шинжилгээ судалгааны үйлдвэрлэлийн дэлхийн нөөц потенциалын ихэнх хэсгийг эзэмшдэг. Эрдэм шинжилгээ, инноваци, эрэл хайгуулыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, ирээдүйн хойч үеийн судлаач, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үүрэг хүлээсэн дээд боловсролын байгууллагууд нь нээлттэй шинжлэх ухаан, нээлттэй хандалтын бэлэн холбоотон юм.

### Нээлттэй нийтлэг мэдлэгт зориулсан их сургуулийн шинжилгээ судалгаа

Мэдлэгийг - олон тоон дээр - бүх нийтийн сайн сайхан аж байдлын төлөө хөгжүүлэх, ашиглах хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Бүс нутгуудын хэмжээнд бий болоод байгаа өнөөгийн мэдлэгийн нэгэн төрөл (homogenization) болсон байдал, тэгш бус хуваарилалтын эсрэг ажиллах хэрэгтэй. Их сургуулиудын шинжилгээ судалгаа нь өнөө цагийн эдийн засаг, улс төр, нийгмийн хэм хэмжээнд хайрцаглагдсан мэдлэгийг бий болгохын оронд ирээдүйн шинэ бололцоонуудад тэргүүлэх ач холбогдол өгөх нь зүйтэй. Энэ нь мэдлэгийн олон хэлбэр байдгийг хүлээн зөвшөөрч, өөр өөр хэлийг илүү ихээр ашиглахаас эхэлнэ. Ийм байдлаар их сургуулиуд нийтлэг мэдлэгийн цар хүрээг өргөжүүлэх, түүний инклюзив оролцоот байдал ба олон янз байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж чадна.

Их сургуулиуд хоорондын хамтын ажиллагаа болон олон улсын түвшинд хүргэх хүчин чармайлтууд нь нээлттэй байдлын тод жишээ бөгөөд дэлхий нийтийн түвшинд хамтын сайн сайхан аж байдлыг цаашид улам бүр ахиулах томоохон амлалт юм. Ирэх арван жилд их дээд сургуульд элсэгчдийн тоо тасралтгүй өсөхийг бүх тооцоолол төсөөлөл харуулж байна. Олон их сургууль суралцахуйн нийтлэг орон зайг бий болгох, засаглалаа уян хатан, олон нийтийн өмнө эгэх хариуцлага хүлээдэг болгох, нийтийн ашиг сонирхлыг дэмжих замаар боловсролыг нийтлэг зориулалттай байлгахад дэмжлэг үзүүлдэг талархууштай өгөөмөр уламжлалтай. Гэхдээ их дээд сургуулиуд бол өртөг зардлын саад бэрхшээл, оюуны өмчийн нэхэмжлэлээс болж ялангуяа, сүүлийн хэдэн арван жилд саад тотгор ихтэй газар болсон. Үүний эсрэг чиглэсэн хүчин чармайлтууд гаргаж байгаа хэдий ч дээд боловсролын систем нь хасагддаг, гадуурхагддаг газрууд хэвээрээ байна. Үүнийг яаралтай шийдвэрлэх ёстой.

Дээд боловсрол нь мэдлэг, шинжлэх ухааныг тухайлбал, академик шинжилгээ судалгааны тэтгэлэг, суралцахуйн материал, хэрэглэгдэхүүнүүд, программ хангамж, дижитал холболт болон бусад зүйлийг үнэ төлбөргүй, нээлттэй, хүртээмжтэй болгохын төлөө тууштай тэмцэгч байх хэрэгтэй. Хамгийн чухал нь “нээлттэй” гэсэн нэр томъёо нь зөвхөн

Дээд боловсрол нь мэдлэг, шинжлэх ухааныг үнэ төлбөргүй, нээлттэй, хүртээмжтэй болгохын төлөө тууштай тэмцэгч байх хэрэгтэй.

хүртээмжийн боломжтой, энгийн хялбар байдлыг илэрхийлээд зогсохгүй хувь хүмүүс мэдээлэл ба мэдлэгийг өөрчлөх, чадварлагаар удирдах боломжтой байх гэсэн утгатай юм.

### **Техникийн болон мэргэжлийн дээд боловсрол ба нийтлэг мэдлэг**

Дунд сургуулийн дараах техник, мэргэжлийн боловсролын байгууллагууд, тэр дундаа олон нийтийн коллеж, политехникийн сургуулиудыг зөвхөн сургалтын байгууллага төдийгүй хэрэглээний судалгаа явагддаг газар гэж үзэх ёстой. Боловсролын эдгээр байгууллагууд нь бидний хувь хүний болон хамт олны амьдралд үзүүлэх бүтээмжийн нөөц чадваруудын ач холбогдол, суралцагч нийгэм хэрхэн ажиллаж байгаагийн үр өгөөж, утга учиртайгаар ажиллаж хөдөлмөрлөх олон арга зам, янз бүрийн секторууд ба олон нийт хоорондын интеграци, түншлэл, хамтын ажиллагааны нөөц потенциалыг дайчлахад тус тус чухал ач холбогдол өгөх ёстой. Олон нийттэй нягт харилцаатай мэргэжлийн боловсролын байгууллагуудын орон нутгийн шинжтэй байх чанар нь суралцахуйн тухайн орон нутгийн соёлыг тэтгэн хөгжүүлэх боломжийг олгодог. Орон нутгийн нийгэмлэгүүд нь нийтлэг мэдлэгтэй өвөрмөц холбоотой байдаг бөгөөд техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагууд нь энэ мэдлэгийг хэрэглэх тухай гүн гүнзгий ойлголтыг өвөрмөцөөр, хам нөхцөлдөө нийцсэн байдлаар хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна.

### **Мэдлэг бүтээх олон янз арга хандлагыг дэмждэг дээд боловсрол**

Дээд боловсрол, соёл хоорондын, мэдлэгийн онол-эпистемийн олон янз байдлууд хоорондын харилцаа нь ихэвчлэн нэг утгатай байж ирээгүй ээ. Нэг талаас, дээд боловсрол нь оюутнуудыг ертөнцийг үзэх шинэ үзлүүд болон шинэ санаануудтай танилцуулж байгаагаараа бахархдаг. Гэвч үүний зэрэгцээ дээд боловсрол нь мэдлэг үйлдвэрлэлийн тодорхой хэлбэрийг зохион байгуулах, тохирцыг баталгаажуулах, хууль ёсны болгох өвөрмөц арга замуудыг боловсруулсан.

Байгалийн шинжлэх ухааны аргууд болон нийгмийн шинжилгээ судалгааны “хатуу чанд байдал”, “найджартай байдал”, “тохирсон байдал” гэх мэт үзэл баримтлалууд нь соёлын хувьд төвийг сахисан байр суурьтай байдаггүй. Эрдэм шинжилгээний бүтээлийн хэвлэлийн нийгмийн үйл явцууд, чанарын баталгаа, эдийн засаг нь ихэнхдээ соёл хоорондын болон эпистемийн олон янз байдлыг урамшуулдаггүй. Уугуул иргэдийн мэдлэгүүд, мэдлэгийг бий болгох, хуваалцах арга хэлбэрийг ерөнхийдөө судалгааны арга хэлбэр гэхээсээ илүү судалгааны объект гэж үздэг.

Мэдэх ба хийх арга замууд дахь олон ургалч байдал улам бүр дэлгэрч байгаагийн хэрээр соёл ба туршлагын арвин баялгаас урган гарсан мэдлэгийн экосистем нь илүү үнэ цэнтэй болох болно. Дэлхийн өнцөг булан бүрд байгаа дээд боловсролын байгууллагууд ба олон нийтийн түншлэл жинхэнэ утгаараа харилцан бие биетэйгээ уялдаатай байх ёстой. Хүчирхэг болон тогтвортой байдлын эх үүсвэр болох мэдэх ба хийх арга замуудын олон ургалч байдлыг нээлттэйгээр хүлээн авах нь дээд боловсролын салбарын өөрийнх нь дотор байдаг зарим тэгш бус хэмийг багасгахад тусална.

Дээд боловсролын ландшафтын хүрээнд институцийн төрөл зүйлийг зохих ёсоор нь үнэлснээр түүний олон янз байдлыг дэмжиж чадна. Хэрэв дээд боловсролын хүртээмж цаашид өргөжин тэлсээр байх юм бол бидэнд олон төрлийн институтүүд хэрэгтэй болно. Түүнчлэн нийтлэг

мэдлэгийн нээлттэй байдал нь аль болох олон хүнийг хандах боломжоор хангадаг дээд боловсролын уян хатан бүтцийг шаарддаг.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд



Энэ бүлэгт боловсролын нийгмийн шинэ гэрээнд сургалтын хөтөлбөрүүд нь сурагчдад мэдлэг олж эзэмших, үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ, тэдний шүүмжлэлт сэтгэлгээ, мэдлэгээ хэрэглэх чадавхыг хөгжүүлэхэд нь тусалдаг экологийн, соёл хоорондын болон судлагдахуун хоорондын суралцахуйг онцгойлон чухалчлахыг санал болгосон. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг урагш ахиулахад хэрэгтэй яриа хэлэлцээ, үйл ажиллагааг удирдан чиглүүлж чадах дараах дөрвөн зарчим байна.

- **Сургалтын хөтөлбөр нь суралцагчдын нийтлэг мэдлэгийг хүртэх болон түүнд хувь нэмрээ оруулах чадамжийг нэмэгдүүлэх ёстой.** Хүн төрөлхтний үе үедээ хуримтлуулсан хамтын мэдлэгийн нөөц нь боловсролын сургалтын хөтөлбөрийн үндэс суурийг бүрдүүлэх ёстой. Нийтлэг мэдлэг нь түүнээс авах, түүнийг нэмэгдүүлэх өргөн боломж олгохуйц хүртээмжтэй байх чухал юм. Бид сурагчдыг (бүх насны) мэдлэгт бүтээлчээр, шүүмжлэлтэй ханддаг, түүний дэвшүүлж буй таамаглал, сонирхолд эргэлздэг болгож сургах нь зүйтэй. Боловсрол нь хүмүүст нийтлэг мэдлэг дэх орхигдуулсан, хасагдсан зүйлсийг засаж залруулах боломжийг олгох ёстой бөгөөд энэ нь дэлхий ертөнцийг мэдэх, дэлхий дээр оршин байх арга замуудын олон янз байдлыг тусгасан, өнө удаан үргэлжлэх, нээлттэй эх сурвалж байх учиртай.
- **Экологийн хямрал нь дэлхий дээрх хүн төрөлхтний байр суурийг үндсээр нь өөрчлөх сургалтын хөтөлбөрийг шаардаж байна.** Үр өгөөжтэй, нийцтэй уур амьсгалын өөрчлөлтийн боловсролыг нэн тэргүүнд тавих зүйтэй. Сургалтын хөтөлбөрөөр дамжуулан бид хүний үйл ажиллагаанаас шалтгаалан гэмтэн сүйдэж байгаа гараг дээр хүндэтгэлтэй, хариуцлагатай амьдрах урлагт сургах ёстой.
- **Шинжлэх ухаан, дижитал болон хүмүүнлэгийн бичиг үсэгт тайлагдах замаар ташаа мэдээлэл түгээхийн эсрэг ажиллах хэрэгтэй.** Сургалтын хөтөлбөрүүд нь шинжлэн судлах эрэл хайгуулыг болон нарийн нягт судалгааг худал хуурмагаас ялгах чадамжийг чухалчлах нь зүйтэй. Бид суралцагчдад технологийг утга учиртайгаар ашиглах боломж олгодог дижитал ур чадварыг хөгжүүлэх нь чухал. Сургалтын хөтөлбөрүүд нь сурагчид шинжлэх ухаан, технологийг хэрхэн, ямар шалтгаант зорилгоор ашиглахыг тодорхойлоход оролцож, тодорхой үүрэг гүйцэтгэх замаар тэдгээрт “нөлөөлөх” чадамжтай болох баталгаагаар хангах ёстой.
- **Хүний эрх, ардчилсан оролцоо нь хүмүүсийг болон дэлхийг хувирган өөрчилдөг суралцахуйн гол блокууд байх ёстой.** Бид суралцагчдын бие даан шийдвэр гаргаж, түүнийхээ үр дүнг үнэлэх эрх чөлөө ба чадварыг дэмждэг, хүн бүрийг хүлээн зөвшөөрдөг, хөгжин цэцэглэх боломж нь хангагддаг ёс суртахууны ертөнцөд нэвтрэх гол цэгийг санал болгодог хүний эрхийн боловсролд тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой. Сургалтын бүх хөтөлбөрт жендэрийн тэгш байдлыг тусгаж, жендэрийн дарангуйлагч хэвшмэл ойлголтыг арилгах хэрэгтэй. Сурагчид арьс өнгөөр болон бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхахын эсрэг шууд сөрөн зогсож, хэрхэн тэмцэх талаар суралцах нь чухал юм.

Эдгээр дөрвөн үндсэн зарчим нь боловсролын нийгмийн шинэ гэрээг боловсролын практик болгон хувиргахад түлхэц болж, урам зориг өгч чадна.

## Бүлэг 5

# Багшийн хувирган өөрчлөх ажил

 “Багш нь мэргэн үнэнийг олж авах давуу эрхтэй байх албагүй. Тэрээр сурагчдынхаа нэгэн адил, байх учиртай хүн болох шатандаа явж байна.” 

**Вэй-мин Ту (Wei-ming Tu)**, *Хүн төрөлхтөн ба өөрийгөө хөгжүүлэх, 1996 он.*

**Боловсролын нийгмийн шинэ гэрээнд багш нарт гол анхаарлаа хандуулж, тэдний мэргэжлийг боловсрол, нийгмийн хувирган өөрчлөлтийг авчрах шинэ мэдлэгийг өдөөж сэрээдэг хоршин ажиллах хамтын хичээл зүтгэл гэж дахин үнэлж, дахин төсөөлөх ёстой.**

Боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахад багш нар өвөрмөц онцгой үүрэг хүлээнэ. Багшлах нь олон нийт болон хувь хүмүүсийн хоорондын хурцадмал байдлын дор хөдөлмөрлөдөг нарийн нийлмэл, ээдрээтэй, бэрх мэргэжил юм. Багш нар яриа хэлэлцээгээр нийтлэг мэдлэгийг идэвхжүүлэхийн тулд ирээдүйг өвлөн авах, хамтран бүтээх залуу хойч үеийнхэнтэй хоршин ажилладаг. Багшлахуй нь сурагч бүрийн хосгүй өвөрмөц хэрэгцээ, чадавхад хүрч ажиллахын зэрэгцээ бүлгээр ажиллахыг хамардаг. Эдгээр хурцадмал байдал, парадоксууд нь багш нарын орлуулшгүй хөдөлмөрийг тодорхойлдог.

Багшлах нь нигүүлсэх ариун сэтгэл, цогц чадамж, мэдлэг, ёс зүйн шийдэмгий байдлыг шаарддаг. Ухаалаг, эрдэмтэй хүмүүс дэлхийн соёлд хүлээн зөвшөөрөгдсөөр ирсэн бөгөөд энэ уламжлалаар “багш” нь сургуулийн хам нөхцөлд мэргэшсэн тоглогчийн үүрэг гүйцэтгэдэг. Багш нар бол хувирган өөрчлөлт хийх бололцоотой гол хүмүүс юм. Тэд сурган хүмүүжүүлэх нүүр тулсан уулзалтаар дамжуулан сурагчдынхаа оролцох, хоршин ажиллах, суралцах үйлийг таньж мэдэх ёстой. Энэхүү нарийн төвөгтэй ажлыг гүйцэтгэхийн тулд багш нарт зохих эрх чөлөө, дэмжлэг бүхий баялаг хоршин ажиллах хамтын нийгэмлэг хэрэгтэй. Багш нарын бие даасан байдал, хөгжил, хорших ажиллагааг дэмжих нь боловсролын ирээдүйн төлөөх олон нийтийн эв нэгдлийн чухал илэрхийлэл юм.

Энэ бүлэг нь олон янз суралцагчдад зориулсан боловсролын олон талт ажлыг хүчирхэгжүүлдэг багийн ажил болон мэргэжилтнүүдээр дамжуулан цэцэглэн хөгжиж, хувьсан өөрчлөгдөж үйлдэгддэг, “хоршин ажиллагч мэргэжил (collaborative profession)” болох багшлахуйн ирээдүйг дахин тодорхойлохоос эхэлнэ. Багш нар рефлексив дадлагажигч, мэдлэг бүтээгч гэдгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд тэд боловсролын орчин, бодлого, шинжилгээ судалгаа, практикийг өөрчлөхөд шаардлагатай мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Дараа нь, тус бүлэгт боловсролын нийгмийн шинэ гэрээний цаад утгыг багшийн хөгжлийн мөчлөгийн бүхий л хугацаанд буюу ажилд орохоос эхлээд шинэхэн дагалдангаар ажиллах, туршлагатай баталгаатай дадлагажсан мэргэжилтэн болох хүртэлх өөр өөр цаг үе болон орон зайд бие даан болон бусад хүмүүсийн хамт хийсэн аялал хэмээн авч үзэх болно.

Энэ бүлэг нь сургууль, хамт олон, гэр бүл, удирдлагууд, дээд боловсрол, улс төрийн байгууллагууд багш нараа тойрон нэгдэж, тэдний ажлын ач холбогдлыг ухамсарлаж, амжилтад хүрэх орчин нөхцөлийг бүрдүүлэхийн чухлыг тэдэнд хандан уриалсан. Энэ нь багш нарын хорших ажиллагааг дэмжих, мэдлэгийг бий болгохыг чухалчлах, багшийн бие даасан байдал болон боловсролын талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох оролцоог дэмжих зэрэг багш нар, сургуулийн удирдагчид, засгийн газруудын анхаарлыг татсан яриа хэлэлцээ, үйл ажиллагааны 2050 үндсэн зарчмуудыг багтаасан.



## Багшлахуйг хоршин ажиллагч мэргэжил болгон хувиргах нь

Өөр өөр цаг үе, газарт багш нар өргөн хүрээний нийгмийн үүрэг роль, чиг үүрэгтэй байдаг. Багш нарын үүрэг ролийн талаарх үзлүүд нь соёлын хувьд харилцан адилгүй байдаг, жишээлбэл, тэд төрийн албан хаагч ба ардын сэхээтэн, мэргэжилтэн ба уран бүтээлчид, олон нийтийн удирдагчид ба өөрчлөлтийг бүтээгчид, ёс суртахууны хүч чадалтай хүмүүс ба ирээдүйн итгэлийг даагч байж болно. Шашны удирдагчид, эрдэмтдээс эхлээд эртний философич, математикч хүртэл бүгд эргэн тойрныхоо хүмүүсийг сургахын зэрэгцээ хүн төрөлхтний өвлөн авсан мэдлэгийг шинэ өндөрлөгт хүргэсэн бөгөөд хүн төрөлхтний хамгийн агуу түүхэн зүтгэлтнүүдийн ихэнхийг багш гэж тодорхойлсон байдаг.

Түүхийн хувьд багш нар XIX-XX зууны боловсролын нийгмийн гэрээг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэд нийгэмтэй харилцах харилцаанд болон сургуулиар суралцахуйн аль алинд нь массыг хамарсан заавал эзэмших боловсролыг бий болгож бэхжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Эртнээс багш нар нь ихэвчлэн анхны улсын сургуулийг санаачлагч, сурган хүмүүжүүлэгч нь байсны хувьд анхны шан татагчид байсан. "Хэвийн сургууль (normal school)" гэсэн анхны тодорхойлолт нь тэднээс сургуулийн стандарт бүтэц, сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүй, ердийн ажлыг нормчлохыг хүсэж байсан нь харагдаж байна. Стандартчилал, загварчлал нь бусад сургуулиудад жишиг болохуйц норм, хэв маягийг бий болгох ёстой байв. Өнгөрсөн зууны энэ ажил нь дэлхийн хэмжээнд АНУ-аас Хятад хүртэл, Бразилаас Энэтхэг хүртэл багшийн боловсролын байгууллагуудыг нэгдэл нягтралаар харагдаж байна.

Сургуулийн боловсрол нэмэгдэхийн хэрээр багш нар өөрсдийн ажил, үүрэг, алдар гавьяаны гол төлөөлөгч болсон. Үүнтэй нэгэн адил боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгдэх болсноор "нэг өрөө (one room)" загвараар насны бүлгээр ангилан янз бүрийн ангид хуваарилсан сургуулиуд үйлдвэрлэгдэн бий болов. Гэвч сургуулиар суралцахуйн энэхүү өргөтгөсөн "өндөгний хайрцаг (egg crate)" загвар нь хичээлийн төлөвлөгөө, сургалтын материалаа урьдын адил бие даан хувиараа хариуцдаг багш нарын үүрэг ролийг дахин төсөөлж шинэчлээгүй бөгөөд тэдэнтэй харилцах нь ч ховор байсан. Энэ загвар нь багш нарын тогтворгүй байдлыг нэмэгдүүлж, тэдэнд дарамт шахалт болсоор байна.

Багш нарын хувь хүний авьяас, чадамжийг хорших ажиллагаа болон шаардлагатай дэмжлэгээр бэхжүүлэх хэрэгтэй. Бидний хамтын ирээдүйн боловсролын нийгмийн энэхүү гэрээнд дахин тохируулга хийхэд багш нар гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд цаашид ч гүйцэтгэх ёстой. Хамтын ажиллагаа, хорших ажиллагаа нь багшийн ажлын горим, арга барилд хэр зэрэг нэвтэрч байгаа нь үүнийг хийх тэдний чадамжид шууд нөлөөлнө.

Багш нарын хувь хүний авьяас, чадамжийг хорших ажиллагаа, шаардлагатай дэмжлэгээр бэхжүүлэх хэрэгтэй.

## Инклюзив боловсролын орчин дахь багш нар

Сурагчдыг дэмжихийн тулд багш нар сургуулийнхаа багш нар болон бусад мэргэжилтнүүдтэй хоршин ажиллаж, сурагч бүрд сурахад нь дэмжлэг үзүүлэх ёстой. Боловсрол бол багшийн гоцлох ажил гэсэн ойлголт нь ганц хувь хүн биелүүлэх боломжгүй шаардлагыг тавьж, олон хүнийг мэргэжлээ орхиход хүргэдэг. Үүний зэрэгцээ сурагчдын бие бялдар, нийгэмшил, сэтгэл санааны хэрэгцээ нь тэдний суралцах чадамжийн салшгүй хэсгүүд байдаг. Бусад зайлшгүй үйлчилгээ бүхий багшийн ажлын үр өгөөжийг нэмэгдүүлдэг тогтолцоогоор сурагчдыг дэмждэг байх шаардлагатай. Үүнд эрүүл мэнд, хоол тэжээл, нийгмийн үйлчилгээ, сэтгэцийн эрүүл мэнд, суралцахуйн тусгай хэрэгцээнд үзүүлэх дэмжлэг хамаарна. Ялангуяа, түүнд хүүхдийнхээ боловсролыг дэмждэг гэр бүлийн үр өгөөжтэй оролцоо багтана.

Багш нар багаар ажиллах ирээдүйтэй санаачилгууд гарч ирж байна. Жишээлбэл, зарим сургуулиуд өргөн хүрээг хамарсан суралцагчдыг хэл, уран зохиол дээр хэрхэн сургах талаар хүн бүрийн гүн гүнзгий ойлголт, санаа, ажиглалтыг хуваалцах боломж олгосон ангийн багш, бичиг үсгийн мэргэжилтэн, тусгай боловсролын багшаас бүрдсэн нэгдсэн төлөвлөлтийн баг байгуулж ажилладаг. Хамтран багшлах ийм түншлэлээр багш нар сурагч бүрийн тусгай хэрэгцээг хангаж ажиллахын зэрэгцээ ангийн хамт олонч хандлагыг урагш ахиулдаг. Бусад жишээ гэвэл, төрийн үйлчилгээний болон ашгийн төлөө бус байгууллагууд нь сурагчдын суралцахуйн ерөнхий байдал, эрүүл мэнд, сайн сайхан аж байдлыг дэмжихийн тулд сурагчид болон гэр бүлүүдтэй нь сургуулийн анги танхимаас гадуур холбоо тогтоох замаар тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд сургуулиудтай зэрэгцэн ажилладаг. Сурагч бүрд халамжлан хүмүүжүүлэгч, зөвлөгч, мэргэжилтэн, туслах багшаас авхуулаад шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлэх ирээдүйтэй тоо томшгүй олон арга хандлагууд байдаг.

Ийм хоршин ажиллах бололцоонуудыг тооцож үзвэл олон талт байршил, оролцоо бүхий боловсролын шинэ ландшафтын бүтээн байгуулалтад багш нарын уриалан холбогч үүрэг ролийг илүү сайн ойлгож чадна. Эдгээр шинэ орчин нь тохиолдлын үр дүн биш, харин орон нутаг бүрд системтэй, зориудаар хийгдсэн ажил юм. Орон нутгийн удирдагчид, ахмадууд, эрх баригчид, олон нийт, гэр бүлүүд бүгд өөрийн гэсэн гүйцэтгэх чухал үүрэгтэй. Багш нарын бүрдүүлсэн суралцах орчинд сурагчдын бий болгодог ер бусын өвөрмөц динамикийг нийгмийн ажилтнууд, чиглүүлэгч зөвлөхүүд, тусгай боловсролын нөөцүүд, номын санчид, бичиг үсгийн мэргэжилтнүүд нь улам бүр бэхжүүлж чадна.

Сургуулийн эргэн тойрон дахь боловсролын орчин нь суралцахуйн орон зайн сүлжээг багтаах ёстой. Сургууль доторх болон гадуурх анги танхимын сургалт мөн хичээлээс гадуурх үйл ажиллагаа хоорондын ялгааг бүдгэрүүлэх эсвэл арилгах нь зүйтэй. Багш нар эдгээр сүлжээг хадгалах холболтыг дизайнчилах, бүтээж бий болгоход гол үүрэг гүйцэтгэдэг боловч үүнийг үр өгөөжтэй хийхийн тулд тэдний ёс суртахуун, ижилслийн болон ялгагдан танигдах өвөрмөц шинжүүдэд шилжилт хийх шаардлагатай байна. Боловсролын шинэ экосистем, суралцахуйн орон зайн сүлжээнд оролцогчдыг холбогч, тэднийг нэгтгэн зохион байгуулагч эзэд болохынхоо хувьд нийгмийн болон институцийн энэхүү үүргийнхээ дагуу багш нар, тэдний хамт олон боловсролын ирээдүйг тодорхойлох чухал зуучлагчид болж байна.

Багшлах гэдэг нь ангийн хаалттай хаалганы цаана үйл ажиллагаа эсвэл хичээлээр сурагчийг удирдан чиглүүлдэг хувь хүн биш юм. Үүний оронд бид багшлах ажлыг сургууль даяар бусад сурган хүмүүжүүлэгчидтэй хамтран хийдэг ажил гэж үзэх хэрэгтэй. Анги танхимд төвлөрч байснаа суралцагч байгууллага болох сургуульд төвлөрөх шилжилт нь тийм ч амар байдаггүй. Үнэндээ, сургуулийн уян хатан бус байдал нь багшийн мэргэжлийн хорших ажиллагааны үйл явцыг хүндрүүлдэг. Хоршин ажиллах санаа нь хувь хүмүүсийн үүрэг хариуцлага, ач холбогдлыг бууруулдаггүй. Харин ч сургуулийн бүх орон зайд хамтаараа ажиллах шинэ үүрэг хариуцлагыг хүлээж, сургуулийн менежмент ба удирдах чиглүүлэлтэд хувь хүний өргөтгөсөн үүрэг роль гүйцэтгэдэг. Хоршин ажиллахыг хүчлэх нь үр ашиггүй бөгөөд сөрөг үр дагавартай юм. Хорших ажиллагаа мөн чанараараа аяндаа хөгжих хөгжлийг тэтгэхийн тулд сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүйн зохион байгуулалтад өөрчлөлтүүд оруулах ёстой. Хэрэв бүх боловсролыг танхимд лекц унших багш нартай байхаар зохион байгуулбал хоршин ажиллах нь хэнд ч хэрэггүй болно. Гэхдээ хэрэв суралцахуйг асуудалд болон төсөлд суурилан орон зай, цаг хугацааны олон янз байдалтай байхаар зохион байгуулбал хорших ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно.

Багшлах гэдэг нь ангийн хаалттай хаалганы цаана үйл ажиллагаа эсвэл хичээлээр сурагчийг удирдан чиглүүлдэг хувь хүн биш юм.

### Хөтөлбөр болон сурган хүмүүжүүлэх арга зүйг урьдчилан төсөөлж, баталгаажуулан хэрэгжүүлэх нь

Сургалтын хөтөлбөр нь зөвхөн дизайнчилсан, жор төдий зөвлөмж биш, харин албан ёсоор баталгаажуулж, хэрэгжүүлдэг зүйл юм. Нээлттэй, нийтлэг мэдлэгт суурилсан сургалтын хөтөлбөрийн шинэ хэлбэрүүдийг төсөөлж, хэрэгжүүлэх нь багш нарын ажиллагаанаас ихээхэн хамаарна. Дижитал технологи нь маш олон бололцоог санал болгодог хэдий ч инновацууд нь өвөрмөц хам нөхцөлүүд дэх сурагчдын тодорхой хэрэгцээ, шинж чанарыг хангахад зориулагдсан тохиолдолд л амжилтад хүргэх магадлал өндөртэй байдаг. Суралцахуйг хувь хүний үйл болгон хувиргахад багш нар чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ суралцахуй нь жинхэнэ чин сэтгэлээсээ бас нийцтэй байх нь чухал. Сурагчдад дасан зохицох, бүтээн туурвих, дизайнчилах суралцахуйн хамгийн сайн боломжуудыг бүрдүүлэхийн тулд багш нарт эрх чөлөө, тохиромжтой орчны бэлтгэл, зааварчилгаа материалын нөөцүүд, дэмжлэгүүд хэрэгтэй. Ирээдүйн сургалтын хөтөлбөрүүд нь багш нарыг өргөн хүрээний бие даасан байдлаар хангах ёстой бөгөөд энэ нь үе тэнгийнхэнтэйгээ хоршин ажиллах баялаг туршлага болон их сургуулийн профессор, эрдэмтэд зэрэг тухайн судлагдахууны мэргэжилтнүүдтэй тогтоосон түншлэлээр бий болох хүчирхэг нэмэлт дэмжлэг түүний дотор санал болгох технологиор дэмжигдэх ёстой.

Оролцооны болон хамтран ажиллах арга хандлагад суурилсан сурган хүмүүжүүлэх арга барил нь зөвхөн анги доторх хамтын суралцахуйгаар бус, харин анги танхим болон хамтдаа суралцагч олон нийт хоорондын хамтын суралцахуйгаар дамжиж “цоморлогоо нээдэг”. Багш нарт тулгардаг зарим нарийн төвөгтэй сорилт бэрхшээлүүдийг тэд бие даан шийдвэрлэх боломжгүй ч энэ тохиолдолд сургуулиудын сүлжээ, их дээд сургуулиудтай тогтоосон түншлэл эсвэл боловсролын тусгай байгууллагуудын дэмжлэгтэй мэргэжлийн нийгэмлэгүүдээр шийдвэрлэх боломжтой. Өндөр чанартай суралцахуйн туршлагаудыг дизайнчилахын тухайд багш нар бусадтай буюу судалгааны

бүлэг, багш нарын зөвлөл, сурган хүмүүжүүлэх баг, мэргэжил нэгтэй үе тэнгийнхний зөвлөгөө, дасгалжуулалт, ажиглалт, сайтаар зочлох зэрэг хамтран ажиллах олон арга замууд байдаг.

## Багш нарын оролцоогүйгээр сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүйг дахин төсөөлөх боломжгүй.

Багшлах мэргэжлийн мэдлэг (professional teaching knowledge) нь онолын болон практикийн яриа хэлэлцээнд тулгуурлан бүтээгдэж, өсөн нэмэгдэж буй туршлагын сан хөмрөгийн репертуарын талаарх хувь хүний болон хамт олны байнгын эргэцүүлээр хөгжиж байдаг. Сурган хүмүүжүүлэх хоёр ижилхэн нөхцөл байдал хэзээ ч байдаггүй бөгөөд энэ нь багш нарын харилцаа дээр суурилсан ажлыг хамгийн боловсронгуй техникээр ч орлуулж болдоггүй зүйлийн нэг хэсэг болгодог. Сурган хүмүүжүүлэх ухаан нь сурагч бүрд мэдлэгтэй харилцах хүний харилцааны нэг хэсэг болж, ойлгомжтой, бүтээлч, мэдрэмжтэй ертөнцөд нэвтрэх боломжийг олгодог зүйл юм. Багш нарын оролцоогүйгээр сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга зүйг дахин төсөөлөх боломжгүй.

### Багш нар ба боловсролын шинжилгээ судалгаа

Багш нарын эргэцүүлэн бодох хамгийн чухал асуудлын нэг бол мэдлэгтэй харилцах харилцаа юм. Зарим хүмүүсийн хувьд хамгийн чухал зүйл бол заах судлагдахууны маш сайн мэдлэг байдаг бол бусад хүмүүсийн хувьд дидактик, сурган хүмүүжүүлэх мэдлэг нь тэргүүн эгнээнд ордог. Гурав дахь төрлийн мэдлэг бол багшлахуйн мэргэжлийн мэдлэг юм. Аливаа мэргэжлээр дадлагажигч нар системтэй туршилт болон туршлага, дадлагын үнэлэлт дүгнэлтийн үр дүнд экспертийн мэдлэгийг бий болгож, олон нийтэд түгээхэд хувь нэмэр оруулдаг.

Дадлагад суурилсан мэдлэг нь багш нар өөрсдийгөө ижилсэл болох эргэцүүлэгч-дадлагажигч хэмээн үздэг тэдний мэргэжлийн төлөвшилд амин чухал юм. Хувь хүний түвшинд багшлахуйн мэргэжлийн мэдлэг нь зөн совин, практик, харилцааны гэсэн хэмжээсүүдтэй байдаг. Хоршин ажиллах багшлахуй нь мөн чанартаа мэргэжил нэгтэй үе тэнгийнхний дундах эргэцүүлэн бодох ба хуваалцах хэмжээсийг аяндаа интеграцчилдаг. Энэхүү судалгааг бичигт хөрвүүлж, түүний зохиогч нь багш нар болох явдал улам бүр нэмэгдэж болно. Аливаа мэргэжил нь зөвхөн өв уламжлал, туршлага, дадлагаа баримтжуулан бүртгүүлээд зогсохгүй, мөн эрэл хайгуул, инновацын шинэ хил хязгаарыг тогтоож, судалгааны асуултуудыг тодорхойлж, тэдгээрийн араас мөшгөн хэрэгжүүлэх шаардлагатай. Багш нар эргэцүүлэн дадлагажигч, мэдлэг бүтээгч гэж хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд мэргэжлийнхээ хүрээн дэх болон мэргэжлээсээ гадуурх боловсролын орчин, бодлого, судалгаа, практикийг хувирган өөрчлөхөд хэрэгтэй мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

## Амьдралд уягдсан багшийн хөгжлийн замнал

Дэлхий дээр багш нарыг үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь бэлтгэх өргөн хүрээний тогтолцоо, байгууллагууд бий. Гэрчилгээжилт эсвэл хуримтлуулсан туршлагаас үл хамааран багш нарын мэргэжлийн ижилсэл, чадавх, мэргэжлийн хөгжил нь хэзээ ч “дуусдаггүй” эсвэл “бүрэн төгс” болдоггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Багшийн хөгжил бол амьдралд уягдсан, насан туршдаа суралцан туршлага хуримтлуулж, тасралтгүй үргэлжлэн баяжиж байдаг динамик үйл явц юм.

Багш нарын хувь хүний болон соёлын хэмжээсийг мөн хүлээн зөвшөөрч, үнэлж байх ёстой. Багш байхын тулд өөрийн туршлагын репертуарыг өргөжүүлэхийг, мөн мэдлэг, бодол санааны ертөнцтэй холбогдохыг шаарддаг. Багш идэвхтэй уншигч биш бол сурагчдын дунд ном уншихыг сурталчилж чадахгүй. Үүний нэгэн адил шинжлэх ухааныг сониучлах, сонирхохгүйгээр шинжлэх ухааныг үр дүнтэй заах боломжгүй юм. Сурагчид багш нарын хэлсэн үгнээс ихийг сурдаг шиг тэдний амьдралын жишээнээс ч ихийг сурдаг.

Багш бүрийн “амьдралын номын сан” нь тэдний ажиллах үндэс суурь юм. Үнэндээ суралцах болон соёлоо баяжуулах яг энэ баяр баяслын хүрээнд багш нар амьдралд уягдсан боловсролын зуучлагчид болдог бөгөөд үүгээрээ дамжуулан бусад хүмүүс болон амьд гарагтайгаа баяр хөөр, эв нэгдлийн шинэ хэлбэрүүдийг бий болгоход хувь нэмрээ оруулж чадна.

### Багшийн ажилд авах нь

Зарим хүмүүсийн хувьд багш болох замнал нь боловсрол эзэмшсэн цагаас нь эхэлдэг. Бусад нь хожмоо амьдралынхаа явцад ямар нэг шалтгаанаар карьерын бусад замналаас шилжиж болзошгүй боломжуудыг олж харж болно. Сүүлийн гучин жилийн хугацаанд сургуулиар суралцахуйг их хэмжээгээр өргөжүүлсэн нь ажил горилогчдыг урьд өмнө тооцож байснаас хамаагүй илүү өргөн хүрээгээр ажилд элсүүлэхэд түлхэц болсон. Энэ нь зарим газарт багш мэргэжлээр эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх эерэг ашиг тустай байсан бол, зарим хам нөхцөлд мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн багш нарын эзлэх хувь буурах, цалин хөлс, нийгмийн статусыг бууруулах, халамжийн системийг хүчин чадлаас нь хэтрүүлэх зэрэг сөрөг үр дагавруудыг авчирсан.

Олон газар багш нарт тавигдах шаардлага нэмэгдэж, чадварлаг хүмүүсийг ажилд авахад нөлөөлсөн. Багшлах ажлын дарамт, эрсдэл, бэрхшээл нь багшлах хүсэлтэй хүмүүсийн сонирхол, хүсэл тэмүүллээс давж, улмаар энэ мэргэжлээр элсэгчдийн тоо мэдэгдэхүйц буурч байна. Үүний зэрэгцээ эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байна: ТХЗ 4-ийн товлосон зорилтуудыг биелүүлэхийн тулд 2030 он гэхэд дэлхий даяар 70 сая орчим бага, дунд боловсролын шинэ багш ажилд авах шаардлагатай болно. КОВИД-19 тахлын үеэр энэ нөхцөл байдал улам дордсон бөгөөд багшийн мэргэжлийг орхисон хүмүүсийн дутагдлыг нөхөхөд илүү их хүн шаардлагатай болно. Бодитой өөрчлөлт хийхгүй бол хомсдолыг арилгахад шаардлагатай олон тооны багш болох хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийг татахад хэцүү байх болно. Энэ нь төрийн бодлогын болон нийгэм бүхэлдээ яаралтай шийдэх асуудал байх болно.

Энэ нөхцөл байдал нь ялангуяа, улс орнууд, бүс нутгуудын хооронд тэгш бус байна. Сургуулийн насны хүн ам хамгийн хурдацтай өсөж буй бүс нутаг болох Сахараас урагших Африкт багшийн хомсдол хамгийн их байна. Ирээдүйн багш нарын шинэ боловсон хүчний багшлах чадавхыг нэмэгдүүлэхийн тулд яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна. Асар их авьяас чадвар байгаа хэдий ч хангамж, нийлүүлэлтийн талын саад бэрхшээл нь олон салбарт ялангуяа, дээд боловсрол эзэмших боломжууд хязгаарлагдмал улс орнуудад гэрчилгээ, мэргэшлийг олж авах боломжийг хязгаарладаг. Орон нутгийнхантай хоршин ажиллах баялаг нөөц потенциалд тулгуурлан орон нутгийн чадавхыг бэхжүүлэхийн тулд багшийг сонгон шалгаруулах, хөгжүүлэх бүтээлч хандлагыг анхаарч үзэх хэрэгтэй.

Гол төлөв тэгш бус байдлаас үүдэлтэй мэргэшсэн багш нарын хомсдол нь тухайн улсын холбооны/ бүсийн (subnational) түвшинд ч ажиглагдаж болно. Сайн бэлтгэгдсэн, туршлагатай багш нар нь хот, хөдөөгийн тохируулгат орчинд, нийгэм, эдийн засгийн янз бүрийн давхаргын хүүхдүүдэд үйлчилдэг сургуулиудын хооронд цар тахлаас өмнө аль хэдийнээ эрс ялгаатайгаар тэгш бусаар хуваарилагдсан байв. Хамгийн хачирхалтай нь, хамгийн шилдэг, хамгийн туршлагатай багш нарыг шаарддаг орчинд ихэвчлэн шинэхэн, сайн дурын эсвэл дутуу мэргэшсэн багш нар ажиллаж, байнга солигдож байдаг. Шинэ үеийнхнийг энэ мэргэжилд татан оролцуулах бодлогын зэрэгцээ хамгийн чадварлаг багш нарыг авч үлдэх яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.

**Хамгийн чадварлаг багш нарыг авч үлдэх яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.**

Сургуулиудад уугуул иргэдийн, нутгийн болон дүрвэж ирсэн багш нарыг элсүүлж, тэднийг баталгаажуулах нь зарим тохиолдолд сурагчдынхаа соёлын өв уламжлалаа илүү сайн тусгах, олон янз байдлыг үнэлж, сурагчдын суралцахуйг сайжруулахад чухал хувь нэмэр оруулж чадна. Үнэн хэрэгтээ эдгээр бүлгийн мэргэжилтнүүд нь боловсролын шударга, үл алагчлагдах ирээдүйг бий болгоход асар их үнэ

цэнтэй хэрэгцээ, хүсэл эрмэлзэл, соёлын хэв маягийг ойлгох боломжийг олгодог олон нийттэй харилцаатай бөгөөд амьдралын туршлагатай хүмүүс байдаг.

## Багш боловсрол

Багш боловсролыг боловсролын тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулж, ирээдүйн сорилтууд болон хэтийн төлөвүүдэд илүү сайн чиглэсэн баримжаатай болгохын тулд дахин бодож үзэх хэрэгтэй. Дэлхийн янз бүрийн бүс нутагт, ялангуяа Сахараас урагших Африкт олон багшийн мэргэшил сул байгаа нь яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна. Энэ өөрчлөлтийн хувьд бүх асуудалд тохирсон нэг төрлийн загвар байхгүй. Багш боловсролтой холбоотой янз бүрийн тоглогчид, тухайлбал, төрийн байгууллагууд, судлаачид, багш нарын холбоо, олон нийтийн удирдагчдын хорших ажиллагаа нь суралцахуй ба инновацын шинэ орон зайг бий болгох бололцоог бүрдүүлдэг.

Багш боловсрол нь мэдлэг бүтээгдэж, эргэлтэд ороход дижитал соёлын ач холбогдлыг, мөн хүний амьдрал болон манай гарагт түүний авчирч буй өөрчлөлтийг үл тоомсорлож болохгүй. Технологийг бүхнийг анагаагч болгон ашиглахгүйгээр дижитал медиаг зөвхөн холимог, алсын зайн мэргэжлийн хөгжлийг дэмжих хэрэгсэл болгох төдийгүй судалгааны сэдэв болгон оруулах

хэрэгтэй.Түүнчлэн, дижитал медиа, платформуудын чадал чинээ, сурган хүмүүжүүлэх үр нөлөө, эпистемик болон ёс зүйн бололцоонууд, мөн харалган бүс болон дутагдалтай талуудын талаар шинжлэн судлах хэрэгтэй байна.

Үр өгөөжтэй багш боловсрол нь багшийн алдагдал (teacher attrition)-д нөлөөлж буй хүчин зүйлсийг арилгахад чиглэх ёстой. Багш мэргэжлийг дэмжих нь хангалттай мэргэшсэн нэр дэвшигчдийг татахаас илүү зүйлийг шаарддаг. Энэ нь шаардлагатай туршлага, нөөц, дэд бүтцээр сайн дэмжигдсэн багууд хоорондын хорших ажиллагаа нь мэргэжлийн амжилтад хүрэхийн тулд багшийн үүрэг ролийг дахин дизайнчилхыг шаарддаг. Тухайлбал, цар тахлын үед дэлхийн ихэнх оронд зайны сургалтыг үр дүнтэй дэмжих технологийн платформууд байгаагүйгээс, мөн түүнчлэн мэргэжлийн хөгжил тохирч нийцээгүйн улмаас багш нар стрессдэж, ядарч туйлдан улмаар зарим нь мэргэжлээ орхисон.

### Шинэ багш нар

Аливаа мэргэжилд шинэ үеийг хэрхэн угтаж, нийгэмшүүлэхээс илүү чухал зүйл байдаггүй. Шинэ хүмүүстэй ажиллаж ажлын байранд дасгах хөтөлбөр (Induction programmes) нь илүү туршлагатай хамт ажиллагчидтайгаа хамтран хичээл төлөвлөх, зөвлөн туслах хоршсон бүтцээр шинэхэн багш нарын ажил амьдралд нь маш чухал нөлөөтэй эхний жилүүдэд дэмждэг байх ёстой. Багшаар бэлтгэгдэх ба мэргэжлийн дадлага хоёрын хоорондох шилжилтийн энэ үе шат нь багшлах мэргэжлийн амьдралд хамгийн чухал шийдвэрлэх үе байдаг ч бодлогын болон мэргэжлийн түвшинд энэ үеийг үл тоомсорлодог бөгөөд үүний үр дүнд багшийн алдагдал хамгийн өндөр хувьтай байдаг.

Багшлах мэргэжил нь бусад мэргэжлийн нэгэн адил мэдлэгийн бааз суурьтай холбоотой байдаг. Багшлах мэргэжлийн мэдлэг нь багш бэлтгэх байгууллага, сургууль, туршлагажсан багш нарын үйл ажиллагааг интеграцчилах, нийгэмшүүлэх үйл явцыг шаарддаг. Хэрэв бид XXI зуунд боловсролын өөрчлөгдөж буй тухайн нөхцөл байдал, хам нөхцөл, суралцахуйн орчин, түүнчлэн суралцагчдын олон янз байдлыг авч үзэж байгаа бол энэ холболт нь илүү чухал юм. Шинэ сорилтууд нь үе үеийн багш нарын хорших ажиллагааг шаарддаг. Ингэхэд, ирээдүйн сорилтуудыг даван туулахад харилцан итгэлцсэн мэргэжил нэгт хамт олон болохынхоо хувьд бие биеэ дэмжих чадамжуудаас өөр юу ч тэдэнд тусалж чадахгүй.

Багш нар суралцагчдаа үйлийн судалгаа, асуудал-шийдвэрлэлт, болон төслийн ажилд татан оролцуулах эсвэл шинэ арга техникийг туршиж үзэх үед мэдлэг бүтээх ажлыг тэргүүлдэг. Эдгээр үйл явц нь ажлын байранд дасгах хөтөлбөр хэрэгжүүлэх болон шинэхэн багшийг мэргэжил нэгт нөхдийн хоршин ажилладаг нийгэмлэгтэй интеграцчилах үндэс суурь болох ёстой.

### Мэргэжлийн тасралтгүй хөгжил

Багш нарт үндэс угсаа, хэл, соёлын олон янз бүхий хүн амын янз бүрийн бүлгүүдтэй ажиллах, тусгай хэрэгцээт сурагчдыг хамруулж, тэдэнд тохирсон дэмжлэг үзүүлэх, суралцахуйг хувь хүний онцлогт тохируулахад шаардлагатай мэргэжлийн хөгжил, боловсролын боломжууд олгож, зохих

дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Тэд түүхийн явцад хасагдаж болон орхигдож гадуурхагдсан бүлгүүдийн суралцагчдыг тэдэнд тохирсон дэмжлэгээр хангах ёстой. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, нийгэм, улс төрийн хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөн, дотоодын шилжин суурьшилт ихсэх зэрэг ойрын жилүүдэд өсөх төлөвтэй байгаа нөхцөл байдлын улмаас ялангуяа, анги танхимын бүтэц эрс өөрчлөгдөж болзошгүй бүс нутгуудад бодит үнэн болоод байна.

Мэргэжлийн хөгжил нь анхан шатны багш боловсрол, удирдагчтай багшлах дадлагаас эхэлж дараа нь шинэ багшийг ажлын байранд дасгах, зөвлөн туслах болон мэргэжил дээшлүүлэх зэрэг байнгын шинжтэй мэргэжлийн тасралтгүй хөгжлийн нэг хэсэг байх ёстой. Карьерын замналын шатуудаар урагшлан үр өгөөжтэйгөөр ахиж дэвших нь багшийг өдөр тутмын үйл ажиллагаанд төвлөрч уялдсан, мэргэжлийн практикт хялбархан интеграцчиглагддаг утга учир бүхий мэргэжлийн тасралтгүй хөгжилтэй холбоотой байх ёстой.

Үр өгөөжтэй мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрүүд нь ихэвчлэн сурагчид юу сурах ёстойд, ийм суралцахуйг дэмжих, сурагчдын ахиц дэвшлийг үнэлэхийн тулд багш нар юу хийж чаддаг байх ёстойд тов тодорхой төвлөрсөн байдаг. Хамгийн үр өгөөжтэй хөтөлбөрүүд нь харьцангуй урт хугацаанд үргэлжилдэг бөгөөд зарим талаараа сургуульд-суурилсан, туршлагад шигтгэгдэж суусан байдаг ба мөн сурсан зүйлээ хэрэглэх, сурган хүмүүжүүлэх ухаан болон ухагдахууны мэдлэгийг хөгжүүлэх олон удаагийн давталттай байх боломжуудыг олгодог.

## Багшлахуйг хувирган өөрчлөхийн төлөөх нийтийн эв нэгдэл

Багш нар боловсролын нийгмийн шинэ гэрээнд хувь нэмрээ оруулах боломжтой байхын тулд багшийг сонгох, бэлтгэх, карьерын замналыг засаглах бодлогод болон багш мэргэжлийн зохион байгуулалтад өөрт нь чухал өөрчлөлтүүд хийх шаардлагатай. Хорших ажиллагаа нь зөвхөн багш нарт илүү их үүрэг хариуцлага хүлээлгэх биш харин тэднийг дэмжиж, өргөн хүрээтэй боловсролын хувь нийлүүлэгчид, ялангуяа гэр бүл, олон нийт, дээд боловсрол, олон төрлийн нийгмийн байгууллагуудыг татан оролцуулж, тэдэнтэй хамтран ажиллах боломж олгосон санхүүгийн нөөцөөр хангах ёстой.

### Багшийн ажиллах орчин нөхцөл

Сургууль дахь чанартай багшлахуй нь сурагчдын сурлагын амжилтыг тодорхойлдог цорын ганц хамгийн чухал хүчин зүйл болохыг харуулсан судалгаануудыг үл харгалзан багш нар хүлээн зөвшөөрөгдөөгүй, дутуу үнэлэгддэг, бага цалинтай, тохирсон дэмжлэг авдаггүй хэвээрээ байна. Багшийн карьерын бүтэц, түүний менежмент, багшийн сэдэл тэмүүлэл, ажлын байрны сэтгэл ханамжтай холбоотой асуудлуудыг улсын хөрөнгө оруулалт ба нийтийн хүсэл зоригийн шаардлагын хэмжүүргүйгээр дэлхий нийтийн хэмжээнд шийдвэрлэхэд хэцүү байдаг. Тохиолдлын эсвэл сул мэргэшсэн багшид хэт найдах нь мэргэжлийн болон нийтийн боловсролыг доройтуулдаг.



Ажлын муу орчин нөхцөл, бага цалин хөлс нь ирээдүйтэй багш нарыг зугтахад хүргэдэг. Эдгээр хурцадмал байдал, шаардлагын анализад багшийн ажлын жендэрийн шинж чанар нь харагдахуйц тод байх ёстой, учир нь зарим улс оронд эмэгтэй багшийн тоо нэмэгдсэн нь тэдний цалинг бууруулах эсвэл цалингийн үл алагчлах байдлын зөрөөг нэмэгдүүлэх шалтаг болж байна. Зөвхөн мөнгөн нөхөн олговор олгох замаар биш, харин нэг багшид ноогдох сурагчдын тоог багасгах, сургуулийн аюулгүй байдлыг сайжруулах, мэргэжлийн хувьд хүлээн зөвшөөрч хууль ёсны байдлыг бэхжүүлэх, байгууллагын дэмжлэгийг нэмэгдүүлэх, хорших ажиллагааны соёлыг төлөвшүүлэх замаар багшийн ажиллах нөхцөлийг сайжруулах шаардлагатай.

Ерөнхийдөө багшийн карьерыг дахин дизайнчлах хэрэгтэй. Ахиц дэвшил нь цогц чадамж, мэргэжлийн хөгжил, сургуулийн хөтөлбөр дэх оролцоо зэрэгт тулгуурласан байх ёстой. Үүнд шинэ залуу багш нарт зөвлөн туслах, хамтарч-багшлах (co-teaching) нэгдсэн төлөвлөлт хийх, судлагдахууны чиглэлүүд эсвэл мөчлөгийг тэргүүлэх, хувиараа багшлах, зөвлөх гэх мэт дэмжих үйлчилгээг зохион байгуулах, бүтээлийн чөлөө авч шинжилгээ судалгаа хийх, мэргэжлийн хөгжлөө ахиулахаар цаашид суралцах болон бусад үйл ажиллагаа багтана. Өсөн нэмэгдэж буй дарамт шахалтын дунд багш нар хүнд суртал, сурган хүмүүжүүлэх шаардлагын хооронд илүү тэнцвэртэй харилцаа тогтоохыг шаардаж байна. Түүнчлэн багшлахуйн үл үзэгдэх ажлыг жишээлбэл, тэд өөрсдийн хамтын нийгэмлэгийн тохируулгат орчинд гүн гүнзгий татагдан оролцох явцад гардаг ажлыг тооцдог байхыг шаардаж байна.

Багшийн хөдөлмөрийн дүрэм журам, норм норматив, ажлын ачааллыг боловсролын шинэ тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэхийн тулд тэдгээрт нягт нямбай хандан жендэрийн мэдрэмжтэйгээр эргэн харж өөрчлөх хэрэгтэй байна. Үүнээс гадна эрэлт хэрэгцээ ба эгэх хариуцлагын технологиор дамжуулан багш нарын бие даасан байдлыг ихэвчлэн бууруулдаг хяналтын шинэ хэлбэрүүд гарч ирж байгааг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Томоохон хэмжээний сорилгууд нэмэгдэж байгаа нь багшийн үнэлгээ, сургуулийн шалгалтууд, багшлахуйн стандарт зэрэг нь багш нарт нөхөх хариу дэмжлэггүйгээр дарамт шахалт үзүүлж байдгийн цөөн хэдэн жишээ юм.

Зарим боловсролын системүүд хиймэл оюун ухааны технологийг дотоод засаглал, үр ашиг, олон нийтийн эгэх хариуцлагыг дээшлүүлэх арга зам хэмээн хүлээн авч байна. Мэдлэг ба боловсролын үйл явцын харагдах байдлын хувьд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч машин сургалтын технологийн өсөлт нь боловсролын үйл явцуудыг “өгөгдлийн багц” болгон хэсэгчилж, менежментализм, цагдан хянах, багшийг мэргэшилгүйжүүлэх (de-professionalization) хандлагыг хурдасгах эрсдэлтэй. Ялангуяа ийм нөөцийг улс төрийн хяналтад ашиглах боломжтой улс орнууд нүүр царай таних программ хангамж, хиймэл оюун ухааныг ашиглаж сурагч, багш нарыг хянаж байгаа нь боловсролын зорилго бол хүний үндсэн эрх, эрх чөлөөг дээшлүүлэх гэж баталсан НҮБ-ын Хүний эрхийн тунхаглалын 26 дугаар зүйлтэй зөрчилдөж байна.

Багшийн ажил бол асар их хариуцлагатай ажил учраас нийгмийнхээ, юуны түрүүнд ирээдүйнхээ өмнө эгэх хариуцлага хүлээх ёстой. Үүний тулд тэд нээлттэй, итгэл даасан орчинд ажиллахдаа аюулгүй байдалд илтгэлтэй байх учиртай бөгөөд сэтгэлгээний шинэ арга барил дэвшүүлэх, аливаа нийгэмлэгт харьяалагдах эрх чөлөөг мэдэрч байх ёстой. Ийм байх нь багш нарын ажлыг дэмжих бус харин ч дордуулж байдаг хэт менежментализм, корпоративзм суурилсан эгэх хариуцлагын сүүлийн үеийн зарим хэлбэрүүдтэй зөрчилддөг.

## Багш нартай харьцах их сургуулиудын өнөөгийн харилцаа

Дээд боловсрол ба багшлах мэргэжил хоёрын хооронд нягт уялдаа холбоо байдаг бөгөөд байгууллагын шинэ тохируулгад энэ холбоо биеллээ олсон байх ёстой. Бид ирээдүйгээ *хамтдаа* дахин төсөөлөх гэсэн санаа нь анхан шатны багш боловсрол, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн чиглэлээр сургуулиуд, багш нар, их дээд сургуулиудын хорших болон хамтын ажиллагааны амлалт үүргийн хэрэгжилт болж хувирах ёстой. Дээд боловсрол нь дараагийн үеийн сурган хүмүүжүүлэгчдийн сэтгэлгээ, сурган хүмүүжүүлэх арга барилыг сорьж, төлөвшүүлэх чадалтай. Хариуд нь эргээд, сурган хүмүүжүүлэгчид их дээд сургуулиудад өөрсдийгөө өөрчлөх, нийтийн эрхэм зорилгоо шинэчлэх, боловсролын өргөн хүрээтэй экосистемд гүйцэтгэх үүрэг ролио илүү сайн ойлгоход тусалж чадна.

Тэдгээрийн илүү ерөнхий уялдаа холбооны дотор их дээд сургуулиудын багш боловсролын өмнө хүлээх бодит амлалт үүргийг нэмэгдүүлэх ёстой. Түүхэн үүднээс авч үзвэл энэ нь бага, дунд боловсрол ба их дээд сургуулиудыг холбосон гол холбооснуудын нэг байсаар ирсэн. Гэсэн хэдий ч ихэнх газарт багш боловсролын хөтөлбөрүүд болон стратегиудад зарчмын өөрчлөлтүүд хийх шаардлагатай байна.

Эдгээр амлалт үүргийн хамгийн чухал нь багш боловсролын хөтөлбөрийг бүтээж хэрэгжүүлэх ялангуяа, багш бэлтгэхэд харилцаанд-суурилсан арга хандлагыг хэрэгжүүлэх хэрэгцээ юм.

Багшийн анхан шатны бэлтгэлийг их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн аль аль нь бие даан хийх боломжгүй.

Багшийн анхан шатны бэлтгэлийг их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн аль аль нь бие даан хийх боломжгүй. Зарим хөтөлбөрүүд боловсролын салбарын олон тоглогчид, тэр дундаа төрийн эрх баригчид, багш нарын холбоо, төрийн бус санаачилгууд нэгдэж, хамтран ажиллах шинэ орон зай, тохируулгат орчны гүүр болоход анхаарлаа хандуулснаар энэ цоорхойг нөхдөг. Бусад хөтөлбөрүүд нь суралцахуй болон үйл ажиллагаандаа эрэл хайгуулд-баримжаалсан арга хандлагыг хэрэглэж, сургуулиудад гүн гүнзгий шигтгэж өгдөг. Эдгээр нь зөвхөн боловсролын факультетуудаар хязгаарлагдах учиргүй

бөгөөд бага, дунд боловсролыг их дээд сургуулиудын хөгжүүлсэн, цуглуулсан нийтлэг мэдлэгийн спектрийн бүх хүрээтэй холбох боломжтой. Олон газарт их, дээд сургуулиуд, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн "парк" байгуулсантай адил бид хамтын суралцахуйг дизайнчлах болон багш бэлтгэх ажилд бүх төрлийн хувь нийлүүлэгчдийг хамтад нь нэгтгэж чадах боловсролд-төвлөрсөн ижил төстэй орон зайг бий болгох хэрэгтэй байна.

Холбогдох амлалт үүрэг нь багшийг ажлын байранд дасгах багш мэргэжлийн хөтөлбөрийг бэхжүүлэх явдал юм. Эдгээрийн хамгийн шилдэг нь зөвлөн туслах ажил болон мэргэжлээрээ хөгжих, мэргэжлээрээ дадлагажих үе шатууд хоорондын шаардлагад тохирсон шилжилтийг хангах замаар залуу багш нарыг нийгэмшүүлэх ажилд тус тус тэргүүлэх ач холбогдол өгөх явдал билээ. Энэ бүхэн нь их дээд сургууль, багшийн коллежийн зүгээс хүчтэй хорших ажиллагааг шаардана. Багш нар болон их дээд сургуулиудын хоорондын байнгын холбоо харилцаа нь сургуулиудын болон

боловсролын хувирган өөрчлөлтийн үйл явцыг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулж чадна. Хөтөлбөрүүд болон факультетууд нь мэргэжлийн карьерынх нь туршид багш нартай холбоотой байж, багш гярхайгаар ажигласан зүйлээ коллеж, их сургуульдаа эргүүлэн авчрах диалектик харилцааг хөхиүлэн дэмжих хэрэгтэй.

Эцэст нь, дээд боловсролын багш буюу профессорын сурган хүмүүжүүлэх хөгжил нь мөн хувирган өөрчлөлтийг шаардаж байна. Их, дээд сургууль, коллежийн багш, профессорууд сурагчдын суралцахуйг төлөвлөх, багшлах, дэмжин туслах чиглэлээр хоршин ажиллах амлалт үүргээ хэрэгжүүлэх явцдаа олон зүйлийг олж авах боломжтой. Эв нэгдлийн болон хоршин ажиллах сурган хүмүүжүүлэх арга зүй нь хүүхэд, өсвөр үеийнхний хувьд чухал байдаг шиг дээд боловсролд ч бас чухал ач холбогдолтой бөгөөд их дээд сургуулиудын бэлтгэхийг зорьж буй мэргэжилтнүүд, удирдагчид, судлаачдын шинээр төрөн гарч буй хойч үеийнхэнд илүү их хамаарах нь дамжиггүй.

### Боловсролын шийдвэр гаргалт ба нийтийн орон зай дахь багш нар

Өнөө үед боловсролын нөхцөл байдал, түүнтэй холбоотой асуудлыг онцгойлон хэлэлцэж, тал талаас нь эргэцүүлэн дэнслэх болсон нийтийн оролцооны ач холбогдлыг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь зөвхөн ярилцаж, зөвлөлдөх асуудал биш, харин төрийн эрх бүхий байгууллага, эцэг эхчүүд, олон нийт, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, холбоод, залуучуудын хөдөлгөөн, багш нар болон тэдний байгууллагуудын оролцоотойгоор шийдвэр гаргах механизмыг бүрдүүлэх явдал юм.

Багшлах мэргэжил нь мэргэжлийн орон зайд дуусгавар болдоггүй, харин олон нийтийн орон зай, нийгмийн амьдрал, нийтлэг сайн сайхны төлөөх бүтээн байгуулалтаар дамжин үргэлжилдэг. Энэ утгаараа төрийн бодлогыг тодорхойлоход багш нар оролцох ёстой. Гэвч хэд хэдэн хам нөхцөлд багш нар эрх мэдэл багатай, мөн тэднийг боловсролын бодлогын талаарх мэтгэлцээн, хэлэлцүүлэгт оролцуулдаггүй.

Багш байна гэдэг нь тухайн мэргэжлээрээ нийгэмд тодорхой байр суурь эзлэхээс гадна боловсролын томоохон асуудлуудын нөхцөл байдлыг хэлэлцэх, төрөөс баримтлах бодлогыг зохиоход олон нийтийн өмнө байр сууриа илэрхийлэхийг хэлнэ. Энэхүү оролцоо нь үндсэндээ тэдний ашиг сонирхлыг хамгаалах зорилготой биш харин тэдний дуу хоолой, мэдлэгийг нийгэм, улс төрийн илүү өргөн орчинд хүргэж хэрэгжүүлэх зорилготой юм.

Ирээдүйд багшийн ажил зөвхөн анги танхимын орон зайгаар хязгаарлагдахгүй, харин сургууль гэсэн байгууллагыг болон түүний үйл ажиллагааг бүхэлд нь хамрах ёстой гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Багш нар нь сургуулийг бүх сурагчдынхаа суралцахуйд төвлөрсөн алсын харааг төлөвшүүлж, хуваалцдаг; бүх ажилтнуудад тасралтгүй суралцах боломжууд байдаг суралцагч-байгууллага болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Багш нар нь шинжилгээ судалгаа, инновац, эрэл хайгуулын соёлын хүрээнд хамтдаа хоршин ажиллах, суралцах хүчин чармайлтын анхдагчид байж, суралцахуйг зохион байгуулах, хуваалцахад зориулсан интеграцчилгдсан системийг бий болгож чадна.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Энэ бүлэгт боловсролын нийгмийн шинэ гэрээнд багшийг мэдлэг бүтээгч, боловсрол болон нийгмийн хувирган өөрчлөлтийн гол зүтгэлтэн хэмээн хүлээн зөвшөөрч, багшлахуйг хоршин ажиллах хичээл зүтгэл болгон мэргэжлийн түвшинд хүргэх гол чиглэлүүдийг санал болгосон. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг урагш ахиулахад хэрэгтэй яриа хэлэлцээ, үйл ажиллагааг удирдан чиглүүлж чадах дараах дөрвөн зарчим байна:

- **Багшийн ажлыг хорших ажиллагаа, багийн ажил тодорхойлж байх ёстой.** Багш нар боловсролын орчин, харилцаа холбоо, орон зай, цаг хугацааг холбогч, нэгтгэн зохион байгуулагч мастер болон нийтээрээ ажиллахад нь тэдэнд бид дэмжлэг үзүүлэх ёстой. Чанартай багшлахуй гэдэг нь сурагчдын бие бялдар, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн хэрэгцээг хангах таатай орчин болон багуудаар дамжин бий болгодог.
- **Мэдлэг бүтээх, эргэцүүлэн бодох, шинжлэн судлах нь багшлахуйн салшгүй хэсэг байх ёстой.** Багш нар өөрсдөө эрэл хайгуул хийдэг, инновац гаргадаг, судалгааны шинэ асуултуудыг томьёолж тодорхойлдог, сурган хүмүүжүүлэх шинэ туршлагаудыг бий болгодог оюунлаг идэвхтэй суралцагчид болохынх нь хувьд тэд хүлээн зөвшөөрөгдөж, дэмжигддэг байх ёстой.
- **Багшийн бие даасан байдал, эрх чөлөөг дэмждэг байх ёстой.** Багш мэргэжлийн хүчтэй ижилслийг хөхиүлэн урамшуулдаг байх хэрэгтэй. Үүнд багш нар өөрсдийн шүүмж-дүгнэлт, туршлагаа сурагчдын суралцахуйг дизайнчлах, удирдан чиглүүлэхэд үр өгөөжтэй ашиглах боломжоор хангадаг ажлын байранд дасгах хөтөлбөр болон ажил, мэргэжлийн тасралтгүй хөгжил багтана.
- **Багш нар боловсролын ирээдүйн талаар нийтийн мэтгэлцээн, яриа хэлэлцээнд оролцох ёстой.** Боловсролын хамтын ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөхөд шаардлагатай нийгмийн хэлэлцүүлэг, оролцоонд суурилсан шийдвэр гаргах механизмд багш нарын оролцоог хангах ёстой.

Боловсролын нийгмийн шинэ гэрээ байгуулахдаа багш нарын хувирган өөрчлөх ажилтай холбоотой эдгээр дөрвөн үндсэн зарчмаас бид санаа авах ёстой. Багшлахуй болон багш нарын талаар хамтын яриа хэлэлцээ нь боловсролын шинэчлэлийн чухал хэсэг юм.

## Бүлэг 6

# Сургуулийг хамгаалах ба хувирган өөрчлөх нь



Гэр маань намайг хэн байх ёстой, яаж байх ёстой талаар өөр хэн нэгний төсөөлөлд нийцүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэдэг газар байсан. Сургууль бол би өөрийгөө мартаж, санаа бодлоороо дамжуулан өөрийгөө шинээр бий болгож чадах газар байсан... Анги танхим бүх хязгаарлалтуудынхаа хамт бололцоогоо ашиглаж болдог газар хэвээрээ үлдсэн. Тэрхүү бололцоонуудын талбарт бид эрх чөлөөний төлөө хөдөлмөрлөх, тэр байтугай хил хязгаарыг давах, зөрчих арга замыг хамтдаа төсөөлж байхдаа ч бодит байдалтай нүүр тулах боломжуудыг олгодог оюун санаа, зүрх сэтгэлээ нээлттэй байлгахыг өөрөөсөө болон нөхдөөсөө шаардах боломжтой.

**Белл Хукс (Bell Hooks)**, *Хил хязгаар давахыг багшлахуй: Боловсрол нь эрх чөлөөний практик болох нь*, 1994 он.

**Сургуулиуд нь инклюзив оролцоо, үл алагчлах байдал, хувь хүний болон хамт олны сайн сайхан аж байдлыг хангасан боловсролын хотхон болж хамгаалагдах ёстой бөгөөд түүнчлэн илүү шударга, үл алагчилсан тэгш, тогтвортой ирээдүйд чиглэсэн дэлхий ертөнцийн хувирган өөрчлөлтийг улам сайн дэмждэг болохын тулд түүнийг дахин шинээр төсөөлж төлөвлөх ёстой.**

Хамтын ажиллагаа, эв нэгдлийн сурган хүмүүжүүлэх зүйг бий болгож, нийтлэг мэдлэгтэй харилцах харилцааг бэхжүүлэхийн тулд эдгээр шалтгаант зорилгод тусгайлан зориулагдсан цаг хугацаа, орон зайтай байх нь маш чухал юм. Сургуулиуд нь бүхий л нөөц потенциал, үүрэг амлалт, алдаа дутагдал ба хил заагийн хязгаарлалттайгаа боловсролын хамгийн чухал тохируулгат орчны нэг хэвээр байх болно. Сургуулиуд нь хүмүүний бүх нийтийг хамарсан үйл ажиллагаа болох боловсролын төлөөх нийгмийн амлалт үүргийг илтгэн харуулж байдаг. Гэсэн хэдий ч сургуулиудыг хэрхэн дизайнчлах нь тодорхой бус зүйл биш бөгөөд энэ нь суралцахуй, ололт амжилт, зорилго зорилтдоо хүрсэн үр дүн, харилцан үйлчлэлүүдийн талаарх таамаглалыг тусгаж байдаг.

Сургуулиудад бий болсон орчин, цаг хугацааны зохицуулалт нь юу хийж болохыг, юуг хориглохыг, хэнийг хүлээж авч, хэнийг хасаж гадуурхаж байгааг тод томруун харуулдаг. Боловсролын нүүр тулсан уулзалтуудыг зохион байгуулагч болохынхоо хувьд багш нар эдгээр уулзалтын зохион байгуулалтын дүр зургийг гаргах болон уулзалтын үе дэх харилцан үйлдэл, суралцахуйн төрлүүдийг сонгох, тэдгээрийн хэрэгжих нөхцөлийг төлөвлөхөд ихээхэн цаг зарцуулах шаардлагатай болдог. Сургуулийн орчин нь хорших ажиллагаа, эрэл хайгуул, туршилт хийхэд тохиромжтой байх болов уу? Туршилт хийж, алдах ба онох замаар суралцах ба эргэцүүлэх нь маш их шүүмжлэл дагуулах уу, эсвэл урам зориг өгөх болов уу? Энэ нь зөвхөн нэг анги эсвэл насны бүлэгт төдийгүй бүхий л насандаа, амьдралынхаа үе шат бүрд олон төрлийн, олон тооны нүүр тулах уулзалтуудыг хөнгөвчлөхөд дэмжлэг болж чадах болов уу? Эдгээр нүүр тулах уулзалтууд ямар төрлийн зөвлөгөө халамж, нөхөрлөл, сэтгэлгээний хэв маягийг бий болгох вэ? Сургуулийн орчин нь хувь хүний амжилтыг юу юунаас илүү чухалчилж үзэх үү, эсвэл хувь хүний болон үе тэнгийнхний хөгжлийг харилцан холбоонд дэмжих үү? гэсэн олон асуулт гарч байна.

Энэ бүлэг нь бараг бүх соёл, уламжлалд чухал үүрэг гүйцэтгэдэг нийгмийн амин чухал институци болох сургуулиуд үүсэж бий болсон тухай товч тоймоор эхэлнэ. Сургуулиуд нь зөвхөн бага, дунд боловсролын хөгжлийн ер бусын гэхээр цаг хугацаа, орон зайг төлөөлөөд зогсохгүй тэдгээрийн олонх нь хувь хүн, гэр бүл, олон нийтийн сайн сайхан аж байдлын төлөөх нийгмийн олон төрлийн бараа, үйлчилгээг нэгтгэж, бүрэн эрхийнхээ хүрээнд бие даасан нийгмийн төвүүд болж чадсан юм. Гэвч сургуулиудын хүрсэн амжилтын хязгаарлагдмал байдал нь зарим талаараа суралцахуйн орон зай, цаг хугацааны бүтцүүдийг явцуу тодорхойлж байсантай холбоотой. Дараагаар нь энэ бүлэгт сургуулиудын боломжит хувирган өөрчлөлтүүдийн талаар авч үзэх болно. Суралцахуйг анги танхимын хил хязгаараас гаргаж, түүний үйл ажиллагааны эрх хэмжээг өргөжүүлэх; суралцахуйд илүү гүнзгийгээр татагдан оролцох боломжийг хөнгөвчлөн дэмжихийн тулд хичээлийн цаг ба бүтцийг эргэн харах; сургуульд болж буй үйл явдлыг дэмжих дижитал технологийн нөөц потенциалыг тусгах гэсэн энэ бүгд нь сургуулийг хувирган өөрчлөх талаар боловсролын нийгмийн шинэ гэрээнд оруулах ёстой зүйлс юм.

Хэрвээ боловсрол нь хямрал, үл мэдэгдэх байдал, тодорхойгүй байдалд дасан зохицож амьдрах боломж олгосон хамтын ирээдүйг бий болгоход бидэнд туслах ёстой юм бол хүчирхэг сургуулиуд амин чухал шаардлагатай.

Энэ бүлгийн төгсгөлд сурагчид, багш, сурган хүмүүжүүлэгчид, засгийн газар болон иргэний нийгмийн түншүүдийн сонирхлыг татахуйц яриа хэлэлцээ, үйл ажиллагааг 2050 он хүртэл чиглүүлэх зарчмууд болгож, сургуулиудыг хоршин ажиллах орон зай болгон хамгаалах, дахин дизайнчлах; дижитал технологийг эерэг хөшүүрэг болгон ашиглах; тогтвортой байдал ба хүний эрхийг загварчлах гэсэн гол зарчмуудыг товч танилцуулна.

## Сургуулийн орлуулшгүй үүрэг роль

Хэрэв сургууль байхгүй байсан бол бид түүнийг шинээр зохион бүтээх хэрэгтэй болох байсан. Сургууль бол боловсролын томоохон экосистемийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Сургуулиудын амьдрах чадвар нь боловсролыг нийтлэг сайн сайхан байдал хэмээн үзэх нийгмийн амлалт үүргийн илэрхийлэл юм. Сургуулиуд нь хүүхэд залуучуудад нийтлэг мэдлэгт хувь нэмэр оруулан оролцох ер бусын өвөрмөц олон орчныг бүрдүүлдэг. Сургууль бол эрсдэл хүлээх, сорилтуудтай тулгарах, бололцоогоо туршиж үзэх газар бөгөөд бидний хамтын ирээдүйг дэмжих туршлага, чадамж, мэдлэг, ёс зүй, үнэт зүйлсийг хүн бүр эзэмших боломжийг ханган баталгаажуулдаг. 2050 онд тулж очиход сургуулиуд үе хоорондын, соёл хоорондын болон олон ургалч үзлийг уралдуулсан нүүр тулах уулзалтуудаар дамжуулан эв нэгдэл, харилцан ойлголцлын ёс зүйг төлөвшүүлсэн байх шаардлагатай болно.

Боловсролын чухал үйл хэргүүд янз бүрийн цаг хугацаа, орон зайд явагддаг боловч сургуулийн нийтэд зориулсан цаг хугацаа, орон зай нь өвөрмөц онцгой байдаг. Сургуулийн орон зай нь нийгмийн харилцааг тэтгэн дэмждэг. Боловсрол ба суралцахуй нь хүмүүсийн харилцан үйлдэл, яриа хэлэлцээ, мэдээлэл солилцоог өдөөн идэвхжүүлдэг бөгөөд тэдгээрт сургаж хүмүүжүүлэх шалтгаанаар сургуулиудыг тусгайлан байгуулдаг. Сургууль бол янз бүрийн нас, амьдралын үе шатанд хүмүүсийг нэгтгэж, бусдаас болон бусадтай суралцдаг хамтын амьдралын хэлбэр юм. Зайны буюу алслагдсан нутгийн зайн суралцахуй нь сургуулиудын ажлыг дэмжиж болох боловч тэдгээрийн харилцан үйлчлэлийн шинж чанарыг бүрэн орлож чадахгүй.

Хэрэв сургууль байхгүй байсан бол бид үүнийг шинээр зохион бүтээх хэрэгтэй болно.

Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахал, баруун Африкт гарсан Эболагийн голомтот халдвар, хүчтэй мөргөлдөөнүүд, уур амьсгалын аюулт үзэгдлүүд зэрэг үйл явцыг тасалдалт нэмэгдэж байгаа нь сургуулиудын хосгүй өвөрмөц үүргийг улам бүр тодруулж байна. Эдгээр санамсаргүй явдлууд нь сургууль бол суралцахад чухал ач холбогдолтой төдийгүй нийгмийн сайн сайхан аж байдлын төв гэдгийг дахин сануулсан билээ. Сургууль бол хамгийн ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах, тэдэнд боломж олгох зорилготой цөөхөн байгууллагуудын нэг юм. Сургуулиуд нь нийтийн амьдралын төв болохынхоо хувьд сурагч өөртөө итгэлтэй байж өөрийн хүчинд тулгуурлах, орон нутгийн иргэд болон байгаль дэлхийтэй тогтвортой харилцаа тогтооход хүчтэй дэмжлэг үзүүлэх боломжтой билээ. Жишээлбэл, 2020 ба 2021 онд гэнэт, урьд өмнө байгаагүй өргөн цар хүрээнд сургуулиуд хаагдсаны улмаас дэлхий даяар сая сая хүүхэд, өсвөр насныхан сургууль, ангийнхан, багш нартайгаа уулзах боломжгүй болсон. Энэхүү танхимын сургалтад хамрагдах боломжгүй байдалд хүргэсэн боловсролын хомсдол нь олон сая хүүхэд,

өсвөр үеийнхний нийгэмшил, оюун ухаан, оюун санааны сайн сайхан аж байдалд гүнзгий нөлөө үзүүлсэн бөгөөд энэ нь тэдний амьдралын туршид мэдрэгдэх болно.

Сургуулиуд сурагчдынхаа наснаас үл хамааран тэдний сониуч зан, мэдлэгт тэмүүлэх хүслийг тэтгэн дэмжих ёстой. Сурагчид гэртээ эсвэл ойр тойрныхоо олон нийтийн дунд ихэвчлэн тааралдаж байгаагүй шинэлэг санаанууд, туршлагаудтай сургууль дээрээ танилцах боломжтой байх учиртай. Зориуд бодож боловсруулсан сурган хүмүүжүүлэх нүүр тулах уулзалтууд нь сургуулийг юугаар ч орлуулшгүй болгодог. Боловсролын олон тооны бусад газрууд дундаас сургуулийн ялгарах өвөрмөц онцгой тал бол тэнд суралцахуй ба багшлахуй хамт явагддаг газар юм. Хүн сурах ба сургах чадвартай бөгөөд эдгээрт хоёуланд нь суралцдаг. Энэхүү гайхамшигтай динамик нь биднийг бүхий л орон зай, цаг хугацааны туршид үе үеийнхнийг дамжсан нийтлэг мэдлэг, мэдэхүйн аргуудтай болон биднийг өөр хооронд нь холбож өгдөг. Багшгүй сургууль гэж байдаггүй. Багш нар мэдлэгийг хүн бүрд хүртээмжтэй болгох, хамтын шалтгаант зорилго ба чадавхыг бий болгох, оюуны чөлөөт эрэл хайгуулыг дэмжих зэрэг сурган хүмүүжүүлэх эрхэм зорилгыг тэтгэн ажилладаг. Үүнтэй нэгэн адил багш нар тэдний ажлыг бэхжүүлж дэмждэг сургуулийн орон зай, цаг хугацааны эрүүл ажиллагаанаас ихээхэн хамааралтай байдаг.

### Нийтлэг түүхэн амлалт үүргүүд

Мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс, ойлголцлыг хөгжүүлэхэд зориулагдсан орон зай, цаг хугацаа ихэнх соёлд байдаг бөгөөд тэдний мэдлэгийн практик нь зөвхөн ажиглах, дуурайх, ярьж өгүүлэх замаар суралцах боломжгүй нарийн төвөгтэй түвшинд хүрсэн байдаг. Ихэнх тохиолдолд эрт үеийн сургуулиар суралцахуй нь бичиг үсэг үүсэж хөгжсөнөөр бий болсон. Сонирхолтой нь, “school-сургууль” гэсэн англи үг нь Грекийн “skhole” гэсэн чөлөөт, чөлөөт цаг гэсэн утгатай үгнээс гаралтай ажээ. Грекийн институци нь Европ дахь боловсролын хөгжлийн гол загвар байсан хэдий ч олон соёлд ешива (yeshiva), медресе (madrasah), калмека (calmécac) зэрэг сургууль, боловсролын байгууллагууд хөгжиж байсан байна. Сургуулиуд сүүлийн хоёр зууны турш дэлхий даяар хөгжиж, тархаж байгаагийн хэрээр тэд хэрхэн дэлхий ертөнц дээр амьдрах, түүнийг бүтээх, түүнд анхаарал халамж тавих талаар үеийн үеийнхэн хоорондын яриа хэлэлцээг зохион байгуулах нийгмийн гол дэд бүтцүүдийн үүрэг гүйцэтгэх болсон. Сургууль нь бидэнд соёлын өвтэй танилцах, түүнийг дахин бүтээх, өргөжүүлэх боломжийг олгодог.

Сургууль нь нийтлэг мэдлэгтэй нүүр тулан харьцах ажлыг зориудаар зохион байгуулах гол -цаг хугацаа-орон зайн нэг юм. Сургуулиуд сурагчдыг шүүн хэлэлцэх, судлан суралцах, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх баялаг уламжлалтай танилцуулах замаар мэдлэгийн онолын практик чадваруудыг дэмжих эрх мэдэлтэй байсан ба байсаар байна. Сургуулийн үйл ажиллагаа, дасгал, арга хэмжээнүүд нь мэдлэгт хандах тодорхой ёс зүй, харилцан хамаарлыг урамшуулан тусалдаг. Түүхийн хувьд авч үзэхэд үнэнийг баталсан бэлэн нотлох баримтуудыг (итгэл үнэмшлийн тогтолцооны үнэн болохын нотолгоо) шууд дамжуулахад илүү их ач холбогдол өгч ирсэн. Гэвч сүүлийн хэдэн арван жилд гарсан чухал өөрчлөлтүүд нь олон сургуульд хэрэглэж байгаа шууд зааварчлах арга барилд эргэлзээ төрүүлэх болсон. Олон нийтийн оролцоог илүү хангасан сургуулиар суралцахуйн практик болон соёлыг бий болгосноор үнэний тухай туршлагаар батлагдаагүй үзэл баримтлал (truth-claims)-ын үүсэл гарал, үр дагаврын талаарх ойлголтыг



төлөвшүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна. Сургуулиудад мэдлэгийн олон төрлийн практикийг дэлгэрүүлж, мэдлэгийн эпистемологи болон экологийн хооронд бүтээлч, илүү өргөн хүрээний холбоог бий болгон хөгжүүлснээр өдгөө бидэнд тулгараад байгаа ацан шалаа, сорилтуудыг үр дүнтэй шийдвэрлэх боломжтой.

Сургуулиудад мэдлэг дамжуулах орон зай нь илүү их оролцоо, эрэл хайгуулаар солигдох шилжилтийн энэ бүх хугацаанд сургуульд суралцахуй чухал хэвээр байх болно. Гэсэн хэдий ч уян хатан бус байхаас зайлсхийж, дэлхийд нүүрлэсэн сорилтуудад хариу үйлдэл үзүүлэхийн тулд хүмүүний бүтээсэн туршлагаудыг үнэгүйдүүлэхийн оронд арвижуулан өсгөдөг мэдэхүйн ямар олон аргуудыг цаг хугацаа, орон зайны хувьд кодчилж болохыг ойлгох шаардлагатай байна. Үе дамжиж ирсэн суралцахуйн нийтийн үйл хэрэгт түлхэц, тус дэм болох боломжтой сургуулийн шинэ орон зай, цаг хугацааг бий болгохын тулд цаашид маш их ажил хийх шаардлагатай байна.

## Сургуулийн хувирган өөрчлөлт зайлшгүй болох нь

Сургууль нь хүн бүр хувирган өөрчлөлт, өөрчлөлт, сайн сайхны аж байдлын төлөөх хүсэл тэмүүлэлтэй болж, түүнийгээ хэрэгжүүлэх боломжтой газар болох ёстой. Юуны өмнө, сургуулиуд өмнө нь урьдчилан тооцоолж байгаагүй бололцоонуудыг хувиараа болон хамтдаа бодит үйл хэрэг болгох боломжийг бидэнд олгох ёстой. Дэлхийн олон хэсэгт сургуульд суралцах хүртээмж нэмэгдэж байгаа нь хувь хүний болон бүхэл бүтэн нийгэмлэгийн ухамсрыг дээшлүүлэх, шинэ ур чадвар, ойлголтыг хөгжүүлэх, суралцахуй ба хөгжлийн шинэ траекторыг урьдчилан харахад нь хувь нэмэр оруулахуйц хувирган өөрчлөх боломжуудыг олгож байна. Гэвч хэт олон тохиолдолд өнөөгийн сургуулиуд тэгш бус байдлыг бэхжүүлж, тэнцвэрт бус байдлыг өргөжүүлэхэд үйлчилж байгаа бөгөөд энэ байдлаасаа зайлшгүй салах, засаж залруулах шаардлагатай.

Сургуулиуд өмнө нь урьдчилан тооцоолж байгаагүй бололцоонуудыг хувиараа болон хамтдаа бодит үйл хэрэг болгох боломжийг бидэнд олгох ёстой.

Гүн гүнзгий өөрчлөлтийг авчрахын тулд ирээдүйн сургуулийн зохион байгуулалтын зарчмууд нь инклюзив оролцоо, хорших ажиллагаанд төвлөрөх ёстой. Төгс төгөлдөр чанар, ололт амжилт, чанар, хэмжилт, ахиц дэвшил нь үнэ цэнтэй амлалт үүргүүд байх бөгөөд тэдгээрийг үл тоомсорлон орхигдуулахаас илүүтэйгээр дахин тохируулж, шинэчлэх боломжтой.

Сургуулийн шинэ орчныг бид зарим сурагчид интернэтэд холбогдсон эсэхээс үл хамааран ганцаараа хичээллэдэг, зарим нь ангийнхандаа болон багш нартаа бүтээлээ толилуулдаг том номын сан гэж төсөөлж болно. Бусад нь номын сангийн гадаа, сургуулиас гадуур байгаа хүмүүс, хүрээлэл орчинтой магадгүй, алс газрынхантай ч харьцаж байдаг байж болох юм. Номын сан нь тухайн нөхцөл байдал, орон зай, цаг хугацааны маш олон янз байдлыг дэмждэг. Энэ бол сургууль, анги танхимын ердийн бүтцээс тэс өөр шинэ орчин юм. Ийм номын санг зүйрлэн бас шууд утгаар нь ойлгож болно. Энэ нь сургуулийн цаг хугацаа, орон зай нь суралцагчдыг нийтлэг мэдлэгтэй холбох портал болж ажиллах ёстойг бидэнд сануулж байна.

## Сургууль бол хамтын ажиллагаа, анхаарал халамж, өөрчлөлтийн платформ юм

Инклюзив оролцоог хангасан, хорших суралцахуйн орчин болохын тулд сургуулиуд нь хүчирхийлэл, дээрэлхэлтээс ангид, суралцагчдыг ялгаатай болон олон янз байдлаар нь хүлээж авдаг аюулгүй орон зай байх ёстой. Хамт олноороо болон хоршин суралцах нь нэг янзын байх гэсэн үг биш юм. Үр өгөөжтэй хорших суралцахуй нь сурагчид ба багш нарын ялгааг (чадавх, чадамж, танин мэдэхүй, сонирхол, хандлага) гол хөшүүрэг болгон ашигладаг. Нэг талаас харахад, суралцахуй нь бидний хүн нэг бүрд хамаарах хувь хүний аялал байдаг. Хорших суралцахуй нь суралцагчдын хувийн шинж чанарт хохирол учруулахгүйгээр инклюзив оролцоо, үл алагчлах байдлыг хангасан байх ёстой. Гэхдээ нөгөө талаас нь харахад, суралцахуй нь бусадтай харилцах харилцаа хэлбэрээр тодорхойлогддог хамтын аялал юм.

Боловсролын хувь хүний болон хамтын үйл ажиллагаа нь харилцан бие биеэ дэмжиж, бэхжүүлдэг тул өөрийгөө боловсруулах явдлыг энэхүү илүү том зургийн нэг хэсэг болгож харах нь чухал юм. Бид хэн нэгний төлөө сурч чадахгүй ч хамтдаа илүү ихийг сурч чадна. Бидний юу мэдэж байгаа маань бусдын юу мэдэж байгаагаас эргээд хамаарч байдаг. Ингэж л бидний харилцаа, харилцан үйлчлэлүүд дээр боловсрол явагдаж байдаг. Үр өгөөжтэй хамтын суралцахуй нь дэлхийн даяар зориг тэмүүлэлтэй олон сургуулиудад аль хэдийн хэрэгжиж эхлээд байна. Гэвч дэлхийн хаана ч байгаа сургуулиуд ийм харилцаа, харилцан үйлчлэл руу илүү сайн чиглэх ёстой.

Сургууль, багш нар суралцагчдыг дэмжих зайлшгүй шаардлагатай ажил хийдэг. Олон хүмүүс өөрсдийнх нь амьдралыг эергээр өөрчилсөн багш эсвэл сургуулийн туршлагыг нэрлэж чадна. Үүний зэрэгцээ сургуулиуд сурагчдыг маш ихээр орхин, хасан гадуурхах байдлаар тэгш бус байдлыг дахин бий болгодог. Дэлхийд нийт сурагчдын тал орчим хувь нь суурь цогц чадамжууд эзэмшилтийн доод түвшинд ч хүрч чадахгүйгээр дунд сургуулиа төгсдөг нь хүлээн зөвшөөрөхийн аргагүй үр дүн бөгөөд сургуулиудын өөрсдийн сурагчид болон нийгмийнхээ өмнө гаргаж буй том бүтэлгүйтэл юм. Дасан зохицох, хувиран өөрчлөгдөх чадавхтай сургуулиудын динамик өөрчлөлтийг идэвхжүүлэх ёстой бөгөөд энэ нь бүрэн бололцоотой гэдгийг дэлхийн өнцөг булан бүрээс авсан тоо томшгүй олон жишээ бидэнд харуулж байна.

Сургуульд боловсролын бусад орон зайтай илүү ойр дотно байснаар хожил авах боломжтой бүх зүйл бий. Боловсролын Ирээдүйн санаачилгад хамрагдсан сая гаруй хүмүүс сургуулиудын дизайныг (барилга, сургалтын хөтөлбөр, анги танхимын зохион байгуулалт, сургалтын үйл ажиллагааны хувьд) өөрчлөх шаардлагатай гэсэн маш тодорхой зөвшилцөлд хүрсэн. 2050 он хүртэлх боловсролын алсын хараанаас сэдэвлэн бүтээсэн урлагийн бүтээлд сургууль нь эгнэж, цувсан ширээнээс салсан байгааг бэлгэдэн харуулсан байна. Боловсролын шинийг санаачлагчдыг оролцуулсан хэд хэдэн хэлэлцүүлэгт бид суралцахуй нь янз бүрийн цаг хугацаа, орон зайд явагддаг арга замуудыг зөв танин мэдсэнээр, тухайлбал анги танхим болон гадаад ертөнцийн хоорондох ханыг зөөлрүүлж, хичээлийг аялал хэмээн шинэчлэн ойлгох замаар сургуулиудыг хувирган өөрчлөх арга замуудыг хөндөж хэлэлцсэн. Дүгнэж хэлэхэд, сургуулиуд илүү инклюзив оролцоотой, уриалган, сонирхолтой, нийцтэй болж ирээдүй хойч үеийнхэнд өөрөөр харагдаж бас мэдрэгдэж байх ёстой.

Сургуулиуд нь сурагчид тогтвортой амьдралын хэв маягт суралцдаг, улмаар сурсан зүйлээ гэр орон, нийгэмдээ хүргэдэг газар болох хэрэгтэй. “Ногоон” сургуулиудыг байгуулж, боловсролоор дамжуулан нүүрстөрөгчийн саармагжилтад хүргэх асар их нөөц потенциал бидэнд бий. Сурагчид энэ ажилд манлайлан, манай дэлхийд маш их хэрэгтэй байгаа ногоон эдийн засгийг бий болгоход туслах мэдлэг, ур чадвараа хөгжүүлж чадна.

Бид зорьж буй зүйлдээ хүрэхийн тулд сүүлийн хоёр зуун жилийн түүхийн ихэнх хэсгийг тодорхойлж ирсэн хатуу хөшүүн, нэгэн жигд хэв маягтай зохион байгуулалтын загвараасаа сургуулиуд салах ёстой. Сэргээн шинэчлэх нь амин чухал үйл хэрэг юм. Бидний өнөөдрийн мэддэг ердийн уламжлалт сургуулийн загваруудыг бий болгосон арван ес, хорьдугаар зууны гайхалтай хүчин чармайлт нь ирээдүйн талаарх гүн гүнзгий ойлголтын эх сурвалж нь болох учиртай. Сүүлийн зуун тавин жилийн турш архитекторууд, нийтийн эрүүл мэндийн шинжээчид, философич, төрийн албан хаагчид, сурган хүмүүжүүлэгчид, олон нийт, гэр бүлүүд боловсролын боллоцгоог улам өргөжүүлэхийн тулд хүн төрөлхтний урт удаан түүхэн дэх боловсролын үзэл баримтлалуудад тулгуурлан ажилласан. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр энэ нь материаллаг хэлбэрээр тухайлбал, сургуулийн барилга, анги танхимуудаар дамжин бүх нийтийн боловсролын нийгмийн ер бусын институцууд болж хэлбэржсэн. Илүү шударга, үл алагчилсан хамтын ирээдүйд чиглэсэн шинэ сургуулиудыг материаллаг талаас нь хэлбэржүүлэхэд өнөөдөр дээрх төсөөлөл, шийдэмгий байдал, хорших ажиллагаа зайлшгүй хэрэгтэй байна.

### Анги танхимаас суралцагчдын хамтын нийгэмлэг рүү

Дэлхий даяар сургуулийн анги танхимууд нь багшлах ба суралцах үйл явагддаг боловсролын уулзалтын үндсэн байр болжээ. Инклюзив оролцоо ба хорших ажиллагаанд зориулсан уулзалтын шинэ газруудыг “өрөө” гэж төсөөлөх нь ихэнхдээ ард хоцорсон, хуучирсан ойлголт байж магадгүй юм. Гэхдээ суралцагчдын нийгэмлэгүүдийн олон янз байдлын нэг хэсэг болох хамтдаа суралцдаг нэг ангийнхан, курсийнхний үнэт зүйлсээс татгалзан тэдгээрийг орхигдуулж болохгүй.

Сургуулийн уламжлалт ердийн загварууд нь сурагчдыг нас, хүрсэн амжилт, чадамж эсвэл жендэрээр нь ангилахад ихээхэн хүч зарцуулдаг. Эсрэгээр нь авч үзвэл, багш нар сургууль доторх сурагчдын бүлэглэлд дасан зохицож, тэднийг хөгжүүлэх, туршилт явуулахад уян хатан байж чадах боломжоор хангагдсан байх ёстой. Суралцагчдыг заримдаа жижиг бүлгүүдээр, зарим үед илүү том бүлгээр зохион байгуулж болох юм. Гэхдээ суралцагчдын нийгэмлэгийн нэг хэсэг байхын үнэ цэнийг бататгах нь сургуулийн онцлог байх нь зүйтэй. Сурагчид ирээдүйд сургалтын уламжлалт загвар болох анги танхимаар хязгаарлагдахаа больсон ч тэд ангийнхантайгаа байнгын харилцаа холбоо тогтоох шаардлагатай хэвээр байж, хамтдаа суралцахын бүх баяр баясгалан, инээд хөөр бас уйтгар гуниг, гомдол нулимсаа хамтдаа хуваалцдаг байх ёстой.

Сурагчид ирээдүйд сургалтын уламжлалт загвар болох ердийн анги танхимаар хязгаарлагдахаа больсон ч тэд ангийнхантайгаа байнгын харилцаа холбоо тогтоох шаардлагатай хэвээр байх болно.

Анги танхим дахь суралцахуйтай холбоотой хүлээлтийн талаар бас дахин эргэцүүлэн бодох хэрэгтэй. Дэлхийн дэндүү олон газарт хүүхэд залуучууд өдөржин

суугаад их хэмжээний мэдээллийг идэвхгүй байдлаар хүлээн авдаг. Энэхүү норм нь сургуулийн архитектур, тавилгын дизайн, анги танхимд байгаа эд зүйл, материалуудад нэвт шингэсэн байдаг. Дуугүй, дуулгавартай сурагч нь төвлөрсөн, бүтээмжтэй байхтай ижил утгатай болсон. Маш олон тохиолдолд ур чадвартай багшлахуй нь дэг журам сахиулах, "шаардлагагүй" дуу чимээ, хөдөлгөөнийг арилгахтай адилтгагдах болсон. Хөдөлгөөнгүй байхыг суралцахуйн хэрэгцээ гэж үзвэл сургууль ба анги танхим нь уйтгартай, тааламжгүй газар болж хувирна. Гүнзгий, шимтэн, шингээх анхаарал нь боловсролын асар их ач холбогдолтой байж болно. Гэхдээ манай анги танхим, сургуулийн орчин нөхцөл үүнийг зөвөөр хангаж байгаа эсэхийг өөрсдөөсөө асуух хэрэгтэй.

Сургуулийн нийгэмшлийн орон зайг бид яаж ч, хэчнээн ч их хамгаалсан дөрвөн ханаар хаших шаардлагагүй юм. Энэ орон зай нь нийгэм, соёл, байгалийн хүрээлэл орчны өргөн хүрээний нөөцөд тулгуурлан нээлттэй, уян хатан байж болно. Боловсролыг нэг төрлийн стандартчилагдсан ангиудаар хязгаарлах нь суралцах үйл ажиллагааг хязгаарлаж, сургуулиудын бий болгож чадах бололцоонууд ба ашиглаж чадах боломжуудыг хязгаарлаж байна.

### **Олон янз байдалтай сурган хүмүүжүүлэх арга зүйг дэмжих бүтцүүд**

Хичээл ба цагийн хуваарийг өөрчилж дахин томъёолох хэрэгтэй байна. Хичээл нь сурагчдыг бүлэг бүлгээр нь хамтын хичээл зүтгэлд төвлөрүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэх зориулалттай бөгөөд боловсролын нүүр тулах уулзалтуудыг бүтэцчилэн зохион байгуулах, үе үеийнхэн хоорондын харилцан яриаг зөвөөрлөн дамжуулах чухал механизм юм. Гэсэн хэдий ч уламжлалт ердийн хичээлийн дизайн нь ялангуяа, өдөр бүр эсвэл долоо хоног бүр давтагддаг тогтмол цаг гэж тодорхойлогдсон тохиолдолд энэ нь ихээхэн хязгаарлалттай байдаг.

Хичээл нь суралцахуй болон судлахуйн арга, хэв загварын олон янз байдлыг чухалчлан үнэлдэг сурган хүмүүжүүлэх ухаанд байр сууриа тавьж өгөх ёстой. Үе үеийнхэн хоорондын болон соёл хоорондын мэдээлэл солилцоог хөшүүрэг болгож, багш нарын өндөр түвшний мэдлэг, чадамжийг дайчилж, суралцахуй болон судлахуйн олон янзын хэв маягийг ашиглан хүмүүсийг нийтлэг хичээл зүтгэлд нэгтгэх өөр олон арга замууд бий. Жишээлбэл, асуудалд-суурилсан болон төсөлд-суурилсан боловсролын арга хандлага нь уламжлалт хичээлээс илүү оролцоотой, хоршин ажиллах боломж олгодог байж болно. Эрэл хайгуулд-суурилсан болон шинжлэн судлах үйлд-суурилсан сурган хүмүүжүүлэх арга зүй нь сурагчдыг мэдлэг эзэмших, хэрэглэх, шинээр бий болгоход нэгэн зэрэг татан оролцуулдаг. Олон нийтийн оролцоо бүхий сурган хүмүүжүүлэх арга зүй болон үйлчлэх суралцахуйг даруу байдлаар явуулсан тохиолдолд суралцахуйн шалтгаант зорилгын хүчтэй мэдрэмж төрүүлдэг. Сурагчдын хамтарсан ажил хийх чадамжийг дээшлүүлдэг, эв нэгдлийн үзэл санааны үүднээс хамт олны хэлэлцүүлэг ба үйл ажиллагаа хэрэгжүүлэх чадавхыг өргөжүүлдэг сурган хүмүүжүүлэх арга зүйг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхийн тулд сургуулийн сургалтын зохион байгуулалт дээр дорвитойхон дахин ажиллах шаардлага байна.

## Сургуулийг дэмжих дижитал

Дижитал харилцааны технологиуд нь сурагчдад ижил төстэй сонирхол болон асуултаар бусадтай холбогдох боломжийг олгодог бол энэ нь багш, сургуулийн ажлыг дэмждэг гэсэн үг. Дижитал холболт нь багш, сурагчдад дэлхийн өнцөг булан бүрээс оруулсан мэдээлэл, бичвэр, урлагийн бүтээлүүдэд хандах бололцоог ихээхэн нэмэгдүүлдэг. Дэлхийн хамгийн том номын сангууд, музейнүүдийн цуглуулгыг одоо хаана ч хэзээ ч ашиглах боломжтой. Мөн дижитал багаж хэрэгсэл нь сурагчдад видео бичлэг хийх, холимог медиа танилцуулга бэлтгэх, тоглоомууд ба аппликейшнууд кодлох зэргээр тэдний бүтээлч санааг дэлхий нийтийн түвшинд гаргах боломжийг олгодог.

Сургуулиудын шинэлэг байдлаар багшлах, суралцах үйлд нь дэмжлэг болох цоо шинэ нөөц потенциал дижитал төхөөрөмжүүдэд байдаг. Дижитал багаж хэрэгсэл нь эцэг эх, багш, сурагчид хоорондын үр өгөөжтэй харилцаа холбоог дэмжих, улмаар эцэг эхчүүдэд хүүхдийнхээ сургуульд суралцахад нь туслах ашигтай арга хэрэглүүр болсон.

Сургуулийг бүхэлд нь виртуал орон зайд шилжүүлэх боломжгүй гэдгийг цар тахал нотолсон. Интернетийн холболт өндөртэй, төхөөрөмжүүд харьцангуй тэгш хүртээмжтэй байгаа газруудад ч гэсэн ид дэгдэлтийн үед сургуулийн хаалгыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хааж, сургуулийн үйл ажиллагаа тасалдсан нь суралцахуй дахь биечилсэн оролцоо болон хамт олны нийгэмшлийн ач холбогдлыг ойлгууллаа. Гэрээсээ орох боломжтой цахим ангиуд нь сургуулийн орон зайг нөхөх хязгаарлагдмал орон зай юм.

Сургуулийг бүхэлд нь виртуал орон зайд шилжүүлэх боломжгүй гэдгийг цар тахал нотолсон.

КОВИД-19 цар тахлаас авхуулаад бусад онцгой байдлын үеийн боловсрол хүртэлх сорилтууд ба үйл явцын тасалдалтын үед ямар ч бэлтгэлгүйгээр шууд авсан арга хэмжээ ба туршилтууд нь багш, сурагчдын шийдэмгий, тууштай, авхаалжтай байдлыг харуулсан. Жишээлбэл, сургуулийн олон системүүд хувь хүний хэрэгцээ, нийгмийн халамжийг нэгдүгээрт тавих ёстойг ухаарсан тул шалгалтыг хойшлуулж, сургалтын хөтөлбөрүүдийн агуулгын хамрах хүрээнд тавигдах шаардлагыг түр зогсоож, харин анги доторх харилцан үйлдлүүд дэх жинхэнэ бодитой суралцахуй, сайн сайхан аж байдалд анхаарлаа төвлөрүүлсэн. КОВИД-19-ийн туршид багш нарын ажил нийтэд, ялангуяа эцэг эхчүүдэд илүү ил тод болсон. Багшаас шаардагддаг өндөр түвшний шинжээчийн мэдлэг, сурагчдаа татан оролцуулах багшлах ур чадварыг олон хүн нэгэн зэрэг үнэлж, сонжин харсан. Зарим сурагчид онлайн болон зайн сургалт таатай санагдсан бөгөөд тэдний энэхүү эерэг туршлага нь ирээдүйн сургуулиуд сурагчийн нийгэмшил, сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, ёс суртахууны хөгжлийг бүхэлд нь дэмжих арга замаар сурагч-төвтэй байх шаардлагатайг санууллаа.

Улам бүр харилцан уялдаатай болж буй дэлхий ертөнцөд хувь хүмүүс бие биедээ санаа тавих, өөр үзэл бодол, туршлагыг найрсгаар хүлээн авах, хүрээлэл орчин, байгалийн баялгийн нөөцдөө хариуцлагатай хандах боломжийг олгохын тулд суралцахуйг нийгэмшил талаас нь тордож дэмжих түүнчлэн иргэний боловсролыг тогтвортой байлгах явдал чухал юм. Зөвхөн дижитал хэрэгсэл нь эдгээр зорилтод хүргэж чадахгүй. Сургууль доторх болон гаднах бусад газруудад оролцоот суралцахуй (participatory learning) болон олон нийтэд түшиглэсэн (engaged learning) суралцахуй зайлшгүй шаардлагатай.

Сургууль бол сурагчид нь өөрийнхөө өнгөрсөн үеийн хязгаарлалтуудаас илүүтэйгээр ирээдүйн бололцоонуудтай нягт холбогддог газар байх ёстой. Нийгмийн гарал үүсэл бол нийгэмшлийнх нь хувь тавилан биш бөгөөд хувь хүний төдийгүй нийгмийн ирээдүй ч өнгөрсөн үеэсээ илүү сайн байж болох тул нийгмийн гарал үүслээсээ үл хамааран бусдын хүлээлтэд баригдахаас өөрийгөө чөлөөлөх боломжийг сурагчдад олгоход тэгш боломжийн зарчим чиглэгддэг.

Ихэнх машинт сургалт (machine learning)-ын гол асуудал нь өнгөрсөн үеийг харж байж л ирээдүйг бий болгож чадна гэдэгт оршдог. Судалгаанаас харахад өнөөгийн нийгэмд оршин байдаг тэр л нэг талыг баримталсан ижил үзлийг агуулсан өгөгдөл мэдээллийн багц дээр машинууд “сургагдсан” байдаг энгийн шалтгаанаар хүний шийдвэр гаргахад байж байдаг нөгөө л хэвшмэл ойлголтууд, жендэрийн ерөөсгөл хандлага, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл одоогийн дижитал платформд нуугдан бэхлэгдэж, улам бүр гүнзгийрсээр байна. Энэ нь технологид суурилсан хувиараа суралцахуйн ихэнх программуудын үндэс болсон алгоритмуудын хувьд үнэн бодит зүйл юм. Ийм сургалтад хамрагдсан сурагчдыг өнгөрсөн удаад хэчнээн асуултын хариулт буруу байсан, ямар сул талууд байгааг илрүүлсэн зэрэг зөвхөн өмнөх гүйцэтгэлтэй нь холбож тодорхойлдог. Энэ нь сурагч дахин шинээр зохион бүтээх, өөрийгөө танин мэдэх болон сургуулиуд тэднийг тэтгэн дэмжих бололцоогоо олж мэдэхэд бага зай үлдээдэг.

Багш нар сурагчдынхаа өмнөх хувийн бүтэлгүйтэлд нь бус харин татагдан оролцох, харьяалал хамааралтай байх бололцоонд нь баримжаалсан таамаглалын янз бүрийн багцад тулгуурласан хувь хүн бүрд тохирсон суралцахуйн дизайнер болж чадна. Дижитал хэрэгсэл нь олон хэлбэрээр багшлах ба суралцах үйлийг дэмждэг. Гэвч энэ нь сурагчдыг хүн төрөлхтний бүтээсэн хамтын мэдлэгийн өв баялаг болон түүний олон янз байдалтай холбож, оюун ухааны эрх чөлөөг дэмжин хамтдаа ажиллах түүнчлэн шударга ёс, тогтвортой ирээдүйг хамтран бүтээх боломжийг олгодог зүйл бол хүмүүс бидний хоорондох нүүр тулсан уулзалтууд, бат бөх харилцаа (багш, сурагчдын хооронд, мөн сурагч хоорондын, багш нар хоорондын) юм.

Бид сурагчдад дижитал орон зай ба хүрээлэл орчныг давтагдаж зөөлрөх чанартай, алдаанд өртөмтгий хүний бүтээл гэж үзэж сургах газар бол бас сургууль юм. Кодлох ба тооцоолох сэтгэлгээ нь боловсролын олон системд үндсэн судлагдахуунууд болон гарч ирсэн. Эдгээр нь манай дижитал байгууламж (digital edifices)-ийг хэрхэн яаж барьж байгуулж байгааг гэрэлтүүлэн тодруулах, тэдгээрийг дахин тохируулах практик болон онолын хэрэгслээр хангахад тустай. Зөвхөн дижитал медиа хэрэгслийн, тэр байтугай боловсролын медиа хэрэгслийн ашиглалт нь суралцагчдад дижитал шинэ бололцоонуудыг тооцож үзэх холын хараатай байх боломж өгөх нь ховор байдаг. Технологиуд ба сүлжээнүүдийн янз бүрийн зохицуулалтын механизм, урамшуулал, чиглэл, логик болон функциональ боломжууд нь биднийг хооронд нь холбож, бидний сэтгэлгээний тухай маш их зүйлийг бидэнд мэдээлдэг. Эдгээр шалтгааны улмаас боловсрол нь дижитал харилцан үйлдлүүд дэх зөвхөн суралцахуйн зорилтуудыг мөшгөх хэрэгсэл биш харин эрэл хайгуул, өөрийгөө судлах судлагдахуун болгон авч үзэх нь чухал юм. Дижитал эрх, тандалт, өмчлөл, нууцлал, эрх мэдэл, хяналт, аюулгүй байдлын талаарх хэлэлцүүлэг нь албан боловсролын нэг хэсэг байх ёстой. Бид хэзээ нэгэн цагт виртуал ертөнцөд амьдарч магадгүй гэж ихэвчлэн ярьдаг ч зарим талаараа, зарим газарт энэ нь аль хэдийн үнэн бодит зүйл болсон. Зарим улс оронд дундаж хүн өдөрт арав гаруй цагийг онлайнд өнгөрөөж, дижитал технологид шимтэх тохиолдлууд цөөнгүй байдаг. Сургуулиуд сурагчдад ийм орчинд өсөж өндийхөд суралцах, тэдгээрийг сорилт

бэрхшээлийг даван туулах, бүтээх, өсөлт хөгжилдөө ашиглахад нь туслах хэрэгтэй. Сургуулиуд хамт олны түүнчлэн хувь хүний талаас технологит тавих хүмүүний хяналтын ёс зүйг сурталчлах ёстой.

### Хорших ажиллагааны соёлыг төлөвшүүлэх нь

Сургуулиуд нь хорших ажиллагаа, хамт олны манлайлал, хамтын суралцахуй болон илүү шударга, үл алагчлагдах ирээдүйн төлөөх тасралтгүй өсөлтийг дэмжих бүрэн чадвартай. Гэсэн хэдий ч үүнийг сургуулийн боловсролын гол чиглэл болгон хэвийн төлөвт байлгахын тулд багш нар, сургуулийн удирдлагууд, бусад ажилтнуудад шинэ чадавхыг хөгжүүлэх шаардлагатай болно. Сургуулийн эгэх хариуцлагыг дагаж мөрдөх хэлбэрээс хамтын зорилгоо тохируулах, үнэлэх үйл явц руу шилжүүлэх шаардлагатай. Сургуулийн удирдлагын менежмент нь тушаах, хянахаас илүү мэргэжлийн хамтын ажиллагаа, бие даасан байдал, харилцан туслалцааг дэмжих хэрэгтэй. Сурагчдын хорших ажиллагааг урамшуулан дэмждэг сургуулиуд нь багш нарынхаа дундах хорших ажиллагааг ч мөн нэгэн адил урамшуулан сурталчлах ёстой. Үүнийг багш, удирдлага, ажилтнуудынхаа мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмждэг сургуулийн соёл дэмждэг. Дасгалжуулалт, зөвлөн туслах ажил, ганцаарчилсан болон бүлгийн судалгаа, үйлийн судалгаа, сургууль ба их дээд сургуулийн хамтын шинжилгээ судалгааны хорших ажиллагаа энэ бүгд нь сургуулийг өөрөө суралцагч байгууллага болж шинэчлэгдэхэд тусалдаг.

Дэлхий даяар хэдэн зуун мянган багш, тоо томшгүй олон сургууль эдгээр чиглэлд аль хэдийн урагшлан ахисан. Жишээлбэл, уугуул ард түмний төрөл бүрийн тохируулгат орчинд үе дамжин ирсэн өвөг дээдсийн мэдлэг, хэл яриа, судалгааны арга барилд тулгуурласан суралцахуй түүнчлэн соёл хоорондын түвшинд хүмүүний бус ертөнцтэй харьцах харилцан үйлчлэлийн эргэн тойронд сургуулиудыг шинээр дахин төсөөлж байна. Өөр тохиолдлуудад сургуулиуд олон нийтийн бүтээлч оролцоо, хамтын бүтээлч хичээл зүтгэлд тулгуурласан эрэл хайгуулыг холбогдох чиг шугамынхаа дагуу өөрсдөө зохион байгуулж байна. ТМБС дахь ахиц дэвшил нь дагалдуулсан сургалт, утга учиржсан курс хичээлүүд, үр өгөөжтэй сургалтын шинэчилсэн хэлбэрүүдээр дамжуулан онол, практикийн хооронд үүссэн зохиомол ялгааг нөхөж байна.

Бидэнд дэлхий нийттэй эв санааны нэгдэлтэй, бусад сургууль болон улс үндэстэнтэй мэдлэгээ хуваалцах үүрэг хүлээсэн, олон нийтийн орон зай, хоршин ажиллах орчин болж шинэчлэгдэх, сэргээн босгоход өөрсдийгөө зориулсан сургуулиуд хэрэгтэй байна. Сургууль нь нийтлэг сайн сайхан байдал болох боловсролыг бүхэлд нь бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

## Сургуулиас дээд боловсрол хүртэлх шилжилтүүд

Түүхээс харахад боловсролын факультетуудаас бусад их, дээд сургууль, коллежууд нь бага, дунд боловсролд анхаарал бага хандуулж ирсэн. Гэсэн ч сүүлийн хэдэн арван жилд их, дээд сургууль, коллежийн оюутнуудын сурлагын амжилттай холбоотой олон асуудлыг дээд боловсрол тэдгээрт



суралцаж эхлэхээс нь өмнө шийдвэрлэх ёстой гэдгийг улам бүр ухамсарлаж байна. Математикаас байгалийн шинжлэх ухаан, утга зохиолоос гүн ухаан хүртэлх дээд боловсрол болон дунд сургуулиуд хоорондын холбоог бэхжүүлэхийн тулд олон янзын завсрын ба нэмэлт хөтөлбөрүүдийг гүүр болгож, ихэнхдээ түүхэнд бага төлөөлөлтэй бүлгүүдийн оролцоог хангах зорилготойгоор боловсруулж хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ боловсролын тухай ерөнхий мэтгэлцээнд их сургуулийн судлаачид илүү товойж тодрох болсон.

Дээд боловсролын үүрэг ролийн талаарх аливаа бодол эргэцүүлэл нь бага, дунд боловсрол, түүнчлэн насанд хүрэгчдийн боловсрол, албан бус боловсролтой салшгүй холбоотой байдгийг орхигдуулан гэж болохгүй. Суралцагчид 2050 онд дээд боловсрол эзэмшиж, түүнээс цааш хөгжихийн тулд бүх шатны боловсролын үнэт зүйл, зохион байгуулалтыг уялдуулах ёстой.

Ирээдүйн дээд боловсролын бодлогын мөрийн хөтөлбөрүүд нь уламжлалт бус боловсролын чиглэл, траекторыг илүү сайн тооцох хэрэгтэй болно.

Ирээдүйн дээд боловсролын бодлогын мөрийн хөтөлбөрүүд нь бүх түвшний боловсролыг хамарч, уламжлалт бус боловсролын чиглэл, траекторыг илүү сайн тооцох хэрэгтэй болно. Боловсролын янз бүрийн түвшин, төрлүүдийн харилцан уялдаа холбоог хүлээн зөвшөөрч, дээд боловсролын ирээдүйн хөгжилд сектор-дамнасан насан туршийн суралцахуйн арга хандлагыг нэвтрүүлэх хэрэгтэй байгааг өгүүлж байна.

Сургуулийн систем болон их дээд сургуулиудын түншлэл нь боловсролыг дахин төсөөлөн төлөвлөх, бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна. Их сургуулийн номын сан, судалгааны байгууламжууд нь бага, дунд шатны сурагчдад дэмжлэг үзүүлэх боломжтой. Профессоруудын мэргэшсэн байдал орон нутгийн сургуулиудын дуудлагад бэлэн байх ёстой. Ийм түншлэл нь шийдлүүд боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх боловсролын системийн институцийн чадавхыг өргөжүүлэн сайжруулна. Эдгээр нь их дээд сургуулиудын судалгаа хийх, багшлах, сурталчлах гэсэн үндсэн гурван чиг үүргээ өнөөдрийн хамгийн чухал зарим асуудлын хүрээнд нийгэмд зориулсан үйлчилгээндээ ухамсартайгаар интеграцчилах бас нэг боломж юм.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Энэхүү бүлэг нь боловсролын нийгмийн шинэ гэрээнд сургуулиуд инклюзив оролцоо, үл алагчлах байдал болон хувь хүний ба хамт олны сайн сайхан аж байдлыг хангах үүднээс боловсролын хотхонуудыг хамгаалахад туслан дэмжихийн зэрэгцээ илүү шударга, илүү үл алагчлагдах, тогтвортой ирээдүйн төлөөх дэлхий нийтийн хувирган өөрчлөлтийг илүү сурталчлан дэмжихийн тулд суралцахуйг шинээр харж, боловсролыг дахин төсөөлөхийг санал болгосон. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж, урагшлахад хэрэгтэй яриа хэлэлцээ, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх дараах дөрвөн зарчим байна.

- **Сургуулиудыг сурагчдад өөр хаана ч байхгүй сорилтууд, бололцоонуудтай нүүр тулгардаг орон зай болгон хамгаалах ёстой.** Хэрэв сургуулиуд оршин байдаггүй байсан бол бид тэдгээрийг шинээр зохион бүтээх хэрэгтэй болно. Сургуулиуд хүмүүсийн янз бүрийн бүлгүүдийг





нэгтгэж, бие биеэсээ суралцдаг бас бусадтайгаа хамтдаа суралцах боломжийг бүрдүүлэх ёстой.

- **Хамт олны чадавхыг бий болгох нь сургуулиудыг дахин дизайнчлахад хөтлөх ёстой.** Сургуулийн архитектур, орон зай, хугацаа/цагийн хуваарь, сурагчдын бүлгийн зохион байгуулалт нь хувь хүмүүсийн хамтдаа ажиллах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байхаар дизайнчлагдсан байх нь зүйтэй. Хорших ажиллагааны соёл нь сургуулиудын засаглал, менежмент, сургуулиуд хоорондын харилцаанд нэвт шингэсэн байх ёстой.
- **Дижитал технологи нь сургуулиудыг орлох биш харин дэмжихэд чиглэх ёстой.** Сурагчийн бүтээлч байдал, харилцаа холбоог өргөжүүлэн сайжруулахын тулд бид дижитал арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй. Хиймэл оюун ухаан болон дижитал алгоритмуудыг сургуулиудад нэвтрүүлэх үед бид тэдгээр нь одоо байгаа хэвшмэл ойлголтууд, хасан гадуурхах системийг зүгээр л тэр чигт нь дахин хуулбарлахгүй байх учиртай.
- **Сургуулиуд хүний эрхийг хангах замаар бидний зорьж буй ирээдүйг загварчилж, тогтвортой байдал, нүүрстөрөгчийн саармагжилтын үлгэр жишээ болох ёстой.** Сурагчдад итгэл хүлээлгэж, боловсролын салбарыг ногоон болгоход манлайлах үүрэг даалгавар өгөх ёстой. Бид боловсролын салбарын бүхий л бодлого нь хүний эрхийг хангаж, урагшлуулдаг баталгааг хангахад чиглэх ёстой.

Боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахдаа хүн төрөлхтний хамгийн чухал, хүчирхэг боловсролын байгууллагуудын нэг болох сургуулийг хамгаалах, хувирган өөрчлөхтэй холбоотой эдгээр үндсэн дөрвөн зарчмаас хүн бүр шинэ санаа олж, урам зориг авдаг байх нь зүйд нийцнэ.

## Бүлэг 7

# Өөр өөр цаг хугацаа, орон зайн боловсрол

 Хээр тал, уулс, хөндий, гол мөрөн, гудамж, талбай, усан оргилуур, орон гэр, байшин барилгыг эзэгнэн амьдарч буй бүхий л хүмүүс бид бүгдийн боловсрох, суралцах, багшлах, мэдэх, бүтээх, мөрөөдөх, төсөөлөн бодох хэрэгцээ шаардлагын дагуу тухайн хот боловсролын зориулалттай болж байдаг бөгөөд хотын бүх зүйл дээр тодорхой цаг үе, хэв маяг ул мөрөө хадгалан, тухайн эрин үеийн таашаал мэдрэмж үлддэг... Хот бол бид, бид бол Хот юм. 

**Пауло Фрейре (Paulo Freire)**, *Улс төр ба боловсрол*, 1993 он.

**Боловсролын нийгмийн шинэ гэрээгээр бид амьдралынхаа туршид болон соёлын, нийгмийн янз бүрийн орон зай дахь боловсролын боломжуудыг эдэлж, тэдгээрийг баяжуулан өргөжүүлж байх ёстой.**

Өнөөдөр олон хүмүүс боловсролыг голчлон хүүхэд, залуучуудад чиглэсэн, тэднийг насанд хүрсэн амьдралд нь бэлтгэхэд зориулагдсан гэж боддог. Нийтийн олон хэлэлцүүлэгт “боловсрол” гэдгийг сурагчийн гэр бүл ба нийгмээс харьцангуй зайтай үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудтай лугаа адилтгаж үздэг. Тусгайлсан орчин нөхцөл нь хамтын суралцахуй ба багшлахуйд тусгайлан зориулагдсан цаг хугацаа болон орон зайг хадгалж хамгаалахад тустай болох нь туршигдаж нотлогдсон. Сургуулийн боловсрол нь өөрийн гэсэн онцлог шинж чанар бүхий хүн төрөлхтний туршлагын чухал орон зай-цаг хугацаа болсон. Хүүхэд, залуучуудад нэн тэргүүнд анхаарал тавих нь боломжийг хүртэх тэгш байдал ба хүртээмжийг ахиулахад чухал ач холбогдолтой байв.

Гэвч боловсролын тухай хэлэлцүүлгийг зөвхөн албан ёсны байгууллагуудаар хязгаарлах нь нийгмийн бүхий л хэсэгт байдаг боловсролын баялаг бололцоонуудыг бүрэн хамруулж чаддаггүй. Энэхүү илтгэлд дэвшүүлсэн боловсролын нийгмийн гэрээний суурь зарчим бол хүн бүрийн амьдралынхаа туршид боловсрол эзэмших эрх юм. Энэ зарчим бол суралцахуй нь төгсгөлгүй үйл явц болохыг зөвшөөрч боловсролыг бүхий л цаг хугацаа, орон зайд улам өргөжүүлж, баяжуулах ёстойг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү зарчим нь нийгэм ба бидний хамтын амьдралын бүх түвшинд тухайлбал, манай хамт олон, хот, тосгон, суурин, үндэсний ёс заншил, соёлын тогтолцоо, бүс нутгийн болон олон улсын хамтын нийгэмлэгт асар их дэг. Ажил хөдөлмөр, халамж асаргаа, чөлөөт цаг, соёл урлаг, спорт, иргэний болон олон нийтийн амьдрал, нийгмийн арга хэмжээ, дэд бүтэц, дижитал болон хэвлэл мэдээллийн оролцоо зэрэг энэ бүгд нь тоо томшгүй олон зүйлийн дундаас бидний хамтын ирээдүйд зориулагдсан нөөц потенциал бүхий гэгээрч боловсрох, сургаж хүмүүжүүлэх, утга учиртай суралцахуйн боломжууд юм. Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь бүхий л цаг үе, орон зайд суралцах динамик соёлын хэрэгцээ ба үнэ цэнийг олж харах ёстой.

Бидний гол ажлуудын нэг бол боловсрол хаана, хэзээ явагддаг тухай ойлголтоо өргөжүүлэх явдал юм. Энэхүү шинэлэг хойшлуулшгүй сорилтыг 50 жилийн өмнө Фаурегийн Комиссын илтгэлд дэвшүүлсэн бөгөөд уг илтгэлд боловсролын тогтолцоог дахин эргэцүүлэн бодоход чиглэсэн “*Cité éducatif*”-ийн алсын харааг тодорхойлсон. Бусад хэл рүү (жишээ нь англи хэл рүү ‘learning society’ буюу “суралцагч нийгэм” гэж) янз бүрээр орчуулсан байдаг бол энд байгаа “city буюу хот” гэдэг нь бүх бололцоо, нөөц потенциалыг өөртөө багтаасан, ялангуяа тэдгээр нь өөр хоорондоо харилцан уялдаатай байдаг орон зайн зүйрлэл юм. Энэ нь боловсролыг дэмжих орон зай болон нийгмийн хичээл зүтгэлийн баялаг шимт чанар, олон янз байдал, түүнчлэн хэн тэдгээрт оролцож байгаа талаар цогцоор нь бодох хэрэгтэй гэсэн санаан дээр суурилдаг.

Өнөөгийн төлөв байдлын тогтсон хэв маяг нь ерөнхийдөө боловсролыг 5-6 наснаас эхэлж арав орчим жилийн дараа төгсгөлийн цэгтээ хүрдэг гэж төсөөлсөөр байна. Хугацааны энэ хүрээ жил ирэх тусам өргөжиж, боловсролын хүчин чармайлтыг бага насны хүүхэд хүртэл өргөжүүлэхийн тулд нярай болон балчир насны хүүхдүүд түүнчлэн насанд хүрэгчид, тэдний амьдралынх нь туршид тархаахад анхаарал хандуулж, ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Эхний тохиолдолд, бага насны хүүхдийн боловсрол нь өөрөө боловсролын бие даасан чухал мөч гэж үздэг ч гэсэн түүнийг ихэвчлэн сургуульд сурахад бэлтгэх “сургуулийн өмнөх” гэж нэрлэсэн хэвээрээ байна.

Хоёрдох тохиолдолд, ихэвчлэн “хоёр дахь боломж” буюу ажлын байранд дахин ур чадваржих ба ТМБС-ын үүднээс авч үзвэл насанд хүрэгчдийн боловсрол нь дэлхийн ихэнх улс орны боловсролын бодлого, стратегийн гол төв болсон хэдий ч энэ нь ихэвчлэн сургуулийн үргэлжлэл, өргөтгөл гэж тооцсон хэвээрээ байна.

Бидний хэлэх гээд байгаа зүйл бол “сургуулийн хэлбэр (school format)”-т суурилсан боловсролын загварууд нь ихэвчлэн бага насны хүүхэд, насанд хүрэгчдийг сургах арга замаар зонхилон дуусаж, боловсролын янз бүрийн, тов тодорхой хэлбэрүүдийг бий болгох бололцоог бууруулдаг. “Сургуулийн хэлбэр”-ийг тодорхой нас ба онцлог шинж чанартай бүлгүүдэд дээрх байдлаар нялзаан хэрэглэхийг эсэргүүцдэг эртний уламжлал байдаг нь үнэн бөгөөд яг ийм ялгаатай байх шалтгаанаар боловсролын өөр өөр үйл явц, үйлийн хүрээ байх ёстой.

Бага насны хүүхдийн боловсролын тухайд бол туршилт, сайн сайхан аж байдал, түүнчлэн сэтгэл хөдлөл, мэдрэхүйн болон харилцааны хэмжигдэхүүнийг үнэлэхэд онцгой анхаарал хандуулдаг боловсролын янз бүрийн стратегийг тохируулан авч хэрэглэснээр энэхүү уламжлал тогтсон юм. Орон зай, цаг хугацааны шинэ зохион байгуулалтын үүднээс авч үзвэл сургуулийн хувирган өөрчлөлт нь бага насны хүүхдийн боловсролын илүү нээлттэй, уян хатан загвараас санаа авах ёстой гэж олон хүн үздэг.

Насанд хүрэгчдийн боловсролын тухайд бол насанд хүрэгчдийн бие даасан байдал болон тэдний амьдрал, ажил, суралцахуйн албан ёсны сургуулийн хүрээнээс гадуурх үйлийн хүрээний туршлагад хүндэтгэлтэй хандсан арга хэлбэр, үйл явцуудыг хэрэгжүүлэхийн тулд олон арван жилийн турш насанд хүрэгчдийн боловсролыг “сургуулийн биш” (deschool) болгох талаар тоо томшгүй олон санал дэвшүүлснээр энэ уламжлал улам ч тод харагддаг. Эдгээр нь хүмүүнлэг бус, дарангуйлах, колоничлох тогтолцооны эсрэг тэмцэж, насанд хүрэгчдийн боловсролтой харилцах харилцаанд нь боломж, эрх чөлөө олгосон боловсролын саналууд юм.

Гэсэн хэдий ч эсэргүүцлийн эдгээр хэлбэрийг үл харгалзан “сургуулийн хэлбэр” нь бага насны хүүхдийн боловсролд ч, насанд хүрэгчдийн боловсролд ч тархан өргөжиж, чухамхүү насан туршийн суралцахуйн чиг хандлагаар жигүүрлэн хүрээгээ тэлж байгааг үгүйсгэх аргагүй юм. 2050 он хүртэл боловсролын талаар тунгаан бодохын тулд бид бүх орон зай, бүх цаг хугацаа, хэлбэрийн боловсролын ач холбогдлыг ойлгох ёстой. Гэвч энэ нь бид дэлхийг асар том нэг анги болгон хувиргана гэсэн үг биш юм. Бидний хийх ёстой сэтгэлгээний үндсэн өөрчлөлт бол өнөөгийн нийгэмд соёл, ажил хөдөлмөр, сошиал медиа, дижитал сүлжээгээр дамжуулан боловсролын тоо томшгүй олон боломжууд байгааг тэдгээрийн байр сууринаас үнэлж, боловсролын чухал боломжууд болгон ашиглах хэрэгтэйг ухамсарлан ойлгох явдал юм. Ирэх 30 жилийн хугацаанд нийгмийн шинэ гэрээний нэг чухал тал бол боловсрол нь амьдралтай хэрхэн сүлжигдэн уялдаж байгааг ойлгох явдал юм. Тиймээс бид сургуулийг боловсролд зориулагдсан ер бусын өвөрмөц орон зай-цаг хугацаа гэж хамгаалахын зэрэгцээ амьдралын бүхий л орон зай, цаг хугацааг хамарсан байхаар алсын хараагаа бас тэлэн өргөжүүлэх ёстой.

**Бид сургуулийг боловсролд зориулагдсан ер бусын өвөрмөц орон зай-цаг хугацаа гэж хамгаалахын зэрэгцээ амьдралын бүхий л орон зай, цаг хугацааг хамарсан байхаар алсын хараагаа бас тэлэн өргөжүүлэх ёстой.**

Энэ бүлэг нь олон тооны боловсролын хотхонууд болон боломжуудын талаар ярилцаж, тэдгээр нь шинэ сорилтуудыг даван туулахад инклюзив оролцоо болон хариу үйлдлийн дэмжлэгээр хангадаг байхад бид хүчин чармайлтаа чиглүүлэх ёстой болох үндэслэлээс эхэлнэ. Дараа нь боловсрол эзэмших эрхийг бодитоор хангахад улс орнууд чухал үүрэг гүйцэтгэхийг, түүнчлэн бидний хамтын ирээдүйд үйлчилдэг байхаар технологи нь боловсролыг дахин төсөөлж төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх дижитал орон зайн засаглалын хэрэгцээ шаардлагыг хэлэлцэнэ. Дэлхийн биосфер нь бас чухал ач холбогдолтой боловсролын орон зай мөн бөгөөд үүнийг орхигдуулж болохгүй. Тус бүлэг нь засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудын онцгойлон сонирхсон яриа хэлэлцээ, үйл ажиллагааны 2050 он хүртэлх удирдамж болох багц зарчмаар төгсөнө. Үүнд насанд хүрэгчдийн инклюзив оролцоотой боловсролын ач холбогдлыг онцлон тэмдэглэх; суралцахуйн шинэ орон зайг дахин төсөөлөх; санхүүжилтийг бэхжүүлэх; боловсрол эзэмших эрхийг өргөтгөх зэрэг багтана.

## Инклюзив оролцоо ба тогтвортой байдлын төлөө боловсролын боломжуудыг удирдах нь

Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд боловсролын засаглал нь боловсролын байгууллага, нийгмийн институци, цаг хугацааны хоорондох харилцан хамаарлын капилляр чанар (capillarity), сүвэрхэг сийрэг чанар (porosity), хаа сайгүй тохиолдох чанар (ubiquity)-тай байдгийг хүлээн зөвшөөрч, үнэлэх ёстой. Ийм олон янзын тоглогчдын инклюзив оролцоо ба тогтвортой байдлын төлөө тэмүүлж ажиллах боломжийг хангахын тулд албан ёсны байна уу, үгүй юу гэдгээс үл хамааран боловсролын боломжууд нь бүх нийтэд хүртээмжтэй байх баталгааг хангасан хорших ажиллагаа ба амлалт үүргийг шаардана.

Инклюзив оролцооны ёс зүй нь энэ оролцоог дизайнчилсан зарчмуудад үндэслэн боловсролыг засаглах бидний хамтын ажлыг удирдан чиглүүлэх ёстой. Эхлэх цэг маань ихэвчлэн хамгийн орхигдон гадуурхагдсан хүмүүс болон хамгийн эмзэг, аюул эрсдэлтэй орчин нөхцөл байх ёстой. Тов тодорхой бөгөөд инклюзив оролцооны үнэт зүйлс байхгүй бол боловсролын экосистем нь эрүүл бус, өвчин эмгэгтэй болж хувирдаг. Эрх мэдэл, эрх ямба, мөлжлөг, хүчирхийлэл дарангуйллын нөхцөл байдал нь аливаа боловсролын харилцаанд нэвчин орж, нөлөөлж болно. Дэндүү олон боловсролын дизайнууд, байгууллагууд нь суралцагчдыг бүтэлгүйтэл, хасагдан гадуурхагдахад хүргэдэг. Тухайлбал, угсаатны бүлгүүд, уугуул ард түмэн болон бусад орхигдон гадуурхагдсан бүлгүүд албан боловсролын системээс завсардахаас илүүтэйгээр түрэгдэн шахагдаж болно. Дүрвэгсэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх үйлчилгээ маш муу байдаг. Боловсролын системийн орон зүйд илүү өргөн хүрээгээр хандах хандлага нь институци, тоглогчид, орон зайн хоорондын гинжин урвал, харилцан уялдаатай нөлөөлөлд онцгойлон анхаарч, эдгээр бүтэлгүйтлийг анзаарахгүй өнгөрөхөд улам хэцүү болгож байна.

## Засгийн газар ба улс орны үүрэг роль

Боловсрол бол хүний үндсэн эрх бөгөөд хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд энэ эрхийг эдлүүлэхэд улс орон, нийгэм онцгой үүрэг хариуцлага хүлээдэг гэдэгтэй дэлхий нийтээрээ зөвшилд хүрсэн. Иймээс засгийн газрууд болон улс орнууд боловсролын экосистемд чухал үүрэг роль гүйцэтгэж, үлэмж хариуцлага үүрдэг бөгөөд үүний төлөө тэд эгэх хариуцлага хүлээх ёстой болдог.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд тусгагдсан боловсрол эзэмших эрхийг улс орнууд хууль зүйн хувьд заавал дагаж мөрдөх хэд хэдэн гэрээгээр улам боловсронгуй болгосон. Эдгээрт 1960 оны Боловсрол дахь ялгаварлан гадуурхахын эсрэг конвенц (Convention against Discrimination in Education-CADE) болон 1966 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын (International Covenant on Economic, Social and Cultural Rights-ICESCR) 13 дугаар зүйл багтана. Энэхүү хоёр дахь пактын оролцогч бүх улсууд боловсрол нь чөлөөт нийгмийн амьдралд үр өгөөжтэй оролцох боломжийг бүх хүнд олгож, бүх үндэстэн хоорондын харилцан ойлголцол, хүлээцтэй байдал, эв найрамдлыг дэмжих ёстой гэдэгт санал нэгдсэн.

Одоогийн олон улсын хууль тогтоомжид нэгдсэн улс орнууд бага боловсролыг заавал эзэмших, үнэ төлбөргүй боловсрол байлгах үүрэгтэй. Дунд боловсрол нь янз бүрийн хэлбэрээрээ бүх нийтэд боломжтой (available), хүртээмжтэй (accessible) байх ёстой. Дээд боловсрол нь хувь хүний чадавхад суурилсан, хүн бүрд тэгш хүртээмжтэй (equally accessible) байх ёстой. Улс орнууд боловсрол эзэмших эрхэд хамааралтай *биелүүлэх, хүндэтгэх, хамгаалах* гэсэн гурван үүрэг хүлээдэг. Төрийн биелүүлэх үүрэг нь дэмжих, хангах үүргийг агуулдаг бол хүндэтгэх үүрэг нь боловсрол эзэмших эрхийг дордуулах арга хэмжээнээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Эцэст нь, төр боловсрол эзэмших эрхэд хамаарах гуравдагч этгээдийн хөндлөнгийн оролцооноос хамгаалах, урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

Боловсрол эзэмших эрх нь хүний бусад эрхтэй нягт холбоотой байдаг. Энэ утгаараа эрхийн баталгаа гаргадгийн хувьд улс орнууд бүх хүүхэд, залуучуудын суралцахуйг боломжтой болгож, хөнгөвчлөхөд зайлшгүй шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэхийн тулд салбар дамнансан хүчин чармайлтуудыг уялдуулах үүрэг хариуцлага хүлээдэг. Энэ нь ус, ариун цэврийн байгууламж, эрүүл хоол хүнс, шим тэжээл, нийгмийн хамгаалал болон сэтгэл санаа, бие махбодын сайн сайхан аж байдлыг хангасан бат бөх, эрүүл гэр бүл ба нийгмийн орчинд аж төрөх амьдрал, хүчирхийллийн бүх хэлбэрээс ангид эрх чөлөөтэй амьдрал зэрэг хүний түгээмэл эрхүүдээ эдлэх боломж ба нөхцөлийн хүртээмжийг хангана гэсэн үг юм.

2000-аад оны эхэн үеэс эхлэн НҮБ-ын Боловсролын эрхийн асуудлаар мэргэшсэн тусгай илтгэгчид боловсролыг нийгмийн хамтын ашиг сонирхлыг хамгаалдаг нийтийн сайн сайхан байдал гэж нэрлэж ирсэн. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2005, 2015 онд гаргасан боловсролын эрхийн тухай тогтоолууддаа боловсролыг нийтийн сайн сайхан байдал гэж хүлээн зөвшөөрсөн. 2015 онд “Боловсрол 2030: Инчоны тунхаглал ба үйлийн хүрээ” гэсэн баримт бичгийг Дэлхийн Боловсролын Форумаас 160 гаруй орны төлөөлөгчид баталсан. Энэхүү баримт бичигт боловсрол бол “хүний үндсэн эрх бөгөөд бусад эрхийг хэрэгжүүлэх баталгааны үндэс” мөн түүнчлэн “боловсрол бол нийтийн сайн сайхан байдал бөгөөд түүний төлөөх албан үүрэг хариуцлагыг төр үүрнэ” гэдгийг дахин нотолж, стандарт, хэм хэмжээг тогтоох ба мөрдүүлэхэд төр гол үүрэгтэй гэж үзсэн.

Боловсролын экосистем нь боловсролыг нийтийн сайн сайхан байдал болгон тулж түшдэг болоход Засгийн газрууд гол үүрэг гүйцэтгэх ёстой. Өмнө дурдсанчлан, бидэнд “онцгой нөхцөлд бүгд гар нийлэн ажиллах” (all-hands-on-deck) арга хандлага хэрэгтэй. Боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгож шинэчлэх үүрэг нь хаа сайгүй жишээлбэл, бүх сурган хүмүүжүүлэгчид, бүх сургууль, боловсролын бүх хөтөлбөрт хамаатай. Түүнчлэн, дэлхийн даяар маш олон тохиолдолд төрийн болон төрийн бус олон тоглогчид хамтдаа нийтийн боловсролыг олон нийтэд сурталчлах, тэдний анхаарлыг татах боломж олгодгийг санах нь зүйтэй.

### Улс орнууд боловсролын тогтолцоог зүй зохистой, үл алагчилсан шударгаар санхүүжүүлэх гол үүрэг хариуцлага хүлээдэг.

Улс орнууд боловсролын тогтолцоог иргэдийнхээ болон түүний хамгаалалтад амьдарч буй бусад хүмүүсийн хэрэгцээг хангахуйц түвшинд зүй зохистой, үл алагчилсан шударгаар санхүүжүүлэх гол үүрэг хариуцлага хүлээдэг. Улс орнууд хувийн баялгийг татварын диваажин дахь оффшор бүсэд алдалгүй, харин нийтийн сайн сайхны төлөө зохих ёсоор хувь нэмэр оруулдаг байх татварын бодлогоор дамжуулан шаардлагатай төрийн санхүүжилтийг бүрдүүлэн өсгөх ёстой. Засгийн газрууд

боловсрол эзэмших нийтлэг эрхийг хэрэгжүүлэхийн тулд эдгээр нөөцийг үл алагчилсан шударгаар, үр ашигтайгаар зарцуулах ёстой.

Тухайн экосистемийн хүрээнд бүх үйлчилгээ үзүүлэгчдээс хүний эрхийг хүндэтгэж, аюулгүй, чанар сайтай суралцахуйн туршлагаар хангаж буй боловсролын үйлчилгээг зохицуулахад улс орнууд гол үүрэг гүйцэтгэдэг.

Эцэст нь, улс орнууд нутаг дэвсгэрийнхээ хилийн дотор амьдардаг иргэд болон бусад хүмүүсийн хэрэгцээ ялангуяа, түүхэн нөхцөл байдлын үүднээс хасагдаж гадуурхагдсан эсвэл орхигдож гадуурхагдсан хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээгээр хангах ёстой. Боловсролын тогтолцооны сайн засаглал нь шийдвэр гаргалт, яриа хэлэлцээнд иргэд болон бусад хувь нийлүүлэгчдийг татан оролцуулахыг шаарддаг бөгөөд бүх түвшинд ихээхэн ил тод, эгэх хариуцлагатай байх шаардлагатай гэсэн үг юм.

Уугуул иргэдийн тухайд нэмэлт заалтууд байдаг. Уугуул ард түмний эрхийн тухай НҮБ-ын тунхаглалд уугуул иргэд төрөөс баталгаажуулсан боловсролын бүх түвшин ба хэлбэрт хамрагдах эрхээс гадна “өөрсдийн хэл дээр боловсрол эзэмших, тэдний соёлд тохирсон арга барилаар суралцах ба багшлах боломж олгосон боловсролын тогтолцоо, байгууллагыг бий болгох, хянах эрхтэй” гэж тэмдэглэжээ.

Ялангуяа, уур амьсгалын өөрчлөлтийн дарамтаас болж хүн амыг амьдрах байршлаа өөрчлөн нүүхэд (displacement) хүргэж, төрийн хамгаалалтгүй дүрвэгсэд (refugees) эрс олширч дэлхий даяар албадан шилжилт хөдөлгөөн (forced migration) нэмэгдэж байгаа тул тэдэнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Ийм нөхцөл байдалд боловсрол эзэмших эрхийг хангахад олон улсын байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь чухал бөгөөд ийм нөхцөл байдал нь улам бүр түгээмэл шинжтэй болж магадгүй юм.

## Дижитал суралцахуйн орон зайг засаглах нь

Зөв, сайн ашиглаж чадвал технологи нь боловсролд нийтийн байх шинж чанар, инклюзив байдал, нийтлэг шалтгаант зорилгыг дэмжих боломжтой. Дижитал технологийн үндэс суурь нь олон талт логик байдаг бөгөөд зарим нь чөлөөлөх асар их нөөц потенциалтай, зарим нь асар их нөлөөтэй бас эрсдэлтэй байдаг. Энэ талаараа “дижитал хувьсгал” нь хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хувьсгал зэрэг өнгөрсөн үеийн бусад агуу технологийн хувьсгалуудаас ялгаагүй юм. Хамтын томоохон ололт амжилтууд нь тэгш бус байдал, хасан гадуурхалт зэрэг сэтгэл түгшээсэн өсөлтүүдийг дагуулж ирсэн. Гол сорилт нь эдгээр холимог үр нөлөөг залуурдах хийгээд тэдгээрийн ирээдүйн дам үр дүнгүүдийг хянах явдал юм.

Боловсрол, мэдлэгтэй холбоотой дижитал технологийн талаарх гол шийдвэрүүдийг нийгмийн орчинд гаргахдаа боловсролын нийтийн болон нийтлэг сайн сайхны төлөө гэсэн зарчмыг удирдлага болгох шаардлагатай байна. Энэ нь дижитал дэд бүтцүүд дэх хувийн өмчийн хяналтыг шийдвэрлэх, мөн боловсролын экосистемийн нэг хэсэг болж улам бүр өсөн нэмэгдэж буй дижитал нийтлэг мэдлэгийг ардчилсан бусаар эзэгнэх, хаан боогдуулахаас хамгаалах гэсэн утга санаа юм.

Сүүлийн хэдэн арван жилд дижитал платформууд нь мэдлэг, боловсрол, шинжилгээ судалгаанд тодорхой хувь нэмэр оруулсан хэдий ч нийгмийн ашиг тус нь ихэвчлэн технологи үйлдвэрлэлийн бодит, зар сурталчилгааны нүсэр бизнесийн загварын дайвар байдаг. Жишээлбэл, Google/Alphabet нь бидний дижитал амьдрал дахь хүрээгээ тэлэхийн тулд нийтийн дижитал орчны хамгийн чухал зуучлагчдын нэг болсон. Тиймээс Google Scholar, Google Classroom гэх мэт боловсролын хамгийн чухал үйлчилгээнүүдийн зарим нь зар сурталчилгаанаас ямар ч орлого олдоггүй бөгөөд Google тэднийг дэмжих ашиг сонирхолтой л байвал ихээхэн хэмжээний зардал гаргана. Энэ нь боловсролд улам бүр чухал болж буй дижитал дэд бүтцийг маш эрсдэлт байдалд байгааг харуулж байна.

Үүнтэй төстэй нөхцөл байдалд орж, эцэстээ хаагдсан Google-ийн бусад үйлчилгээний маш урт жагсаалтыг тооцож үзвэл ерөнхийдөө одоогийн зохицуулалтын хэврэг, эмзэг байдалд санаа зовох үндэслэл байна. КОВИД-ын цар тахлын улмаас 2020, 2021 онд олон их сургуулийн байгууламжууд хаагдахад манай гараг дээрх хамгийн баян чинээлэг, хангамж тохируулга сайтай зарим их сургуулийн эрдэмтэд хүртэл Google Scholar зэрэг үйлчилгээний ашиг тусын талаарх Google-ийн зөвхөн дотоод шийдвэрээр л материалуудад хандах боломжтой байсан. Google Scholar нь олон жилийн турш оршин тогтнохдоо цөөн хэдэн өөрчлөлтийг хийсэн бөгөөд томоохон шинэ функцүүд нэмээгүй нь компанийн ерөнхий төлөвлөгөөнд энэ чиглэл чухал биш, ач холбогдол багатай байдгийг харуулж байна. Энэ нь суралцахуй дахь хувийн хэвшлийн дэд бүтцийн хэврэг, эмзэг байдлын талаарх сэрэмжлүүлэг болж, нийтийн боловсролын ирээдүйн төлөөх найдвартай нийтийн дижитал дэд бүтцийн илүү бат бөх загварууд байгаа эсэхийг асуухад хүргэж байна.

Дижитал платформуудын олон нийтэд үнэ төлбөргүй байх чадамж нь “шинэ газрын тос”-той зүйрлэхүйц маш ашигтай бүтээгдэхүүн болох хэрэглэгчийн хувийн мэдээллийг асар их хэмжээгээр системтэй олборлохоос ихээхэн хамаардаг. Эхэндээ энэ өгөгдөл мэдээллийг зар сурталчилгааны борлуулалтад ашиглах зорилгоор цуглуулсан. Хожим нь дижитал үйлчилгээний ард ажилладаг платформууд дахь асар том, байнга өргөжиж буй хэрэглэгчдийн мэдээллийн сангийн зарим нэг хэсгийг арилжааны үйлчилгээ ба бүтээгдэхүүнүүд бий болгох, сайжруулахад ашигтай төдийгүй



хиймэл оюун ухаан, машины суралцахуйгаар дамжуулан шинэ санаа, үзэл бодол, сонголтуудыг инженерчлэхэд ашиглаж болохыг олж мэдсэн.

Энэ нь дэлхийн хамгийн том компаниудын хооронд хиймэл оюун ухааны салбарт ноёрхохын төлөөх уралдааныг эхлүүлсэн бөгөөд тэд зах зээлийг эзлэх энэ тэмцэлд ялалт байгуулахыг эрмэлзэх болсон. Үүний үр дүнд өнөөгийн дижитал эдийн засаг нь цахим ном уншигчаас эхлээд интернэт хөтөч, ухаалаг цаг хүртэл байгууллага болон хувь хүмүүсийн хувьд өмнө нь нүдээр үзэх боломжгүй байсан мэдрэгч, алгоритм, сүлжээг амьдралын домэйн болон халаасанд тараан түгээхийг зөвшөөрч, олборлолт заавал хийгдэж байх үзэл баримтлалд хөтлөгдөж байна. Бид газар сайгүй, байнгын хараа хяналт дор буюу ажиглалт тандалтад байх цаг үед амьдарч байна гэсэн олон хүмүүсийн мэдрэмж нь улс төрийн асар их үр дагавартай. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хүмүүсийн оюун санааны бие даасан байдлын мэдрэмжид жихүүцэл, айдас төрүүлэхүйц нөлөөлөл үзүүлдэг. Ажиглалт тандалттай холбоотой ийм түгшүүр нь хүмүүсийн бүтээлч үйл ажиллагаанд өөрийгөө цензурдэх үл үзэгдэх саад тотгорыг бий болгож, хэн нэгэн бухимдал ихтэй эсвэл аюултай ном унших нь хүний нэр хүндэд ноцтой нөлөө үзүүлж болох уу гэсэн хоёрдогч асуултуудыг төрүүлдэг бөгөөд энэ нь өнөөдөр бидний онлайн үйлийн шууд үр дагавар болж байна.

Ажиглалт тандалт, олборлолт нь манай боловсролын экосистемд нэвтэрсэн тохиолдолд дээрхтэй ижил төстэй нөлөөлөл, түгшүүрүүд үүсэж болно. Ажиглалт тандалтыг хэвийн зүйл болгон үргэлжлүүлэх нь ялангуяа, боловсролын систем нь хүүхдийг бага наснаас нь эхлэн үүнд дасгах нь хүний эрхэм чанар гэсэн бидний ойлголтыг үндсээр нь элэгдэлд оруулах, мөн хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний хувийн нууцын халдашгүй байдлыг алдагдуулж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг үлэмж хэмжээгээр алдагдуулах зам руу чиглүүлж байна.

Боловсролын экосистемд эзлэх дижитал платформуудын байр суурийн талаарх ямар ч яриа хөөрөөнд сурагч ба багшийн өгөгдөл мэдээллийг хамгаалахад анхаарал хандуулж, санаа тавьж сэтгэл зарах хэрэгтэй. Дижитал орон зайд өгөгдөл цуглуулах, хадгалах, хяналт-шинжилгээ хийхэд хялбар байх нь багшлахуй ба суралцахуйг сайжруулахад тусална. Сурагчид болон багш нарыг хэт халдлагад өртөхөөс хамгаалахын тулд зохих дүрэм, журам, протокол шаардлагатай. Ил тод байдлын ёс зүй нь өгөгдлийн бодлогыг удирдан чиглүүлэх ёстой бөгөөд анхдагч тохиргоо нь хувь хүмүүст хор хөнөөл учруулахгүйн тулд өгөгдлийг тодорхой эзэнгүй болгож нууцлах явдал юм.

Мэдлэгийг баяжуулах алгоритмын хэлбэр бүхий дижитал платформууд боловсролын экосистем болон бусад олон салбарт тэргүүлж байгаагийн нэг шалтгаан нь дэлхий нийтийн хэмжээнд хурдацтай өсөн нэмэгдэж буй өргөн цар хүрээтэй мэдлэг, мэдээллийг системтэйгээр зохион байгуулах, хариуцан зохицуулахад учирч буй сорилтод олон нийтийн хэрэгжүүлэх боломжтой хариулт байхгүй байгаатай холбоотой юм. Үүний үр дүнд шинжээчид ч гэсэн одоо өөрсдийн мэргэшсэн, мэдээлжсэн санал бодлоо нийтэлдэг платформыг сайжруулах алгоритмыг дур зоргоороо барьцаалдаг дижитал платформуудын зуучлалын үйлчилгээнд найдах шаардлагатай болжээ. "Хуурамч мэдээ" (fake news) болон шинжлэх ухаан, төрийн байгууллагуудад итгэх итгэл найдварын хямрал зэрэг өнөө цагт олон газарт ажиглагдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх урт хугацааны шийдлийг олоход үнэн зөв, магадлан итгэмжлэгдсэн мэдээлэл бүхий бидний хамтын оролцоо мөн мэдлэгийг цуглуулан сонгох буюу өгөгдөл, мэдээллийн сан хөмрөгийг бэхжүүлэх үйл явцын ардчилал нэн шаардлагатай байна.

Эдгээр олон жишээ нь боловсролын дижитал дэд бүтцийн хэврэг, эмзэг байдлыг тодруулж байна. Илүү сайн дижитал хэрэгслүүдийг зохион бүтээх боломжтой төдийгүй тэдгээрийг зохион бүтээх ёстой ч боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон дэмжих чиглэлд дижитал тасалдалтыг арилгах хамгийн сайн стратеги бол олон нийтийн хүрээнд түүний ардчиллыг шийдэмгий, тууштай байдлаар хангах явдал юм. Нээлттэй эх сурвалж, хоршин ажиллах хамтын хүчин чармайлтаар олон тооны дижитал нийгэмлэгүүд болон интернэтийн анхны технологиуд бий болж хөгжиж ирсэн. Тогтвортой байдал, шударга ёс, инклюзив оролцоог удирдлага болгох чиглэлээр боловсролын дижитал технологиудыг тасралтгүй хөгжүүлэхийн тулд засгийн газраас арга хэмжээ авахдаа иргэний нийгмийн дэмжлэг ба боловсролд хандан өргөн олны хүчин чармайлт нь боловсролыг ашиг гаргах талбар биш, харин тогтвортой, шударга, амар амгалан хамтын ирээдүйд зориулан улсын хөрөнгө оруулалт хийх орон зай гэж үзэж ажиллахыг шаардах ёстой.

Боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон дэмжих чиглэлд дижитал тасалдлыг арилгах хамгийн сайн стратеги бол олон нийтийн хүрээнд түүний ардчилалыг шийдэмгий, тууштай байдлаар хангах явдал юм.

### Амьд гарагтайгаа хамт суралцахуй

Бид хүнд төвлөрсөн орон зай, институциас гадна цэцэрлэгт хүрээлэн, хотын гудамж, хөдөөгийн зам, цэцэрлэгжүүлсэн талбай, зэлүүд газар, тариалангийн талбай, ой мод, элсэн цөл, нуур цөөрөм, намгархаг газар, далай тэнгис болон бусад бүх зүйлийг багтаасан хүний амьдралын орон зайнаас илүү хүмүүний бус ертөнцийн чухал хотхонуудад явагдах суралцахуйн талаарх ойлголтоо өргөжүүлэх ёстой.

Хүмүүс бол Дэлхий хэмээх амьд гаригийн нэг хэсэг юм. Эртний олон уугуул соёлууд хүмүүс ба хүмүүний бус харилцан үр өгөөжтэй харилцааг бий болгох талаар зохих ёсны өргөн хүрээтэй үзэл баримтлалыг авч үздэг. Биосфер бол суралцахуйн чухал орон зай юм. Өнөөдөр дэлхийн биологийн олон янз байдлын 80 орчим хувь нь уугуул иргэдийн засаглалтай газар нутагт байгаа нь нутгийн уугуул иргэдийн үзэл баримтлал нь эх дэлхийгээ халамжилж хайрладаг боловсролыг хүн бүрд зааж сургах их зүйл байдгийг хангалттай харуулж байна.

Уугуул иргэдийн газар- ба усанд-суурилсан мэдлэг, сургаал түүнчлэн Африк, Азийн олон сансар огторгуй судлаачид нь хүмүүний бус ертөнцийг зөвхөн өөрсдийн гэсэн оршин байх эрхтэй гэж ойлголгүй, харин сурган хүмүүжүүлэгч, багш нар гэж ойлгох харилцан холбоонд суралцуулдаг. Зарим ёс уламжлалд хүмүүний ертөнцөөс илүү дээд ертөнцийн элементүүдийг урт настай, мэргэн ухаантай, хүндэтгэх ёстой гэж ойлгодог бөгөөд тэдгээр нь бидэнд сургах зүйл ихтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Барууны боловсролын уламжлалд эдгээр асуултын заримыг авч үзсэн урт түүх бий. Газар нутаг, байгаль орчин, гаднах орчин, туршилтад суурилсан боловсролын талбар нь суралцахуйн үйл явцад байгаль ертөнц, хүрээлэл орчны оролцоог хамтран-оролцогчийн байр сууринд байлгахыг оролдож ирсэн. Гэвч эдгээр ажилд хүрээлэл орчныг сурагчдын суралцах үйлд үйлчилдэг гэж үздэг. Сурагчид

өөрөөр мэдэж чадахааргүй байсан чухал зүйлсийг эдгээр нүүр тулах уулзалтуудаар дамжуулан сурдаг тохиолдол ихээхэн гардаг. Ихэнх тохиолдолд хүн-байгалийн харилцааг харилцан тэгш шинжтэй, харилцан хамааралтай байдаг талаар төсөөлдөггүй. Түүнчлэн хүмүүс хүмүүний бус ертөнцийг өөрийн гэсэн арга хэлбэр, оролцоо нөлөөлөл бүхий багш гэж ойлгодоггүй. Хүрээлэл орчин ба газар нутагт суурилсан боловсролын сүүлийн үеийн хэлбэрүүд энэ байр сууринаас улам холдож байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхээс эхтэй, боловсролыг “дахин онголон сэргээх” (rewilding) гэсэн зүйрлэл нь боловсролыг шинээр бүтээх нэн ирээдүйтэй үзэл санаа юм.

Дэлхийн мэдлэгийн олон систем ба сансар судлал хоорондын яриа хэлэлцээгээр бий болж буй сурган хүмүүжүүлэх нүүр тулах уулзалтууд нь боловсрол ба амьд гараг хоёрын хоорондын харилцааг эх Дэлхийтэйгээ хамтдаа хувьсаж, хамтдаа үүсэн бий болох харилцаа болгон дахин тодорхойлоход нэгэн адил ирээдүйтэй чухал арга зам болох юм. Хүн төрөлхтөн өөрийгөө зөвхөн нийгмийн амьд оршихуй биш экологийн амьд оршихуй гэж ойлгох хэрэгтэй. Биднийг байгалийн “халамжлагч” буюу “хамгаалагч” болгож буй байгаль орчныг удирдан зохицуулж буй зарчмууд нь хүн төрөлхтөн ба тэдний хүрээлэл орчныг хоёр тусад нь хувааж үзэхийг санал болгодог хэвээр байна. Бидний экологийг дахин төсөөлөхдөө амьд гараг дотор өөрсдийгөө бүрэн байршуулах ёстой.

Хүмүүсээс шалтгаалан үүссэн экологийн хямрал нь нийтлэг шалтгаант зорилгод чиглэсэн боловсролын гол цөм болох суралцагчийн талаар дахин эргэцүүлэн бодоход хүргэж байна. Зөвхөн хүний хөгжилд голлон анхаардаг боловсролд төсөөлөгддөг “ХИХ зууны суралцагч” гэгдэх харилцан уялдаатай ертөнцөд өөрийгөө эрх чөлөөтэй, чадварлагаар мэдэрдэг, төгс төгөлдөр космополитан суралцагчийн төлөө боловсрол зорьж болохгүй. Боловсролыг шударга, тогтвортой ирээдүйг дэмждэг болгохын тулд бид гараг ертөнцийг бүхэлд авч үзэх ухамсраа (consciousness of the planetary) хөгжүүлэх ёстой. Бусад оршихуйтай хамт ертөнцийг бүтээх үүрэг хариуцлага хүлээсэн суралцагчийг боловсролын төвд байрлуулах ёстой. Энэхүү хэтийн шинэ төлөв нь бараг бүх салбар дахь боловсролын практикт нөлөөгөө үзүүлнэ. Ялангуяа, дэлхийн иргэний боловсрол нь гараг ертөнцийг бүхэлд нь авч үзэх энэхүү ухамсартай нягт уялдаатай байх ёстой.

Амьд гарагтай харьцах харилцаагаа дахин тэнцвэржүүлэх нь биднээс харилцан хамааралдаа дахин суралцаж, хүний байр суурь, сонгох эрхээ дахин төсөөлөхийг шаарддаг. Бид хүн төрөлхтнийг дэлхийн бусад хэсгээс салгаж чадахгүй гэдгийг олон соёл иргэншил олон зуун, мянган жилийн туршид ухаарч ирсэн. Жишээлбэл, Кечуа (Quechua) хэлээр “Сумак Кавсай” (Sumak Kawsay) хэмээх ойлголт нь байгальд эрх олгох бөгөөд экологийн хувьд тэнцвэртэй амьдралын хэв маягийг дүрсэлсэн байдаг. Үбүнтү (Ubuntu)-гийн Нгуни Банту (Nguni Bantu) философийн харилцан хамаарал (бид байгаа учраас би байна)-ын зарчмууд нь Буддын шашны Каруна (Karuna)-гийн ёс зүй (нигүүлсэх ариун сэтгэл)-н нэгэн адил олон чухал зүйлийг санал болгодог бөгөөд хүн төрөлхтний эш болгож болох соёлын баялаг нөөцөөс ердөө хоёрхон жишээг дурдахад ийм байна.

Бусад нийгмүүд өнөөдөр ч гэсэн, заримдаа зовлонтой зүдгүүртэйгээр, бидний хүмүүний болон гараг ертөнц хоорондын хамтын харилцан хамааралтайгаа ухамсарлаж эхлээд байна. Бид 2050 он гэхэд эв зохицол, сайн сайхан аж байдал, шударга ёсны зарчмаар Дэлхийн нэг хэсэг болж хэрхэн амьдрах вэ? Дэлхий нийтийн түвшний бүрэн хариулт бидэнд хараахан байхгүй байна. Амьдралын бүхэл бүтэн (wholeness) байдалд үндэслэсэн боловсрол нь хамтын шийдэл боловсруулах гол арга хэрэгслүүдийн нэг байх ёстой.

## Боловсрол “хэзээ” эзэмших цаг хугацаа ТЭЛЭЛТ

Илүү олон хүн урт насалж, эрүүл саруул амьдрахын хэрээр боловсролын амьдралтай уягдан холбогдох (life-entangled) арга замууд өөрчлөгдөнө. Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувьд залуучууд ба ахмад настан хоорондын тэнцвэрт байдалд, иргэдийн дундах хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувьд, түүнчлэн хэнээр, хэзээ асран халамжлуулах болон сайн дурын халамжийн ажил (цалинтай, цалингүй)-ын төрлүүдэд шилжилт гарах үед боловсролын хэрэгцээ, тэргүүлэх чиглэл, арга хэлбэрүүд өөрчлөгддөг. Үнэн хэрэгтээ эдгээр асуудал нь манай нийгэм үнэ цэнийг бий болгоно гэдэг юу гэсэн үг вэ гэсэн үндсэн таамаглалд шинэ гэрэл гэгээ тусгадаг.

### Амьдралын турш дахь боловсрол ба халамж

Бидний сайн сайхан аж байдал, эдийн засгийн аюулгүй байдал зөвхөн албан ёсны эдийн засгаас бий болдоггүй гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрч байна. Цалинтай ажил бол эдийн засгийн нэг хэсэг ч гэлээ хүнээ асран халамжлахын тулд гэр бүлдээ хийж байгаа ажил түүнээс дутахааргүй чухал юм. Үүнд хүүхэд, ахмад настныг асрах, хоол хүнс бэлтгэх, үйлдвэрлэх, орон байр барих, экологийн дарамттай олон газарт бол ус авах зэрэг хөдөлмөр багтана. Гэр бүл, олон нийт, эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, тэр ч байтугай хүрээлэл орчин, экосистемийн эрүүл мэндийг дэмжихэд охид, эмэгтэйчүүд хамгийн их ачааг үүрдэг ч тэдний оруулдаг асар их, чухал хувь нэмрийг чамлалттай хэмжээнд хүлээн зөвшөөрч, дэмждэг.

Ирэх 30 жилийн хугацаанд нарийн нийлмэл харилцан үйлчлэл нь “хангалтын (provisioning)” гэхээр эдгээр бүх төрлийн үйл ажиллагаа хоорондын тэнцвэрийг бүс нутгийн болон орон нутгийн түвшинд ялгаатай арга замуудаар дахин шинээр тогтоох болно. Зарим бүс нутагт эрүүл мэндийг сайжруулах ба/эсвэл ажиллах хүчний хомсдол нь ахмад настнуудад ажиллах хүчнээр удаан үлдэх боломж болон шаардлагыг бий болгож болзошгүй юм. Бусад тохиолдолд ахмад настны асрамжийн сорилтууд нь сүүлийн 30 жилийн хугацаанд ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн тоо улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор хүүхэд асрах сорилтуудтай адил түвшинд зэрэгцэн ирж болох юм. Хэрвээ дэлхийн олон газарт хамтын амьдрал, том гэр бүлийн дэмжлэг илүү ач холбогдолтой болбол өрх гэрийн шинэ хэлбэрүүд гарч ирж магадгүй. Энэ бүгд нь хүмүүсээс урт хугацаанд үргэлжлэх, бат бөх, анхаарал халамжтай харилцааг бий болгох чадавхыг шаардаж, улмаар бүх насны суралцагчдын боловсролын асуудал болж байгааг харуулж байна.

Асран халамжилж сурах болон асаргаа халамжийг амьдралтай холбоотой боловсролын нэг онцлог болгох нь зүгээр л нэг “байхад аятайхан” байдаг шинж чанар биш юм. 2050 он ба түүнээс цааших хугацааг харж байгаа бол үүнд буулт хийхээргүй хатуу логик бий. Өдөр тутмын хоол хүнс бэлтгэх, заримдаа тариалах ажлыг дэмждэг боловсрол, мөн бие махбод, гэр бүлээ тэжээж тэтгэх боловсролыг нэн тэргүүнд тавих ёстой. Энэ бол өөр өөр орон зай, цаг хугацаанд явагдах боловсролыг амьдралтай холбох талаар маш тодорхой ойлголтод биднийг чиглүүлэх суралцахуйн илүү өргөн хүрээний хэтийн төлөв юм.

## Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг чөлөөлөх төсөл

Сүүлийн хэдэн арван жилд насан туршийн суралцахуйн зарчим дэлхийн хэмжээнд боловсролын бодлого боловсруулалтын гол цөм болсон. Жишээлбэл, ТХЗ 4 нь “Хүн бүрийг чанартай боловсрол эзэмших инклюзив оролцоо, үл алагчлах шударга нөхцөлөөр хангаж, насан туршдаа сурч боловсрох боломжийг нь хөхиүлэн дэмжих”-ийг бидэнд уриалж байна.

Насанд хүрэгчдийн суралцахуй болон боловсролыг чөлөөтэй болгох хүчтэй уламжлал байдаг бөгөөд энэ нь хувь хүмүүст нээж өгч буй нөөц потенциалд тусгалаа олж, өргөн хүрээтэй иргэдийн оролцоо нь ямар утгатай болохыг харуулж байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд насан туршийн суралцахуйн мэргэжлийн болон ур чадварын хэмжүүрт хэт их анхаарал хандуулснаар энэ нь багасаж байна. Нэг ёсондоо насанд хүрэгчдийн, ялангуяа амьдралынхаа эхэн шатанд боловсрол бүрэн эзэмшиж чадаагүй хүмүүсийн хамгийн чухал “эрх”-үүдийн нэг байсан зүйл нь олон хүний хувьд цаг үетэйгээ хөл нийлүүлсэн, ажилтай байх “үүрэг” болж хувирсан. Үр дүн нь ур чадваржих, дахин ур чадваржих гэсэн байнгын логик юм.

Насанд хүрэгчдийн боловсрол нь хөдөлмөрийн зах зээлийн шалтгаант зорилгод нийцэж, насан туршийн суралцахуйгаас хол давах хэрэгтэй болно.

Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь дараагийн үеийнхэнд маш өөр байх ёстой. Манай эдийн засаг, нийгэм өөрчлөгдөхийн хэрээр насанд хүрэгчдийн боловсрол нь хөдөлмөрийн зах зээлийн шалтгаант зорилгод нийцэж, насан туршийн суралцахуйгаас хол давах хэрэгтэй болно. Ажил, мэргэжлийн карьераа өөрчлөх, дахин ур чадваржих боломжууд нь олон талт, уян хатан замыг бий болгохыг чухалчилдаг бүх боловсролын тогтолцооны өргөн хүрээний өөрчлөн байгуулалттай холбогдох шаардлагатай. Бүх айн (domains) боловсролтой нэгэн адил насанд хүрэгчдийн боловсролыг

зөвхөн хариу үйлдэл үзүүлэх эсвэл дасан зохицох (хөдөлмөрийн зах зээл, технологи эсвэл хүрээлэл орчны гэх зэрэг өөрчлөлтөд) гэхээсээ илүү жинхэнэ хувирган өөрчлөх суралцахуйн эргэн тойронд шинэ үзэл баримтлалыг боловсруулах хэрэгтэй.

2050 он ба түүнээс цааших ирээдүйг харахад насанд хүрэгчдийн боловсролд гүн гүнзгий багц өөрчлөлтүүд гарахыг урьдчилан таамаглах боломжтой. Тун удахгүй хүний наслалт 100 жилийг даван тогтмолжиж магадгүй гэж зарим хүмүүс таамаглаж байна. Хүний урт наслалт эрс тэлэхийг тооцохгүй орхилоо гэхэд олон хүн аль хэдийнээ урт насалж байгаа баримт нь цаашид боловсрол шаардлагатай болох үед түүнийг үргэлжлэх талаар дахин эргэцүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Зарим бүс нутагт түүхэнд хэзээ ч байгаагүй байдлаар дөрвөн үе нэгэн орон зай-цаг хугацаанд хамтран амьдрах болно. Нас бие гүйцсэн байдал (adulthood) болон төлөвшсөн байдал (maturity)-ын тухай соёлын ойлголтууд шалгагдана. Бидний дасал болсон амьдралын хэв маяг, ажил ба чөлөөт цагт хандах хандлага өөрчлөгдөнө. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн мөн чанар нь тухайн нэг хүний ажил, амьдралын туршид эрс өөрчлөгдөж болохыг аль хэдийн хүлээн зөвшөөрсөн. Иргэний болон улс төрийн амьдрал ч гэсэн нэгэн насны туршид өөрчлөгдөж байгааг, магадгүй ирээдүйд улам бүр өөрчлөгдөхийг бид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэхүү илтгэлд өгүүлж буй шинэ эко ухамсар, шинэчлэн томьёолсон хүмүүнлэг үзэл нь наснаас үл хамааран бүх насны суралцагчид тулгарах ёстой боловсролын шинэ асуудлуудын жишээ юм. XXI зуун урагшлахын хэрээр

боловсролын бодлого нь амьдралд бүхэлд нь төвлөрч, насанд хүрэгчид болон ахмад настнуудад онцгой анхаарал хандуулах шаардлагатай болно.

Насан туршийн суралцахуйн шилдэг уламжлалын нэг хэсэг болох хоёр дахь хэмжээс нь боловсролын боломжуудаас байнга хасагдан гадуурхагддаг эмзэг бүлгийн хүмүүсийн оролцоо (participation) ба инклюзив оролцоо (inclusion)-г хангах үзэл санаатай холбоотой юм. Оролцоо ба инклюзив оролцоо нь насанд хүрэгчдийн боловсролыг чөлөөлөх алсын хараатай гар гараасаа хөтлөлцөн явдаг бөгөөд үүнд амьдрах орчноос суралцахуй (informal) буюу сургуулийн албан ёсны тохиргооноос гадуур эзэмшсэн мэдлэг, нөөц чадваруудын үнэлгээ багтана. Насанд хүрэгчдийн боловсролын бодлого нь насан туршдаа амьдрах орчноосоо суралцахуйг оролцоо ба инклюзив оролцооны тэргүүлэх чиглэлийн нэг хэсэг болгон хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болно.

Эцэст нь, насанд хүрэгчдийн боловсрол эзэмшиж буй хүмүүс нь дижитал хэрэглүүрээр дамжуулан оролцоог улам бүр зуучилж, боломжтой болгож байгаа арга замуудыг шуурхай судлан ажиллах хэрэгтэй. Залуу үеийнхэн бага наснаасаа дижитал ертөнцтэй танилцдаг бол ахмад үеийнхэнд мэдлэгээ үргэлжлүүлэн хөгжүүлж, бэхжүүлэхийн тулд мөн л эдгээр хэрэгслүүдийг хэрэглэх хэрэгтэй болно. Насанд хүрэгчдийн боловсрол нь дижитал хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн хүртээмжтэй болгохыг хөхиүлэн дэмжих ёстой бөгөөд нээлттэй хандалт, нээлттэй эх сурвалжийн төлөө хөдөлгөөнийг хүчтэй дэмжих ёстой. Шинжлэх ухааны мэдлэгийг бэхжүүлэх, бүх төрлийн ташаа мэдээлэлтэй тэмцэх нь өнөөгийн болон ирээдүйн насанд хүрэгчдийн боловсролын аль ч стратегийн гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь олон талт үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь хүмүүст янз бүрийн бэрхшээлийг даван туулах арга замыг олоход нь тусалдаг бөгөөд цогц чадамж ба эрх хүчийг нэмэгдүүлдэг. Энэ нь хүмүүст ирээдүйнхээ төлөө илүү хариуцлага хүлээх боломжийг олгодог. Цаашилбал, энэ нь насанд хүрэгчдэд өөрчлөгдөж буй парадигмууд ба эрх мэдлийн харилцааг ойлгож, шүүмжлэх, мөн шударга, тогтвортой ертөнцийг бий болгох алхам хийхэд тусалдаг. Аль ч цаг үеийн боловсролын нэгэн адилаар ирээдүйн чиг баримжаа нь насанд хүрэгчдийн боловсролыг амьдралтай холбоотой боловсрол гэж тодорхойлох ёстой. Насанд хүрэгчид нь өөрсдийн амьдарч буй ертөнц, мөн түүнчлэн ирээдүйн ертөнцийн төлөө хариуцлага хүлээдэг. Ирээдүйн төлөө үүрэг хариуцлагыг хойч үедээ шууд шилжүүлчхэж болохгүй. Үе үеийнхний эв нэгдлийн нийтлэг ёс зүй хэрэгтэй.

## Боловсрол эзэмших эрхийг өргөтгөх нь

Бидний өмнө тулгамдаж буй хүнд сорилтуудыг харгалзан сурган хүмүүжүүлэгчид, засгийн газрууд, иргэний нийгмийн хувьд боловсролыг өөр өөр цаг хугацаа, орон зайд зөв засаглах дээрх саналуудыг хэрэгжүүлэх нь улам бүр чухал болж байна. Энд санал болгож буй зүйл бол утопи загвар биш, харин хүмүүн хэмээх төрөл зүйлийн амьд тэсэж үлдэх стратеги юм. Суралцахуйг үндэс суурийнхаа нэг хэсэг болгосон амьдралын гүн утга учир, баяр баясгалантай биднийг дахин холбоход боловсрол уриалан дуудах ёстой.

Энэхүү илтгэл нь боловсролын тухай авч үзэхдээ амьдралын бүхэл бүтэн шинж чанар талаас бодох шаардлагатайг цохон тэмдэглэж байна. Хэчнээн чухал ч гэсэн сургууль, их сургууль зэрэг

сургалтын байгууллагуудад эзэмшдэг боловсролыг цорын ганц хэлбэр гэж үзэх ёсгүй. Хамгийн сайн нь боловсрол бол үе тэнгийнхэн, үе хооронд болон соёл хоорондын суралцахуйн үнэ цэнийг тус тус хүлээн зөвшөөрч хамтдаа хэрэгжүүлдэг үйл явц юм. Энэхүү нийгмийн хэмжигдэхүүн нь бие биеэ, хамтын нийгэмлэгүүдээ болон гараг Дэлхийгээ халамжилж сурахыг чухалчилдаг. Эдгээр хамтын үйл явц, нийгмийн хэмжигдэхүүн нь зөвхөн сургууль, их дээд сургуулиудад хамааралтай байх ёстой юм бишээ.

2050 он хүртэлх төсөөлөлдөө бид боловсрол эзэмших эрхийг авч үзэхдээ хэзээ, хаана боловсрол эзэмшүүлэх тухай ердийн ойлголтоор хязгаарлагдахгүй байх нь улам чухал болж байна. Боловсрол эзэмших эрхийг зөвхөн хүүхэд залуучууд төдийгүй бүх хүмүүс илүү ил тодоор эдлэх шаардлагатай болно. Зөвхөн анги танхим, сургууль гэхгүй, сургуулиас гадна олон газарт явагддаг боловсролыг илүү тодорхой авч үзэх хэрэгтэй болно.

КОВИД-19-ийн цар тахлын хөл хорионы үед сургуулиуд хаагдахад сурагчдын академик суралцахуйг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор радио, телевизийг хэрэглэсэн нь боловсрол, соёл, ерөнхий мэдлэгт, ялангуяа онлайн материал, ухаалаг төхөөрөмж ашиглах боломжгүй сурагчдад эдгээр мэдээллийн хэрэгсэл чухал болохыг бидэнд сануулсан. КОВИД-19-өөс шалтгаалан үүссэн хямрал нь дижитал холболт, онлайн платформуудын асар их ач холбогдлыг илчилсэн бөгөөд арван жилийн өмнө төсөөлөөгүй байсан, боловсрол эзэмших эрхтэй холбогддог үндсэн эрх болох мэдээллийн хүртээмжийн асуудлыг бид авч үзэх шаардлагатай болсон.

Боловсрол эзэмших эрх нь мэдээлэл авах эрх, соёлын эрхээр дэмжигддэг (мөн эргээд дэмждэг). Хүмүүс мэдээлэл, шинэ санааг эрэлхийлэх, хүлээн авах, түгээх чадамжтай байж л үзэл бодол ба өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөг зохих ёсоор эдэлнэ. Хуурамч, төөрөгдүүлсэн мэдээллээр дүүрэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ханасан манай орчин үеийн ертөнцөд боловсрол нь хүмүүсийн үнэн зөв мэдээллийн эрэл хайгуулд дэмжлэг үзүүлж, мөн мэдээллийг хууран мэхлэлтээс ангид, үнэнчээр дамжуулах хүсэл зоригийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Соёлын ижилслийг төлөвшүүлэх, ертөнцийг үзэх үзлийг тэлэхэд хэрэгтэй соёлын нөөцүүдээс хүртэх боломжийг хангах замаар боловсрол нь соёлын амьдралд оролцох эрхийг дэмждэг. Эргээд, боловсрол нь хүмүүсийн соёлын нөөцөд хувь нэмрээ оруулах чадамжийг дэмжиж чадна. Соёл хоорондын нээлттэй, хөндлөн чиглэлийн яриа хэлэлцээ нь соёлын олон ургалч үзлийг дэмжих гол түлхүүр юм. Боловсрол нь соёлын олон ургалч үзлийг хөхиүлэн дэмжихэд оруулж буй олон хувь нэмрийн нэг болох яриа хэлэлцээг үлгэрлэн хэлбэршүүлэх ёстой.

Соёлын ижилслийг төлөвшүүлэх, ертөнцийг үзэх үзлийг тэлэхэд хэрэгтэй соёлын нөөцүүдээс хүртэх боломжийг хангах замаар боловсрол нь соёлын амьдралд оролцох эрхийг дэмждэг

Сурч боловсрох эрхийн талаарх ойлголтыг өөр өөр цаг хугацаа, орон зайд өргөжүүлэх нь боловсролыг бидний бүтээж, засаглаж, удирдан явуулдаг нийтлэг хичээл зүтгэл болгон бэхжүүлдэг. Боловсрол нь нийтлэг сайн сайхан байдал буюу хамтдаа хүрсэн, сонгосон хамтын сайн сайхан аж байдал болохынхоо хувьд бидний өдөр тутмын амьдралтай нягт холбоотой байх учиртай. Хүүхэд, насанд хүрэгчид нь боловсролын туршлагыг бүтээхэд үйлчлүүлэгч, үзэгч биш, харин гол тоглогч байх ёстой. Бид амьдралын янз бүрийн мөчид, амьдралын янз бүрийн талбарт боловсролын янз бүрийн хэсэгт үүрэг гүйцэтгэдэг бөгөөд бид боловсролын нэг хэсэг болдог. Хүн бүр өөрийн хувийн амьдралд



бодож, мэдэж, мэдэрч хийж байгаа зүйлээ бататгах, мөн бид бүгд хамтдаа хийж байгаа зүйлээ бэхжүүлэх тийм боловсролын нэг хэсэг болох эрхтэй.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Энэхүү бүлэгт бид боловсролын нийгмийн шинэ гэрээнд амьдралынхаа туршид, соёл болон нийгмийн янз бүрийн орон зайд тохиолдох боловсролын боломжуудыг эдлэх, өргөжүүлэхийг санал болгосон. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж, урагшлахад хэрэгтэй яриа хэлэлцээ, үйл ажиллагааг удирдан чиглүүлж чадах дараах дөрвөн зарчим байна.

- **Амьдралын бүхий л цаг үедээ хүмүүс утга учир бүхий чанартай боловсрол эзэмших боломжтой байх ёстой.** Суралцахуй нь насан туршийн, амьдралын бүх хүрээнд байх ёстой бөгөөд насанд хүрэгчдийн боловсролд ач холбогдол өгч, хүлээн зөвшөөрөх ёстой. Бид инклюзив оролцооны зарчмуудыг хэрэглэж, хамгийн ихээр орхигдож гадуурхагдсан болон хүн амын хамгийн эмзэг, хэврэг бүлгийнхэнд үйлчлэх тохиргоонуудад төвлөрч аливаа төлөвлөлтийг эхлэх хэрэгтэй.
- **Боловсролын эрүүл экосистем нь байгалийн, биет, виртуал суралцахуйн хотхонуудыг холбодог.** Биосферийг бид суралцахуйн орон зай гэж илүү сайн үнэлэх ёстой. Дижитал сургалтын орон зай нь боловсролыг нийтэд хүртээмжтэй, инклюзив оролцоог дэмжсэн, нийтлэг шалтгаант зорилгод чиглэсэн болгож хөгжүүлэх ёстой бөгөөд одоо боловсролын экосистемийн салшгүй хэсэг болсон. Сурагчдын болон багш нарын өгөгдлийг хүчтэй хамгаалсан, нээлттэй хандалт, нээлттэй эх үүсвэрийн платформуудад нэн тэргүүний ач холбогдол өгөх нь зүйтэй.
- **Боловсролын салбарын нийтийн санхүүжилт, зохицуулалтын төрийн чадавхыг бэхжүүлэх ёстой.** Бид үл алагчилсан, хүний эрхийг дээдэлсэн боловсролын үйлчилгээний стандарт, хэм хэмжээг тогтоож, хэрэгжүүлэх улс орны чадавхыг сайжруулж байх нь зүйтэй.
- **Боловсрол эзэмших эрхийг өргөжүүлэх хэрэгтэй.** Зөвхөн сургуульд сурснаар бид боловсрол эзэмших эрхээ сайн эдэлж чадахгүй. Хүн бүр хаана ч байсан насан туршдаа суралцах эрхтэй байх ёстой. Мэдээлэл авах эрх, соёлтой харьцах эрхийг боловсрол эзэмших эрхийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон дэмжих ёстой. Холбогдох эрхүүд энд багтсан байх учиртай.

Боловсролын нийгмийн шинэ гэрээг хийхдээ эдгээр дөрвөн үндсэн зарчмыг баримтлах ёстой. Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, дэлхий нийтийн түвшинд бид эдгээр зарчмуудын хүрээнд яриа хэлэлцээ хийж, үйл хэргээ явуулах амлалтаа биелүүлж, ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөхөд туслах хэрэгтэй.



# Хэсэг III

## Боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгах нь

Хүн төрөлхтөн болон манай гаригийн оршин тогтнолд заналхийлж буй олон давхацсан хямралыг даван туулах нь мэдээжийн хэрэг эрс өөрчлөлтийг шаарддаг. Бид ирээдүйг өөрчлөхөд туслах нийгэм, эпистемик, эдийн засаг, байгаль орчны шударга ёсны зарчмуудаас санаа авсан боловсролын шинэ нийгмийн гэрээг яаралтай байгуулах ёстой. Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь боловсролыг нийгэм дэх нийтийн хичээл зүтгэл, нийтлэг сайн сайхан байдал болгож бэхжүүлэх, нийтлэг мэдлэгийг хамгаалах гэсэн шинэчлэгдсэн арга хандлагын илэрхийлэл юм. Өнгөрсөн хугацаанд биелэгдээгүй амлалт үүргээ биелүүлэх, ирээдүйн боловсролын өөрчлөлтийн нөөц потенциалыг илрүүлж нээхийн тулд төрийн болон төрийн бус олон түншүүд хамтран ажиллах шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Их дээд сургуулиуд болон бусад түншүүд боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон шинэчлэх, боловсролын нийгмийн шинэ гэрээг хамтран байгуулахад дэмжлэг үзүүлэх судалгаа, инновацад гол үүрэг гүйцэтгэнэ. Үүний нэгэн адил, 2050 он хүртэл бидэнд хэрэгтэй олон улсын хамтын ажиллагаа, эв нэгдлийн хэлбэрийг бий болгоход бүс нутгийн болон олон улсын боловсролын хөгжлийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг өөрчлөх нь чухал юм. Гэсэн хэдий ч эцсийн дүндээ боловсролыг нийтлэг сайн сайхан байдлын үүднээс засаглахад чухал үүрэг рольтой олон улсын болон бүс нутгийн түвшнээс гадна, боловсролын шинэ нийгмийн гэрээг хурдасгах ажлыг дэлхийн хүн амын олон тооны бүлгүүдийн хооронд тодорхой хам нөхцөлүүдэд нийцсэн нийгмийн өргөн хүрээний яриа хэлэлцээгээр үргэлжлүүлэх шаардлагатай болно. Энэхүү Илтгэл нь яриа хэлэлцээг үргэлжлүүлэх урилга юм.

## Бүлэг 8

# Шинжилгээ судалгаа, инновацад уриалсан дуудлага



Олон нийтэд суурилсан арга хандлагын бүх үйл явц буюу өөрөөр хэлбэл арга зүй, аргууд маш чухал байдаг. Олон төсөлд үйл явц нь үр дүнгээс хамаагүй илүү чухал байдаг. Үйл явц нь хүндэтгэлтэй хандсан, хүмүүст боломж олгосон, хүмүүсийг эдгээсэн, мөн хүмүүс сургагдсан байх ёстой. Тэд өөрийгөө тодорхойлох чиглэлд нэг жижиг алхмаар ахиулах ёстой.

**Линда Тухивай Смит (Linda Tuhiwai Smith)**, *Колоничлолоос ангижруулах арга зүй, 1999 он*

Боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгахын тулд тус Комисс амьдралын туршдаа боловсрол эзэмших эрхэд суурилсан хоршин ажиллах хамтын шинжилгээ судалгааны дэлхий дахины мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхийг уриалж байна. Түүнчлэн анхан шатны холбоод, сурган хүмүүжүүлэгчид, институци, салбар, соёлын олон янз байдлын хувь нэмрийг талархан хүлээн авч байна.

Өмнөх бүлгүүдэд дурдсан саналуудыг урагш ахиулахын тулд урьд өмнөхөөсөө илүү өргөн хүрээний хам нөхцөл болон тухайн тодорхой нөхцөл байдал бүрд тохирсон боловсролын хүчин чармайлт, туршилт, эрэл хайгуул, инновац шаардлагатай болно. Энэ бүлэг нь бидний дахин төсөөлсөн ирээдүйн боловсролын талаар хоршин ажиллах хамтын шинжилгээ судалгаа, инновац хийхийг уриална. Боловсролын нэгэн адил шинжилгээ судалгаа, инновац нь боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгахад гол үүрэг гүйцэтгэдэг нийтийн сайн сайханд зориулсан бүтээгдэхүүн, үйл явц юм.

Боловсролын ирээдүйн талаарх шинжилгээ судалгааны мөрийн хөтөлбөр нь суралцагч, багш нар байгаа газраас эхэлнэ. Олон талаараа, боловсролын ирээдүйг бүрдүүлэх тэр хэсгүүд бидний дунд, ядаж аль нэг анхны хэлбэрээр аль хэдийн бий болсон байдаг. Аливаа боловсролын систем дэх эхлэлийн цэг нь энэхүү илтгэлд тусгагдсан зарчмуудыг аль хэдийн өөртөө биежүүлсэн сайн туршлагын голомт, эерэг тохиолдлуудыг олж харах явдал юм. Олон нийтийн нийгэмлэгүүд практикт юуг өөр байдлаар хийх хэрэгтэй байгаа талаарх өөрсдийн бодол санаагаа нарийвчлан тодорхойлсон үйлдлийн стратеги болгон хөрвүүлэх арга замыг эрэлхийлж байдаг тул тэдгээр гарах үр нөлөөг нь түүнийг боломжтой болгосон нөхцөл байдлын хамт судалж, дүн шинжилгээ хийх нь энэхүү Илтгэлд дурдсан үзэл санаануудыг улам үндэслэлтэй болгож чадна. Боловсрол нь судалгааны өргөн хүрээтэй эх сурвалж, арга зүй, парадигм ашиглаж ирсэн урт түүхтэй. Дадлагажигчид болон олон нийтийн яриа хэлэлцээнээс эхлээд их дээд сургууль, судалгааны түншлэл, үндэсний болон олон улсын форум, тэр дундаа ЮНЕСКО-ийн форум хүртэлх бүх түвшинд эдгээр арга хэрэглэгдэхүүнийг бэхжүүлж, сайжруулах шаардлагатай.

Энэ бүлэг нь юуны түрүүнд шинжилгээ судалгаа, инновац нь системтэйгээр хамтдаа суралцах буюу эргэцүүлэн бодох, туршиж үзэх, хамтдаа нийгэмд нөлөө үзүүлэх, ингэснээр ирээдүйгээ дахин төсөөлөх боломжийг олгодог арга замыг онцолно. Энэ үүднээс авч үзвэл шинжилгээ судалгаа, инновац нь төсөөллийг хүчирхэгжүүлж, боловсролд бидний харж, хийж байгаа зүйлд ирээдүй ямар үүрэг гүйцэтгэх талаарх бидний ойлголтыг гүнзгийрүүлэх замаар бидний алсын

хараа, ирээдүйн бичиг үсэг (futures literacy)-ийн чадавхыг бэхжүүлэх ёстой. Хоршин ажиллах ёс зүй, даруу байдал, алсын хараа нь бидний боловсролын судалгааны мөрийн хөтөлбөрийн бүх талыг тодорхойлдог

**Судалгаа, инноваци нь бидний алсын хараа, ирээдүйн бичиг үсгийн чадавхыг бэхжүүлэх ёстой.**

Энэ бүлэг нь энэхүү илтгэлийн төсөөлөл, таамаглалын талаарх мэдлэг ба судалгааг гүнзгийрүүлэхэд боловсролын бүх оролцогчдыг хувь нэмрээ оруулахыг уриалж байна.

Нэмж хэлэхэд, эдгээр сэдвийн хүрээнд суралцахуй ба гүн

гүнзгий ойлголтуудыг дэмжих, системчлэхэд их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагуудыг тусгайлан уриалж байна. Боловсролын нийгмийн шинэ гэрээний

зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд бид олон улсын түвшинд түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслээр өөрсдийгөө хангах шаардлагатай болно. Энэ бүлэг боловсролын бүх оролцогчдын сонирхлыг татахуйц 2050 он хүртэл яриа хэлэлцээ, үйл ажиллагаандаа удирдлага болгох үндсэн зарчмуудаар төгсгөх бөгөөд өөр өөр үзэл бодол, агуулга, газар нутгийг зурагласан, инклюзив оролцоог хангасан дэлхий дахины шинжилгээ судалгааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх уриалгыг багтаасан болно.

## Боловсролын шинжилгээ судалгааны шинэ мөрийн хөтөлбөр

Энэхүү илтгэл нь боловсролын ирээдүйн талаарх шинжилгээ судалгааны шинэ мөрийн хөтөлбөрийг удирдан чиглүүлэхэд хэрэгтэй гэж үзэж Комиссоос зарлан мэдэгдэж буй ажиглалт, зарчим, саналуудыг дэвшүүлсэн. Энэхүү судалгааны мөрийн хөтөлбөр нь өргөн цар хүрээтэй, олон талт, ирээдүйд чиглэсэн, бидний хамтын ирээдүйн талаар гараг даяараа суралцах үйл явц юм. Мөрийн хөтөлбөр нь мэдлэг ба хэтийг харах үзэл бодлын янз бүрийн хэлбэрүүд түүнчлэн сөргөлдөх гэхээсээ илүү харилцан бие биеэ нөхсөн олон төрлийн эх сурвалжийн гүн гүнзгий ойлголтууд бүхий үзэл баримтлалын үйлийн хүрээнд үндэслэгдсэн юм.

Илтгэлд онцолсон тэргүүлэх чиглэлүүд нь энэхүү шинжилгээ судалгааны дотоод уялдаа холбоотой нийтлэг мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бие биеэ дэмжин бэхжүүлнэ. Мөрийн хөтөлбөр нь Бүлэг 1-д онцлон тэмдэглэсэнээр, бүх нийтэд чанартай, үл алагчлагдах боловсрол эзэмшихэд учирч буй бүх саад бэрхшээлийг судалж, боловсрол эзэмших эрхийн асуудалд төвлөрсөн байх ёстой. Мөн Бүлэг 2-т тайлбарласан өөрчлөлтийн векторууд буюу бидний өөрчлөгдөж буй уур амьсгал, хүрээлэл орчин, хурдацтай явагдаж буй технологийн өөрчлөлтүүд, улс төрийн байгууллагын гүнзгий ан цав, ажил, амьдралын тодорхой бус ирээдүй зэрэг нь нэн чухал ирэх он жилүүдэд боловсролтой хэрхэн огтлолцохыг судлах ёстой. Энэхүү илтгэлийн Хэсэг II-т тодорхойлсон үйлдлийн зарчмуудын дагуу буюу эв нэгдэл, хамтын ажиллагаанд суурилсан сурган хүмүүжүүлэх арга зүй, сургалтын хөтөлбөрийн нийтлэг мэдлэгтэй харьцах харилцаа, багш нарт боломж, эрх мэдэл олголт, сургуулиудыг дахин төлөвлөх төсөөлөл, мөн амьдралын бүхий л цаг хугацаа, орон зайд уягдсан суралцахуй зэрэг боловсролын шинэчлэлийг олборлон судлахын тулд судалгаа нь энгийн нэг хэмжилт ба шүүмжлэлийн хүрээнээс давж гарах ёстой. Ийм холд тэмүүлсэн судалгааны мөрийн хөтөлбөрөөс олж авсан мэдлэг, гүн гүнзгий ойлголт, туршлага нь боловсролын нийгмийн шинэ гэрээг хамтдаа байгуулах хурдасгуур болно.

### Боловсрол доторх шинжилгээ судалгаа

ХХ зууны эхэн ба түүнээс хойших үеэс эхлэн бий болсон бүтээл, чиг урсгал, үзэл баримтлалын олон янз байдал бүхий боловсролын судалгааны эртний, чухал өв нь нөлөө бүхий сэтгэлгээ ба үйлийн үүсэл гарлын гол шугамыг дэлгэрүүлэн үргэлжлүүлж, тодорхой болгон хэлбэржүүлсээр байна. Боловсролын судалгаа нь бидэнд сургууль, анги танхим болон боловсрол явагддаг олон газарт болж буй бодит байдлыг илүү сайн ойлгох боломжийг олгодог. Мөн хувь хүн, хамт олон,

нийгэмд болж буй хувирган өөрчлөлтүүдэд хамаарах гүн гүнзгий ойлголтуудаар хангадаг.

Практик судалгаа, үйлийн судалгаа, түүх архивын судалгаа, тохиолдлын судалгаа, угсаатны зүй гэх мэт олон аргууд нь энэ салбарт ажиллаж буй хүмүүсийн хувьд үр өгөөжтэй болох нь батлагдсан олон аргуудын нэг юм. Энэ мэтчилэн боловсролыг зөвхөн түүний гадна хийгдсэн туршилт, судалгааг хэрэглэдэг талбар биш, харин өөрөө эрэл хайгуул, анализ хийдэг талбар гэж ойлгох ёстой.

Сургуулийг мэдлэг бүтээдэг газар, багш нарыг мэддэг хүмүүс гэж үзэхийн баталгаа нотолгоо нь их дээд сургууль, боловсролын байгууллага, судлаачдын боловсролд холбогдсон хүмүүстэй хэрхэн харилцаж, хоршин ажиллаж, тэдний баялаг гүн гүнзгий ойлголт, эргэцүүлэл, туршлагаас хэрхэн суралцахаас ихээхэн хамаардаг. Их дээд сургуулиуд нь тухайн шинжлэх ухааны мэдлэгийг урагш ахиулах, шинжлэх ухааны өөр өөр салбарын хил хязгаарыг давах аль ч туршлагаараа боловсролын судалгааг дэмжихэд тулах цэгийн үүрэг гүйцэтгэдэг. Багш нар эргэцүүлэл, туршлагаа хуваалцсаны үр дүнд мэргэжлийнхээ талбарт мэдлэгийг бий болгодог учраас үргэлж мэдлэгийн гол зохиогчдын нэг байх болно. Иймээс өөрсдийн судалгаа, эргэцүүллийг нийтлэхэд нь тэдэнд дэмжлэг үзүүлдэг байх ёстой.

Сурагчид ч бас өөрсдийн боловсролын туршлага, хүсэл тэмүүлэл, хүрсэн амжилт, эргэцүүллийн талаарх мэдлэг, ойлголтын чухал эх сурвалж болдог.

**Сурагчид ч мөн өөрсдийн боловсролын туршлага, хүсэл тэмүүлэл, хүрсэн амжилт, эргэцүүллийн талаарх мэдлэг, ойлголтын чухал эх сурвалж болдог.**

Их дээд сургуулиуд болон судлаачид нь сургууль, багш, сурагчидтай үргэлж холбоотой байснаар тэдэнд үзүүлэх дэмжлэгээ өргөжүүлж чадна. Оролцоот үнэлэлт дүгнэлт, хоршин ажиллах хамтын шинжилгээ судалгаа, залуучууд манлайлсан судалгаа, практик эрэл хайгуул зэрэг нь боловсролын доторх ба гаднах хүрээнд судалгаа хийж буй хүмүүс хоорондын суралцахуйг цаашид системчлэхэд хэрэглэж болох арга зүйн олон уламжлалын нэг хэсэг нь юм. Боловсролын шинжилгээ судалгаа нь боловсролын нийгмийн шинэ гэрээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хувирган өөрчлөлтүүдийг төсөл болгон төлөвлөх, хяналт-шинжилгээ хийх гол арга хэрэгсэл байх болно.

### **Суралцахуйн шинжлэх ухааныг дайчлах нь**

Сүүлийн хэдэн арван жилд боловсролын салбарт гарсан шинжлэх ухааны ер бусын өвөрмөц дэвшлийн нэг бол мэдрэл судлалын шинжлэх ухаан болон суралцахуйтай холбогдуулан тархийг судлах болсон явдал юм. Эдгээрт хүний хөгжлийн бүх үе шатанд нейропластик шинж чанарыг илүү сайн ойлгох; тархи ба хүний мэдрэлийн системийн анатоми, бүтэц, тэдгээрийн ажиллагаа; ой санамж, мэдээлэл боловсруулах, хэл яриа хөгжүүлэх, нарийн нийлмэл зүйлийг цогцоор сэтгэх чадварууд; нойр, биеийн хөдөлгөөн, сэтгэл хөдлөл, стресс, хүчирхийлэл зэрэг эерэг ба сөрөг өдөөлтүүдийн суралцахуйд үзүүлэх нөлөөллүүд багтана. Суралцахуйн тухай танин мэдэхүйн үйл явцууд нь ярих, унших, бичих, орон зайн мэдрэмж гэх мэт тусгайлсан ур чадварын талаар гүн гүнзгий ойлголт өгдгөөрөө маш чухал ач холбогдолтой байдаг.

Эрдэмтэд энэ салбар болон түүнийг боловсролд хэрхэн хэрэглэх талаарх ойлголтын бодит үнэний эхний шатанд байгаа хэдий ч энэ (тархийг судлах болсон нь) нь багшлахуй ба суралцахуйд асар их ач холбогдолтой бөгөөд гүн гүнзгий ойлголтыг багш, судлаач, мөн суралцагчдад өөрсдөд нь аль болох хүртээмжтэй болгох хэрэгтэй. Жишээлбэл, эрдэмтэд хяналттай лабораторийн тохиргоот орчинд зан үйл ба тархины ажиллагаа хоорондын хүчтэй төрх байдал, харилцан хамаарлыг ажиглаж болох боловч эдгээр төрх байдал нь суралцахуйн нийгмийн нарийн нийлмэл орчинд шилжихдээ хэрхэн хувирч болох, эсвэл янз бүрийн хүн ам, хүмүүс болон цаг хугацаа, орон зайд хэрхэн өөрчлөгдөж болох нь тодорхойгүй байна.

Ирээдүйн суралцахуйн шинжлэх ухааны судалгаанд өргөн хүрээний олон асуулт, төсөөлөл, таамаглал, тэргүүлэх чиглэлийг үл алагчлан илэрхийлэх нөхцөлийг хангахын тулд жендэр, соёл, нийгэм эдийн засаг, хэл шинжлэл, нас гэх мэт янз бүрийн мэргэжил, өгөгдөлтэй судлаачдыг татан оролцуулах ёстой. Мэдрэлийн олон янз байдал, суралцахуйн ялгаанууд, хөгжлийн бэрхшээлийн судалгаа, тусгай боловсрол зэрэг нь суралцахуйн ухааны томоохон ололт амжилтын ашиг тусыг бас хүртэж чадах болно.

Суралцахуйн шинжлэх ухааны гүн гүнзгий ойлголт-санаанууд нь хэчнээн хүчирхэг бөгөөд амин чухал ач холбогдолтой ч боловсролыг бүхэлд нь самнаж хамардаггүй. Танин мэдэхүй бол бидний суралцах үйлийн цорын ганц арга зам биш юм. Нийгмийн мэдлэг, биежсэн мэдлэг, сэтгэл хөдлөлөө удирдах чадамж гэх мэт нь мэдрэл судлалын шинжлэх ухаанаар ойлгож болох зүйлтэй харилцан үйлчилдэг боловч дан ганц мэдрэл судлалын шинжлэх ухаанаар тодорхойлогдохгүй.

Сурган хүмүүжүүлэх ухаан, сургалтын хөтөлбөрийн талаар өмнөх бүлгүүдэд онцлон тэмдэглэсэнээр, боловсролын нарийн нийлмэл байдал нь нийгэм, эдийн засаг, хүрээлэл орчин, материаллаг болон оюун санааны хэмжээснүүд зэрэг нь ертөнцийн бүх талуудтай салшгүй огтлолцож байдгаас үүдэлтэй юм. Оюун санааг материас салгах нь асар их аюултай бөгөөд энэ нь суралцаж буй олон хүмүүсийн хувьд боловсролыг үл хайхрах сэдлийг өгдөг. Энэхүү илтгэлд дурдсан тэргүүлэх чиглэлүүдийг урагш ахиулахдаа өндөр чанартай боловсролын санал болгож буй танин мэдэхүйн болон нийгмийн үр өгөөжийг бий болгохын тулд суралцахуйн мэдрэл судлалын шинжлэх ухаан нь судалгааны үр дүнгээ боловсролын олон талт, нарийн нийлмэл шинж чанар бүхий хам нөхцөлтэй улам бүр ихээр уялдуулах шаардлагатай болно.

### **Боловсролын шинжилгээ судалгааны түншлэлийг хувирган өөрчлөх нь**

Эрдэм шинжилгээ, иргэний нийгэм, боловсролын замналын үе шатны тэмдэглээнүүдийг хамарсан, хамтын харилцаа холбоо, харилцан суралцахыг дэмжсэн шинжлэх ухаан хоорондын, нийгмийн салбар хоорондын, соёл хоорондын судалгаануудын түншлэл нь энэхүү илтгэлд дэвшүүлсэн тэргүүлэх чиглэл, саналуудыг урагш ахиулах асар их нөөц потенциалыг санал болгож байна.

Шинжилгээ судалгааны бүх түншлэл шударга, эрх тэгш байдаггүй бөгөөд илүү их нөөцтэй, эсвэл институцийн эрх мэдэлтэй түншүүд санамсаргүй байсан ч түншлэлийн үйл явц, үр дүнд зүй бусаар нөлөөлж болно. Хүн төрөлхтөн ба нийгмийн мөн чанар, хүмүүний бус ертөнцийн талаарх бидний үзэл баримтлалд гүн гүнзгий шингэсэн боловсрол болон түүний эргэн тойронд байгаа төсөөллүүдийг сориход эпистемик даруу байдал хэрэгтэй. Бидний үйлдлийн парадигм нь “Хойд/

Өмнөд” эсвэл “Баруун/Барууны бус” гэх мэт мэдлэгийн харилцааны хялбаршуулсан ангиллаас татгалзаж, мэдлэгийн нарийн төвөгтэй, харилцааны экологи руу шилжих шаардлагатай болно.

Боловсролын нийгмийн шинэ гэрээний хувьд боловсролын эдгээр экологийг хасан гадуурхалт, сэтгэлгээний хомсдол, явцуу эпистемик төсөөллөөр доройтуулалгүй, олон янзын туршлага, мэдэх арга замаар баяжуулах шаардлагатай. Боловсрол бол сурагч, багш, гэр бүл, хамт олон хоорондын харилцааны үйл явц учир бид шаталсан мэдлэгээс илүү харилцааны мэдлэгийг эрэлхийлэх ёстой. Энэ нь үндэсний болон орон нутгийн судалгааны чадавхад боломж, эрх мэдэл өгөх, өөр өөр хам нөхцөл, соёл, хэлний тодорхой арга замуудаар мэдлэг бүтээж, төлөөлөх хүмүүсийн чадавхыг багтааж болох юм.

Нэмж дурдахад, жирийн иргэдийн нийгэмлэг, нийгмийн хөдөлгөөнүүдийн дуу хоолой нь бидний ирээдүйг тодорхойлох үйл явцын тасалдалтууд ба өөрчлөлтийн тэргүүн эгнээнд байдаг тул боловсрол нь улам бүр энэ дуу хоолойг сонсож, түүнээс суралцаж, хувь нэмрээ оруулж байх хэрэгтэй бөгөөд ингэх нь мэдлэг, гүн гүнзгий ойлголтын чухал эх сурвалж болох юм. Манай гарагийг гэмтээн сүйрүүлэхийг эсэргүүцэж, мухардмал зан заншил, ялгаварлан гадуурхлын бүх хэлбэрийг үгүйсгэдэг хөдөлгөөнүүд нь бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлж буй олон жишээнүүдийн нэг юм. Ийм олон нийтийн нийгэмлэг, хөдөлгөөнүүдтэй хоршин ажиллах нь үргэлж албан ёсны эсвэл институцилэгдээгүй байж болох ч боловсролын үүрэг роль болон эдгээр хөдөлгөөнтэй харилцах харилцаанд хамтдаа суралцахад чухал ач холбогдолтой байх болно.

## Мэдлэг, өгөгдөл, нотолгоог өргөжүүлэх нь

Боловсролын ирээдүйн төлөөх шинжилгээ судалгааны шинэ мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд тоон болон чанарын, норматив ба дүрслэн тайлбарласан, дижиталжсан ба түр зуурын, онолын болон практик гэх мэт олон янзын хэлбэрээс ихээхэн хэмжээний мэдлэг, өгөгдөл, нотолгоог гаргаж авах болон ашиглах хэрэгтэй болно.

Өнөөгийн нөхцөлийг ойлгох, боловсролын ирээдүйн шинэ бололцоонуудыг төсөөлөхийн тулд мэдлэгийг дамжуулах, өргөжүүлэх шаардлагатай. Гэхдээ түүхийн хувьд мэдлэгийн тодорхой хэлбэр, эх сурвалжийг чухалчилсан хэр нь заримыг нь хассан байдаг. Ерөнхийлөн ярьдаг мэдлэг болон боловсрол дахь мэдлэг хоёулаа эрх мэдэлтэй хэдэнтээ огтлолцдог. Хүмүүс болон гараг дэлхийгээс дээгүүр байх эрх мэдлийн давамгайлсан хэлбэрүүд нь боловсрол дахь оролцоо ба инклюзив оролцооны шинэ хэлбэрүүдийг бидэнд олгож, хүмүүст хандах болон хүмүүстэй хамт байх эрх мэдлийн хэлбэрээр солигдох ёстой. Ирэх хэдэн арван жилд боловсролын ирээдүйг урагшлуулах судалгааны мөрийн хөтөлбөр болохынхоо хувьд уг хөтөлбөр нь боловсролын талаарх мэдлэг, өгөгдөл, нотолгооны мөн чанарыг байнга дахин авч үзэж байх шаардлагатай болно.

## Мэдлэгийн нарийн нийлмэл экологийг бэхжүүлэх нь

Цаашдын боломжит ирээдүйн илүү олон янз байдлыг төсөөлөхийн тулд судалгаа, инновац нь олон янзын хүн амын популяци, соёл, уламжлал нь ертөнцийг хэрхэн уншиж, ойлгодог олон арга замыг үгүйсгэх ёсгүй юм. Үнэн хэрэгтээ энэхүү илтгэлийн сурган хүмүүжүүлэх арга зүй, мэдлэг, оролцоо, хорших ажиллагаа, эв нэгдлийн талаарх удирдамжууд нь аль хэдийнээ олон соёлын ертөнцийг үзэх үзэл, алс хэтийн төлөвийн талаарх баялаг мэдлэгийн өв уламжлалд оршиж байдаг. Мэдлэгийг колоничлолоос ангижруулах нь өнөөгийн болон ирээдүйн хойшлуулшгүй хэрэгцээ шаардлагад мэдлэгийн олон янзын эх сурвалжуудын тохирц болон хэрэглэгдэх боломжийг илүү ихээр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Энэ нь уугуул хүмүүсийн танин мэдэхүйн ухааныг ертөнцийг мэдэх, ойлгоход хэрэгтэй арга барил гэхээсээ илүүтэй судалгааны объект гэж үзэх үзлээс татгалзахыг шаардана.

Хөгжлөөс эхлээд, эдийн засаг, боловсрол гэх мэт олон салбарт зарим төрлийн мэдлэг нь бусад мэдлэгээс давуу эрхтэй байдаг. Тодорхой бүс нутагт бий болсон мэдлэг гэж байхгүй эсвэл бүрэн бус гэсэн таамгаар дэлхийн Хойд нутгийн мэдлэг ихэвчлэн хөгжиж буй хам нөхцөлд дамжуулагддаг. Харин эдгээр гаргасан “шийдлүүд” нь энэхүү хам нөхцөлийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахгүй, эсвэл эмзэг бүлгийнхэн болон байгаль орчны сайн сайхан аж байдалд урт хугацааны туршид ашиг тусаа өгөхгүй байх нь элбэг.

Мэдэхүйн олон арга замыг үнэлж, хүлээн зөвшөөрөх нь хэт харьцангуй үзлийг дэвэргэх, эсвэл үнэний төлөөх амлалт үүргээ орхих гэж ойлгож болохгүй. Харин ч мэдэхүйн талаарх уугуул иргэдийн болон олон ургалч арга замууд нь бодит байдалд зохих ёсоор тохируулж чадаагүй хөгжлийн загварууд болон практикийг сорьдог. Жишээлбэл, барууны сэтгэлгээний олон уламжлалд, тэр дундаа боловсролын уламжлалд онол ба практик, хувь хүн ба хамт олон, урлаг ба шинжлэх ухаан, хүн ба байгаль, дэвшилтэт ба консерватив, мэдэхүй ба мэдрэхүй, оюун ухаан ба бие махбод, оюуны/сүнслэг болон материаллаг, орчин үеийн болон уламжлалт гэх мэтээр хоёр хуваан эсрэгцүүлэн сэтгэх дихотоми (dichotomy) арга хандлага нь ердийн хэвшмэл сэтгэлгээ болсон байдаг. Өрнөдийн бус олон олон үзэл баримтлалын оруулсан зайлшгүй тэмдэглэх ёстой хувь нэмэр бол эдгээр туйлшралын анхдагч нөхцөлийг сорьж, тэдгээр ойлголтуудын хоорондох уялдаа холбоо болон нарийн нийлмэл харилцан хамааралтай ертөнцийн бие биеэ нөхцөлдүүлсэн салшгүй хэсгүүдийн шүтэлцээнд шинэ гэрэл тусгасан явдал байв.

Жишээлбэл, орон нутгийн иргэд хямралын үед боловсролыг онцгой байдалд дасан зохицох, хөнгөвчлөх асар их туршлага, мэдлэг, бүтээлч сэтгэлгээг гаргаж чаддаг. Тогтвортой хөдөө аж ахуйн үйл явц, нийгмийн харилцан үйлдэл, байгаль ертөнцтэй хамт амьдрах арга барилын талаарх өвөг дээдсийн олон жилийн турш хуримтлуулсан мэдлэг, түүний зөвхөн зарим хэсэг нь л гэхэд хүн төрөлхтөнд урьд өмнө байгаагүйгээр их хэрэг болох мэдлэгийн чухал эх сурвалж юм. Гэвч ийм мэдлэгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй, хуульчлаагүй, албан боловсролоос хассан байдаг.

Боловсролын ирээдүйн талаарх шинжилгээ судалгаа нь энэхүү илтгэлд тодорхойлсон тэргүүлэх гол чиглэлүүдийн талаарх мэдлэгийн олон янзын төрөл болон эх сурвалжуудын шинэчлэл, мөн инклюзив оролцоог шаардах болно. Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан, энэ нь шударга, үл алагчлагдах байдалд суурилсан нийтлэг мэдлэгт идэвхтэй оролцохоос хамаарна. Боловсролын ирээдүйн төлөө амжилттайгаар мэдлэг бүтээх нь ухамсартай инклюзив оролцоо, нийгэм, соёлын



олон янз байдал, шинжлэх ухаан хоорондын болон мэргэжил хоорондын харилцаа холбоо, хорших ажиллагаа, эзэмшил, харилцан суралцах чадвараа хөгжүүлэхийг тус тус шаардана.

### Статистик өгөгдлүүд, индикаторууд ба тэдгээрийн задлан шинжилгээ

Статистикийн өгөгдөл нь тодорхой индикаторын тухайн агшин дахь үзүүлэлтийг харуулах хүч чадалтай бөгөөд бусад өгөгдлийн цэгүүдтэй холбож үзэхэд цаг хугацаа, орон зай хоорондын хамаарал, өөрчлөлт, нөхцөл байдлын талаар үнэлж баршгүй гүн гүнзгий ойлголтуудыг өгдөг. Эдгээр нь тодорхой индикаторын үзүүлэлтүүд тодорхой хугацааны туршид явсан чиглэлийг дүрсэлж, янз бүрийн хувилбар, сонголт, үйл явдал эсвэл хөндлөнгийн оролцооны дагуу боломжит гаралтын дам үр дүнгийн хүрээг урьдчилан таамаглах боломж өгч чаддаг.

ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн (ЮСХ) нь боловсролын олон тооны индикаторын талаар амин чухал статистик мэдээллийг цуглуулж, олон нийтэд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. ЮСХ-ийн арга хандлагын нэг чиглэл нь үндэсний, бүс нутгийн, дэлхий нийтийн түвшинд статистик мэдээллийг цуглуулах, баталгаажуулах чадавхыг бий болгох явдал юм. Жендэр, байршил, орлогын түвшин болон бусад шинж чанараар нь статистик өгөгдөл, мэдээллийг ангилсан задаргааг нэмэгдүүлэх нь үл алагчлах байдал, тэгш боломжтой холбоотой асуудлуудын талаар гүн гүнзгий ойлголт өгөхөд тусалдаг. Тодорхойлолтыг байнга боловсронгуй болгохын зэрэгцээ утга учиртай анализ хийхэд статистикийн бүрэн бүтэн байдлыг хангах ЮСХ-ийн ажил нь статистик өгөгдөл, мэдээллийн чанар, ашиг тусыг баталгаажуулахад амин чухал юм. ЮСХ-ийн цаашдын ажлыг дэмжих нь бидний боловсролын хамгийн чухал индикаторуудын талаар амин чухал өгөгдлөөр хангах, эдгээр өгөгдлийг хүн бүрд хүртээмжтэй байлгахад чухал ач холбогдолтой байх болно.

Үүний зэрэгцээ, ойрын хэдэн арван жилд статистик болон тоон өгөгдөлд хандах хандлага нь редукционизм (reductionism)-аас зайлсхийх ёстой. Категоричлол нь анализ хийхэд тустай боловч үүнийг өөрчлөгддөггүй, тогтмол гэж үзэж болохгүй. Категори нь бодит байдал дээр тооцоолж болох тоон үзүүлэлтээс илүү нарийн өнгө аястай, төвөгтэй, тодорхой бус байдаг. Статистикийн өгөгдлийг, ялангуяа томоохон цар хүрээгээр цуглуулах, баталгаажуулах ажил нь хөдөлмөр их шаарддаг бөгөөд зардал өндөртэй байдаг. Боломжтой бол зэрэгцээ өгөгдлийн багцад ноогдох өндөр өртөг зардал, хэрэгцээ шаардлагаас зайлсхийхийн тулд өгөгдөл цуглуулах хүчин чармайлтыг одоо байгаа үндэсний өгөгдлийн эх сурвалжийг бататгах, хүчитгэн бэхжүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй.

Үүний нэгэн адил орон нутгийн боловсролын тэргүүлэх чиглэл, олон улсын зорилгод нийцсэн утга учиртай индикаторуудыг тодорхойлохын тулд анхааралтай авч үзэх шаардлагатай. Ийм хандлага нь бүх зүйлийг хэмжих нь үнэ цэнтэй зүйл биш бөгөөд боловсролд үнэ цэнтэй бүх зүйлийг тоогоор илэрхийлэх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс статистик мэдээлэл цуглуулж, ашигладаг хүмүүсийн даруухан байх хандлага нь боловсролын зорилт, тэргүүлэх чиглэлийг ахиулах цаашдын судалгаа, эрэл хайгуулын эхлэлийн цэг гэж үзэх гол түлхүүр юм. ЮНЕСКО-ийн хэлтсүүд, бусад төлөөлөгчид, судлаачдын сайтар бодож хийсэн ажил нь боловсролын статистикийг бодитой болгож, боломжтой бол төсөл, төлөвлөгөө болгохын зэрэгцээ статистикийн тайлбарлах хүч чадлыг сорьсон, тодорхой болгосон түүхийг өгүүлж чадна.

## Их өгөгдөл ба мэдлэгийн өөрчлөгдөж буй мөн чанар

Технологийн дэвшил нь мэдлэг гэж юу болох, түүнийг хэрхэн бий болгох талаар шинэ төсөөллүүдийг бий болгосон. Манай өнөөгийн технологиуд нь мэдээлэл, болон түүний бий болгож буй мэдлэг, ойлголтыг их (ганц туршлагаас бус олон өгөгдлөөс авсан), хайх боломжтой (сэргээн засах боломжтой, олоход хялбар), хадгалагдах (архивлах боломжтой), дамжуулж болох (хэсэг хэсгээр нь хуваалцах боломжтой), хувийн болгон өөрчлөх (өөрийн хэрэглээнд зориулж оновчилсон) боломжтой гэсэн хүлээлтэд хувь нэмэр оруулсан. Эдгээр чанар тус бүр нь боловсролын талаарх үзэл бодол, түүний шалтгаант зорилго, үйл явцуудыг бий болгож, мөн хэлбэршүүлэн төлөвшүүлж, зарим бололцоог нээж, заримыг нь хаадаг учраас сайтар шалгаж үзэх нь зүйтэй.

Дижитал хэрэглүүрүүдэд илүү өргөн нэвтрэх болсон нь судлаачдад боловсролын урьд өмнө байгаагүй өргөн хүрээтэй мэдээллийн багцыг зохион байгуулах, синтезлэх, боловсруулах урьд хожид үзэгдээгүй их эрх мэдлийг өгсөн. Дижитал арга, хэрэгсэл, өгөгдөл цуглуулах, хадгалах, алгоритмын өгөгдөл боловсруулах хүч чадал нь боловсролын аргууд болон арга хандлагын талаарх ойлголт, дадлага, үр өгөөжийг дээшлүүлэхэд хэрхэн ашиглаж болох талаар асар их урам зоригийг өгсөн. Статистикийн өгөгдөл боловсруулах, график үүсгэх, газарзүйн зураглал гаргах, сүлжээний зураглал гаргах, зүй тогтол хайх, түлхүүр үгээр хайх зэрэг нь судлаачдын ашиглаж болох хэрэгслүүдийн нэг хэсэг юм. Мөн бидний боловсролын амьдралын улам бүр дижиталчлагдаж буй талуудын талаар судалгаа хийх сайхан боломж бий.

Өнөөдөр их сургуулийн лекцийн танхим, өрийн алба, компанийн төв байранд “их өгөгдөл”-ийг магтан дуулж байна. Энэхүү зуршил нь хоёр нөлөө үзүүлдэг. Эхнийх нь олон тооны өгөгдлийн цэгүүд, эсвэл их хэмжээний профайл, бичил зан үйл, товчлуур тогшилт, нүдний алим эсвэл электрон дохиогүйгээр ямар ч хэв загварыг ялгах боломжгүй гэж үзэх явдал юм. Өгөгдлийн аналитикийн логикийн дагуу хэв загвар байхгүй бол ямар ч утга байхгүй. Хоёр дахь нөлөө нь өгөгдөл, ялангуяа дижитал технологитой сайн тохирдог тоон өгөгдлийг мэдлэгийн хамгийн чухал хэлбэр гэж нарийвчлалтай хандах (subtler tendency) хандлага юм. Өдгөө бид өгөгдлийн шинжлэх ухаан нь техникийн мэдлэгийн тусгай салбар болж үүссэний гэрч болсон бөгөөд бусад салбарын олон нэгэн адил өгөгдлийн шинжлэх ухаан нь боловсролын салбарт анхаарал татахуйц өгүүлэмж, тайлбарыг бий болгоход асар их нөлөө үзүүлж байна.

Аливаа хэрэгслийн нэгэн адил судлаачид дижитал судалгааны хэрэгслээр юуг олж болох, юуг хийж болохгүйг тодруулах нь чухал юм. Тухайн эрэл хайгуулын шалтгаант зорилгоос хамааран илүү их өгөгдөл нь илүү сайн эсвэл илүү нарийвчлалтай байх албагүй. Бидний байр суурь бол хэрэглүүрт суурилсан гэхээсээ илүү шалтгаант зорилгод суурилсан судалгааны мөрийн хөтөлбөр, соёл юм. Компьютерын дөхөх гүн гүнзгий ойлголт нь хүний хүрэх гүн гүнзгий ойлголттой ижил биш юм. Заримдаа программ хангамж нь хүн төрөлхтөн аналог аргуудын тусламжтайгаар өгөгдлийг урьд өмнө хэзээ ч хийж байгаагүй хэмжээнд хурдацтай боловсруулах чадамжтай учраас гайхмаар, гэрэлтсэн үр дүнг гаргаж чаддаг. Бусад үед хүний оюун ухаан нь хиймэл оюун ухааны хувьд хэт боловсронгуй арга замаар хам нөхцөл, утга учир, үнэ цэнэ, үр дагаврыг ойлгож чаддаг.

Судлаачид боловсролын салбар дахь их өгөгдөл болон дижитал хэрэглүүрийн асар их нөөц потенциалыг ашиглаж байгаа тул бид таамаглал бүхий бодитой байдлыг харуулах дижитал аналитик программ хангамжид ховсдуулахаас татгалзах ёстой. Ялангуяа, бид дижитал судалгааны

аргуудынхаа өрөөсгөл хандлага, харалган байдлыг шударга ёс, үл алагчлах байдлын линзээр байнга үнэлж, түүний программчлалын хүрээнээс гадуур юу байгааг тооцох хэрэгтэй. Хэрэв эдгээр хандлага үргэлжилбэл 2050 онд бидний мэдлэгийн ихэнх хэсэг нь тоон, алгоритмд ээлтэй, молекул бүтэцтэй, хадгалахад хялбар, зөвхөн дижитал төхөөрөмжүүдийн зуучлалаар л нэвтрэх, хурдан хуваалцах боломжтой хэлбэрт хувирах эрсдэлтэй. Тэсрэх адил гарч ирж буй хиймэл оюун ухааны салбар нь эдгээр шинж чанаруудыг өөрөө үргэлжлэх, бие даасан, хүний удирдлагаас хараат бус болгохыг эрэлхийлж байгаад санаа зовох ёстой. Ирэх гучин жилийн хугацаанд ийм амбицын ёс зүйн эрсдэлд анхаарал болгоомжтой хандах шаардлагатай болно.

## Боловсролын ирээдүйг шинэлэг болгох нь

Боловсролын инновац нь туршилт хийх, хуваалцах, өргөжүүлэх, бусдад урам зориг өгөх чадамжийг илтгэдэг. Энэ нь нэг сурагч эсвэл анги хамт олонтой ажилладаг багшаас авхуулаад сургуулийн хэмжээнд эсвэл улс орны хэмжээнд хэрэглэгдэх арга хандлага хүртэл бүх газар, бүх цар хүрээнд боломжтой. Инновац нь ихэвчлэн олон янзын хам нөхцөлд бусад сурган хүмүүжүүлэгчид, бодлого боловсруулагчид, судлаачид, сургуулиудын туршлага, амжилтаас хурааж авсан урам зориг, хорших ажиллагааны үр жимс юм.

### Хөгжлийн бодлого ба хөтөлбөрийн хөгжүүлэлт, зээллэг ба тохируулга

Практик ба бодлогыг хуваалцах замаар боловсролын туршлага, инновацыг шинэ тохируулгат орчинд өргөжүүлэх нь нэн чухал байх болно. Харьцуулж сурах хүсэл эрмэлзэл нь алсыг харах хэтийн төлөвийг өргөжүүлж, ердийн мэтээр хүлээн зөвшөөрөгдсөн өвөрмөц шинж байдал болон төсөөллүүдийг шалган нягтлах замаар “энгийн зүйлийг өөр өнцгөөс харж хачирхалтай” болгох хүч чадалтай байдаг. Дасан зохицох ба зээлэхийг суралцахуй ба инновацын үйл явц гэж тус тус үзэх ёстой. Бид бүгдээрээ хам нөхцөлийн орчин, туршлага, одоо байгаа мэдлэгээ харгалзан үзэж, энэ илтгэлд тодорхойлсон норматив зарчмуудын дагуу өөр газарт үүсгэн бий болгосон туршлагаас санаа авч, урам зоригоор жигүүрлэн ажиллаж чадна.

Боловсролын тогтолцооны тоглогчид шинэлэг арга хандлага, гүн гүнзгий ойлголтын чухал эх сурвалж болдог. Бүхэлдээ салбарын “гаднаас” нэвтрүүлсэн инновацад тэдгээр тоглогчдын гүн гүнзгий ойлголт, санал болгож буй шийдлүүдэд хязгаарлагдмал эсвэл бүр гажуудсан талууд байж болно. Боловсролын мэдлэгийг янз бүрийн аргаар бүтээж, хууль ёсны болгодог. Үүний гол тоглогчид болох багш, сурагч, захирал, сургууль зэрэг нь бүгд судалгаа, инновацыг бүтээхэд оролцогчид юм. Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, өөрчлөлт шинэчлэлийг түүнийг ашигладаг, нийтлэг мэдлэгт илүү гүнзгий оролцдог, хүмүүсийн оруулах хувь нэмрээр баяжуулж болно. Энэ чиглэлд засгийн газрууд чухал үүрэг гүйцэтгэж, яриа хэлэлцээнд оролцох, нийтийн боловсролын тогтолцоо, үйл явцыг шинэчлэхэд нь багш, сургуулиудад хангалттай дэмжлэг үзүүлэх ёстой.

Судалгаа, инновацад цар хүрээний асуудал байнга гарч ирдэг. Ирээдүйтэй туршлага нь ашигтай бөгөөд хуваалцаж болох ч “шилдэг практикууд” нь ихэвчлэн тэдгээрт хөтөлж хүргэсэн үйл явц

эсвэл орчин нөхцөлүүдийг нарийвчлан тайлбарлахаас илүү үр дүнд анхаарлаа төвлөрүүлдэг. Багш нар, сургуулиуд, хэл шинжлэлийн мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид болон бусад субъектүүд дундах хоршин ажиллах хамтын сүлжээ, суралцагч нийгэмлэгүүдийг нэмэгдүүлэх нь өөр өөр хам нөхцөлөөс шалтгаалсан сургалтын хөтөлбөр, бусад хөтөлбөр, бодлогын гүн гүнзгий ойлголтыг тухайн цагт нь судалж, хэрэгжүүлэхэд тусална. Даруу байх ёс суртахуун нь боловсролын аливаа инновацаас хамаардаг түүхэн бус, хам нөхцөлөөс ангид байх төсөөллөөс хамгаалахад тусалдаг.

Боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон шинэчлэх, боловсролын нийгмийн шинэ гэрээг хамтран байгуулахад дэмжлэг үзүүлэхийн тулд судалгаа, инновацад онцгой анхаарал хандуулахыг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, тэдний түншүүдэд уриалж байна. Гэвч тэд гагцхүү аль хэдийн боловсролын салбарт ажиллаж, бодож, сэтгэж буй хүмүүстэй буюу багш, сурагч, сургууль, гэр бүл, олон нийттэй харилцах, яриа хэлэлцээ өрнүүлж байж л хамгийн үр өгөөжтэй болж чадна. Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан, энэ нь нээлттэй, хүртээмжтэй нийтлэг мэдлэгийг бий болгоход чиглэсэн их дээд сургуулиудын нийтийн эрхэм зорилгыг шинэчлэх, өөрсдийн болон хүн төрөлхтний ашиг тусын төлөө мэдлэгийг хөгжүүлэхэд туштай ажилладаг судлаач, мэргэжилтнүүдийн шинэ үеийг бэлтгэх шаардана.

Олон улсын байгууллагууд бас боловсролын салбарт нийгмийн шинэ гэрээ байгуулахад чиглэсэн шинжилгээ судалгаа, инновацыг хөгжүүлэхэд өвөрмөц онцгой бөгөөд хүчирхэг нөлөө бүхий үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү илтгэлийн дараа бие биетэйгээ яриа хэлэлцээ хийж, уг илтгэлд дэвшүүлсэн саналыг тус бүрдээ өөрийн гэсэн арга замаар бодитой болгож чадах туршлагыг нэгтгэх төвийг байгуулахыг ЮНЕСКО-гоос урьж байна. Дэлхий ертөнцийн өөрчлөгдөж буй болон шинээр гарч ирж буй мэдлэгийн хурд нь энэхүү илтгэлийг хөгжил хөдөлгөөнд нь байлгаж, цаг мөч бүрд дахин бичих боломжтой байхыг шаардаж байна.

Их, дээд сургууль,  
эрдэм шинжилгээний  
байгууллага, тэдгээрийн  
түншүүдэд боловсролыг  
нийтлэг сайн сайхан  
байдал болгон  
шинэчлэхэд дэмжлэг  
үзүүлэхийн тулд судалгаа,  
инновацид онцгой  
анхаарал хандуулахыг  
уриалж байна.

### Үнэлгээ дүгнэлт, туршилт, зэрэглэл

Үнэлгээ дүгнэлт, эргэцүүлэл нь боловсролын хөтөлбөрүүд ба бодлогуудын амьдралын мөчлөгт зайлшгүй шаардлагатай үйл явц болохыг илтгэдэг. Үнэлгээ дүгнэлт нь хөтөлбөр эсвэл бодлогын дизайныг сэдэлжүүлэхэд чиглэсэн зорилтууд нь бодит ажил хэрэг болсон эсэхийг баталгаажуулахад тусална. Үнэлгээ дүгнэлт болон эргэцүүлэл нь хөтөлбөр болон дизайны гаралтын дам үр дүнг ойлгож, дүрслэн тайлбарлаж чаддаг бөгөөд хамгийн чухал нь эдгээр нь зориуд товлосон болон урьдчилан товлгоогүй үр дүнг тооцож гаргах ёстой. Жишээлбэл, хэрэв хөтөлбөр эсвэл бодлого нь үл алагчлах байдлыг ерөнхийд нь нэмэгдүүлж чадах өртөг зардлаар зөвхөн зарим хүмүүст тодорхой ашиг тус өгч байгаа, эсвэл урт хугацааны тэсвэртэй байдлын зардлаар богино хугацааны гүйцэтгэлийг эрчимжүүлж байгаа бол ийм хөндлөнгийн оролцооны урьдчилсан нөхцөлийг нэн даруй дахин бодох хэрэгтэй.

Энэхүү илтгэлд дурдсан хоршин ажиллах ёс зүйд нийцүүлэн үнэлгээ дүгнэлт нь боловсролын систем дэх багш, сурагч, сургуулиудын эргэцүүлэн бодох чадавхыг ашиглах замаар инновацын зөвхөн сорилт хүндрэл, сул эсвэл давуу талыг таньж тодорхойлоод зогсохгүй мөн түүний өөрчлөлт, сайжруулалт, няцаалтын үндэслэл, утга учир бүхий бололцоонуудыг илрүүлж санал болгох ёстой. Хамгийн чухал нь инновацын дизайн, үнэлгээ дүгнэлт, зөвлөмжийн шалтгаант зорилгууд хоорондын дотоод уялдаа холбоог хангасан тодорхой аналитик үйлийн хүрээ хэрэгтэй.

Сорил, туршилт, санамсаргүй хяналтын сорилгууд нь төсөөллүүдийн тохирцыг шалгах, арга техникийг тохируулах, буруу тооцооллыг засах, ерөнхийлөх чадварын хязгаарыг ойлгоход тусална. Нарийн нийлмэл систем дэх хувьсагчдыг тусгаарлах чадамж нь нягт нямбай бодол, нарийн дизайн шаарддаг. Боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахдаа хоршин ажиллах ёс зүйг хөгжүүлэхийн тулд бид хүмүүс дээр туршилт хийдэггүй ёс зүйн зарчмыг санаж байх ёстой. Сурагч, багш, гэр бүл буюу бүх хүмүүсийг өөрсдийн боловсрол, хөгжлийнхөө төлөө суралцаж буй бүрэн дүүрэн оролцогч гэж үзэх ёстой. Боловсролын туршлагад аль хэдийн мэдрэгдэж буй өргөн хүрээтэй хөндлөнгийн оролцоо эсвэл өөрчлөлтийн үр нөлөөг ойлгохын тулд "байгалийн" туршилтуудыг ашиглах нь ойрын жилүүдэд, ялангуяа ойрын ирээдүйд гарч болзошгүй ноцтой өөрчлөлтүүд, үйл явцын тасалдалтуудтай холбоотой хэрсүү арга ухааныг олж авч чадна. Ийм төрлийн анализ нь боловсролын уян хатан тэсвэртэй байдал болон өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх чадварын талаарх бидний ойлголтод илүү холын бодолтой мэдлэгийн зээл олгох болно.

Мөн эргэцүүлэн бодох, сайжруулах, урам зориг өгөх үүднээс бусад давуу талыг санал болгох, эсвэл илүү их эрэл хайгуул, анхаарал, дэмжлэг хэрэгтэй тэргүүлэх чиглэлүүдийг тодруулах зорилгоор ашигтай харьцуулалтууд хийж болно. Гэсэн хэдий ч ихэнхдээ харьцуулалт ба зэрэглэл нь буруутгах өнгө аясаар ашиглагддаг бөгөөд энэ нь санхүүгийн дэмжлэг эсвэл гэр бүлийн хамрагдалтыг хамгийн их хэрэгцээтэй байгаа тохируулгат орчнуудаас холдуулдаг. Харьцуулалт нь туршлагыг тэгшитгэж, хүлээлтийг нэгэн төрлийн болгож, хам нөхцөл, нөөц баялаг, түүхэн хүчин зүйлсийн олон янз байдлыг үл тоомсорлож байвал үр дүн багатай байна.

Мөн дээд боловсрол дахь харьцуулсан зэрэглэл тогтоох арга замыг эргэн харах нь чухал юм. Сайн санааны үүднээс, ёс суртахууны хувьд, нэг төрлийн байдлыг тусгахгүйгээр харьцуулалт хийхэд хэцүү байдаг. Тэс өөр хам нөхцөлүүдэд үйл ажиллагаа явуулдаг маш их ялгаатай дээд боловсролын байгууллагууд өөрсдийн онцлог нөхцөл байдлаас үл хамааран олон улсын зэрэглэлд өрсөлдөхийг албадах үед харьцуулалт нь асуудалтай болдог. Нөөцийн эх үүсвэр сайтай, судалгаа нь эрчимжсэн их дээд сургуулиудын элит загварууд нь бусад, ихэнхдээ орон нутагт хамааралтай зардалдаа нийцсэн, орон нутгийн сурагчид болон тэдний нийгэмлэгийн хэрэгцээг хангадаг дээд боловсролын байгууллагуудын хүсэл эрмэлзэлд пропорциональ бусаар нөлөөлдөг.

Гэвч өрсөлдөөнт-чиглүүлэгтэй нөхцөлдөж бий болсон дээд боловсролын байгууллагуудын чансааны зэрэглэл тогтоох болон тэдгээрийг нэгэн төрлийн болоход хүргэсэн явдал нь зөвхөн өөрсдийнх буруу биш юм. Засгийн газрууд болон дэлхийн бодлогын хамтын нийгэмлэгүүд ч дээд боловсролын тогтолцооны судалгаа шинжилгээ нь эрчимжсэн хэсгийг үл тоож, тэнд бага анхаарал хандуулах хэрэгтэй. Харин илүү санаа тавьж халамжлах шаардлагатай дэлхийн дийлэнх олон хүмүүс суралцдаг сургалтын байгууллагуудын зонхилох байдалд илүү их анхаарал хандуулах шаардлагатай болно. Боловсролын байгууллагууд нь сурагчдынхаа суралцахуй, мэргэжлийн ирээдүй, тэдний нийгэмлэгт хэр сайн үйлчилдэг; иргэний ярилцлага, улс төрийн хэлэлцүүлгийг

хэр сайн дэмждэг; байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шударга ёсыг хэр сайн урагш ахиулдаг байна вэ гэдгийг ихэнхдээ үл тоомсорлодог боловч эдгээр нь бид бүгдийн суралцаж болох асар үнэ цэнтэй харьцуулалтын цэгүүд юм. Дээд боловсролын үнэлгээ дүгнэлт нь өрсөлдөөнт эрэмбэлэлтээс хальж, үүний оронд нийтийн эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд бүх дээд боловсролын байгууллагуудын багшлахуйн болон судалгааны чадавхыг сайжруулахыг эрмэлзэх хэрэгтэй.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Бид 2050 оныг төсөөлөн харвал боловсролын ирээдүйн шинжилгээ судалгаа, инновацтай холбоотой дөрвөн гол тэргүүлэх чиглэл байна:

- **Комисс нь боловсролын ирээдүйн талаарх ерөнхий, дэлхий дахины, хамтын шинжилгээ судалгааны мөрийн хөтөлбөр гаргахыг уриалж байна.** Энэхүү шинжилгээ судалгааны хөтөлбөр нь хүн бүрийн боловсрол эзэмших эрхэд төвлөрч, ирээдүйд тохиож болзошгүй үйл явцын тасалдалт, өөрчлөлтүүдийг судлах ёстой бөгөөд энэхүү илтгэлийн Хэсэг II-т дэвшүүлсэн зарчмуудын талаарх ойлголт, туршлагыг гүнзгийрүүлэн арвижуулах ёстой. Энэхүү илтгэлийн үзэл санааны дагуу тэрхүү шинжилгээ судалгааны хөтөлбөр нь ирээдүйн бичиг үсэг, ирээдүйн сэтгэлгээний үүднээс тэргүүлэх чиглэлээ өөрчлөх шаардлагатай байна.
- **Боловсролын ирээдүйн талаарх мэдлэг, өгөгдөл, нотолгоо нь янз бүрийн эх сурвалж, мэдэх арга замыг багтаасан байх ёстой.** Өөр өөр өнцгөөс харсан гүн гүнзгий ойлголтууд нь бие биеэ үгүйсгэж, шахахын оронд боловсролын талаарх нийтлэг ойлголтод өөр өөр давуу талуудыг санал болгож чадна.
- **Боловсролын инновац нь олон янзын хам нөхцөл, газар нутгийг бүхэлд нь нэвт хамарч, маш их өргөн бололцоог тусгах ёстой.** Харьцуулалт ба туршлага нь бие биеэ өдөөх боловч тухайн хам нөхцөлийн тодорхой нийгэм, түүхэн бодит байдалд зохих ёсоор хариу үзүүлдэг байх ёстой.
- **Боловсролын нийгмийн шинэ гэрээний шинжилгээ судалгааг цаашид хүн бүрийг оролцуулан шинэчлэх ёстой.** Оролцооны энэ үр үндэс аль хэдийнээ, ялангуяа багш, сурагчид, сургуулиудын дунд соёолж байна. Судалгааны байгууллагууд, засгийн газар, олон улсын байгууллагуудад боловсролын нийгмийн шинэ гэрээг хамтран байгуулахад түлхэц болох шинжилгээ судалгааны мөрийн хөтөлбөрт оролцож, дэмжлэг үзүүлэх тусгай үүрэг хариуцлага оногдох болно.

## Бүлэг 9

# Дэлхий нийтийн эв санааны нэгдэл болон олон улсын хамтын ажиллагаанд уриалсан дуудлага



“Нийгэм дэх нийгмийн шинэ гэрээ нь залуучуудад эрхэм чанараа эрхэмлэн амьдрах боломжийг олгож;

эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн адил ирээдүй, боломжоор хангаж; мөн өвчтэй хүн, эмзэг бүлгийнхэн, бүх төрлийн нийгмийн цөөнхүүдийг хамгаалах болно... Бага, дунд орлоготой орнуудын нэг үе доторх бүх хүүхдүүд бүх түвшинд чанартай боловсролд хамрагдаж чадах болсон. Энэ бол бололцоотой юм. Бид үүнийг хийхээр шийдэх л үлдлээ... Эдгээр ялгааг арилгах, нийгмийн шинэ гэрээг бололцоотой болгохын тулд бидэнд эрх мэдэл, баялаг, боломжуудыг олон улсын түвшинд илүү өргөн хүрээнд, шударгаар хуваалцах дэлхийн шинэ шийдэл хэрэгтэй байна.

**Антонио Гутерреш (António Guterres)**, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Нельсон Манделагийн лекц, 2020 оны 7-р сарын 18.

**Боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгахын тулд тус Комисс орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд төрийн болон төрийн бус байгууллагуудын хоорондох илүү шударга, эрх тэгш хамтын ажиллагаанд тулгуурлан боловсролыг нийтлэг сайн сайхан байдал болгон дэмжих дэлхий нийтийн хорших ажиллагаанд шинээр авч үзсэн амлалт үүрэг хүлээхийг уриалж байна.**

Боловсролыг нийтлэг сайн сайхан гэх зарчим нь дэлхий нийтийн хариуцлагатай салшгүй холбоотой. 2020, 2021 онуудад бид засгийн газар, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний нийгмийн дэмжлэгтэйгээр КОВИД-19-ийн эсрэг вакциныг боловсруулахын тулд дэлхийн өнцөг булан бүрд шинжлэх ухааны нийгэмлэгүүд урьд өмнө байгаагүйгээр боллоцоо хүчээ дайчлан идэвхийлэн ажиллаа. Хүн төрөлхтний ирээдүй эрсдэлд орсон үед дэлхийн шинжлэх ухааны хамтын ажиллагаа юу хийж чадахыг харуулсан энэхүү гайхалтай жишээ нь харин эдгээр ижилхэн вакциныг нийлүүлэхэд олон улсын үл алагчлах байдлыг хангах илүү хэцүү сорилтоос

болж намжсан юм. Бүгд аюулгүй болтол хэн ч аюулгүй байдаггүй гэдгийг олон нийт хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч вакцины үндсэрхэг үзэл нь дэлхийн нийтлэг сайн сайхны төлөө хамтран ажиллах бидний чадамжид ноцтой цоорхой байгааг онцолж байна.

Вакцины үндсэрхэг үзэл нь дэлхийн нийтийн сайн сайхны төлөө хамтран ажиллах бидний чадамжид ноцтой цоорхой байгааг онцолж байна.

Боловсрол нь эдүгээ үеийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай хүний мэргэн ухаан, хамтын үйл ажиллагааны нөөц потенциалыг хөгжүүлдэг. Ийнхүү чинээлэг, шударга, тогтвортой, амар амгалан дэлхийг цогцлоохын тулд бүх хүн төрөлхтөн гарал үүсэл, соёл, орчин

нөхцөлөөсөө үл хамааран амьдралынхаа туршид чанартай боловсрол эзэмшихийг өнөөдөр хүн төрөлхтний түүхийн бусад цаг үеийнхээс илүүтэйгээр шаардаж байна. Албан боловсрол, сургалтын хүртээмжийг хүн бүр, хаанаас ч цахимаар мэдлэг, мэдээллийг тэгш хүртээмжтэй авах замаар нөхөх шаардлагатай. Аливаа хүний эрүүл мэнд хүн бүрийн эрүүл мэндтэй холбоотой байдагтай адил бидний ирээдүйн оршин тогтнох эсэх нь дэлхий даяарх хүүхэд, залуучууд, насанд хүрэгч бүрийн боловсролын хэрэгцээг хангаж, бидний хамтын ирээдүйг бүрдүүлэх, удирдахад ухамсартай, идэвхтэй оролцохоос хамаарна.

Боловсролыг нийтлэг сайн сайхан байдал гэж ухамсарлах нь боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн боловсролын салбарын санхүүжилтийг дотоод, гадаадын аль алинд нь бэхжүүлэх үндэс суурь байх ёстой. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн хэлсэнчлэн хүүхэд, залуучуудыг чанартай боловсрол эзэмших баталгаа өгөх нь илүү шударга, тогтвортой дэлхийн хэв журамд чухал тулгуур багана юм. Боловсрол эзэмших эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүрэг нь улс бүр төдийгүй олон улсын хамтын нийгэмлэгт ногддог.



## Улам бүр аюултай болж буй дэлхийн дэг журамд хариу үйлдэл үзүүлэх нь

Олон улсын боловсролын хамтын ажиллагаа нь бүх нийтийн нийтлэг үнэт зүйлд тулгуурласан дэлхийн нийгэм гэсэн ойлголт гүнзгий элэгдэж улам бүр найдваргүй болж буй дэлхийн дэг журмын хүрээнд явагдаж байна. Нэгдсэн зорилгуудыг тодорхойлох, олон улсын хамтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй НҮБ зэрэг дэлхийн чуулганууд хатуу шүүмжлэл, төсвийн хязгаарлалттай тулгардаг.

XX зуунд дотоодод болон олон улсад хүний эрхийг урагшлуулах үүрэг хүлээсэн хил хязгаарыг тогтоогчид, жишиг хэм хэмжээг сахиулах бизнес эрхлэгчид болох төрийн бус тоглогчид ба иргэний нийгэм нь улам бүр хуваагдмал болж буй дэлхийн дэг журмын нөхцөлд урт хугацаандаа бат бөх байх эвсэл, холбоо байгуулахын төлөө тэмцэж байна. Тэдний маневр хийх орон зайд цар тахлын дараах дэлхийн эдийн засгийн бодит байдал, түүнчлэн тэдний ажлын гэрээнд зориулагдах олон улс санхүүжилт нөлөөлж байна. Үүний зэрэгцээ, НҮБ-ын Хүний эрхийн тунхаглалд тусгагдсан, мөн хамгийн сүүлд ТХБ-д тов тодорхой илэрхийлсэн үнэт зүйлсийн эсрэг үйл ажиллагаа явуулахдаа дижитал технологи, мэдээллийн урсгалыг ашиглах чадвар нь улам нэмэгдсээр байгаа либерал бус төрийн бус оролцогчид нь өөрөө жирийн бизнес эрхлэгчид, сурган хүмүүжүүлэгчид болон нэмэгдэж байна.

Сүүлийн хагас зуун жилийн эдийн засгийн өөрчлөлтүүд нь улс төрийн эдгээр шилжилтүүдээс дутахааргүй гүн гүнзгий шинжтэй байсан. Эдийн засгийн даяаршлын зэрэгцээ технологийн болон шинжлэх ухааны дэвшил нь хөгжил цэцэглэлтийг сайжруулах, дэлхий даяар өрхийн ядуурлыг бууруулах, боловсролын хүртээмжийг сайжруулахад хувь нэмэр оруулсан нь гарцаагүй. Гэвч тэд улам "хавтгай", илүү нээлттэй ертөнцийг бий болгож байгаагаа тэмдэглэхээ больсон. Эдийн засгийн өсөлт нь баян чинээлэг хүмүүсийн хувьд хүчирхэг талбаруудыг бий болгосон. Технологийн хөгжил нь либерал ардчиллын үндэс суурийг заналхийлж буй эдийн засгийн болон мэдээллийн монополын шинэ хэлбэрүүдтэй зэрэгцэн явагдсан. Эдийн засгийн өсөлт ба ардчиллын хоорондын харилцааг бэхжүүлнэ гэдэгт удаан хугацааны туршид итгэж ирсэн хэдий ч хамтын үйл ажиллагаа, ардчилсан засаглалын нөөц чадвар нь улс үндэстний дотор ч, тэдгээрийн хооронд ч эдийн засгийн ахиц дэвшлийн сүүлийн хэдэн арван жилд гэнэтийн байдлаар хязгаарлагдаж байна.

Уур амьсгалын үйл ажиллагаанд ахиц дэвшил удаашралтай гаргаж, олон улсын хамтын ажиллагаа нэн шаардлагатай байгаа бусад салбар (шилжилт хөдөлгөөн, энх тайван, мэдээллийн нууцлал) нь сүүлийн хэдэн арван жилд дэлхий нийтийн нийтлэг сайн сайхны талаар болон ядууст пропорциональ бус нөлөөлж буй өнөөгийн сорилтуудыг даван туулахад шаардлагатай олон улсын хамтын ажиллагааны хэлбэрүүдийн зөвшилцөл (эсвэл зөвшилцөх чадавх) хязгаарлагдмал байгааг эмгэнэлтэйгээр харуулсан.

НҮБ-ын одоогийн шинэчлэл нь энэхүү олон талт үзлийн хямралын хариуд шинийг санаачлахыг оролдож байна. Энэ бүлэгт гурван шинэ хандлагыг санал болгож байна: түншлэлээр дамжуулан дэлхийн засаглалд төрийн бус олон янзын тоглогчдын инклюзив оролцоо; дээрээс доошоо

бус олон төвт үйл ажиллагаа руу чиглэсэн хөдөлгөөн; бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ хэлбэр, ялангуяа Өмнөд-Өмнөд болон гурван талт хамтын ажиллагаа.

### Тусламжаас түншлэлд

Боловсролын олон улсын хамтын ажиллагаа нь дэлхийн тодорхойгүй дэг журам дор явагдах төдийгүй түүнд хариу үйлдэл үзүүлэх ёстой. Боловсролын дэлхийн шинэ хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн тулд олон улсын хамтын ажиллагааны шинэчилсэн хэлбэр шаардлагатай. Үүний зэрэгцээ боловсролын байгууллагууд өөрсдөө өнөөгийн тулгамдсан асуудал, хамтын үйл ажиллагааны хэрэгцээний талаар, ялангуяа залуучуудын талаар өргөн хүрээтэй ойлголт өгөх үндэс суурийг тавихад тусалж чадна.

Боловсролын хамтын ажиллагааны олон улсын архитектур нь үндэсний эдийн засаг, геополитикийн ашиг сонирхлыг хангахын зэрэгцээ колоничлолын гүн гүнзгий нөлөөгөөр тодорхойлогдож ирснийг түүх харуулж байна. Энэхүү архитектур нь хойд бүсээс өмнөд рүү хийгдэх санхүүгийн урсгал болон үзэл санаагаар тодорхойлогддог. Өнөөдөр олон улсын боловсролын хөгжил, гадаадын тусламж асуудалтай хэвээр байна. Боловсрол нь хөгжлийн албан ёсны тусламжаас (ХАЁТ) маш бага хувийг авдаг төдийгүй боловсролд үзүүлэх тусламж нь дундаж орлоготой улс орнууд руу хазайсан байна. 2050 онд залуучуудын хамгийн их хувийг эзлэх Сахараас урагших Африкт боловсролд үзүүлэх тусламж буурч байгаа бөгөөд энэ нь дэлхий дээрх байгаль орчин, эдийн засгийн шууд сорилтуудтай тулгарах төлөвтэй байна.

Түүгээр ч зогсохгүй боловсролын хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) нь дээд боловсрол, тэр дундаа тэтгэлэгт хамрагдах, ялангуяа Их долоогийн бүлгийн (G7) хандивлагч орнуудын хамгийн том эдийн засагтай орнуудыг дэмжих хандлагатай байдаг. Бага насны боловсрол, сайн чанарын бага, дунд боловсролыг бүх нийтээр авах боломжийг хангахад хэтэрхий бага дэмжлэг үзүүлж байна. XX зууны дундуур НҮБ-аас анх баталсан хүүхдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах хамтын ажиллагааны дэлхийн стратеги батлагдаагүй хэвээр байна. Боломж муутай олон хүүхэд сургуулийн гадна үлдэхийн зэрэгцээ олон тооны хүүхэд залуучууд сургуульд сурдаг ч бага зүйл сурч байна. Дүрвэгсэд болон албадан цагаачдын боловсролын хэрэгцээг ч бас дутуу санхүүжүүлдэг.

### Дүрвэгсэд болон албадан цагаачдын боловсролын хэрэгцээг ч бас дутуу санхүүжүүлдэг.

Боловсролын тусламж хандивлагчдын хоорондын уялдаа холбоо дутмаг байгаа нь бэрхшээлтэй хэвээр байна. Энэ нь ялангуяа тусламжийн хэмжээгээр давамгайлж буй хойд зүгийн хоёр талт (bilateral) байгууллагуудын дунд үнэн юм. Тусламжийн чанар, үр өгөөжтэй байдлын тухай Парисын тунхаглалаас хойш бараг хорин жилийн дараа боловсролын хандивлагчид улс орны хэрэгцээ шаардлагад нийцэхгүй,

салангид, төсөлжсөн хэлбэрээр хөгжлийн тусламжийг санал болгосоор байна. Боловсролын хөгжлийн олон талт суваг дутуу ашиглагдаж, инновацыг дэмжих, нотлох баримтыг илүү сайн ашиглах, үндэсний чадавхыг бэхжүүлэх арга замаар нөөцийг нэгтгэх, уялдуулан зохицуулах боломжууд алдагдаж байна.

Гэсэн хэдий ч боловсролын салбарт тулж босож болохуйц хамтран ажиллах шинэ, ирээдүйтэй бүтээн байгуулалтууд бий. Боловсролын салбарт орон нутгийн, үндэсний, олон улсын хэмжээний иргэний нийгмийн оролцоо сүүлийн хэдэн арван жилд цэцэглэн хөгжиж, засгийн газар болон төрийн бус байгууллагуудын хооронд шинэ түншлэл бий болж байна. Өмнөд-Өмнөд болон гурван талт хэлбэрийн хөгжлийн хамтын ажиллагаа нэмэгдэж байна. Сүүлийн үеийн ухуулга сурталчилгааны хүчирхэг хүчин чармайлт нь боловсролын асуудлыг дэлхийн улс төрийн мөрийн хөтөлбөрт дээгүүр түвшинд тавигдахад тусалсан. Боловсролын асуудал олон улсын болон бүс нутгийн улс төрийн байгууллагуудын мөрийн хөтөлбөрт улам бүр нэмэгдэж байна.

Цаашид дэлхий нийтийн түвшин дэх нийтийн сайн сайхан байдлын гурван төрөл нь хамтын, илүү үл алагчилсан, илүү нийцтэй, илүү тогтвортой боловсролын ирээдүйг бий болгоход онцгой ач холбогдолтой байх болно. Нэгдүгээрт, олон улсын нийгэмлэг засгийн газар болон төрийн бус байгууллагуудад боловсролын нийгмийн шинэ гэрээ байгуулахад шаардлагатай шинэ нийтлэг шалтгаант зорилго, хэм хэмжээ, стандартыг нэгтгэхэд туслахын тулд хамтран ажиллах хэрэгтэй. Хоёрдугаарт, олон улсын нийгэмлэг боловсролын талаарх нийтлэг хүртээмжтэй мэдлэг, судалгаа, өгөгдөл, нотлох баримтын санд хөрөнгө оруулалт хийж, сурталчлах, бүх шатны сурган хүмүүжүүлэгчид боловсролын системийг сайжруулахын тулд нотлох баримтыг бий болгож, ашиглах боломжоор хангах ёстой. Эцэст нь, олон улсын санхүүжилт өргөжин тэлж, бүх нийтийн боловсрол эзэмших эрх нь хамгийн их эрсдэлд буй хүн амыг дэмжихэд ашиглах ёстой.

## Хамтын шалтгаант зорилго, үүрэг амлалт, хэм хэмжээ, стандартын төлөө

НҮБ, ЮНЕСКО байгуулагдаж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсан XX зууны дунд үеэс боловсролын салбарын олон улсын хамтын ажиллагаа нь боловсролын зорилго болон шалтгаант зорилгын талаар зөвшилцөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн. Өнөөдөр боловсролын хамтын зорилгын талаар хэлэлцээ, зөвлөгөөний хэрэгцээ улам бүр чухал болж байна.

Бид олон улсын хамтын ажиллагааг аж үйлдвэржсэн ертөнцийн үзэл санаа, институцийг хуулбарлахад чиглэсэн түүхэн төвлөрлөөс (historical focus)-өөс холдуулах ёстой. Бид Өмнөд-Өмнөд болон гурван талт хэлбэрийн тал талаас нь нягталсан хэлэлцүүлгийг хөгжүүлэх хэрэгтэй. Багш нарын холбоо, оюутны хөдөлгөөн, залуучуудын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн нийлүүлэгчид ба ажил олгогчид, буяны үйлстэн, засгийн газар, иргэд зэрэг боловсролын янз бүрийн төрлийн тоглогчдын дунд яриа хэлэлцээ, зөвшилцлийг сайжруулах хэрэгцээ онцгой их байна. Урт хугацааны ирээдүйд чиглэсэн хамтын ажиллагаа нь хүүхэд залуучуудын дуу хоолойд төвлөрөхгүй байж болохгүй.

Бид КОВИД-19 тахлын тархалт удаан үргэлжилснээс үүдэлтэй төсвийн хязгаарлалтын үе рүү орохын хэрээр нийтлэг зорилгоо илүү чухалчлах, олон улсын болон дотоодын санхүүжилт нь амлалт үүргээ дагаж мөрдөх хэрэгцээ улам бүр нэмэгдэх болно. Эдгээр зорилгод хүрэхийн тулд хоёр талт (bilateral) болон буяны санхүүжилтийн төлөө өрсөлдөхийн оронд зохицуулалт хийж, нийтлэг ухуулга сурталчилгаа, хөрөнгө босгох хөтөлбөрийг дэмжихээр олон улсын оролцогчид нэгдэх ёстой.

Үйлийн нийтлэг зорилго, бүтэцчилэгдсэн хүрээг тогтоохдоо боловсролын салбар нь уур амьсгалын болон эрүүл мэндийн салбараас зохих сургамжийг авч болно. Олон улсын хамтын ажиллагааны ширээний ард сууж буй бүх оролцогчид өөрсдийн тодорхой, тодорхой хугацаатай зорилго, амлалт үүргийг тогтоодог болгохын тулд бид илүү их зүйлийг хийж чадна. Зорилго нь илүү тодорхой, орон нутгийн өмчийн зорилго байх тусам хамтын ухуулга сурталчилгаа, хариуцлагын товлосон зорилт болохуйц бодитой болж, зорилгын тодорхой “ээзд” нь зорилгоо биелүүлэх магадлал өндөр байх тул олон улсын хамтын ажиллагааг субсидиар зарчмын дагуу зохион байгуулах ёстой. Боловсролын оролцогч бүрийн эдгээр амлалт үүрэг, зорилгынхоо төлөө хариуцлагатай байлгахын тулд ахиц дэвшлийг нотолгоонд суурилсан үнэлгээ ашиглан бүс нутгийн болон олон улсын хяналтын илүү хүчтэй механизмыг бий болгож болно.

Дэлхийн хэмжээнд боловсролын салбар болон олон улсын холбогдох байгууллагууд сэдэвчилсэн болон дэд салбарын нөхцөл байдлыг эрэмбэлэхэд бэрхшээлтэй байдаг нь ихэвчлэн олон тооны гүйцэтгэлийн тунхаглал, хүч тарамдсан үйл ажиллагаа, мөн бидний хамгийн эрхэмлэн, удаан хүлээсэн боловсролын зорилгын заримыг биелүүлж чадахгүйд хүргэдэг. Олон улсын байгууллагууд бүх зүйлийг хийх гэж оролдох ёсгүй. Тэдний ажил хэрэг бол бусдын үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх явдал юм. Ингэхийн тулд тэд зөвшилцөлд суурилсан амлалт үүргийг бий болгох дэлхий нийтийн болон бүс нутгийн чадавхыг нэмэгдүүлэх, эдгээр амлалт үүргийн хариуцлагыг хүлээлгэхэд анхаарлаа хандуулах ёстой. Олон улсын оролцогчид мэдлэг, нотлох баримтыг зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, мэдлэгийг бий болгох, ашиглахад олон янз оролцогчдын оролцоог хангах нь үр дүнтэй байдаг. Тэд мөн боловсролын гэнэтийн сорилт, ялангуяа орлого багатай улс орнууд болон онцгой байдлын хам нөхцөлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хамгийн эцсийн найдварын санхүүжүүлэгчийн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Боловсролын нийтлэг ирээдүйг тодорхойлоход олон улсын байгууллагууд бидний анхаарлыг урт хугацааны сорилтод чиглүүлэх өвөрмөц онцгой үүрэг гүйцэтгэж чадна. Жишээлбэл, ажлын болон автоматжуулалтын өөрчлөгдөж буй ертөнцөд хариу үйлдэл үзүүлэх боловсролын үүрэг ролийн талаар; шилжилт хөдөлгөөн, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хил дамнасан гаднын нөлөөллийг хэрхэн оновчтой шийдвэрлэх талаар; улам бүр цахимжиж, үндэстэн дамнасан байдлаар үзүүлж буй боловсролын үйлчилгээг хэрхэн зохицуулах талаар илүү их судалгаа, мэтгэлцээн хийх ёстой.

**Боловсролын нийтлэг ирээдүйг тодорхойлоход олон улсын байгууллагууд бидний анхаарлыг урт хугацааны сорилтод чиглүүлэх өвөрмөц онцгой үүрэг гүйцэтгэж чадна.**

Өргөн хүрээний оролцоо, хамтын шийдвэр гаргах замаар нийтлэг мөрийн хөтөлбөрийг хамтдаа бий болгох ёстой. Энэ мөрийн хөтөлбөр нь ирээдүйг удирдах урт хугацааны сэтгэлгээ хоорондын хурцадмал байдлыг шийдвэрлэх ёстой бөгөөд өнгөрсөн үеэс уламжлагдан ирсэн боловсролын тэгш бус байдал, хасан гадуурхалтыг засахын тулд өнөө үед яаралтай оролцох шаардлагатай байна.

## Мэдлэг бүтээх, нотлох баримт ашиглах чиглэлээр хамтран ажиллах

Судалгаа ба нотлох баримт бол боловсролын салбарт зайлшгүй шаардлагатай дэлхийн бүтээгдэхүүн юм. Эдгээр хамтдаа засгийн газрууд болон тэдний түншүүдэд боловсролын өөрчлөлтийг хурдасгахын тулд асуудлыг шийдвэрлэх, шинийг санаачлахад тусалдаг. Эдгээр нь мөн дэлхийн, бүс нутгийн, үндэсний амлалт үүргийн төлөөх олон улсын хариуцлагыг бэхжүүлэх үндсэн суурь юм.

ЭЗХАХБ-аас НҮБ-ын агентлаг хүртэлх олон улсын томоохон байгууллагуудын үйл ажиллагаанд эзгүй/хоосон өгөгдөл, лигийн хүснэгтүүд болон “тоогоор удирдах” бусад хэлбэрийг буруу ашиглаж байгаа талаар маш их шүүмжлэл гарсан. Эдгээр шүүмжлэл нь үндэслэлтэй боловч боловсролын тогтолцоог шударгаар удирдаж, нийтлэг сайн сайхныг хангахын тулд бидэнд статистикийн нэгдсэн мэдээлэл хэрэгтэй байна. Эрүүл мэнд, уур амьсгалын салбарт болон боловсролын салбар дахь сүүлийн үеийн үндэстэн дамнасан ухуулга сурталчилгааны харуулсан шиг ахиц дэвшлийг хянах, үнэлэх хүчин чармайлт нь бидний хамтын зорилгод хүрэх, мөн боловсролын янз бүрийн төрлийн оролцогч талуудыг татан оролцуулахын тулд дэлхийн хэмжээнд илүү хариуцлага хүлээхэд хувь нэмрээ оруулж чадна.

Дэлхийн оролцогчид олон улсын нотлох баримт, мэдээллийн хүртээмж, ашиг тусыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтыг өнөөдрийг хүртэл нэгтгэж, зохицуулж чадаагүй байна. Олон талт томоохон байгууллагууд өндөр чанартай хяналттай өгөгдөл гаргахын тулд нөөцөө нэгтгэдэг дэлхийн эрүүл мэндийн салбараас ялгаатай нь НҮБ-ын агентлагуудын хооронд стандарт тогтоох, статистик болон холбогдох чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх түншлэлийн хэлэлцээр байдаггүй. Нотлох баримтыг үр дүнтэй нэгтгэх, түгээх, нотлох баримт ба судалгааны зөрөөг тодорхойлох, мөн чадавхыг бэхжүүлэх нь олон улсын оролцогчдоос шинэ түвшний зохицуулалт, санхүүжилтийг шаардана.

Мэдлэг, өгөгдөл, нотлох баримтыг бий болгох, ашиглах чадавхыг бэхжүүлэх дэмжлэгийг мөн илүү сайн санхүүжүүлж, зохицуулах ёстой. Заримдаа мэдлэг, судалгааны олон улсын хүчин чармайлт нь нэг талын яриа мэт харагддаг. Үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Олон улсын хамтын ажиллагаа нь дэлхийн өмнөд бүсийн орнуудад өөрсдийн өвөрмөц онцгой нөхцөл байдалд нь тохирсон шинэ, шинэлэг судалгааны парадигмуудыг тодорхойлох илүү их орон зайг нээх ёстой. Эрүүл мэндийн салбарын хувьд сүүлийн үеийн хүчин чармайлт нь үндэсний болон орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх, улс орнууд бие биеэсээ суралцахад дэмжлэг үзүүлэх зорилготой зохицуулалтын платформыг бий болгоход чиглэгдэж байна. Боловсролын асуудлыг шийдвэрлэхэд Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаанд хөрөнгө оруулах шинэ загварууд зайлшгүй шаардлагатай. Бүлэг 8-д онцлон тэмдэглэсэнээр, энэ нь сэтгэлгээг баяжуулж, илүү олон төрлийн шинэлэг шийдлүүдийг дэмжих олон янзын мэдэхүйн арга замууд болон танин мэдэхүйн онолд онцгой анхаарал хандуулахыг шаарддаг.

Олон улсын судалгаа, нотлох баримт, өгөгдлийг санхүүжүүлэх нь боловсролын салбарын томоохон сорилт юм. Дэлхийн эрүүл мэндийн салбарт хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн

25 орчим хувийг ийм төрлийн бараа бүтээгдэхүүнд зарцуулж (ойролцоогоор 7 тэрбум доллар) байхад 2015 онд нийтлэг мэдлэг, нотлох баримт, өгөгдлийн бүтээгдэхүүний санхүүжилтийг ХАЁТ-ийн 3%-аас бага (эсвэл 200 сая ам. доллар) гэж тооцсон байна. НҮБ-ын хэд хэдэн агентлагуудын дэргэд боловсролын мэдлэг, нотлох баримт бий болгох урьдчилан таамаглах боломжтой нэгдсэн сан байгуулах гэх мэт судалгаа, мэдлэг, нотлох баримтад зориулсан дэлхийн санхүүжилтийг сайжруулах шинэ хувилбаруудыг авч үзэх нь зүйтэй.

## Боловсрол нь аюулд байгаа газарт боловсролыг санхүүжүүлэх нь

Боловсролын салбар дахь олон улсын хамтын ажиллагааг үндсээр нь эргэн харж, тусламжаас хамааралтай гэсэн логигоос татгалзах шаардлагатай байгаа ч боловсролын салбар дахь олон улсын тусламжийн шинэ харилцан хамаарлын үүрэг, гол анхаарлаа дахин үнэлэх ёстой.

Тусламж нь үндэсний хэрэгцээний маш бага хувийг хангадаг тул дэлхийн тавцанд үзүүлэх нөлөө, нийцтэй байдал нь буурах болно. Энэ нь колоничлоос үүдэлтэй хүчний тэнцвэргүй байдлыг хурцатгаж, боловсролын тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хэтэрхий бага зүйл хийсэн. Үүний зэрэгцээ бага, дундаас доош орлоготой орнуудыг, ялангуяа ойрын арван жилд залуучуудын ихэнх нь амьдрах Африкийн орнуудыг дэмжих санхүүжилтийн нөөц шаардлагатай байна. Өнөөдөр тусламжийн дөнгөж 47% нь бага, дундаас доош орлоготой орнуудын K-12 боловсролд зарцуулагддаг. Мөн бид цаг уурын хямрал гүнзгийрэх тусам тоо нь өсөх дүрвэсэн хүн ам болон албадан цагаачдын боловсролын хэрэгцээг дэмжихэд дэлхийн санхүүжилтийг зориулах хэрэгтэй. “КОВИД-19” цар тахлын харуулсан шиг бидэнд хямрал, онцгой байдлын дараа яаралтай хариу арга хэмжээ авах, боловсролын сэргээн босголтод олон улсын санхүүжилтийн нөөц хэрэгтэй хэвээр байна.

Эндээс 2050 он хүрэхийн тулд бид одоо байгаа олон талт сувгуудаа сайжруулах шаардлагатай бөгөөд ингэснээр хүрэлцээгүй байгаа хэсгээ нөхөх шинэ нөөцийг бүрдүүлэхийн зэрэгцээ үндэсний нөөцийг дайчлах, үндэсний чадавхыг бэхжүүлэх шаардлагатай болно. Олон улсын хандивлагчид 2005 онд Тусламжийн чанар, үр өгөөжтэй байдлын тухай Парисын тунхаглалыг баталсантай адил улсуудын-дотооддоо боловсролын төлөвлөгөө, үндэсний тогтолцооныхоо хүрээнд хандивлагчдын тусламж, зохицуулалтыг илүү уялдуулах нь өнөөдөр ч чухал хэвээр байна.

Олон талт сувгууд нь тусламжийн үр өгөөжтэй байдлыг дээшлүүлэх илүү сайн боломжуудыг санал болгодог бөгөөд тусламжийг хамгийн их хэрэгцээтэй байгаа улс орон, хүн амд чиглүүлэх хандлагатай байдаг. Гэхдээ тэд ч гэсэн төсөлжсөн хэвээр байгаа; өөрсдийн бий болгосон мэдлэг, зааварт зээлдэгч болон тэтгэлэг авагчдыг үндэслэлгүйгээр холбодог; үндэсний чадавхыг дэмжих туршлага сул байгаа зэрэг ажлаа сайжруулах хэрэгтэй болно. Жишээлбэл, дэлхийн нийтийн эрүүл мэндийн хувьд эдгээр алдааг арилгах сүүлийн үеийн саналд агентлаг хоорондын санхүүгийн дэмжлэгийг техникийн дэмжлэгээс салгах, олон талт байгууллагуудын хамтын хариуцлагын механизм зэрэг багтаж байна.

## ЮНЕСКО-ийн үүрэг роль

ЮНЕСКО өнгөрсөн 25 жилийн хугацаанд олон сорилттой тулгарсан. Боловсролын салбарт дэлхийн хэмжээний яриа хэлэлцээ, стандарт тогтоох албан ёсны үүрэг хариуцлагаа хэвээр үлдээж, боловсролын салбарын ТХЗ4-ийн хэрэгжилтийг хангахын тулд эдгээр үүргээ үр дүнтэй биелүүлэхийн төлөө тэмцэж, хатуу шүүмжлэлд өртөж байна. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбарт чиг үүрэг нь өргөн хүрээтэй ч ЮНЕСКО-ийн нийт төсөв нь Европын олон их сургуулиудынхаас бага байгааг тэмдэглэх нь зүйтэй. ЮНЕСКО-ийн боловсролын салбарын нийт төсөв нь Дэлхийн банкнаас боловсролын салбарын мэдлэг, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд зарцуулдаг төсвийн багахан хувьтай тэнцдэг.

Тогтвортой боловсролын ирээдүйн талаарх бидний алсын хараанд үр дүнтэй үүрэг гүйцэтгэхийн тулд ЮНЕСКО боловсролын хөгжилд хандах хандлагаа эргэн харах шаардлагатай болно. ЮНЕСКО нь субсидиар зарчмыг үндэслэн нэгдүгээрт, өөрийгөө бүс нутгийн, үндэсний институци, үйл явцыг бэхжүүлэх үүрэгтэй түнш гэж үзэх ёстой. Хоёрдугаарт, ЮНЕСКО нь нотлох баримтын брокер, боловсролын тогтолцооны бүх түвшинд өгөгдөл, иргэдийн хариуцлагыг бэхжүүлэхийг дэмжигч юм. ЮНЕСКО нь боловсролын нийгмийн шинэ гэрээний төлөө дэлхийн хэмжээний яриа хэлэлцээг дэмжих хосгүй өвөрмөц үүргээ хэвээр хүлээхийн зэрэгцээ санхүүгийн болон хүний нөөцийн дийлэнх хэсгийг боловсрол эзэмших эрх хамгийн ихээр эрсдэлд орж буй бүс нутгуудад, ялангуяа 2050 он гэхэд дэлхийн залуучуудын ихэнх нь амьдарч, суралцах Африкт төвлөрүүлэх ёстой.

Боловсролын хэм хэмжээ тогтоох, санхүүжүүлэх, мэдлэгийг дайчлах үйл ажиллагаанд оролцдог дэлхийн болон бүс нутгийн оролцогчдын цогц экосистемийн хүрээнд ЮНЕСКО нь харьцангуй давуу талынхаа тухай илүү тодорхой ойлгох хэрэгтэй болно. ЮНЕСКО нь НҮБ-ын түншүүдтэй хамтран ажиллаж, бидний тодорхой бус энэ зуунд улам бүр өсөх хандлагатай байгаа албадан цагаачид болон дүрвэгсдийн боловсрол эзэмших эрхийг хангах шинэлэг шийдлүүдийг эрэлхийлэх ёстой. ЮНЕСКО нь хүний эрхийн хувьд дижитал мэдээлэл илүү тэгш, илүү хүртээмжтэй байхыг ухуулан сурталчлахын тулд дэлхийн хэмжээнд оролцоогоо ашиглах ёстой. ЮНЕСКО нь боловсролын засаглалд иргэд, иргэний нийгмийн оролцоог дэмжих ёстой бөгөөд ингэснээр боловсрол тэдний хэрэгцээнд нийцэх юм. ЮНЕСКО нь энх тайван, хөгжил цэцэглэлт, тогтвортой байдлын төлөө боловсролыг бэхжүүлж, бидний хамтын ирээдүйг бүтээхэд боловсролын гүйцэтгэх үүрэг ролийг чиглүүлэгч НҮБ-ын гэрэлт цамхаг хэвээр байх ёстой.

ЮНЕСКО нь бидний боловсролын хамтын ирээдүйг тодорхойлохын тулд дэлхий даяарх хүмүүс, байгууллагуудыг нэгтгэн, дайчлах хосгүй өвөрмөц чадавхтай. Үүнд л түүний агуу хүч оршино. Шинэ, Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахад, мөн хамгийн чухал нь түүнийг хэрэгжүүлэх шинэ зөвшилцөл байгуулахад энэ хүч хэрэгтэй байна.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Энэ бүлэг нь боловсролын ирээдүйн хэрэгцээ, сорилт, бололцоонд хариу өгөхийн тулд олон улсын хорших ажиллагааг шинэчлэх уриалгыг дэвшүүлж байна. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад боловсролын ирээдүйн олон улсын хамтын ажиллагаатай холбоотой дөрвөн үндсэн тэргүүлэх чиглэл байна:

- **Комисс боловсролын бүх оролцогч талуудыг боловсролын сорилтод нийтлэг шалтгаант зорилго, нийтлэг шийдлийг бий болгохын тулд дэлхийн болон бүс нутгийн түвшинд хамтран ажиллахыг уриалж байна.** Бүх хүн төрөлхтний шударга, тэгш боловсролын ирээдүйг дэмжихэд шаардлагатай нийгмийн шинэ гэрээг бий болгох нь боловсрол эзэмших эрх нь дэлхийн сорилтоор хамгийн ихээр эрсдэлд буй хүмүүсийн хувьд онцгой ач холбогдолтой юм. Оролцоонд төрийн бус олон янз оролцогчид, түншлэлүүд багтаж, дээрээс доошоо бус олон төвт үйл ажиллагаа руу шилжиж, бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ хэлбэр, ялангуяа Өмнөд-Өмнөд болон гурван талт хамтын ажиллагааг нэвтрүүлэх ёстой.
- **Олон улсын хамтын ажиллагаа нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх орон нутгийн, үндэсний, бүс нутгийн хүчин чармайлтыг дэмжих, чадавхыг бэхжүүлэх үйл хэрэгт субсидиар зарчмаар ажиллах ёстой.** Боловсролын шинэ амлалт үүрэг, норм, стандартыг бататгахын тулд боловсролын амлалт үүргээ биелүүлэх эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, боловсролыг сайжруулах чиглэлээр уялдаа холбоотой нөлөөллийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай болно.
- **Бага, дундаас доош орлоготой орнуудын олон улсын хөгжлийн санхүүжилтэд анхаарал хандуулах нь чухал хэвээр байна.** Энэ нь ялангуяа эдийн засаг эрс хязгаарлагдмал, залуу хүн амтай улс орнууд, тухайлбал Африкт хамаатай. Мөн хямрал, онцгой байдлын улмаас сурч боловсрох эрх нь тасалдсан хүн амд чиглэсэн санхүүжилт хэрэгтэй байна.
- **Нотлох баримт, өгөгдөл, мэдлэгт нийтлэг хөрөнгө оруулалт хийх нь олон улсын үр дүнтэй хамтын ажиллагааны чухал хэсэг юм.** Энд бидний хүчин чармайлт нь мэдлэгийг бий болгох, ашиглах орон нутгийн, үндэсний, бүс нутгийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатайг онцлон, субсидиар зарчмыг баримтлах ёстой. Боловсролын тэгш бус байдал, ядуурлыг арилгах, төрийн үйлчилгээг сайжруулах зэрэг үндсэн чиглэлээр, мөн автоматжуулалт, дижиталчлал, байгаль орчны тогтвортой байдал, шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй урт хугацааны сорилтуудыг даван туулахын тулд нийгэм, хил хязгаарыг дамнан харилцан суралцах, мэдлэг солилцох ажлыг урьд өмнөхөөсөө илүү бэхжүүлэх шаардлагатай байна. Боловсролын ахиц дэвшлийн талаарх дэлхийн мэдлэг, өгөгдөл гэсэн хоёр чиглэлийг баталгаажуулахын тулд нэгдсэн платформ, санхүүжилтийн шинэ эх үүсвэр хэрэгтэй.

Дэлхий дахины эв нэгдэл, үйл хэргийн энэхүү мөрийн хөтөлбөр нь тууштай, зоримог, уялдаа холбоо дээр суурилсан байх ёстой бөгөөд 2050 он болон цаашдын ирээдүйг үргэлж хараандаа байлгах ёстой. Энэ нь хамтын хариуцлагыг, мөн НҮБ-ын хүрээнд зохицуулалтыг сайжруулах, ЮНЕСКО-ийн үүргийг бэхжүүлэх гэсэн үг юм. Үүнгүйгээр энэхүү илтгэлд тусгасан боловсролыг дэлхий нийтийн түвшинд нийтийн болон нийтлэг сайн сайхан байдал гэж тодорхойлох,



**Бүлэг 9 | Дэлхий нийтийн эв санааны нэгдэл болон олон улсын хамтын ажиллагаанд уриалсан дуудлага**

боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулах тухай саналууд хэрэгжих боломжгүй. Нэг үеийн дотор бид боловсролын системийг үнэхээр хүртээмжтэй, нийцтэй байхаар хувирган өөрчилж, дэлхийн хэмжээнд тулгарч буй сорилтуудыг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх боломжтой.

# Төгсгөлийн үг ба үргэлжлэл

**Боловсролын ирээдүйг  
хамтдаа цогцлоох нь**

Бид хүн төрөлхтөн болон манай гарагийн ирээдүйн хэрэгцээг хангахуйц боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахын тулд яаралтай хамтран ажиллах ёстой. Энэхүү илтгэлд амьдралын туршдаа сурч боловсрох эрхтэй холбоотойгоор боловсролын алсын харааг тэлэх, боловсролыг нийтийн болон нийтлэг сайн сайхны байдал болгон бэхжүүлэх гэсэн үндсэн хоёр зарчимд тулгуурлан энэхүү шинэ гэрээг бүтээхэд баримтлах тэргүүлэх чиглэлүүд болон зөвлөмжүүдийг дэвшүүлсэн болно.

Илтгэлийн гол цөм нь боловсролын нийгмийн шинэ гэрээний санал буюу боловсролын эргэн тойрон дахь нийгмийн эв нэгдлийг идэвхжүүлж, урамшуулах, боловсролын зохих зохицуулалтыг бий болгох далд гүн гүнзгий утга бүхий тохиролцоо ба зарчмууд юм. Энэхүү төгсгөлийн үг (эпилог) нь уншигчдад боловсролын хамтын ирээдүйн төлөө бусадтайгаа хамтдаа урагшлах, дахин тайлбарлах, дахин төсөөлөх талаар санал болгож буй тэргүүлэх гол чиглэлүүд, саналуудыг нэгтгэн дүгнэхэд зориулагдсан болно.

Боловсролын нийгмийн шинэ гэрээ нь боловсролын талаар өнөөг хүртэл хамтдаа сурч, хуримтлуулсан туршлага, бүх зүйлээсээ татгалзаж орхих хэрэг биш, гэхдээ аль хэдийн тодорхойлогдож, тогтоогдсон замынхаа чиглэлийг зүгээр л нэг засаж тохируулах явдал бас биш юм. Сурган хүмүүжүүлэгчид, олон нийт, залуучууд, хүүхдүүд, гэр бүлүүд нь одоо байгаа боловсролын тогтолцооны хязгаарлагдмал талуудыг нарийвчлан тодорхойлж, тэдгээрийг даван туулах шинэ арга хандлагуудын анхны шанг татах, урт удаан хугацаанд хэрэгжих нийгмийн шинэ гэрээний үйл явц хэдийнээ эхэлчхээд байна.

Сурган хүмүүжүүлэгчид, олон нийт, залуучууд, хүүхдүүд, гэр бүлүүд нь одоо байгаа боловсролын тогтолцооны хязгаарлагдмал талуудыг нарийвчлан тодорхойлж, тэдгээрийг даван туулах шинэ арга хандлагуудын анхны шанг татах, урт удаан хугацаанд хэрэгжих нийгмийн шинэ гэрээний үйл явц хэдийнээ эхэлчхээд байна.

Гэвч хүчин чармайлтууд нь боловсролыг сэргээн босгохын төлөөх хичээл зүтгэлийнхээ явцад юу сурч мэдсэнээ илэрхийлэхгүй, бас хамтдаа цугларахгүйгээр, ихэвчлэн тусгаарлагдсан эсвэл томоохон институцийн механизмд бага зэрэг тохируулга хийгдэхээр хязгаарлагдсан байдаг. Шударга, үл алагчлагддаг, тогтвортой ирээдүйг боломжтой болгохын тулд боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулах яриа хэлэлцээ, практик туршилтад идэвхтэй оролцох замаар бид боловсролыг шинэчилж чадна. Энэхүү илтгэл нь эдгээр олон нийтийн яриа хэлэлцээг хам нөхцөлд нь нийцүүлэн нутагшуулах, цаашид улам ахиулан урагшлуулах урилга юм. Энд боловсролын нийгмийн гэрээ нь практикт болон тухайн тодорхой хам нөхцөлд ямар утгатай болох талаар дэлхий даяар өрнөх яриа хэлэлцээг хурдасгагч, өдөөгч байхаар тооцсон. Иймээс энэхүү илтгэл нь ирээдүйд хүрэх урт зам дахь товлосон чухал шав тэмдэг болно. Энэ бол дэлхийн өнцөг булан бүрд байгаа хүмүүс цаашид эрж хайн судлах, хуваалцах, баяжуулахад хэрэг болох олон үйлийн хүрээ, зарчим, зөвлөмжийг санал болгож буй амьд баримт бичиг юм. Түүний чиглэсэн зорилго нь боловсролыг шинэчлэх, хувирган өөрчлөхөд чиглэсэн бодлого боловсруулах, инновацлаг үйл ажиллагаа явуулах шинэ талбар, гарц гаргалгаанд урам зориг өгөх явдал бөгөөд ингэснээр боловсрол нь бүх суралцагчдыг илүү сайн ирээдүйг бүтээхэд үнэхээр жинхэнээсээ бэлтгэхэд

оршино. Энэ нь зөвхөн багш, сурагч, гэр бүл, засгийн газрын албан тушаалтнууд, боловсролын бусад хувь нийлүүлэгчид, ялангуяа хамтын нийгэмлэгүүд нь илтгэлд тусгагдсан үзэл санаануудад анхаарлаа төвлөрүүлж, тэдгээр нь тухайн нийгэмлэгийн практикт ямар утга агуулга илэрхийлэхийг хамтдаа хэлэлцэж шинэлэг үйлийн баримжаа бүтээсэн үед л боловсролын хувирган өөрчлөлт утга учиртай болно.

Тус Комисс нь ЮНЕСКО-г энд дэвшүүлсэн олон шинэлэг санаатай холбоотой хэлэлцүүлэг, оролцоо, туршлагаа хуваалцах зохих арга замуудыг боловсруулж, тогтвортой байлгахыг уриалж байна. Илтгэлийн ирээдүйн амжилт нь түүний байнгын эргэцүүлэх, үйлдэх үйл явцыг урамшуулан зоригжуулах чадамжид тулгуурлана. Боловсролын ажил ямагт “үйл явцдаа” байдаг тул энд танилцуулсан зөвлөмжүүд нь байнга шилжин хөдөлж, хувьсан өөрчлөгдөж байх ёстой гэсэн таамаглалд үндэслэгдсэн болно. Бид бие биетэйгээ болон манай гарагийг бусдаас ялгаж буй гайхалтай амьдралын хэлбэрүүд, системүүд мөн хүн төрөлхтний хөгжил дэвшлийн шинэ орон зай, нөөц потенциалыг хурдтай нээж байгаа ч, ижилгүй эрсдэлийг бий болгож буй хоёр талтай технологитой тус тус зохицож амьдрахад илүү их бүтээлчээр хамтран ажиллах хэрэгтэй байна.

Дэлхий ертөнцийг бүтээх, дахин сайжруулахад гүйцэтгэх боловсролын үнэ цэнийн талаарх дэлхий нийтийн түвшний зөвшилцөл нь бидний хамтдаа зорчих эхлэлийн цэг-гарц юм. Энэхүү хамтын итгэл үнэмшил нь маргашгүй бөгөөд бид ихэнх нь урьд өмнө хэзээ ч байгаагүй шинэ сорилтуудтай тулгарч байгаа үед бидний амлалт үүргийг бэхжүүлэх болно. Аливаа зүйлийг өөрөөр хийхийн тулд бид одоо өөрөөр бодож, ойлгож, сонсож, төсөөлөх хэрэгтэй. Боловсрол, мэдлэг, суралцахуйн тухай сэтгэлгээний ямар ч тогтсон арга барил нь ирээдүйг хувирган өөрчлөх шинэ замыг нээж чадахыг тогтоох нээлттэй шалгалт бидэнд хэрэгтэй байна.

## Нийгмийн шинэ гэрээг бүтээх саналууд

Илтгэл нь боловсролын нийгмийн шинэ гэрээг бүтээхэд шаардлагатай өөрчлөлтүүдийн таван хэмжүүрийг судалсан. Эдгээр хэмжүүр тус бүрд харгалзах гол саналуудыг энэхүү илтгэлийн Хэсэг II-т, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн зарчмуудын хамт тодруулж өгсөн. Эдгээр нь бүрэн гүйцэд төгс биш боловч боловсролоор дамжуулан шинэ ирээдүйг нутагшуулж, ахиулан урагшуулж болохуйц гарааны анхны үйлийн хүрээ болгон энд нэгтгэн харуулав.

## Эв нэгдэл ба хамтын ажиллагааны сурган хүмүүжүүлэх зүй

Сурган хүмүүжүүлэх ухааны хасан гадуурхдаг, хувь хүмүүсийг өрсөлдүүлдэг олон жилийн хэв маягийг хамтын ажиллагаа, эв нэгдлийн зарчмуудаар сольж, эдгээр зарчмуудын эргэн тойрон дахь хувирган өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Сурган хүмүүжүүлэх ухаан нь энэрэх нинжин сэтгэл болон нигүүлсэх ариун сэтгэлийг тэтгэн төлөвшүүлэх ёстой бөгөөд өөрийгөө болон дэлхий ертөнцийг хувирган өөрчлөхийн тулд хамтдаа ажиллах хувь хүмүүсийн чадавхыг хөгжүүлэх ёстой. Суралцахуй нь анги танхимын хэм хэмжээ, ёс зүйн дүрмийн хязгаарлалтаас давсан багш, сурагч, мэдлэг хоорондын харилцаагаар тодорхойлогдох болно. Суралцахуй нь бидний хамтын болон нийтлэг ертөнцийн төлөө хариуцлага хүлээхэд шаардлагатай ёс зүй, анхаарал халамж бүхий сурагчдын харилцаагаар өргөжин тэлэх учиртай. Сурган хүмүүжүүлэх арга зүй бол юу байгаадаа болон юуг шинээр бүтээж болоход тулгуурласан хувирган өөрчлөх нүүр тулах уулзалтуудыг бий болгох ажил юм.

Бид 2050 он хүртэлх ирээдүйг харахдаа хувь хүмүүст төвлөрч, өрсөлдүүлэн уралдуулж амжилтыг тодорхойлохыг урьтал болгодог сурган хүмүүжүүлэх хэв маяг, сургамж, хэмжилтүүдээс татгалзах учиртай. Үүний оронд бид удирдамж болох зарчмуудаа дараах байдлаар эрэмбэлэх хэрэгтэй.

Нэгдүгээрт, хувь хүнийг болон хамт олныг хувирган өөрчилдөг харилцан уялдаа холбоо, харилцан хамаарал, эв нэгдэл нь сурган хүмүүжүүлэх ухаанд зайлшгүй шаардлагатай. Багш нар анги доторх болон ангиас гадуурх сурган хүмүүжүүлэх харилцааг тэтгэн хөгжүүлэхэд хэрхэн суралцахын хэрээр сургуулиуд болон боловсролын системүүд эдгээр туршлагыг илүү институтчиллийн түвшинд нэвтрүүлэх арга замыг хайж олох ёстой. Туршлага ба яриа хэлэлцээ, үйлчилгээ ба утга учиртай үйлүүд, шинжилгээ судалгаа ба эргэцүүлэл, бүтээлч нийгмийн хөдөлгөөн ба олон нийтийн амьдралд оролцох оролцоо зэрэг нь олон зүйлийг амлаж чадах ирээдүйтэй олон арга хандлагын цөөн хэдэн хэсэг юм. Сургууль ба боловсролын систем нь гэр бүл, олон нийтийг сонсож, ангиас гадуурх шинэ холбоо ба сурган хүмүүжүүлэх харилцаануудыг дэмжиж, амьдралын бусад салбарт өргөжин тэлэхийн тулд нийгмийг болон салбарыг тусгаарласан хананаасаа гарах ёстой.

Хоёрдугаарт, хамтын ажиллагаа, хорших ажиллагаа нь хамтын, харилцан хамааралтай үйл явц болох сурган хүмүүжүүлэх ухааны үндэс суурийг бүрдүүлж төлөвшүүлэх ёстой. Шинэ сорилт-зорилтуудыг бүтээлчээр, урьдчилан таамаглаагүй арга замаар бие даан болон хамтдаа даван туулах сурагчдынхаа чадамжийг хөгжүүлэхийн тулд багш нар үе тэнгийнхэнтэйгээ тогтоосон эргэх холбоо, төсөлд суурилсан суралцахуй, асуудал-дэвшүүлсэн болон эрэл хайгуулд суурилсан суралцахуй, сурагчдын лаборатори, техникийн болон мэргэжлийн воркшоп (workshop), урлаг уран сайхны илэрхийлэл, бүтээлч хорших ажиллагаа зэрэг олон төрлийн суралцахуйн стратегид татагдан оролцох боломжтой. Сургуулиуд ба боловсролын системүүд нь насны бүлгүүд, авьяас сонирхол, нийгмийн бусад салбарууд, хэлнүүд, суралцахуйн үе шатуудын асуудлаар илүү өргөн хүрээний нүүр тулах уулзалтуудад тус нэмэр үзүүлэх арга замыг мөшгөн судлах боломжтой.

Гуравдугаарт, эв нэгдэл, бусдыг нигүүлсэх ариун сэтгэл ба энэрэх нинжин сэтгэл нь бидний хэрхэн суралцах арга барилын салшгүй хэсэг нь болсон байх ёстой. Сурган хүмүүжүүлэх ухаан нь

сурагчдад өөрсдийнх нь туршлагаас илүү их өргөн хүрээний туршлагыг ойлгох боломжийг олгодог. Эцэг эх, гэр бүлийг юмс, үзэгдлийн олон янз байдал, санал бодлын олон ургалч үзлийг хуваалцах, үнэлэх ажилд хүүхдүүдтэйгээ хамтдаа оролцохыг урьж байгаа нь сурагчдын хүрээлэл орчин, харилцаанд тулгардаг өрөөсгөл хандлага, мухардмал зан заншил, хуваагдмал байдалд суралцахгүй байхад нь чухал ач холбогдолтой юм. Сургууль, багш нар энэрэх нинжин сэтгэлийг эрхэмлэн, түүх, хэл, соёл, түүний дотор ялангуяа, нутгийн уугуул иргэд, өргөн хүрээний нийгмийн хөдөлгөөнүүдийн олон янз байдлыг дэмжсэн орчныг бүрдүүлж чадна.

Дөрөвдүгээрт, бүх үнэлгээ нь сурган хүмүүжүүлэх шинж чанартай байдаг учраас сурагчийн өсөлт хөгжилт, суралцахууд чиглэсэн сурган хүмүүжүүлэх өргөн хүрээний тэргүүлэх чиглэлийг дэмжихийн тулд үнэлгээг тун анхааралтай авч үзэх ёстой. Багш нар, сургуулиуд, боловсролын системүүд хувь хүний болон хамт олны суралцахууг илүү сайн дэмжихийн тулд сорилт асуудалтай хэсгийг зөв тодорхойлж, шийдвэрлэхэд илүү их ач холбогдол өгч үнэлгээг ашиглах учиртай. Үнэлгээг шийтгэхэд болон “ялагч” ба “ялагдагч” буюу түрүүлэгч ба хоцрогч гэсэн ангиллыг бий болгоход ашиглаж болохгүй. Эргээд сургуулиудын цаг хугацаа, орон зайн онцлогтойгоор явагдаж буй үйл явцад пропорциональ бус дарамт үзүүлэх өндөр-амлалттай, хам нөхцөлөөс ангид шалгалтуудад ач холбогдол өгч зэрэглэл тогтоох замаар боловсролын бодлогод хэт нөлөөлөх ёсгүй.

Сурган хүмүүжүүлэх арга  
зүй бол юу байгаадаа  
болон юуг шинээр бүтээж  
болоход тулгуурласан  
хувирган өөрчлөх нүүр  
тулах уулзалтуудыг бий  
болгох ажил юм

## Сургалтын хөтөлбөр ба нийтлэг мэдлэг

Боловсрол болон түүний сурталчлан дэмжих мэдлэг, нөөц чадварууд, үнэт зүйлсийн хооронд шинэ харилцаа тогтох ёстой. Хүн төрөлхтний нийтлэг өвийн нэг хэсэг болох мэдлэг эзэмших; шинэ мэдлэг ба шинэ боломжит ирээдүйг хамтдаа бүтээх гэсэн боловсролын үндэс суурь болох хоёр амин чухал үйл явцтай холбож сургалтын хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харахдаа сургалтын хөтөлбөрийг зүгээр л сургуулийн хичээлүүдийн сүлжээ гэж үзэх уламжлалт үзэл бодлын оронд сурагчдад хүн төрөлхтний нийтлэг мэдлэгээс суралцах, түүнд хувь нэмрээ оруулах боломжийг олгох судлагдахуун хоорондын болон соёл хоорондын харилцааны хэтийн төлөвт баримжаалан дахин төсөөлөх хэрэгтэй. Удирдамж болох дараах гол зарчмуудыг нэн тэргүүнд тавих ёстой.

Нэгдүгээрт, сургалтын хөтөлбөрүүд нь бүх хүн төрөлхтний өв болсон нийтлэг мэдлэгийг хүртээмжтэй байлгах, түүнд хувь нэмрээ оруулах суралцагчдын чадамжийг хөгжүүлж, олон янзын мэдэх, ойлгох арга замыг тасралтгүй өргөжүүлэх ёстой. Сургалтын хөтөлбөрийг дизайнчлах, хэрэгжүүлэхдээ баримт ба мэдээллийн явцуу дамжуулалтаас татгалзаж, оронд нь суралцагчдад мэдлэг эзэмших, хэрэглэх, шинээр бүтээх олон янз бүхий арга хэлбэрүүдэд татагдан оролцох боломж олгодог үзэл баримтлал, ур чадвар, үнэт зүйлс хандлагыг төлөвшүүлэхийг эрмэлзэх ёстой.

Боловсролын үндэс суурь болох амин чухал хоёр үйл явц:

Хүн төрөлхтний нийтлэг өвийн нэг хэсэг болох мэдлэг эзэмших болон шинэ мэдлэг ба шинэ боломжит ирээдүйг хамтдаа бүтээх

Хоёрдугаарт, бидний хурдацтай өөрчлөгдөж буй уур амьсгал болон гараг дэлхийн нөхцөл нь дэлхий ертөнц дээр хүмүүсийн эзлэх байрыг эргэн харж, дахин баримжаалах сургалтын хөтөлбөрийг шаардаж байна. Гараг дээр гарч буй эргэлт буцалтгүй өөрчлөлтүүд хэдийнээ хурдассан бөгөөд боловсрол нь хүрээлэл орчин, нийгэм, эдийн засгийн сайн сайхан аж байдал хоорондын салшгүй харилцан уялдаа холбоог ухааруулан ойлгуулж, тэтгэдэг байх ёстой. Сургалтын хөтөлбөрүүд нь хүн төрөлхтөн нь хүмүүний бус ертөнцтэй салшгүй холбоотой гэж үзэх үүднээс цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах, буцаахад нь сурагчид болон олон нийтийг бэлтгэхэд чиглэсэн мэдлэгийн олон янзын хэлбэрт

үндэслэх ёстой. Сургалтын хөтөлбөрүүд нь тэдний нийгэмлэг, эх дэлхийд, ялангуяа орхигдон гадуурхагдсан хүмүүст, тухайлбал ядуучууд, цөөнх, эмэгтэйчүүд, охидод уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл ямар үр дагавартайг онцлон тодруулах ёстой. Сургалтын хөтөлбөрийн мэдлэг нь утга учиртай үйлүүдийн хүчирхэг тогтолцоог бүрдүүлж, хүүхэд, залуучуудын ирээдүйд гүн гүнзгий нөлөө үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгалийн хүрээлэл орчноо хамгаалах хүчин чармайлтаа үргэлжлүүлэн манлайлахад нь тэдэнд дэмжлэг үзүүлж чадна.

Гуравдугаарт, хувь хүмүүст үнэн зөв (true), алдаагүй зөв (accurate) мэдлэгт хүрэх замаа олох боломжийг олгодог дижитал, шинжлэх ухаан, бичвэр, экологи, математик зэрэг олон бичиг үсгийн мэдлэгээр дамжуулан худал мэдээлэл, залилан мэхлэлтийн хурдацтай тархалтыг эсэргүүцэх ёстой. Бичиг үсгийн ийм мэдлэгүүд нь харилцан хуваалцдаг, үнэнд суурилсан, ардчилсан оролцоог утга учиртай, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Үр өгөөжтэй бичиг үсгийн тайлагдалт нь хүмүүсийн зөвхөн баримт, мэдээлэл, өгөгдлийн тухай ойлголтыг хөгжүүлэхээс гадна үндэслэл бүхий дүгнэлтэд хүрэх, олж илрүүлсэн зүйлийнхээ тохирцыг үнэлэх, түүнийгээ алдаагүй зөв мэдээлж солилцоход шаардлагатай гэрчлэх нотолгоо, болгоомж сэрэмжтэй эх сурвалжийн хангалт зэрэг үйл явцуудын талаарх ойлголтыг нь сайжруулж байх ёстой. Сургалтын хөтөлбөрүүд нь сурагчдад ухаж ойлгох, нягт нямбай алдаагүй байх, нарийвчлалтай байх, үнэний төлөө тууштай тэмцдэг байх хүсэл эрмэлзэл төлөвшүүлэхийн тулд түүх, соёл, арга зүйн өргөн хүрээний арга хандлагуудад тулгуурлах хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, хүний эрх ба ардчилсан оролцоо нь хүмүүс болон дэлхийг хувирган өөрчилдөг сургалтын хөтөлбөр, суралцахуйн суурь зарчмуудыг бүрдүүлэх ёстой. Хүний эрх нь бүх хүмүүсийн хувьд ариун дагшин халдашгүй хэвээрээ байх ёстой бөгөөд бидний нийгмийн гэрээний үндэс болсон хамтдаа зорчих эхлэлийн цэг-гарц болохынхоо хувьд суралцахуйг бүрдүүлэн хэлбэржүүлдэг сургалтын хөтөлбөрийн үндэс суурь болох ёстой. Сургалтын хөтөлбөрүүд нь хүн бүрийн салшгүй заяагдмал эрх, эрхэм чанарыг чухалчилж, хүчирхийллийг даван туулах, энх амгалан нийгмийг цогцлоохын ач холбогдлыг зайлшгүй онцлох ёстой. Нийгмийн хөдөлгөөнүүд болон жирийн ард иргэдтэй харилцах харилцан үйлдэл нь жендэр, арьс өнгө, уугуул иргэдийн ижилслийн өвөрмөц онцлог, хэл, бэлгийн чиг баримжаа, нас, хөгжлийн бэрхшээл, иргэний харьяалаар ялгаварлан гадуурхдаг эрх мэдлийн бүтцийн эсрэг асуулт тавих, илчлэх, эсэргүүцэх жинхэнэ бодит арга замуудаар сургалтын хөтөлбөрийг баяжуулж өгдөг.

## Багш нар ба багшлах мэргэжил

Мэргэжлээрээ дамжуулан боловсролын нийгмийн шинэ гэрээг бий болгоход багш нар ер бусын онцгой үүрэг роль гүйцэтгэдэг. Сурагчдын мэдлэг, нөөц чадвараа өсгөж хөгжүүлэхэд туслахын тулд хоршин ажилладаг учраас багш нар өөр өөр оролцогчид болон орчныг холбож, нэгтгэн зохион байгуулдаг ажлын гол эзэд юм. Ямар ч технологи одоохондоо сайн багш болох хүний хүчин зүйлийн хэрэгцээг орлож, түүнээс зай барих нөөц чадамжгүй байна. 2050 он хүртэлх ирээдүйг харж, багшлахуйд хандахдаа үр өгөөжтэй суралцахуйг нарийн зохион байгуулах нь дан ганц хувь хүн хийдэг ганцаарчилсан практик гэж үзэхээс татгалзахад хүргэж байна. Үүний оронд багшлахуйг багаар ажиллаж, сурагчийн утга учиртай суралцах боломжийг олгодог хоршин ажиллагч мэргэжил болгох ёстой. Дараах зарчмуудыг нэн тэргүүнд тавих нь зүйтэй:

Нэгдүгээрт, хорших ажиллагаа, багийн ажил нь багшийн ажлыг тодорхойлох ёстой. Боловсролын төлөө зорьж буй бидний өргөн хүрээтэй шалтгаант зорилгууд нь тус тусдаа салангидаар ажиллах хамгийн авьяаслаг багш нарын үр чадвар, нөөц чадамжийн хязгаараас ч давж гарна. Бидэнд мэргэжил нэгт багш нартайгаа болон судлагдахуун бүрийн мэргэжилтэн, бичиг үсгийн мэргэжилтэн, номын санч, тусгай хэрэгцээт боловсролын сурган хүмүүжүүлэгч, зөвлөх туслагч, нийгмийн ажилтан болон бусад хүмүүстэй хоршин багаар ажиллах багш хэрэгтэй болно. Ирэх жилүүдэд хүн төрөлхтөн үйл явцуудын тасалдалтын олон төрлийн бэрхшээлтэй нүүр тулж, багш нар хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд өөрсдийн хувиран өөрчлөгдөж буй ертөнцөө залж удирдахад нь насных нь онцлогт тохирсон арга замуудаар үзүүлэх тусламжууд тэргүүн эгнээнд байх болно. Сурагчдын сайн сайхан аж байдал, эрүүл харилцаа, сэтгэцийн эрүүл мэнд нь боловсролын тохируулгат орчинд дэмжигддэг байх ёстойн нэг адилаар багш нар амьдралд нь хүрэлцэхүйц цалин хөлсний болон албан тушаалын карьераа ахиулах, боловсрол болон мэргэжлээ тасралтгүй хөгжүүлэх, хамтран суралцах орчныг бүрдүүлэх зэргээр тэд өөрсдийн чухал ажлаа урагш ахиулж чаддаг байх түвшинд тэдэнд туслах дэмжлэг нь өргөжсөн байх ёстой.

Ямар ч технологи одоохондоо сайн багш болох хүний хүчин зүйлийн хэрэгцээг орлож, түүнээс зайлсхийх нөөц чадамжгүй байна.

Хоёрдугаарт, мэдлэг, эргэцүүлэл, шинжилгээ судалгааны үйлдвэрлэл нь багшлахуйн салшгүй хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Боловсролын ирээдүйн талаарх шинжилгээ судалгаа, мэдлэг нь багш нарын гүйцэтгэж буй ажлаас эхэлдэг бөгөөд үнэндээ боловсролын нийгмийн шинэ гэрээний зарим бүрэлдэхүүн хэсгүүд нь олон багшийн хэрэгжүүлж буй хувирган өөрчлөх сурган хүмүүжүүлэх практикт аль хэдийн оршин байж болох юм. Мэдлэг бүтээгч, мэргэжлийн сурган хүмүүжүүлэх үйлийн анхдагч болохынх нь хувьд багш нарын хөдөлмөр хүлээн зөвшөөрөгдөж, дэмжигдэх учиртай бөгөөд холбогдох судалгаа ба туршлагыг бусад сурган хүмүүжүүлэгчид болон сургуультай албан болон албан бус хэлбэрийн арга замаар баримтжуулах, хуваалцах, хэлэлцэхэд нь туслах ёстой. Их сургуулиуд болон дээд боловсрол нь мэргэжил-дамнасан мэдлэгийн үйлдвэрлэл (profession-wide knowledge production)-ийг дэмжих үүднээс багш нартай тогтвортой шинжилгээ судалгаа хийх, мэргэжлийн харилцаа тогтоох боломжийг олгодог институцийн шинэ тохиргоог төсөөлж олох болно.



Гуравдугаарт, багшийн мэргэжлийн бие даасан байдлыг мөрдөн баримталж, хамгаалах ёстой. Багшлах мэргэжил нь өргөн хүрээний ахисан ур чадвар, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг шаарддаг. Ирэх хэдэн арван жилд ялангуяа, залуу хүн амын тооны огцом өсөлтийн улмаас сургуулийн боловсролын эрэлт хэрэгцээ нь мэргэшсэн багшийн нийлүүлэлтээс давсан хэвээр байгаа Сахараас урагших Африкт өндөр чанартай багш бэлтгэх боловсролыг бэхжүүлэх, өргөжүүлэхэд ихээхэн дэмжлэг хэрэгтэй болно. Шинэ залуу багш нарын мэргэжлийн хөгжлийг цаашид тасралтгүй боловсрол (ongoing education), зөвлөн туслах, хоршин хамтарч-багшлах арга замаар ханган ажиллах боломжтой. Хичээлдээ бэлтгэх, эргэцүүлэн бодоход хангалттай цаг гаргаж, шударга, үл алагчилсан цалин хөлс авах ёстой. Мэргэжлийн бие даасан байдал, нийгмийн хүндлэл, зохистой цалин хөлсөөр хангах нь урамшсан, ур чадвартай сурган хүмүүжүүлэгчид эзэмшсэн мэргэжилдээ хэвээр үлдээх болон ур чадвартай, сэдэл тэмүүлэлтэй хүмүүсийг татаж, энэ мэргэжил эзэмшихэд түлхэц болно.

Олон нийтийн дунд явагдах боловсролын мэтгэлцээн, яриа хэлэлцээ, боловсролын бодлогод оролцох оролцоог багш нарын үндсэн ажлын нэг хэсэг болгон интеграцчилж, хүлээн зөвшөөрөх ёстой. Сургууль эсвэл анги танхимд болж буй үйл явдлын талаарх шийдвэрүүдийг ихэвчлэн тэдгээрээс хол байгаа хүмүүс бага зэргийн яриа хэлэлцээ, харилцан үйлчлэл, утга учиртай эргэх холбооны учиг гогцоотойгоор гаргадаг. Боловсролын ирээдүйн төлөө ийм нөхцөл байдлыг өөрчлөх шаардлагатай өгөөд боловсролын ирээдүйн талаарх олон нийтийн мэтгэлцээн, бодлого, яриа хэлэлцээнд манлайлагч, амин чухал мэдээлэгч болохынхоо хувьд энэ өөрчлөлтийг багш нар талархан угтах ёстой. Эдгээр талбарт багш нар татагдан оролцох нь багш байхын утга учир, үндсэн чиг үүрэг болохыг хамтын ойлголцолд тодоор шигтгэн оруулах хэрэгтэй бөгөөд тэднийг боловсролын нийгмийн шинэ гэрээг бүтээж дархлах гол оролцогчид гэж үзэх ёстой.

## Сургуулийг хамгаалах ба хувирган өөрчлөх нь

Сургууль нь бүхий л нөөц потенциал, амлалт, гачигдал дутагдал, хязгаарлалтынхаа хамт нийгмийн хамгийн чухал боловсролын тохируулгат орчны нэг хэвээр үлдэнэ. Сургуулиуд бол боловсролын томоохон экосистемийн гол тулгуур багана бөгөөд тэдгээрийн амьдрах чадвар нь нийт хүнийг хамарсан нийгмийн үйл ажиллагаа болох боловсролын болон түүний хүүхэд залуучуудын төлөөх амлалт үүргийн илэрхийлэл юм. 2050 он гэхэд бид хам нөхцөлөөс үл хамааран сургуулиудыг нэг ижил загвараар зохион байгуулах боломжгүй болоод байна. Өнөөгийн архитектур, дүрэм журам, зохион байгуулалтын загваруудын оронд бид сургуулийн цаг хугацаа, газар орныг хамгаалах, хувирган өөрчлөх арга замаар түүнийг дахин дизайнчлахад массыг хамарсан нийтийн асар их хүчин чармайлт хэрэгтэй байна. Энэхүү чухал ажилд дараах тэргүүлэх чиглэлүүдийг удирдлага болгох нь зүйтэй:

Нэгдүгээрт, сургуулийг сурагчид өөр хаана ч байхгүй сорилтууд ба бололцоонуудтай тулгардаг орон зай гэж хамгаалах ёстой. Сургуулиудад хүмүүсийн олон янзын бүлгүүд бие биеэсээ болон бие биетэйгээ хамт суралцдаг хамтын ажиллагаа болон халамж хамгааллын орчин шаардлагатай болно. Эдгээр орчин нь багш, сурагчдад олон шинэ санаа, соёл, ертөнцийг үзэх

арга замтай харилцах боломжийг олгож, хүүхэд, залуучуудыг ирээдүйн амьдралын сорилтод бэлтгэх төдийгүй, тэдний одоо амьдарч байгаа хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцтэй зөвшилцөхөд нь туслах болно.

Хоёрдугаарт, сургуулийн архитектур, орон зай, цаг хугацаа, цагийн хуваарийг төлөвлөж, сурагчдын бүлгийг зохион байгуулахдаа хувь хүмүүсийн хамтдаа ажиллах чадавхыг бий болгох түвшинд дахин төсөөлж дизайнчлах хэрэгтэй. Шинээр бий болох орчин, инклюзив оролцооны дизайн нь сурган хүмүүжүүлэх өөрийн гэсэн ач холбогдолтой бөгөөд суралцахуйн хамтын орон зайд болж байгаа зүйлд ч нөлөөлдөг. Хоршин ажиллах соёл нь суралцахуй, эргэцүүлэл, инновацийн бат бөх сүлжээг бий болгож чадахаар түвшинд сургуулийн захиргааны болон мэргэжлийн удирдлага түүнчлэн сургуулиуд хоорондын харилцааг чиглүүлэх ёстой.

Гуравдугаарт, дижитал технологи нь сургуулиудад болж буй үйл явдлыг дэмжихэд чиглэсэн байх ёстой бөгөөд өнөөгийн болон урьдчилан мэдэж болох хувилбаруудын хувьд ч тэд албан ёсны, биет сургалтын байгууллагуудыг хангалттай орлоход хүрэлцэхгүй. Дижитал хэрэгслүүдийг хөшүүрэг болгон хэрэглэх нь ойрын хэдэн арван жилд сурагчийн бүтээлч байдал, харилцаа холбоог өргөжүүлэн сайжруулахад ашигтай, нэн чухал бөгөөд дижитал орон зайн шилжилтийг залж удирдсанаар тэдэнд нийтлэг мэдлэг болон хүмүүний туршлагад нэвтрэх ба оролцох шинэ боломжуудыг нээж өгч чадах болно. Сургуулиудад хиймэл оюун ухаан, дижитал алгоритмыг ашиглах хүчин чармайлт нь одоо байгаа хэвшмэл ойлголт, хасан гадуурхдаг тогтолцоог дахин бий болгож, гүнзгийрүүлэн даамжруулахгүйн тулд болгоомжтой, анхаарал хянамжтай байх ёстой.

Дөрөвдүгээрт, сургуулиуд хүний эрхийг хангах, тогтвортой байдлыг дэмжих, нүүрстөрөгчийн саармагжилтад үлгэр жишээ болохуйцаар бидний зорьж буй ирээдүйг загварчлах ёстой. Сурагчдад итгэж, боловсролын салбарыг ногоон болгоход туслах үүрэг даалгавар өгөх нь зүйтэй. Хүрээлэл орчны нөхцөл, өөрчлөлтүүдэд тохирсон хариу үйлдэл үзүүлдэг орон нутгийн болон уугуул иргэдийн дизайны зарчмууд нь илүү сайн ирээдүйг цогцлоох хийгээд бид нэг хэсэг нь болж, түүнээс хамааралтай байдаг байгаль ертөнц, түүний системүүдтэй илүү их симбиоз (symbiosis, бие махбодын нягт холбоонд амьдардаг хоёр өөр организмын ихэвчлэн хоёуланд нь ашигтай байдаг харилцан үйлчлэл) тогтоох боломж олгож, уур амьсгалын өөрчлөлтүүдэд дасан зохицох, сааруулах, урьдчилан сэргийлж сурах арга ухааны эх сурвалж болж чадна. Мөн сургуулиудтай холбоотой боловсрол болон бусад бодлого нь тухайн нутагт амьдардаг болон амьдардаггүй бусад хүмүүсийн хүний эрхийг дэмжин хамгаалж, ахиулан урагш ахиулдаг байх нь бидэнд зайлшгүй хэрэгтэй.

Сургуулиуд бол боловсролын томоохон экосистемийн гол тулгуур багана бөгөөд тэдгээрийн амьдрах чадвар нь нийт хүнийг хамарсан нийгмийн үйл ажиллагаа болох боловсролын болон түүний хүүхэд залуучуудын төлөөх амлалт үүргийн илэрхийлэл юм.

## Өөр өөр цаг хугацаа, орон зайн боловсрол

Бидний гол ажил үйлийн нэг бол боловсрол хаана, хэзээ явагддаг тухай өргөн хүрээгээр бодож, түүнийг илүү өөр өөр цаг хугацаа, орон зай, амьдралын үе шатууд болгон өргөжүүлж ойлгох явдал юм. Бид төрөхөөсөө эхлээд өтлөх хүртлээ амьдрал ба нийгэмд байдаг боловсролын нөөц потенциалыг бүрэн дүүрэн ойлгож, боловсролыг урагш ахиулахад зориулагдсан ихэвчлэн соёл, нийгэм, технологийн бололцоонууд нь огтлолцон давхцаж байдаг хотууд болох олон тооны газрыг хооронд нь холбох хэрэгтэй. Ирээдүйн нийгэм маань албан ёсны сургуулиас гадна олон тооны газарт төлөвлөсөн хугацаанд болон аяндаа суралцах боломжийг олгож, урамшуулан

Ирээдүйн нийгэм маань албан ёсны сургуулиас гадна олон тооны газарт төлөвлөсөн хугацаанд болон аяндаа суралцах боломжийг олгож, урамшуулан дэмжиж байна гэж бид төсөөлж чадна

дэмжиж байна гэж бид төсөөлж чадна. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад энэхүү зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэхэд шаардлагатай яриа хэлэлцээ, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх дөрвөн зарчим бий.

Нэгдүгээрт, амьдралын бүхий л үе шатанд хүмүүс утга учир бүхий чанартай боловсрол эзэмших боломжуудтай байх ёстой. Боловсрол бол насан туршийн (lifelong) бөгөөд амьдралын олон талт (life-wide) байдаг. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын “ур чадваржих”, “дахин ур чадваржих” гэсэн учир дутагдалтай үзэл баримтлалаас хальж, амьдралын бүхий л үе шатанд боловсролын өөрчлөн хувиргах бололцоонуудыг хамрахын тулд түүнийг

цаашид хөгжүүлж, дэмжих ёстой. Амьдралын туршид дахь боловсролын аливаа төлөвлөлт нь хамгийн ихээр орхигдож гадуурхагдсан, хамгийн хэврэг эмзэг бүлгийн тохируулгат орчны үйлчилгээнд чиглэж, суралцагчдыг олгогдсон боломжуудыг хэрэгжүүлэх, одоогийн болон ирээдүйд тохиолдох үйл явцын тасалдалтын үед үүсэх саад бэрхшээлийг даван туулахад шаардлагатай мэдлэг, үзэл баримтлал, хандлага, ур чадвараар зэвсэглэхэд туслах ёстой.

Хоёрдугаарт, боловсролын эрүүл экосистем нь суралцахуйн байгалийн, бүтээгдсэн, виртуал сайтуудыг холбодог. Биосфер буюу түүний газар нутаг, ус, амьдрал, эрдэс баялаг, агаар мандал, тэдгээрийн системүүд ба харилцан үйлчлэлийг суралцахуйн чухал орон зай гэж ойлгох хэрэгтэй. Энэ орон зай нь бидний анхны багш нарын нэг байсан. Үүний зэрэгцээ суралцахуйн дижитал орон зайг цаашид боловсролын экосистемд интеграцчилах нь зүйтэй бөгөөд боловсролын олон нийтэд нээлттэй, инклюзив оролцоотой, нийтлэг сайн сайхан байдлын төлөөх шалтгаант зорилгыг дэмжих ёстой. Хүчтэй хамгаалалт бүхий багш, сурагчийн өгөгдлийн нээлттэй хандалтын болон нээлттэй эх сурвалжийн платформыг нэн тэргүүнд тавих учиртай.

Гуравдугаарт, боловсролын эрх зүйн зохицуулалтын төлөөх төрийн санхүүжилт, засаглалын чадавх бэхэжсэн байх ёстой. Бид хариуцлагатай, үл алагчилсан, хүний эрхийг дээдэлсэн боловсролын үйлчилгээний хангамжийн стандартууд болон хэм хэмжээг тогтоож, мөрдүүлэхийн тулд улс орнуудад чадавхыг бий болгох чухал юм. Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон дэлхий нийтийн түвшинд засгийн газар, олон нийтийн байгууллагууд бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлж төлөвлөхөд дэмжлэг үзүүлэхийн тулд эдгээр зарчмын дагуу яриа хэлэлцээ хийж, үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээсэн байх ёстой.

Дөрөвдүгээрт, сурч боловсрох эрх өргөжсөн байх ёстой бөгөөд бид цаашид үүнийг зөвхөн албан ёсны сургуулийн боловсролын хүрээнд хэрэгжүүлэх нь сайн гэж үзэхээ больж байна. Бид ирээдүй рүү харж, мэдээлэл авах, холбоо тогтоох, соёлтой харьцах эрхээр нөхцөлдсөн насан турш (life-long)-ийн болон амьдралын өргөн хүрээ (life-wide)-нд суралцахуйн эрхийг дэмжих ёстой.

## Үйлд уриалсан дуудлагууд

Илтгэлд боловсролын нийгмийн шинэ гэрээний төлөөх хүчин чармайлтыг хурдасгаж, зохицлыг хангахын тулд хоёр зүйлд уриалан дуудсан. Эдгээр нь боловсролын шинжилгээ судалгааны шинэ мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх мөн нийтийн болон нийтлэг сайн сайхан байдал болох боловсролыг дэмждэг эв нэгдлийн болон хамтын ажиллагааг шинэчлэх гэсэн хоёр дуудлага юм. Хурдацтай өөрчлөгдөж буй бодит орчин нөхцөлд хариу үйлдэл үзүүлэхийн зэрэгцээ боловсролын шинэ ирээдүйг цогцлоох хүчин чармайлтуудыг чиглүүлэх, дахин бэхжүүлэхэд туслах үүднээс энэхүү хоёр дуудлагад хариу өгч, удирдлага болгох зарчмуудыг энд нэгтгэн харуулав.

## Боловсролын шинжилгээ судалгааны шинэ мөрийн хөтөлбөр

Энэхүү илтгэлд тодруулж онцолсон тэргүүлэх чиглэлүүд нь дотоод нарийн уялдаа холбоотой бөгөөд шинжилгээ судалгааны нийтлэг мөрийн хөтөлбөрийг дэмждэг. Ийм алсыг зорьсон шинжилгээ судалгааны мөрийн хөтөлбөрөөс олж авсан суралцахуй, мөн чанарт нэвтрэх чадвар, хуримтлуулсан туршлага нь боловсролын нийгмийн шинэ гэрээг хамтдаа бүтээж дархлахад түлхэц болно. Бид 2050 он хүртэлх ирээдүйг харж байхад боловсролын ирээдүйн шинжилгээ судалгаа, инновацыг удирдан чиглүүлэх дөрвөн тэргүүлэх чиглэл байна.

Нэгдүгээрт, боловсролын ирээдүйн талаарх дэлхийг бүхэлд нь хамарсан хамтын шинжилгээ судалгааны хөтөлбөр нь хүн бүрийн амьдралынхаа туршид сурч боловсрох эрхийг хангахад төвлөрөхийн зэрэгцээ ирээдүйд тохиох үйл явцын тасалдалтуудыг урьдчилан харж, тэдгээрийн үр дагаврыг тооцож үзэх ёстой. Энэхүү илтгэлд удирдамж болгон зөвлөмжилсөн зарчмуудын дагуу боловсролын дахин шинэчлэлийг мөшгөн судлахын тулд шинжилгээ судалгаа нь зөвхөн ердийн хэмжилт ба шүүмжлэлээс илүү давж гарах ёстой. Энэхүү шинжилгээ судалгааны хөтөлбөр нь биднийг боловсролын нийгмийн шинэ гэрээ рүү шилжихэд түлхэц үзүүлэхийг тулд ирээдүйн бичиг үсэг, ирээдүйн сэтгэлгээний үүднээс өөрийн тэргүүлэх чиглэлээ дахин дэнслэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, боловсролын ирээдүйн талаарх мэдлэг, өгөгдөл, нотолгоо нь мэдэхүйн олон янзын эх сурвалжууд ба арга замуудын инклюзив оролцоог хангасан байх ёстой. Өөр өөр өнцгөөс гаргасан гүн гүнзгий ойлголт нь бие биеэ үгүйсгэж, орлохыг хичээхийн оронд боловсролын талаарх хамтын ойлголцолд өөр өөр ашигтай давуу талуудаа санал болгох нь чухал юм. Судлаачид, их сургуулиуд, судалгааны байгууллагууд колоничлолоос ангижирсан, ардчилсан,

Боловсролын ирээдүйн талаарх дэлхийг бүхэлд нь хамарсан хамтын судалгааны хөтөлбөр нь хүн бүрийн амьдралынхаа туршид сурч боловсрох эрхийг хангахад төвлөрөх ёстой.

хүний эрхийг хэрэгжүүлэх, дэмжихэд чиглэсэн арга зүйн таамаглал, арга хандлагыг судлах ёстой. Сургуулиуд, багш нар, нийгмийн хөдөлгөөнүүд, залуучуудын хөдөлгөөнүүд, олон нийт бол мэдлэг, мэдээллийн амин чухал эх сурвалж бөгөөд тэднийг судлаачид хэмээн хүлээн зөвшөөрөх ёстой. Суралцахуйн шинжлэх ухаан, мэдрэл судлалын шинжлэх ухаан, дижитал болон их өгөгдөл, статистик индикаторуудын үзүүлэлтүүдээс олж илрүүлсэн зүйлс-үр дүнг чанарын болон практик судалгаа зэрэг өргөн хүрээний эмпирик орцуудтай холбон авч үзэх үед л гүн гүнзгий ойлголтуудын үр жимсийг хурааж чадна.

Гуравдугаарт, боловсролын инновац нь олон янзын хам нөхцөл, цаг хугацаа, газар нутаг дахь илүү өргөн хүрээтэй бололцоонуудыг тусгах ёстой. Харьцуулалтууд ба туршлагауд нь тухайн хам нөхцөлийн нийгэм ба түүхэн бодит байдлын ялгаанд нийцүүлэн дахин авч үзэж, дахин хам нөхцөлдүүлэх нь хүмүүст урам зориг өгдөг. Боловсролын инновац нь цаг хугацаа улирахын хэрээр одоогийн албан ёсны тогтолцоонд нөлөөлж буй байгууллагажихад тэмүүлэх (institutional convergence) үзэгдлээс салах арга замыг эрэлхийлэх ёстой. Үнэлгээ дүгнэлт ба эргэцүүлэл нь боловсролын бодлогыг тасралтгүй, нэгдмэл байдлаар удирдан чиглүүлэх ёстой бөгөөд ингэснээр нэг талаас, зогсонги байдал нөгөө талаас, дэглэмийн төгсгөлгүй өөрчлөлтийн мөчлөгөөс ангижруулдаг өөрчлөлтийн онолын дагуу боловсролын бодлогыг байнга боловсронгуй болгон сайжруулж чадна.

Дөрөвдүгээрт, боловсролын нийгмийн шинэ гэрээний шинжилгээ судалгаанд хувь нийлүүлэгч олон янзын бүлгүүдийг төлөөлөх олон хүнийг, тэр дундаа боловсролын талаарх хэлэлцүүлэгт идэвхтэй оролцдоггүй хүмүүсийг оролцуулах үүднээс энэ судалгааг дахин авч үзэх шаардлагатай. Нийгмийн шинэ гэрээний үр үндэс нь ялангуяа, багш нар, сурагчид, сургуулиудын дунд аль хэдийн амьд байна. Энэхүү гэрээг хамтран бүтээхэд хурдасгуур болох шинжилгээ судалгааны мөрийн хөтөлбөрт оролцож, дэмжлэг үзүүлэх тусгай үүрэг хариуцлага нь судалгааны байгууллагууд, засгийн газар, олон улсын байгууллагуудад оногддог. ЮНЕСКО нь бидний боловсролын ирээдүйн талаар мэдээлэл солилцож, мэдлэг, алсын хараа, үзэл санаагаа бий болгодог мэдээллийн төв (clearing house) болохынхоо хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг.

## Олон улсын эв нэгдэл ба хамтын ажиллагааг шинэчлэх нь

Энэхүү илтгэлд дэвшүүлсэн бүтэцчилэгдэн цэгцлэгдсэн амбицтай алсын хараа нь анги танхим, сургуулийн шуурхай тохируулгуудаас эхлээд үндэсний, бүс нутгийн, дэлхий нийтийн хэмжээний амлалт үүргүүд, бодлогын үйлийн хүрээнүүд хүртэл бүх түвшинд эвлэлдэн нэгдэж, хоршин ажиллахгүйгээр биелэх боломжгүй юм. Энэхүү илтгэлд орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд төрийн болон төрийн бус байгууллагын тоглогчдын дундах илүү шударга, илүү үл алагчилсан хамтын ажиллагаанд тулгуурлан боловсролыг нийтийн болон нийтлэг сайн сайхан

байдал болгон дэмжихийн төлөө дэлхий нийтээрээ хоршин ажиллах амлалт үүргээ хэрэгжүүлэх арга ухаанаа дахин шинэчлэхийг уриалж байна. 2050 он хүртэл бид боловсролын ирээдүйн төлөө олон улсын эв нэгдэл, хамтын ажиллагаатай холбоотой дараах дөрвөн зарчмыг удирдлага болгон баримтлах ёстой.

Нэгдүгээрт, тус Комисс нь боловсролын бүх хувь нийлүүлэгчдийг боловсролын сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын шалтгаант зорилгууд, нийтлэг шийдлүүдийг бий болгохын тулд дэлхий нийтийн болон бүс нутгийн түвшинд хамтарч ажиллахыг уриалж байна. Бүх хүн төрөлхтний амьдралын туршдаа боловсрол эзэмших эрх, боловсролын үнэ цэнийг нийтийн болон нийтлэг сайн сайхан байдлын үүднээс авч үзсэн шударга, үл алагчлагддаг боловсролын ирээдүйн алсын харааг тойрон хүчин чармайлтаа уялдуулан зохицуулж, үйлийн баримжаагаа өөрчлөх ёстой. Хамтын үйл нь дэлхий нийтийг хамарсан үйл явцын тасалдалтууд болон өөрчлөлтүүдийн улмаас сурч боловсрох эрх нь хамгийн ихээр зөрчигдөж буй суралцагчдад нэн тэргүүнд онцгой анхаарал тавих ёстой. Ирэх арван жилүүдийн хугацаанд дэлхий нийтийн түвшин дэх хорших ажиллагаа нь олон янзын төрийн-бус тоглогчид ба түншлэлийг хамран оролцуулах замаар эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг шийдвэрлэх ёстой. Энэ нь цаашид дээрээс-доошоо чиглэсэн арга хандлагаас олон-төвтэй үйлийн арга хандлага руу шилжиж, бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүд, ялангуяа Өмнөд-Өмнөд болон гурван талт хамтын ажиллагааг урам зоригтой хүлээн авах ёстой.

Хоёрдугаарт, олон улсын хамтын ажиллагаа нь тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн хүчин чармайлтыг дэмжиж, чадавхыг бэхжүүлэхдээ субсидиар зарчмаар ажиллах ёстой. Боловсролын шинэ амлалт үүрэг, хэм хэмжээ, стандартын хэрэгжилтийг бататгахын тулд шат бүр дэх эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай. ЮНЕСКО нь нэгдүгээрт, өөрийгөө бүс нутгийн болон үндэсний институцууд, үйл явцуудыг бэхжүүлэхэд оролцогч түнш хоёрдугаарт, нотлох баримтуудыг зуучлагч-блочер, мэдлэг үйлдвэрлэгч, ба боловсролын системүүд болон иргэдийн өмнө хүлээх эгэх хариуцлагын талаарх баримт өгөгдлүүдийг бэхжүүлэхийг дэмжигч хэмээн тус тус үзэж, боловсролын хөгжилд хандах арга хандлагаа эргэн харах шаардлагатай болно.

Гуравдугаарт, бага ба дундаас доогуур орлоготой орнууд ялангуяа, эдийн засаг нь эрс хязгаарлагдмал, залуу хүн амтай орнуудын хувьд олон улсын хөгжлийн санхүүжилтэд анхаарал хандуулах нь урьдын адил чухал хэвээрээ байх болно. Олон улсын хамтын ажиллагааны санхүүгийн болон хүний нөөцийн дийлэнх хэсгийг сурч боловсрох эрхэд нь хамгийн ихээр заналхийлэл учирч буй бүс нутагт ялангуяа, 2050 он гэхэд дэлхийн залуучуудын дийлэнх нь амьдарч, суралцах Сахараас урагших Африкт нэн даруй төвлөрүүлэх ёстой. Эдгээр нөөцийг мөн цаг уурын өөрчлөлт хурдасч байгаагийн хэрээр давтамж нь нэмэгдэх магадлалтай байгаа онцгой байдалд тохирох яаралтай тусламжид чиглүүлнэ.

Дөрөвдүгээрт, баримт нотолгоо, өгөгдөл, мэдлэгт нийтлэг хөрөнгө оруулалт хийх нь бас олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааны чухал хэсэг юм. Ирэх арван жилүүдийн хугацаанд бид

Хамт олны үйл нь дэлхий нийтийг хамарсан үйл явцын тасалдалтууд болон өөрчлөлт улмаас сурч боловсрох эрх нь хамгийн ихээр зөрчигдөж буй суралцагчдад нэн тэргүүнд онцгой анхаарал тавих ёстой.

боловсролын тэгш бус байдал ба ядуурлыг арилгаж, төрийн үйлчилгээг сайжруулах, түүнчлэн автоматжуулалт, дижиталчлал, шилжилт хөдөлгөөн, хүрээлэл орчны тогтвортой байдалтай холбогдсон урт хугацааны сорилтуудыг даван туулах гэсэн хоёр үндсэн чиглэлээр нийгмүүд, хил хязгааруудыг дамнасан харилцан суралцах, мэдлэг солилцох ажлыг бэхжүүлэх шаардлагатай болно. ЮНЕСКО нь улс орнууд болон бүс нутгууд хоорондын энэхүү солилцоог дэмжихэд чухал үүрэг роль гүйцэтгэнэ.

## Яриа хэлэлцээ ба үйлийн зарчмууд

Бидэнд итгэж найдах маш том шалтгаан бий. Боловсролын системийн дизайн, сургууль болон бусад боловсролын тогтолцооны зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга хандлагуудад томоохон цар хүрээтэй өөрчлөлт, инновац хийх боломжтой байна. Хэдийнээ бий болсон хийгээд зайлшгүй шинээр бүтээх зүйлдээ тулгуурлан шударга, үл алагчлагддаг, тогтвортой ирээдүйг цогцлооход тэмүүлэх замаар хамтдаа бид боловсролыг хувирган өөрчилж чадна. Бид сая сая хувь хүний болон хамтын эр зориг, манлайлал, эсэргүүцэл, бүтээлч байдал,

Бид эр зориг, манлайлал, эсэргүүцэл, бүтээлч байдал, хамгаалал халамжийн сая сая хувь хүний болон хамтын үйл, үйлдлээр дамжуулан чиглэлээ өөрчлөх болно.

халамжийн үйл, үйлдлээр дамжуулан чиглэлээ өөрчлөх болно. Бидэнд тулж босох гүн гүнзгий, асар баялаг, олон янзын соёлын өв уламжлал бий. Хүн төрөлхтөн агуу их хамтын хүч, оюун ухаан, бүтээлч чадвартай байдаг. Амлаж буй туршлагауд нь инновацлаг эсвэл өв уламжлалаас үүдэлтэй байж болно, учир нь хоёулаа шинэ бололцоонуудыг нээж өгдөг.

Энэхүү илтгэлд санал болгож буй яриа хэлэлцээ нь аль болох өргөн оролцоотой байх ёстой. Боловсрол бол орон нутгийн, үндэсний, дэлхий нийтийн түвшин дэх иргэнших

үйл явцад шийдвэрлэх хүчин зүйл болдог. Энэ нь хүн бүрд хамаатай бөгөөд хүн бүр өөртөө байгаа нөлөөллийнхөө хүрээнд боловсролын ирээдүйг бүтээхэд оролцох боломжтой. Энэхүү илтгэлд алсыг харсан яриа хэлэлцээ, үйл ажиллагааг цаашид өргөжүүлэхийн тулд багш нар, их сургуулиуд, засгийн газрууд, олон улсын байгууллагууд, залуучуудын оролцоо ба хүлээх тодорхой үүрэг ролийг тэдэнд хандан дэвшүүлсэн:

- **Багш нар.** Багш нар боловсролын ирээдүйн гол цөм хэвээр байна. Тэд XIX зуунаас хойш мөрдөгдөж буй нийгмийн гэрээний үндэс суурь болсонтой нэгэн адил боловсролын нийгмийн шинэ гэрээг бүтээн байгуулахад шийдвэрлэх үүрэгтэй нүүр тулах уулзалтуудын гол холбогчид, практик үйлийн гүйцэтгэгчид, судлаачид байх болно. Үүний тулд тэдний бие даасан байдал, эрх чөлөөг баталгаажуулж, мэргэжлийн амьдралынх нь туршид тэдний хөгжлийг нь дэмжиж, нийгэмд гүйцэтгэх үүрэг, төрийн бодлогод оролцох оролцоог нь хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Багш нар угаасаа яриа хэлэлцээ, инновацын үйл явцыг бий болгох, бусад хүмүүс, бүлгүүдийг хамтад нь нэгтгэх, цуглуулах гол тэмцэгчид байх нь дамжиггүй. Их дээд сургууль, дээд боловсролын байгууллагуудад чиглэсэн тусгай уриалга нь боловсролын шинэ нийгмийн гэрээний бүх бодит байдалд байгаа тул энэхүү тайлангийн бүлэг бүрт тусгагдсан болно.



- **Их сургуулиуд ба дээд боловсрол.** Их сургуулиуд, дээд боловсролын байгууллагуудад хандсан тусгай уриалгууд нь боловсролын нийгмийн шинэ гэрээний бүх бодит байдалд хамаатай тул энэхүү илтгэлийн бүлэг бүрд тусгагдсан болно. Өнөөдөр их сургуулиуд, дээд боловсролын бүх байгууллага мэдлэгийг бүтээх, түгээн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэгт эргэлздэг хүн цөөхөн. Энэ нь бүх шинжлэх ухаанд тохиолддог боловч ялангуяа, боловсролын хувьд бодит үнэн юм. Суурь боловсролын ирээдүйн ихэнх нь их сургуулиудын хийж буй ажлаас шалтгаалах бөгөөд эргээд суурь боловсролын чиглэлээр хийж байгаа ажлаас их сургуулиудын ирээдүйн ихэнх хэсэг нь хамаарна. Мөн их сургуулиуд хүүхэд залуучууд, ялангуяа бага насны хүүхдүүдийг сургах, насанд хүрэгчдийн боловсролын үйл ажиллагаанд илүү их оролцох шинэлэг, илүү үр нөлөөтэй арга замыг хайж олно гэсэн хүлээлттэй байна. Тодорхойлолт ёсоор бол дээд боловсрол нь үе үеийнхэн хоорондын хувирган өөрчлөх яриа хэлэлцээний гол цэг байдаг бөгөөд энэхүү илтгэлд дурдсан ирээдүйн ихэнх хэсэг нь тэдгээрээс хамаарна. Хүчирхэг, бие даасан, итгэл хүлээсэн, шинэлэг дээд боловсролгүйгээр энэхүү илтгэлд тусгасан боловсролын нийгмийн гэрээг бүтээн байгуулах боломжгүй юм.
- **Засгийн газрууд.** Энэхүү илтгэлд засгийн газрын орлуулшгүй үүргийг онцлон тэмдэглэв. Гэвч энэ нь түүний саналууд зөвхөн үндэсний боловсролын тогтолцооны түвшинд байна гэсэн үг биш юм. Энэхүү илтгэл нь боловсролын өөрчлөн байгуулалтын талаарх засгийн газарт төвлөрсөн тайлангийн логикийг дагахын оронд өргөн хүрээний хувь нийлүүлэгчдийг шинжилгээ судалгаа, мэдлэг, инновац, анализ, үйл хэрэгт оролцохыг урамшуулан дэмжихэд чиглэсэн юм. Энэ нь өөрчлөн байгуулалтын логик өнцгөөс бус харин илүү өргөн хүрээний оролцоог дэмжигч, инновацыг идэвхжүүлэгч болох өнцгөөс засгийн газрын үйл ажиллагааг олон түвшинд үнэлж цэгнэх асуудал юм. Цаашилбал, засгийн газрууд нь боловсролыг төрийн зохистой, тогтвортой санхүүжилтээр хангах, түүнийг зөв удирдан зохицуулах чадавхыг бэхжүүлэх замаар боловсролын олон нийтийн байх шинж чанарыг хадгалах, бэхжүүлэхэд онцгой үүрэг рольтой.
- **Олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд.** Энэхүү илтгэлд олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудын ялангуяа, боловсролыг нийтийн болон нийтлэг сайн сайхан байдал гэж олон удаа батлахын ач холбогдлыг онцолсон. Энэхүү давталт нь орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, олон улсын хэмжээнд болон салбар хоорондын боловсролын хамтын ажиллагаанд шинэ дуу хоолойг хүргэх орон зайг өгч, хэтийн төлөвийн чухал өөрчлөлт рүү шилжихийн дохио болгоход зориулагдсан юм. Олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудыг хүчтэй дайчлах нь энэхүү илтгэлд дэвшүүлсэн яриа хэлэлцээг урагшлуулж, тэдний өвөрмөц онцгой мэдлэг, туршлага, дайчлах чадавхаар дамжуулан үүнийг хийнэ гэсэн хүлээлттэй байна. Үзэл баримтлал, жендэр, арьсны өнгө, үндэс угсаа, соёл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн баримжаагаар ялгаварлан гадуурхагдаж буй хүмүүсийг сонсох, халамжлах, хоргодох газраар хангах, тэдний сурч боловсрох эрхийг нь дэмжихэд эдгээр байгууллагууд онцгой байр суурь эзэлдэг.
- **Залуучууд, хүүхдүүд.** Эцэст нь хэлэхэд, энд санал болгож буй яриа хэлэлцээнд залуучууд оролцох ёстой нь маргашгүй. Ирээдүйг тэдний хувьд хүнд дарамт ачаа гэхээсээ илүү боллоцоогоор дүүрэн ирээдүй гэж тодотгох ёстой. Энэ нь зөвхөн тэдний үгийг сонсох, тэдэнтэй зөвлөлдөх асуудал биш, харин хэдийнээ тэднийх болж буй ирээдүйг бүтээн байгуулахад тэднийг дайчлах, дэмжих явдал юм. Ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн



эсрэг, түүнчлэн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, эцгийн эрхт ёс, жендэрийн хязгаарлагдмал хэм хэмжээний эсрэг, соёлын олон янз байдал, уугуул иргэдийн бие даан өөрийгөө тодорхойлох эрхийн төлөөх залуучууд, хүүхдийн хөдөлгөөнүүдийн сүүлийн үеийн жишээнүүд бидэнд ирээдүйн чухал замуудыг харуулж байна. Эдгээр хөдөлгөөнийг удирдаж буй залуучууд зөвшөөрөл хүсээгүй бөгөөд харин тэд насанд хүрэгчдийн зүгээс хэт их дарамталдаг, тэднийг саажилттай болгодог асуудлуудад шуурхай, ёс суртахууны тодорхой байдлаар хариулж байна. Тэд бидний болон тэдний ирээдүйг цогцлоох үр үндэс болж, энэ үйлийг хөтлөн чиглүүлэх үүрэгтэй. Энэхүү илтгэлийг үргэлжлүүлэх хамгийн чухал чиглэл бол боловсролын нийгмийн шинэ гэрээ бүтээн байгуулах ажилд залуучуудыг элсүүлэх бидний чадамж юм.

Дэлхий даяар багш нар, олон нийт, байгууллага, засгийн газрууд шаардлагатай өөрчлөлтийг хийхийн тулд боловсролын ихээхэн ирээдүйтэй олон санаачилгыг аль хэдийн эхлүүлсэн. Мэдлэгийг хамтран бүтээж, бусадтай хуваалцахаар олон нийтэд түгээх олон арга зам байдгийг бидэнд тоо томшгүй олон жишээ харуулж байна. Бусад жишээнүүд ч боловсрол нь хэрхэн утга учир, эрх мэдэл, чөлөөлөлтийг бий болгож, суралцахуйг нийтлэг сайн сайхны төлөө илүү үр өгөөжтэй зохион байгуулж болох арга замуудыг тодруулж өгдөг. Итгэл найдвараар дүүрэн ирээдүйг цогцлоох чиглэлийг зурж төлөвлөхдөө одоо байгаа эдгээр туршлагыг хөгжүүлэх хэрэгтэй.

Дэлхий дахинд өрнөж буй сайн үйлсийг илүү сайн таниулах шаардлагатай байгаа тул Комиссоос ЮНЕСКО-г ирээдүйтэй практик туршлагууд болон энэхүү илтгэлд тусгагдсан зарчмуудын инновацлаг хэрэгжилтүүдийн хурдасгуур, мэдээллийн төв болохыг зөвлөж байна.

## Үргэлжлүүлэх урилга

Мөн чанартаа, энэхүү илтгэл нь хүсэн хүлээж буй ирээдүй ба боловсрол тэдгээрийг бий болгоход хэрхэн тусалж болох талаар нийгмийн өргөн хүрээний яриа хэлэлцээг дэмжиж, өдөөхөд чиглүүлж, уриалан дуудаж байна. Түүний үзэл санаанууд нь хоёр жилийн яриа хэлэлцээ, зөвлөлдөх үйл явцын үр дүнд бүтээгдэж, цаг хугацааны тухайн үеийн агшныг тусгасан юм. Илтгэлд дэвшүүлсэн саналууд нь ирээдүйд олон тооны харилцан яриа, хорших ажиллагаа, түншлэлийг үргэлжлүүлэх урилгаар төгсөж байна. Боловсролын ирээдүйд энэхүү илтгэл өөрөө биш харин цаашдын харилцан яриа, хорших ажиллагаа, түншлэл нь хамгийн чухал зүйл болох учиртай.

Энэхүү илтгэлд ирээдүйд боловсрол эзэмшүүлэх хүчин чармайлтад эрч хүч, урам зориг өгч, сорилт бэрхшээл ба итгэл найдварыг тодорхойлсон алсын харааг томьёолж, үүнийг хэрхэн хийх талаар санаа оноо дэвшүүлсэн ч боловсролын нийгмийн шинэ гэрээ нь аяндаа өөрийн-гүйцэтгэлээр (self-executing) хэрэгжих боломжгүй гэдгийг онцолж байна. Энэ нь хэлбэржиж, нөлөө үзүүлэхийн тулд түүнийг сурагчид, багш нарын өдөр тутмын үйл ажиллагаа, туршлагыг хувирган өөрчилдөг хөтөлбөрүүд, нөөцүүд, системүүд, үйл явцууд болгон хөрвүүлэх ёстой.

Боловсрол нь олон тооны хувь хүн, бүлгүүдийг харилцааны нарийн нийлмэл сүлжээнд татан оролцуулдаг. Түүнд сурагчид, багш нар, гэр бүлүүд, боловсролын захиргааны удирдлагууд, засгийн газрын олон түвшний удирдагчид хамрагдаж, энэ сүлжээ нь олон нийт, муж, улс орон, бүс нутаг, дэлхий нийтийн хэмжээнд төр болон иргэний нийгэмд нөлөөлдөг. Боловсролын соёлын хувирган өөрчлөлт нь олон бүлгүүд харилцан ярилцах явцдаа шинэ санаа олж, өөрсдийн ашиг сонирхол, ойлголт төсөөллөө эргэн харж шалгах замаар урагш ахих боломжтой болдог хамтран бүтээх үйл явцын үр дүн юм. Энд дэвшүүлсэн бүх зарчим, санал, стратегийг шинэ бодит байдал болгон хөрвүүлэхэд хамтын ажиллагаа нэн чухал юм. Чухамхүү бид юуны төлөө хэрхэн багшилж, суралцаж байгаа талаарх санаа бодлоо хамтарч нэгтгэх нь эцсийн дүндээ боловсролын практикийг хувирган өөрчилж чадах бүх нөөц болон үйл ажиллагаанд тодорхой байдлаар тууштай хандаж, дэмжлэг үзүүлэхэд хүргэдэг. Энэхүү өөрчлөлтийг дэмждэг тэрхүү нөхцөлийг сайтар ойлгож, хүлээн зөвшөөрч, бүрдүүлснээр практик ажил өөрчлөгддөг.

Бидний хүн нэг бүр өөрийн амьдарч буй нийгэмлэгээ сайжруулж чадна. Яриа хэлэлцээг зохион байгуулах бололцоо бид бүгдэд бий. Энэ нь ялангуяа, жирийн хүмүүст амбицтай шалтгаант зорилгодоо хүрэхийн тулд бусадтай холбогдох, зохион байгуулалтад орох бололцоог олгодог харилцаа холбооны технологи хаа сайгүй тархаж байгаа эрин үед бол үнэн бодит зүйл юм. Технологи болон интернэтийн хүртээмж нь багш нар, боловсролын байгууллагууд, олон нийтийн хооронд урьд өмнө хэзээ ч байгаагүй хорших ажиллагааг бий болгож, байгаа боломжуудаа бодит зүйл болгох, сорилтуудын шийдлийг хайж олох боломжтой болгож байна.

КОВИД-19 цар тахал нь энэхүү илтгэлийг гаргах болон түүний бэлтгэл ажлын ихэнх хэсэгт сүүдэр тусгалаа. Энэхүү дэлхий нийтийг хамарсан үйл явдал нь өргөн хүрээний хорших ажиллагаа, хамтын бүтээн байгуулалтын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхөд хүргэж сэрээсэн. КОВИД-19-ээс үүдэлтэй боловсролын хохирол, алдагдлыг бүрэн хэмжээгээр тооцож амжаагүй байгаа ч энэ нь ноцтой бөгөөд олон арван жилийн ахиц дэвшлийг үгүй хийх эрсдэлтэй гэдгийг бид мэднэ. Түүний үр дагаврыг дэлхийн Өмнөд хэсэгт болон бусад сорилтуудтай хамт байгаа ядуу, орхигдож гадуурхагдсан хүмүүс хамгийн ихээр мэдэрсэн. Түүний үхэл, алдагдлын ул мөр нь уур амьсгалын өөрчлөлтийн хурдацтайгаар улам эрчимжиж буй үеийн бодит байдалтай хосолсон нь бид энэ гараг дээр бусадтайгаа холбоотой амьдарч байгааг бидэнд хамгийн итгэл үнэмшилтэйгээр сануулж байна. КОВИД-19-ээс хамгаалах вакциныг зохион бүтээсэн нь бид мэдлэг, шинжлэх ухаан, суралцахуйн хүрээнд нэгдэж, шийдэл олохын тулд юу хийж болох цар хүрээ, хурдыг урьдчилан тодорхойлсон. Тус илтгэл нь энэхүү шинээр олж авсан хүлээн зөвшөөрөл нь хамтдаа нэгдэж, боловсролын шинэ, гэрэлт ирээдүйг бүтээх уриалгад түлхэц өгнө гэж итгэж найдаж байна.

Хойш тавих боломжгүй, гэхдээ бас асар их бололцоо бүхий ийм хам нөхцөлд энэхүү илтгэлд дурдсан үзэл санаанууд нь ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлж, боловсролын нийгмийн шинэ гэрээг байгуулахад бидэнд тусалж байна. Энэхүү илтгэл нь боловсролын ирээдүйг хамтдаа сэтгэж, бүтээхийн төлөө ажиллах урилга юм. Энэ бол хамтын яриа хэлэлцээ, бүтээн байгуулалтын үйл явцын эхлэлийн цэг-гарц юм. Энэхүү илтгэл нь боловсролтой нэгэн адил төгсөөгүй байна. Харин эсрэгээр, дэлхийн сурган хүмүүжүүлэгчид болон тэдэнтэй мөр зэрэгцэн ажиллаж буй хүмүүсийн хөдөлмөрөөр дамжин түүнийг бодит үйл хэрэг болгох ажил одоо л эхэлж байна.

# Хавсралт

# Сонгогдсон эх сурвалжууд

## Бие даасан тайлангууд

Гол сорилт, боломжуудыг тодорхойлоход туслах болон Боловсролын Ирээдүйн Олон улсын комисст санал, зөвлөмж хүргүүлэх зорилгоор семинар, ажлын хэсгүүдийг зохион байгуулах нээлттэй уриалгын дагуу дараах тайлангуудыг хүлээн авсан. Мөн өөр бусад 200 орчим байгууллага ЮНЕСКО-ийн Боловсролын ирээдүй санаачилгад фокус бүлгийн үндсэн дээр тайлан гаргаж байсан бөгөөд эдгээр түншүүдийг Дэлхийн зөвлөлдөх уулзалтад хувь нэмэр оруулагчдын жагсаалтын доор жагсаасан болно.

Arab Campaign for Education for All. 2020. *Summary report on the Futures of Education in the Arab States: Building the future (2020-2050)*. Ramallah, Arab Campaign for Education for All. <http://www.teachercc.org/articles/view/379>

Asia South Pacific Association for Basic and Adult Education. 2021. *From the margins to the center: Youth informing the futures of education*. Manila, Asia South Pacific Association for Basic and Adult Education. [http://www.aspbae.org/userfiles/2021/Futures\\_of\\_Education\\_Report.pdf](http://www.aspbae.org/userfiles/2021/Futures_of_Education_Report.pdf).

Barber, P., Bertet, M., Choi, J., Czerwitzki, K., Njobati, F. F., Grau I Callizo, I., Hambrock, H., Herveau, J., Kastner, A., Laabs, J., Manalo, A., Mesa, J., Mutabazi, S., Muthigani, A., Richard, P., Scheunpflug, A., Sandler-Koschel, B., White, M., and Wodon, Q. 2020. *Christian schools and the futures of education: a contribution to UNESCO's Futures of Education Commission by the International Office of Catholic Education and the Global Pedagogical Network – Joining in Reformation*. International Office of Catholic Education and Global Pedagogical Network – Joining in Reformation. <http://oiecinternational.com/wp-content/uploads/2020/12/OIEC-GPENR-contribution.pdf>

Bridge 47. 2020. *The role of education in addressing future challenges*. Bridge 47. [https://www.bridge47.org/sites/default/files/2020-12/bridge47\\_-\\_report\\_to\\_unesco\\_foe\\_international\\_commission\\_final.pdf](https://www.bridge47.org/sites/default/files/2020-12/bridge47_-_report_to_unesco_foe_international_commission_final.pdf)

Éducation, Recherches et Actualités. 2021. *L'Éducation du futur - L'enseignement supérieur : défis et paradoxes*. Beirut et Paris, Université Saint Joseph et Université Gustave Eiffel. <https://www.periodicos.ufam.edu.br/index.php/larecherche>

Emmaüs International. 2020. *Rapport à l'attention de la commission internationale de l'initiative de l'UNESCO : « Les futurs de l'éducation : apprendre à devenir »*. Montreuil, France, Emmaüs International. [https://emmaus-international.org/images/actualites/2020/10/EMMAS\\_INTERNATIONAL\\_-\\_Contribution\\_Les\\_futurs\\_de\\_l'ducation\\_\\_juillet\\_2020\\_003.pdf](https://emmaus-international.org/images/actualites/2020/10/EMMAS_INTERNATIONAL_-_Contribution_Les_futurs_de_l'ducation__juillet_2020_003.pdf)

Garcés, C. E. 2020. *Aportación para la Comisión Internacional*. Madrid.

International Council for Adult Education (ICAE). 2020. *Adult Learning and Education (ALE) – Because the future cannot wait*. International Council for Adult Education. <https://en.unesco.org/futuresofeducation/sites/default/files/2020-10/ICAE%20-%20Futures%20of%20ALE%20FINAL.pdf>

International Task Force on Teachers for Education 2030. 2021. *The futures of teaching: Background paper prepared for the Futures of Education Initiative*. Paris, UNESCO <https://teachertaskforce.org/knowledge-hub/futures-teaching-background-paper-prepared-futures-education-initiative-0>

- International Union for Conservation of Nature (IUCN) Commission on Education and Communication (CEC). 2021. *Visions and Recommendations for the Futures of Education*. Gland, Switzerland, International Union for Conservation of Nature. [https://www.iucn.org/sites/dev/files/content/documents/cec\\_report\\_to\\_unesco\\_foe\\_-\\_6.5.pdf](https://www.iucn.org/sites/dev/files/content/documents/cec_report_to_unesco_foe_-_6.5.pdf)
- Mouvement International ATD Quart Monde. 2020. *Contribution du Mouvement International ATD Quart Monde aux Futurs de l'Éducation*. Pierrelaye, France, Mouvement ATD Quart Monde – Agir Tous pour la Dignité. <https://nextcloud.atd-quartmonde.org/index.php/s/DzMMci4yqP6dkPA>
- Red Regional por la Educación Inclusiva de Latinoamérica. 2020. *Los futuros de la educación - Contribuciones de la Red Regional por la Educación Inclusiva de Latinoamérica*. Buenos Aires, Red Regional por la Educación Inclusiva de Latinoamérica. <https://rededucacioninclusiva.org/wp-content/uploads/2020/09/Los-futuros-de-la-educaci%C3%B3n-Contribuciones-de-la-Red-Regional-por-la-Educaci%C3%B3n-Inclusiva-de-Latinoam%C3%A9rica.pdf>
- Schulte, D., Cendon, E. and Makoe, M. 2020. *Re-Visioning the Future of Teaching and Learning in Higher Education: Report on Focus Group Discussions for the UNESCO Futures of Education Initiative*. University of the Future Network. [https://unifuture.network/wp-content/uploads/sites/2/2020/08/20200722\\_UFN\\_UNESCO-report\\_fin.pdf](https://unifuture.network/wp-content/uploads/sites/2/2020/08/20200722_UFN_UNESCO-report_fin.pdf)
- SDG-Education 2030 Steering Committee. 2020. *Contribution to the Futures of Education*. Paris, UNESCO. <https://sdg4education2030.org/sites/default/files/2020-07/Futures%20of%20Education%20SDG-Ed2030%20SC%20contribution%20July%202020.pdf>
- Sefton-Green, J., Erstad, O. and Nelligan, P. 2021. *Educational Futures Across Generations*. Centre for Research for Educational Impact (REDI) at Deakin University and Department of Education at the University of Oslo. [https://www.deakin.edu.au/\\_\\_data/assets/pdf\\_file/0005/2298551/Educational-Futures-Across-Generations.pdf](https://www.deakin.edu.au/__data/assets/pdf_file/0005/2298551/Educational-Futures-Across-Generations.pdf)
- Seguy, F. 2021. *Penser l'avenir de l'éducation en contexte de pandémie*. Port-au-Prince, UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000378392>
- UNESCO. 2020. *Humanistic Futures of Learning: Perspectives from UNESCO Chairs and UNITWIN Networks*. Paris, UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000372577/PDF/372577eng.pdf.multi>
- UNESCO Institute for Lifelong Learning. 2020. *Embracing a culture of lifelong learning: Contribution to the Futures of Education Initiative*. Hamburg, UNESCO Institute for Lifelong Learning. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374112/PDF/374112eng.pdf.multi>
- UNESCO International Institute for Higher Education in Latin America and the Caribbean (IESALC). 2021. *Thinking Higher and Beyond: Perspectives on the Futures of Higher Education to 2050*. UNESCO International Institute for Higher Education in Latin America and the Caribbean. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000377530>
- UNESCO. 2021. *Caribbean Futures of Education – Final Report*. Kingston, UNESCO. <https://en.unesco.org/caribbean-futures-of-education>
- UNESCO's Collective Consultation of NGOs on Education 2030. 2021. *The role of Civil Society Organisations in 2050 and beyond*. Paris, UNESCO's Collective Consultation of NGOs on Education 2030. [https://en.unesco.org/system/files/the\\_role\\_of\\_csos\\_in\\_2050\\_and\\_beyond.pdf](https://en.unesco.org/system/files/the_role_of_csos_in_2050_and_beyond.pdf)
- Unescocat and Fòrum Futurs de l'educació. 2020. *How to Get to the Future of Education: Lessons Learned from the Escola Nova 21 Alliance in Catalonia*. Unescocat-Center for UNESCO of Catalonia. <https://catesco.org/wp-content/uploads/2020/10/Unescocat-contribution-to-Futures-of-Education.pdf>
- Wong, S., Kwok, V., Kwong, T. and Lau, R. 2020. *Individuality, Accessibility, and Inclusivity: Applied Education and Lifelong Learning in Revolutionising Education for the 21st Century*. Our Hong Kong Foundation. [https://ourhkfoundation.org.hk/sites/default/files/media/pdf/UNESCO\\_submission\\_13102020.pdf](https://ourhkfoundation.org.hk/sites/default/files/media/pdf/UNESCO_submission_13102020.pdf)

World Council on Intercultural and Global Competence. 2021. Contribution from the World Council on Intercultural and Global Competence to the UNESCO Futures of Education Initiative. [https://iccglobal.org/wp-content/uploads/World-Council-Futures-of-Education-Learning-to-Become-Initiative\\_.pdf](https://iccglobal.org/wp-content/uploads/World-Council-Futures-of-Education-Learning-to-Become-Initiative_.pdf)

Yidan Prize Foundation. 2021. Perspectives from the Yidan Prize Foundation Council of Luminaries on the Futures of Education

## Суурь өгүүллүүд

Гол сорилт, боломжуудыг тодорхойлоход туслах болон Боловсролын Ирээдүйн Олон улсын комисст санал, зөвлөмж хүргүүлэх зорилгоор семинар, ажлын хэсгүүдийг зохион байгуулах нээлттэй уриалгын дагуу дараах тайлангуудыг хүлээн авсан. Мөн өөр бусад 200 орчим байгууллага ЮНЕСКО-ийн Боловсролын ирээдүй санаачилгад фокус бүлгийн үндсэн дээр тайлан гаргаж байсан бөгөөд эдгээр түншүүдийг Дэлхийн зөвлөлдөх уулзалтад хувь нэмэр оруулагчдын жагсаалтын доор жагсаасан болно.

Assié-Lumumba, N. T. 2020. *Gender, knowledge production, and transformative policy in Africa*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374154>

Buchanan J., Allais S., Anderson M., Calvo R. A., Peter S. and Pietsch T. 2020. *The futures of work: what education can and can't do*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374435>

Common Worlds Research Collective. 2020. Learning to become with the world: Education for future survival. *Education Research and Foresight Working Paper 28*. Paris, UNESCO

Corson, J. 2020. *Visibly ungoverned: strategies for welcoming diverse forms of knowledge*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374085>

Couture, J. C., Grøttvik, R. and Sellar, S. 2020. *A profession learning to become: the promise of collaboration between teacher organizations and academia*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374156>

Damus, O. 2020. *Les futurs de l'éducation au carrefour des épistémologies du Nord et du Sud*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374047>

Desjardins, R., Torres, C. A. and Wiksten, S. 2020. *Social contract pedagogy: a dialogical and deliberative model for Global Citizenship Education*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374879>

D'Souza, E. 2020. *Education for future work and economic security in India*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374880>

Facer, K. 2021. *Futures in education: towards an ethical practice*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000375792>

Facer, K. 2021. It's not (just) about jobs: education for economic wellbeing. *Education Research and Foresight Working Paper 29*. Paris, UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000376150/PDF/376150eng.pdf.multi>

- Facer, K. and Selwyn, N. 2021. *Digital technology and the futures of education – towards 'non-stupid' optimism*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000377071>
- Gautam, S. and Shyangtan, S. 2020. *From suffering to surviving, surviving to living: education for harmony with nature and humanity*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374086>
- Grigera, J. 2020. *Futures of Work in Latin America: between technological innovation and crisis*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374436>
- Hager, P. and Beckett, D. 2020. *We're all in this together: new principles of co-present group learning*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374089>
- Haste, H. and Chopra, V. 2020. *The futures of education for participation in 2050: educating for managing uncertainty and ambiguity*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374441>
- Hoppers, C. 2020. *Knowledge production, access and governance: a song from the south*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374033>
- Howard, P., Corbett, M., Burke-Saulnier, A. and Young, D. 2020. *Education futures: conservation and change*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374087>
- Inayatullah, S. 2020. Co-creating educational futures: contradictions between the emerging future and the walled past. *Education Research and Foresight Working Paper 27*. Paris, UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373581/PDF/373581eng.pdf.multi>
- Labate, H. 2020. *Knowledge access and distribution: the future(s) of what we used to call 'curriculum'*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374153>
- Lambrechts, W. 2020. *Learning 'for' and 'in' the future: on the role of resilience and empowerment in education*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374088>
- Mengisteab, K. 2020. *Education and participation in African contexts*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374155>
- Moore, S.J. and Nesterova, Y. 2020. *Indigenous knowledges and ways of knowing for a sustainable living*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374046>
- Saeed, T. 2020. *Reimagining education: student movements and the possibility of a Critical Pedagogy and Feminist Praxis*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374157>
- Schweisfurth, M. 2020. *Future pedagogies: reconciling multifaceted realities and shared visions*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374077>
- Smart, A., Sinclair, M., Benavot, A., Bernard, J., Chabbott, C., Russell, S. G. and Williams, J. 2020. *Learning for uncertain futures: The role of textbooks, curriculum, and pedagogy*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374078>

- Sriprakash, A., Nally, D., Myers, K., and Ramos-Pinto, P. 2020. *Learning with the past: racism, education and reparative futures*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374045>
- Stitzlein, S. M. 2020. *Using civic participation and civic reasoning to shape our future and education*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374034>
- Vasavi, A.R. 2020. *Rethinking mass higher education: towards community integrated learning centres*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374442>
- Wagner, D., Castillo, N. and Zahra, F. T. 2020. *Global learning equity and education: looking ahead*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000375000>
- Ydesen, C., Acosta, F., Milner, A.L., Ruan, Y., Aderet-German, T., Gomez Caride, E. and Hansen, I. S. 2020. *Inclusion in testing times: implications for citizenship and participation*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374084>
- Alongside this background research, an interactive game was developed for the Futures of Education initiative to think about alternative learning systems and explore their implications with different groups.
- Keats, J. and Candy, S. 2020. *Accession: Building an intergenerational library*. Game developed for the Futures of Education initiative.

## Дэлхий нийтийн түвшний зөвлөлдөх уулзалтын саналууд

Санаачилгад зориулан боловсруулсан фокус групп, онлайн платформ, судалгаа, санал асуулгын сувгуудаар дамжуулан хүлээн авсан хэтийн төлөв, санааг задлан шинжлэх, нэгтгэх зорилгоор ЮНЕСКО-ийн захиалгаар дараах илтгэлүүдийг гаргасан.

- Jacobs, R. and French, C. 2021. *Women, robots and a sustainable generation: Reading artworks envisioning education in 2050 and beyond*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/search/faad9f2c-4a70-4b7a-8ac7-c3cffeec156c>
- Melchor, Y. 2021. *Analysis report of the online consultation modality: Your ideas on the futures of education*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000378271/PDF/378271eng.pdf.multi>
- TakingITGlobal. 2021. *Focus group discussion analysis: Perspectives from the UNESCO Associated School Network's community of students, teachers and parents*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000378054/PDF/378054eng.pdf.multi>
- UNESCO. 2021. *Education in 2050: Analysis of social media polling campaign for UNESCO's Futures of Education report*. Paris, UNESCO.
- Moeller, K., Agaba, S., Hook, T., Jiang, S., Otting, J., Sedighi, M. and Wyss, N. 2021. *Focus group discussions analysis: September 2019 - November 2020*. Paper commissioned for the UNESCO Futures of Education report. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000375579/PDF/375579eng.pdf.multi>



## Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын нийтлэлүүд

Энэхүү тайланг боловсруулах явцад Комиссын санал хүсэлт, санал хүсэлтийг хүлээн авах шалтгаант зорилгоор хийгдэж буй ажлынхаа талаар хэд хэдэн завсрын эмхэтгэл гаргасан. Нэмж дурдахад Комиссоос КОВИД-19 хямралаас үүдэлтэй боловсролын үйл явцын тасалдалтай холбоотой зөвлөмжийг санал болгов.

International Commission on the Futures of Education. 2020. *Visioning and Framing the Futures of Education*. UNESCO, Paris. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373208>

International Commission on the Futures of Education. 2020. *Protecting and transforming education for shared futures: joint statement by the International Commission on the Futures of Education*. UNESCO, Paris. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373380>

International Commission on the Futures of Education. 2020. *Education in a Post-COVID World: Nine ideas for public action*. UNESCO, Paris. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373717>

International Commission on the Futures of Education. 2021. *Progress update of the International Commission on the Futures of Education*. UNESCO, Paris. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000375746>

# Боловсролын Ирээдүйн Олон улсын Комисс

## Бүрэн эрх

Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын бүрэн эрх бол улам бүр ээдрээтэй, тодорхойгүй, найдваргүй болж буй ертөнцөд боловсролыг хэрхэн шинэчлэн бодож болох талаар хамтдаа эргэцүүлэн тунгааж, дүн шинжилгээ, зөвлөмжийг олон түвшний бодлогын яриа хэлэлцээ, үйл хэрэгт мөрийн хөтөлбөр болж чадах түүчээлэх илтгэл хэлбэрээр танилцуулах явдал юм. 2050 он ба түүнээс хойших үеийг авч үзвэл, уг илтгэлд боловсролын бодлого, боловсролын практикийн аль алиных нь алсын хараа, стратегийг санал болгох юм. Комисс илтгэлийг нийтЭлснээс хойшид гарах үр нөлөөг хэрхэн нэмэгдүүлэх талаар судлах нь илтгэлийг боловсруулах болон дэлхийн өнцөг булан бүр дэх оролцогч талуудтай харилцах үйл явцын салшгүй хэсэг юм.

Сүүлийн үеийн геополитикийн өөрчлөлт, хурдассан байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, хүний шилжилт хөдөлгөөний хэв маягийн өөрчлөлт, шинжлэх ухаан, технологийн инновацын экспоненциал хурдыг Комисс харгалзан үзэх ёстой. Үүний зэрэгцээ, тайланд технологи, нийгэм, эдийн засаг, байгаль орчны сүйрлийн олон боломжит ирээдүй, боловсрол эдгээр ирээдүйд хэрхэн нөлөөлж, мөн хэрхэн нөлөөнд нь өртөж болохыг тусгаж, дүн шинжилгээ хийх ёстой.

Комисс илтгэлдээ нийтийн сайхан сайхан байдал болох боловсрол ба мэдлэгт хандах ЮНЕСКО-ийн олон ургалч, нэгдмэл, хүмүүнлэг арга хандлагын олон жилийн амлалт үүргийг авч үзэх болно. Боловсролын талаарх ЮНЕСКО-ийн өмнөх илтгэл, тайланд тусгагдсан үндсэн зарчмуудыг дахин нягталж үзэхийг Комисст уриалж байна. Дүгнэж хэлэхэд, Комисс нь урьдчилан таамагласан, боломжтой, илүүд үздэг ирээдүйн асар их сорилт, боломжуудын үүднээс боловсрол, суралцахуй, мэдлэгийн үүргийг судлахад анхаарлаа хандуулах болно.

## Гишүүд

### **Эрхэмсэг Сахле-Век Завуди ( H.E. Sahle-Work Zewde)**

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын Ерөнхийлөгч, Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын дарга

Сахле-Век Завуди нь 2018 оны 10 дугаар сарын 25-нд Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын анхны эмэгтэй, тав дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсон. 1998 онд Этиопын Гадаад хэргийн яаманд ажилд орсныхоо дараа тэрээр Этиопоос Сенегалд суугаа Элчин сайд бөгөөд Кабо Верде, Гамби, Гвиней, Гвиней-Бисау, Малийн итгэмжлэгдсэн төлөөлөгч; Жибутид суугаа Элчин сайд бөгөөд Засгийн

Газар Хоорондын хөгжлийн газар (IGAD)-ын Суурин төлөөлөгч; Францад суугаа Элчин сайд бөгөөд Марокко, Тунис улсын итгэмжлэгдсэн төлөөлөгч, ЮНЕСКО-ийн суурин төлөөлөгч; АУ болон Африкийн асуудал эрхэлсэн ерөнхий захиралд бөгөөд Африкийн Холбооны суурин төлөөлөгчөөр ажиллаж байсан.

Ерөнхийлөгч Сахле-Век 2009 онд НҮБ-д элсэж, Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс дахь НҮБ-ын Энхийг бэхжүүлэх нэгдсэн албаны даргаар ажиллаж байсан. 2011 онд тэрээр НҮБ-ын Найроби дахь төлөөлөгчийн газрын анхны тусгай Ерөнхий захирлаар Ерөнхий нарийн бичгийн даргын орлогчийн түвшинд томилогдсон. 2018 оны 6-р сард Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш түүнийг Африкийн холбоонд суугаа Тусгай төлөөлөгч бөгөөд Африкийн Холбоо дахь НҮБ-ын төлөөлөгчийн газрын даргаар томилсон. Тэрээр НҮБ-д эдгээр албан тушаалыг хашиж байсан анхны эмэгтэй байв.

### **Антонио Новоа (António Nóvoa)**

Португалийн Лиссабоны их сургуулийн Боловсролын хүрээлэнгийн профессор  
Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссын судалгааны төсөл боловсруулах хорооны дарга

Антонио Новоа нь 2006-2013 онд Лиссабоны Их Сургуулийн ерөнхийлөгчөөр ажилласныхаа дараа тус сургуулийн хүндэт ерөнхийлөгч болсон. Боловсролын профессор, Женевийн их сургууль болон Парисын IV-Сорбонны их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Тэрээр янз бүрийн их сургуулиудаас Хүндэт доктор цол хүртсэн. Тэрээр дэлхийн 40 гаруй оронд семинар орж, лекц уншсан бөгөөд 200 гаруй эрдэм шинжилгээний бүтээлийн зохиогч юм. Новоа одоогоор Португал Улсаас ЮНЕСКО-ийн дэргэд суугаа Элчин сайдаар ажиллаж байна.

### **Масанори Аояги (Masanori Aoyagi)**

Японы Токиогийн Их Сургуулийн эмирит профессор

Масанори Аояги 1944 онд Хятадын Далянь хотод төрсөн. Доктор Аояги нь эртний Грек, Ромын урлагийн түүхийн тэргүүлэх судлаачдын нэгийн хувьд Газар дундын тэнгисийн балгаст 40 гаруй жил малтлага хийсэн байна. 1967 онд Токиогийн Их Сургуулийн Утга зохиолын факультетыг төгсөөд 1969-1972 онд Ромын Их Сургуульд Сонгодог урлагийн түүх, археологийн ангид суралцаж, Утга зохиолын ухааны докторын зэрэг хамгаалсан. Өмнө нь тэрбээр Соёлын асуудал эрхэлсэн газрын комиссараар мөн ажиллаж байсан юм. Одоогоор Нара мужийн Кашихара хотын Археологийн хүрээлэнгийн ерөнхийлөгч, Тама урлагийн их сургуулийн захирлуудын зөвлөлийн дарга зэрэг албан тушаалыг тус тус хашиж байна.

### **Аржун Аппадурай (Arjun Appadurai)**

Нью-Йоркийн Их Сургуулийн Хэвлэл мэдээлэл, Соёл, Харилцаа холбооны эмирит профессор,  
Нью-Йорк дахь Бард төгсөлтийн төвийн Макс Вебер Глобал профессор

Аржун Аппадурай бол Нью Йоркийн Их Сургуулийн Хэвлэл мэдээлэл, соёл, харилцаа холбооны эмирит профессор, Нью Йорк дахь Бард төгсөлтийн төвийн Макс Вебер Глобал профессор юм. Тэрээр глобалчлалын соёлын динамикийн чиглэлийн тэргүүлэх шинжээч юм. Түүний нэрэмжит

тэтгэлэг нь олон янз байдал, шилжилт хөдөлгөөн, хүчирхийлэл, хот зэргийг хамардаг. Түүний хамгийн сүүлийн ном (Нета Александртай хамт) нь Failure (Бүтэлгүйтэл, Polity Press-т 2019 онд хэвлэсэн) юм.

## **Патрик Авуа (Patrik Awuah)**

Гана улсын Ашеси Их Сургуулийн үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч

Патрик Авуа бол Гана улсын шинэ үеийн ёс зүйтэй, бизнес эрхэлдэг удирдагчдыг сургах замаар Африкийн сэргэн мандалтыг урагшлуулах зорилготой Ашеси их сургуулийн үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч юм. Патрикийн удирдлага дор Ашеси их сургууль нь бизнес, компьютерын шинжлэх ухаан, менежмент мэдээллийн систем (MIS), инженерийн өндөр нөлөөтэй мэргэжлийн олон салбарыг хамарсан нарийн цөмийг хослуулсан. Патрик бол МакАртур (MacArthur)-ын гишүүн бөгөөд Боловсролын дэлхийн инновацын дээд хэмжээний уулзалт (Word Innovation Summit for Education-WISE)-ын шагналын эзэн юм. 2015 онд Патрикийг Fortune сэтгүүл дэлхийн шилдэг 50 удирдагчийн нэгээр нэрлэжээ.

## **Абдель Бассет Бен Хассен (Abdel Basset Ben Hassen)**

Тунис улс дахь Арабын Хүний Эрхийн Хүрээлэнгийн ерөнхийлөгч

Абдель Бассет Бен Хассен бол Тунис дахь Арабын хүний эрхийн хүрээлэнгийн ерөнхийлөгч юм. Хүний эрхийн боловсролын салбарт гучин жилийн туршлага хуримтлуулсан Бен Хассен Ойрх Дорнод Хойд Африкийн бүс нутагт хүний эрхийн хөтөлбөр, боловсролын шинэчлэлийг боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан. Тэрээр хүний эрх, хүний эрхийн боловсрол, соёлын сэдвээр нийтлэл бичиж, НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван жилийн төслийн төсөл боловсруулах хорооны гишүүн байсан.

## **Криволам Буарке (Cristovam Buarque)**

Бразилийн Их Сургуулийн эмирит профессор

Криволам Буарке Вашингтон ДС дахь Интер-Америкийн хөгжлийн банканд зургаан жил ажиллахаасаа өмнө Сорбонны их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Тэрээр эмирит профессор, Бразилийн их сургуулийн ректор асан. Бразилд тэрээр Боловсролын сайд, Холбооны дүүргийн захирагч, Бүгд Найрамдах Улсын Сенатчаар ажиллаж байсан. Криволам Буарке бол боловсролтой холбоотой мөнгөн тэтгэмжийн үзэл баримтлалын анхдагч бөгөөд тэрээр суурь болон дээд боловсролын ирээдүйн талаар хүртээмжийг сайжруулах, сурган хүмүүжүүлэх инновацын талаар өргөнөөр хэвлүүлсэн.

## **Элиза Гуэрра (Elisa Guerra)**

Мексикийн Валле де Филадельфия коллежийн багш, үүсгэн байгуулагч

Элиза Гуэрра бол багш, Мексикийн Валле де Филадельфия Коллежийн үүсгэн байгуулагч, Хүний нөөц потенциалын ололт амжилтын институтын Латин Америк хариуцсан захирал юм. Тэрээр Интер-Америкийн хөгжлийн банк болон ALAS сангийн 2015 оны "Латин Америкийн шилдэг

сурган хүмүүжүүлэгч” шагналыг хүртсэн бөгөөд дэлхийн багш нарын шагналын эцсийн шатанд шалгарсан. Элиза нь Монтеррей Технологийн Дээд Сургууль болон Харвардын Боловсролын Сургуулийн хоёр магистрын зэрэгтэй. Тэрээр 26 ном, сурах бичиг зохиосон бөгөөд эрт суралцахуй, дэлхийн иргэн, шинэлэг багшлахуйн талаар идэвхийлэн ажилладаг.

## **Бадр Жафар (Badr Jafar)**

Арабын Нэгдсэн Эмират улсын Crescent Enterprises компанийн гүйцэтгэх захирал

Бадр Жафар бол Crescent Enterprises компанийн гүйцэтгэх захирал, Crescent Petroleum-ийн ерөнхийлөгч юм. Бадр НҮБ-ын Түншлэлийн албатай хамтран ил тод байдал, хариуцлагатай байдлын соёлыг дэмжих зорилготой, ашгийн бус, хувийн хэвшил тэргүүтэй “Сувдан санаачилга” байгууллагыг үүсгэн байгуулжээ. Бадр нь Sharjah интерпрёнёршип төв болон Gaza Sky Geeks-ийн зөвлөхүүдийн зөвлөлд ажилладаг. Бадр нь хэд хэдэн дээд боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж, Кембрижийн их сургуулийн Шүүгчийн бизнесийн сургууль, Массачусетийн Технологийн их сургуулийн Хөгжлийн болон интерпрёнёршип Legatum төв, Бейрутын Америкийн их сургууль, Шаржагийн Америкийн их сургуулийн зөвлөхүүдийн зөвлөлийн гишүүнээр ажилладаг. Бадр бол Кембрижийн их сургуулийн Стратегийн филантропийн төвийн үүсгэн байгуулагч юм.

## **Дох-Ён Ким (Doh-Yeon Kim)**

Сөүлийн Үндэсний Их Сургуулийн эмирит профессор, БНСУ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн сайд асан

Дох Ён Ким нь Сөүлийн их сургуулийн Материалын инженерчлэлийн тэнхимийн профессороор ажиллаж байсан. Дараа нь Улсан их сургууль болон POSTECH-ийн ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. Профессор Ким БНСУ-ын Засгийн газрын Боловсрол, шинжлэх ухаан, технологийн сайд, Үндэсний шинжлэх ухаан, технологийн хорооны даргаар ажиллаж байсан. Түүний сонирхол нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийн улмаас боловсрол, багшлахуйд гарах өөрчлөлтүүдэд оршдог.

## **Жастин Ифу Лин (Justin Yifu Lin)**

Бээжингийн Их Сургуулийн Шинэ бүтцийн Эдийн Засгийн Хүрээлэнгийн декан, профессор

Жастин Ифу Лин нь Шинэ бүтцийн эдийн засгийн хүрээлэнгийн декан, Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа, хөгжлийн хүрээлэнгийн декан, Бээжингийн их сургуулийн Үндэсний хөгжлийн сургуулийн профессор, хүндэт декан юм. Үүнээс өмнө тэрээр Дэлхийн банкны ахлах дэд ерөнхийлөгч, ахлах эдийн засагч, мөн Бээжингийн их сургуулийн Хятадын эдийн засгийн судалгааны төвийн үүсгэн байгуулагч-захирлаар ажиллаж байжээ. Тэрээр эдийн засаг, хөгжлийн талаар олон тооны номын зохиогч юм.

## Евгений Морозов (Evgeny Morozov)

Зохиолч

Евгений Морозов бол нийгэм, улс төр дэх мэдээллийн технологийн үр дагаврын тухай зохиолч, сэтгэгч юм. Тэрээр “Цэвэр төөрөгдөл” (2011) болон “Бүхнийг хадгалахын тулд энд дарна уу” (2013) номын зохиогч юм. Тэрээр Харвардын их сургуульд шинжлэх ухааны түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд Жоржтауны болон Стэнфордын их сургуульд зочин судлаачаар ажиллаж байсан. Мөн тэрээр чухал, эрдэм шинжилгээний мэдлэгийг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох зорилготой “The Syllabus” медиа төслийг үндэслэгч юм.

## Карен Мунди (Karen Mundy)

ЮНЕСКО-ийн Олон Улсын Боловсролын Төлөвлөлтийн Хүрээлэн (IIEP)-ийн захирал, Торонтогийн Их Сургуулийн Онтариогийн Боловсрол судлалын хүрээлэнгийн профессор (чөлөөнд байгаа)

Карен Мунди бол ЮНЕСКО-ийн Боловсролын төлөвлөлтийн хүрээлэнгийн захирал, Торонтогийн их сургуулийн боловсролын бодлого, манлайллын профессор юм. Тэрээр хөгжиж буй орнуудын боловсролын тэргүүлэх мэргэжилтэн бөгөөд Боловсролын төлөөх дэлхийн Түншлэлийн Техникийн албаны эрхлэгч асан юм. Тэрээр Канадын судалгааны дарга, Судалгаа, инновацын дэд декан, Харьцуулсан болон олон улсын боловсролын нийгэмлэгийн ерөнхийлөгч зэрэг албан тушаалуудыг хашиж байсан. Тэрээр боловсролын шинэчлэл, бодлого, иргэний нийгмийн чиглэлээр 6 ном, олон арван өгүүлэл, номын бүлэг, бодлогын баримт бичгийн зохиогч юм.

## Фернандо М.Реймерс (Fernando M.Reimers)

АНУ-ын Харвардын Боловсролын Ахисан Түвшний Сургуулийн профессор

Фернандо М.Реймерс бол Форд сангийн Олон улсын боловсролын практикийн профессор, мөн Харвардын Боловсролын Ахисан түвшний Сургууль дахь Дэлхийн боловсролын инновацын санаачилгын захирал юм. Дэлхийн иргэний боловсролын чиглэлээр мэргэшсэн түүний ажил нь хүүхэд залуучуудыг XXI зуунд цэцэглэн хөгжихийн тулд хэрхэн сургах талаар ойлгоход чиглэдэг. Тэрээр 40 эрдэм шинжилгээний ном бичиж, ганцаар болон хамтран редакторлаж, өөрчлөгдөж буй ертөнцөд боловсролын нийцтэй байдлын талаар 100 гаруй нийтлэл, номын бүлгүүдийг нийтлүүлсэн. Тэрээр мөн төгсөх ангийн оюутнуудынхаа хамтаар дэлхийн олон сургуулиудад хэрэглэгдэж буй НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцүүлэн төсөлд суурилсан хэд хэдэн сургалтын хөтөлбөр боловсруулсан.

## Тарцила Ривера Зеа (Tarcila Rivera Zea)

Перугийн уугуул иргэдийн соёлын CHIRAPAQ төвийн ерөнхийлөгч

Тарцила Ривера Зеа бол Перу болон дэлхийд хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн уугуул иргэдийн идэвхтнүүдийн нэг юм. Тэрээр уугуул иргэдийн соёлын өвөрмөц байдал болон уугуул эмэгтэйчүүд, залуу удирдагчдын боловсролыг сурталчлан дэмжих зорилготой Перугийн уугуул иргэдийн соёлын төв-CHIRAPAQ нийгэмлэгээр дамжуулан 40 гаруй жилийн турш уугуул иргэдийн

эрхийг хамгаалж ирсэн. Тэрээр мөн Америк тивийн уугуул эмэгтэйчүүдийн тивийн сүлжээ (ECMIA) болон Олон улсын уугуул эмэгтэйчүүдийн форумд (FIMI) оролцдог.

### **Серигне Мбайе Тиам (Serigne Mbaye Thiam)**

Сенегал улсын Ус, Ариун Цэврийн Яамны сайд

Серигне Мбайе Тиам нь Руэн хотын бизнесийн сургуулийг төгссөн. Сенегал улсад парламентын гишүүн, төсвийн ерөнхий илтгэгч, засгийн газрын хэвлэлийн төлөөлөгч, Дээд боловсрол, судалгааны сайд, Боловсролын сайдаар ажиллаж байсан. 2018 оны 5 дугаар сараас 2021 оны есдүгээр сар хүртэл дэд дэд -Боловсролын төлөөх дэлхийн түншлэлийн Удирдах зөвлөлийн дарга байсан. Одоо ноён Тиам Сенегалын Ус, ариун цэврийн яамны сайдаар ажиллаж байна.

### **Вайра Виче-Фрейберга (Vaira Vike-Freiberga)**

Латви улсын Ерөнхийлөгч асан, одоо Баку дахь Низами Ганжавийн Олон Улсын Төвийн дарга

Доктор Вайра Виче-Фрейберга 1999-2007 онд Латви улсын Ерөнхийлөгч, 2013-2019 онд Дэлхийн манлайллын холбоо/Клуб де Мадридын ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. Тэрээр НҮБ-ын шинэчлэлийн асуудлаарх тусгай элч болон Европын холбооны олон өндөр түвшний баг бүлэгт ажиллаж байсан. Тэрээр 17 ном, 200 гаруй өгүүллийн зохиогч, таван академийн гишүүн, Оксфордын их сургуулийн Вольфсон коллежийн хүндэт гишүүн юм.

### **Маха Яхья (Maha Yahya)**

Ливан дахь Карнеги Ойрх Дорнодын төвийн захирал

Маха Яхья нь Малколм Х.Керр Карнегийн нэрэмжит Ойрх Дорнодын төвийн захирал бөгөөд түүний ажил нь улс төрийн хүчирхийлэл, ижилслийн өвөрмөц онцлогоороо нэгдэж улс төрийн эвсэл байгуулах хандлага тэгш бус байдал, иргэншил, дүрвэгсдийн хямрал зэрэгт гол анхаарлаа хандуулдаг. Массачусетсийн технологийн их сургууль, Лондон дахь Архитектурын нийгэмлэгт нийгэм ухаан болон хүмүүнлэгийн ухааны чиглэлээр хоёр докторын зэрэг хамгаалсан. Тэрээр хэд хэдэн зөвлөхүүдийн зөвлөлд ажилладаг бөгөөд Гурван талт комиссын дэлхийн гишүүн, Бейрут дахь Америкийн их сургуулийн Иргэний нийгэм, иргэний харьяаллын Асфари хүрээлэнгийн Олон улсын зөвлөхүүдийн зөвлөлийн хамтран даргалагч, мөн Ана Акра нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн юм.

# Боловсролын Ирээдүй санаачилга

## Зөвлөхүүдийн зөвлөл

Зөвлөхүүдийн зөвлөл нь ЮНЕСКО-ийн Ирээдүйн боловсролын санаачилгыг бүхэлд нь стратегийн удирдамжаар хангах үүрэгтэй байв.

### Ноён Тарик Аль Гург (Tariq Al Gurg)

Дубай Карес байгууллагын Гүйцэтгэх захирал

### Хатагтай Алис П.Олбрайт (Alice P. Albright)

Боловсролын төлөөх дэлхийн түншлэлийн Гүйцэтгэх захирал

### Ноён Гордон Браун (Gordon Brown)

НҮБ-ын дэлхийн боловсролын тусгай элч

### Хатагтай Аннет Диксон (Tariq Al Gurg)

Хүний хөгжлийн асуудал эрхэлсэн дэд ерөнхийлөгч,

### Хатагтай Хенриетта Фор (Henrietta Fore)

НҮБ-ын Хүүхдийн сангийн Гүйцэтгэх захирал

### Хатагтай Сюзан Хопгуд (Susan Hopgood)

Боловсролын олон улсын ерөнхийлөгч

### Ноён Карлос Моедас (Carlos Moedas)

Европын Комиссын Судалгааны шинжлэх ухаан, инновацын Комиссар (2014-2019 он),

### Ноён Матиас Родригес Инсиарте (Matias Rodriguez Inciarte)

Сантандер Универсиадын ерөнхийлөгч, Универсиадын дэд ерөнхийлөгч

### Ноён Рефат Саббах (Refat Sabbah)

Боловсролын төлөөх дэлхийн кампанит ажлын Ерөнхийлөгч

### Ноён Жеффри Д Сакс (Jeffrey D Sachs)

Колумбын их сургуулийн Тогтвортой хөгжлийн төвийн Захирал,

### Хатагтай Сесилия Шарп (Cecilia Sharp)

Шведийн Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн Дэд захирал

### Ноён Андреас Шлейхер (Andreas Schleicher)

ЭЗХАХБ-ын Боловсрол, ур чадварын газрын захирал,

### Хатагтай Алетт Ван Леур (Alette Van Leur)

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Салбарын бодлогын газрын дарга

### Land Хатагтай Хилигже вант Ланд (Hillegje van't Land)

Олон улсын их дээд сургуулиудын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга

### Хатагтай Юмэ Ямагучи (Yume Yamaguchi)

НҮБ-ын Их Сургуулийн Тогтвортой байдлын ахисан түвшний судалгааны хүрээлэнгийн Захирал



# Дэлхий нийтийн зөвлөлдөх үйлсэд хувь нэмэр оруулагчид

## Байгууллагууд, сүлжээнүүд

Дараах төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны байгууллага, хувийн хэвшил, залуучууд, сурагчдын байгууллага, сүлжээ, ЮНЕСКО-ийн Үндэсний комиссууд нь боловсролын ирээдүйн талаарх дэлхий нийтийн яриа хэлэлцээ (2019-2021)-нд анхаарлаа хандуулж, хувь нэмрээ оруулав. Боловсролын ирээдүй санаачилгад оролцсон байгууллагуудын шинэчилсэн жагсаалтыг вэбсайтаас үзэх боломжтой.

Abhivyakti Media for Development

Academic and Career Development Initiative  
Cameroon

Accademia delle Arti e delle Nuove Tecnologie di  
Roma

Adream Foundation

African Library and Information Associations and  
Institutions (AFLIA)

Agastya International Foundation

Agency for Cultural Diplomacy (ACD)

Allama Iqbal Open University

Amala

American Psychological Association (APA) at the  
United Nations

Amity University

Arab Campaign for Education for All

Arab Institute for Human Rights

Aristotle University of Thessaloniki

Arizona State University

Ashoka

Asia South Pacific Association for Basic and Adult  
Education (ASPBAE)

Asociación Montessori Española

Association des Parents Adventistes pour le  
Développement de l'Education (APADE)

Association for Sustainable Development  
Alternatives (ASDA)

Association internationale des étudiants en sciences  
économiques et commerciales (AIESEC)

Association Montessori International of the United  
States (AMI/USA)

Association Montessori Internationale (AMI), Russia

Association Montessori Internationale (AMI), Sub  
Saharan Africa

Association Montessori Internationale (AMI), United  
Kingdom

Association Montessori of Thailand

Association Nigérienne des Educateurs pour le  
Développement (ANED)

Athabasca University

AzCorp Entertainment

Bangladesh National Commission for UNESCO

Bangladesh Youth Forum

Beijing Normal University

Bilingualism Matters

Bilingualism Matters, Siena Branch, University for  
Foreigners of Siena

biNu

Board of European Students of Technology	Comisión Costarricense de Cooperación con la UNESCO
Brainwiz	Comisión Nacional Española de Cooperación con la UNESCO
Bridge 47	Comité mondial pour les apprentissages tout au long de la vie
Cameroon International Model United Nations	Commission nationale algérienne pour l'éducation, la science et la culture
Canadian Commission for UNESCO (CCU)	Commission nationale angolaise pour l'UNESCO
Canadian Department for Employment and Social Development (ESDC)	Commission nationale haïtienne de coopération avec l'UNESCO
Catalyst 2030	Commission nationale Lao pour l'UNESCO
Center for Education Development and Skill Acquisition Initiative	Commission nationale libanaise pour l'éducation, la science et la culture (UNESCO)
Center for Engaged Foresight	Commission nationale malgache pour l'UNESCO
Center for Intercultural Dialogue	Commission nationale rwandaise pour l'UNESCO
Centre Catholique International de Coopération avec l'UNESCO (CCIC)	Commission nationale suisse pour l'UNESCO
Centre for Comparative and International Research in Education (CIRE)	Comparative and International Education Society (CIES)
Centre for Research for Educational Impact (REDI) at Deakin University	Comparative Education Society of Asia (CESA)
Centre for Youth and Development Malawi	Consejo de Formación en Educación, Administración Nacional de Educación Pública (ANEP), Uruguay
Centro de Estudos em Educação Superior, Pontifícia Universidade Católica de Rio Grande do Sul (PUCRS)	DAP Graduate School of Public and Development Management
Centro de Investigación Científica, Académica y Posgrados, México	Délégation permanente de la Suisse auprès de l'UNESCO et de la Francophonie
Centro de Investigación y Acción Educativa Social - CIASES	Department of General and Preschool Education, Ministry of Education, Azerbaijan
Centro Regional de Profesores del Este - Maldonado	Developmental Action Without Borders - NABA/A
Centro Regional de Profesores del Suroeste - Colonia	Dhurakij Pundit University
Chartered College of Teaching	Diálogo Interamericano
Cinglevue	Dream a Dream
Civil Society Education Partnerships, Timor Leste	DW International (Germany)
Climate Commission for UK Higher and Further Education	E-Net Philippines
Climate Smart Agriculture Youth Network (CSAYN)	e <sup>2</sup> : educational ecosystems
Coalition for Educational Development, Sri Lanka	ED Wales
Collective Consultation of NGOs	EDUCAFIN Mentoring Program
Columbia University's Teachers College	

Education for all Somalia	Girls Not Brides AR
Education for an Interdependent World	Giving Hope to the Hopeless Association (GHTHA)
Education International	Global Campaign for Education
Éducation, Recherches et Actualités (EDRAC)	Global Changemakers
Education+	Global Edtech Impact Alliance
Educational Futures Network (EFN), School of Education, University of Bristol	Global Education Policy Network
Educational Resource Development Centre Nepal (ERDCN)	Global Hands-On Universe (GHOU)
Eidos Global	Global Pedagogical Network - Joining in Reformation (GPENreformation)
Emmaus International	Global University Network for Innovation (GUNi)
Epiphany Labs	Global Young Greens
Erasmus Student Network	Grow Waitaha - Ōtautahi (Christchurch)
ESD Japan Youth	Hellenic Association for the Promotion of Rhetoric in Education
European Democratic Education Community	HundrED
European Dental Students' Association (EDSA)	Indonesian National Commission for UNESCO
European Parents' Association (EPA)	Initiative for Article 12 UNCRC (InArt12)
European Student Network	Innovazing Vision
European Students' Union	Institute for Research on Population and Social Policies, National Research Council of Italy
European Youth Forum	Institute of Education, University of Lisbon
Expert Advisory Board for Transformative Education of the Austrian Commission for UNESCO	Instituto de Formación Docente - Rocha
Finnish Development NGOs – Fingo	Instituto Politécnico de Beja & Universidade Lusófona de Humanidades e Tecnologias de Lisboa (ULHT)
Finnish National Board of Education	International Association of Universities (IAU)
Firenze Fiera	International Centre for Higher Education Innovation under the auspices of UNESCO (UNESCO-ICHEI)
Foundation For Youth Employment Uganda	International Centre for UNESCO ASPnet (ICUA), China
Franklin University	International Council for Adult Education (ICAE)
Fundação Calouste Gulbenkian	International Council for Open and Distance Education (ICDE)
Fundación Mustakis	International Development Education Association Scotland (IDEAS)
Fundación Santillana	International Model United Nations
Galileo Teacher Training Program (GTTP)	
General Direction of Planning, Ministry of Education of Bolivia	
GeoPoll	
German Commission for UNESCO	

International Pharmaceutical Students' Federation (IPSF)	Ministry of Education, Belarus
International Society for Education through Art (InSEA)	Ministry of Education, Bhutan
International Youth Council	Ministry of Education, Ecuador
INTI International University and Colleges	Ministry of Education, Research and Religious Affairs, Greece
Isa Viswa Prajnana Trust	Ministry of Education, Romania
Istituto Comprensivo Statale "Perna - Alighieri" of Avellino	Ministry of Foreign Affairs, Portugal
Istituto Professionale di Stato per i Servizi per l'enogastronomia e l'ospitalità alberghiera "R. Virtuoso" of Salerno	Ministry of National Education, Indonesia
IUCN Commission on Education and Communication	Montessori Association of Thailand
Karanga: The Global Alliance for Social Emotional Learning and Life Skills	Montessori México
Kidskintha	Mouvement International ATD Quart Monde
Korean National Commission for UNESCO	National Campaign for Education, Nepal
L'Association Internationale des Professeurs et maîtres de Conférences des Universités – IAUPL	National Commission of the Democratic People's Republic of Korea for UNESCO
L'Organisation Internationale pour le droit à l'éducation (OIDE)	National Commission of the People's Republic of China for UNESCO
L'Organisation Mondiale pour l'Éducation Préscolaire (OMEP)	National Institute of Educational Planning and Administration, India
Latvian National Commission for UNESCO	National Youth Council of India
Learning through Landscapes	National Youth Council of Malta
Lebanese University (LU)	National Youth Council of Namibia
Maker's Asylum	Neo-bienêtre
Me2Glosses, Thessaloniki branch of Bilingualism Matters	Network for International Policies and Cooperation in Education and Training (NORRAG)
Millennium Project	Network of Education Policy Centers
Ministère de l'éducation nationale, Haiti	Networking to Integrate SDG Target 4.7 and SEL Skills into Educational Materials (NISSEM)
Ministère de l'éducation, Lao PDR	North American Montessori Teachers Association
Ministère de l'éducation, Rwanda	Northwestern University
Ministero dell'Istruzione (Ministry of Education, Italy)	Oceane Group
Ministry of Education and Science of Republic of Latvia	Office International de l'Enseignement Catholique (OIEC)
Ministry of Education of Quebec	Office of the Secretary General's Envoy on Youth (United Nations)
	Officina Educazione Futuri initiative
	Okayama University
	Omuta City Board of Education, Japan

One Family Foundation	Slovene NGO Platform for Development, Global Education and Humanitarian Aid (SLOGA)
Our Hong Kong Foundation	Society for Intercultural Education, Training, and Research (SIETAR)
Out of the Books ASBL	Southeast Asia ESD Teacher Educators Network (SEA-ESD Network)
People for Education	Strategy and Innovation for Development Initiative
Permanent Delegation of the Kingdom of Saudi Arabia to UNESCO	Study Hall Educational Foundation
Permanent Delegation of Viet Nam to UNESCO	Subcommittee on Migrant and Refugee Children of the NGO Committee on Migration
Peruvian National Commission of Cooperation for UNESCO	SW Creative Education Hub, Bath Spa University
Peruvian National Commission of Cooperation for UNESCO	Swedish Association for Distance Education (SADE)
Philippine Futures Thinking Society	Swedish Association for Distance Learning Hårnösand
Philippine Society for Public Administration	Swedish National Commission for UNESCO
Polish National Commission for UNESCO	Sweducation
Portland Education	Swiss Agency for Development and Cooperation (SDC)
Portuguese National Commission for UNESCO	Te Pū Tiaki Mana Taonga   Association of educators beyond the classroom
Portuguese Network of Communities of Learning (Rede CAP)	Teach For Liberia
Prince's Trust International	Thammasat University
ProFuturo	The Arab Network for Popular Education/The Ecumenical Project for Popular Education – The Lebanese Coalition for Education for All
Protection Approaches	The Dialogue
Proyecto Sinergias ED	The Edge Foundation
Red Regional por la Educación Inclusiva	The George Washington University
Regional Center for Educational Planning (RCEP)	The Goi Peace Foundation
ReSource at Burren College of Art	The Hamdan Foundation
RET International	The Innovation Institute, Australia
Rete Dialogues Nazionale	The International Institute for Higher Education Research & Capacity Building (IIHed), O.P. Jindal Global University
Réussir l'égalité Femmes-Hommes	The International Task Force on Teachers for Education 2030
Right to Education Initiative	The Millennium Project
Saint Petersburg State University	The Ministry of Education of the People's Republic of China
Santander Universidades	
Scholas Occurrentes	
Sciences Po Campus de Poitiers	
SDG-Education 2030 Steering Committee	
ShapingEDU, Arizona State University	

**Хавсралт**

The Montessori Society AMI (UK), United Kingdom	University of Salerno
Tybed	University of the Future Network
UN Association of Norway	University of Tlemcen
UNESCO National Commission of the Philippines	VIA University College
Unescocat, Fòrum Futurs de l'Educació	Vietnam Association for Education for All Vilnius University Students' Representation
United Nations Association of the United States of America	Visionary Education
United Nations University Institute for the Advanced Study of Sustainability (UNU-IAS)	Vote for Schools & Protection Approaches
Universidad Católica de Córdoba	World Council on Intercultural and Global Competence
Universidad Nacional de Tres de Febrero	World Family Organization (South Africa and Europe region)
Universidad Tres de Febrero	World Futures Studies Federation (WFSF)
Université de Cergy	World Heutagogy Group, London Knowledge Lab
Université Laval	World Youth Assembly
University of Bristol	Yale University
University of Dundee	York University
University of Edinburgh	Young Diplomats Society (YDS)
University of Latvia	Youth Agro-Marine Development Association (YAMDA)
University of Leeds	Youth Entrepreneurs Corporation, Democratic Republic of the Congo (YEC-DRC),
University of Maryland, College Park	Zero Water Day Partnership
University of Oslo	
University of Piraeus	

## Сургууль

Дараах сургуулиуд Ирээдүйн боловсролын санаачилгын хам нөхцөлийн хүрээнд сурагчид, багш нар болон/эсвэл эцэг эхчүүдтэй хэлэлцүүлэг, фокус бүлгийн ярилцлагууд зохион байгууллаа. Доорх сургуулиудын ихэнх нь ЮНЕСКО-ийн Холбоот Сургуулиудын Сүлжээнд (ASPnet) харьяалагддаг болохыг анхаарна уу.

### Алжир

- Collège d'enseignement moyen Ahmed Zazoua Djidjel
- École des frères Samet Blida
- Ecole privée El Awael Annaba
- Ecole privée la Citadelle Savoir Alger

### Ангол

- Alda Lara Polytechnic Secondary Institute
- Centre for Professional Education
- Gregório Semedo College
- Industrial Polytechnic Institute of Kilamba Kixi No. 8056 "Nova Vida"

Jacimar College  
 Lyceum Ngola Kiluanji No. 1145  
 Lyceum No. 8054 - PUNIV "Nova Vida"  
 Medium Industrial Institute of Luanda  
 Medium Technical Institute of Hotel Management and Tourism No. 2009  
 Middle Economics Institute of Luanda  
 Middle Institute of Administration and Management n° 8055 "Nova Vida" (IMAG-Nova Vida)  
 Mutu Ya Kevela Secondary School  
 Primary School José Martí No. 1136  
 Primary School No. 1134 - ex 1050  
 Public School No. 1140 (ex 1058) - 1° de Maio  
 Public School No. 1222 (ex-1107) - Bairro Azul  
 Secondary School Juventude em Luta n° 1057 - ex 2033  
 Training School for Health Technicians of Luanda

## Азербайжан

Baku European Lyceum  
 Modern Educational Complex  
 School #220 named after Arastun Mahmudov  
 School-Lyceum # 6 named after T. Ismayiov

## Бангладеш

Abudharr Ghifari College, Dhaka  
 Adamjee Cantonment College  
 Azimpur Govt. Girls School & College, Dhaka  
 Bangladesh International School and College, Mohakhali, Dhaka  
 Cambrian School & College, Dhaka  
 Dhaka Commerce College, Dhaka  
 Dhaka Residential Model College  
 Engineering University School & College, Dhaka  
 Govt. Bangla College, Mirpur, Dhaka

Govt. Bhiku Memorial College, Manikganj  
 Govt. Laboratory High School, Dhaka  
 Madaripur Govt. College, Madaripur  
 Munshiganj Govt. Women's College, Munshiganj  
 Udayan Uchcha Madhyamik Bidyalaya, Dhaka

## Беларусь

Gymnasium No. 1 named after F.Skorina, Minsk  
 Minsk Gymnasium #12  
 State Educational Establishment "Gymnasium No. 33, Minsk"  
 State Educational Establishment "Grodno City Gymnasium"  
 State Educational establishment "Secondary School No. 201 Minsk"  
 State Educational Establishment "Labour Red Banner Order Gymnasium No.50 of the city Minsk"  
 State Educational Institution "Snov Secondary School"  
 State Educational Establishment "Minsk Gymnasium 12"  
 Gymnasium No. 2 Orsha

## Канад

University of Toronto Schools

## Хятад

Hainan Middle School  
 Ledong Huangliu High School of No. 2 High School of East China Normal University  
 Qingdao No.2 High School  
 Shanghai High School  
 Shanghai Song Qingling School  
 The Experimental High School Attached to Beijing Normal University  
 The High School Affiliated to Renmin University of China

## **Колумб**

Corporación Educativa Minuto de Dios

## **Коста Рика**

Colegio Ambientalista de Pejibaye

Colegio de Cedros

Colegio de Santa Ana

Colegio Humanístico Costarricense - Campus  
Nicoya

Colegio Yurusti

CTP de Orosi/Instituto de Alajuela

CTP de Turubares

CTP Don Bosco

Escuela Carmen Lyra

Escuela Carolina Dent Alvarado

Escuela Central de Tres Ríos

Escuela de Palomo

Escuela Infantil NP San José

Escuela INVU Las Cañas

Escuela José Cubero Muñoz

Escuela José Ricardo Orlich Zamora

Escuela Juan Flores Umaña

Escuela La Fuente

Escuela La Gran Samaria

Escuela Líder Daytonia Talamanca

Escuela Líder Sector Norte

Escuela Naciones Unidas

Escuela San Francisco

Escuela Tomás Jefferson

Escuela y Colegio Científico CATIE

Golden Valley School

Instituto de Formación de Docentes de Universidad  
Nacional (UNA)

Liceo de Aserrí

Liceo de Limón - Mario Bourne

Saint Anthony School

Saint Gregory School

Saint Jude School

West College

## **Дани**

Aalborg Handelsskole

Aalborg Katedralskole

Aarhus Statsgymnasium

Absalons Skole

Alminde-VIUF Fællesskole

Allsundgymnasiet

Askov Efterskole

Asmildkloster Landbrugsskole

Aurehøj Gymnasium

Baring Boerneunivers

Bagsværd Kostskole Og Gymnasium

Bredagerskolen

Business College Syd

Campus Jelling, UCL

CELF

Christianshavns Gymnasium

Egaa Gymnasium

Egtved Skole

Eltang Skole og Børnehave

Endrupskolen

Espergærde Gymnasium & HF

EUC Nord

EUC Nordvest

EUC Syd

Faxehus Efterskole

Gammel Hellerup Gymnasium

Gefion Gymnasium



Gladsaxe Gymnasium  
 Haderslev Katedralskole  
 Han Herred Efterskole  
 Helsingør skole - Skolen i Bymidten  
 HF & VUC Fyn  
 Holluf Pile Skole  
 IBC Int. Business College  
 Ingrid Jespersens Gymnasieskole  
 Jelling Friskole  
 Jueslsminde Skole  
 Kold College  
 Langelands Efterskole  
 Learnmark  
 Lillebæltskolen  
 Lindbjergskolen  
 Mercantec  
 Naestved Gymnasium of HF  
 NEXT  
 Niels Brock Int. Gymnasium  
 Nivaa Skole  
 Noerre Gymnasium  
 Nykøbing Katedralskole  
 Odense Katedralskole  
 Oelsted Skole  
 Paderup Gymnasium  
 Pedersborg Skole  
 Professionshøjskolen UCN  
 Professionshøjskolen VIA  
 Randers Social- og Sundhedsudd.  
 Rantzausminde Skole  
 Ranum Efterskole  
 Ranum Skole  
 Roedkilde Gymnasium  
 Roskilde Gymnasium

Roskilde Tekniske Skole  
 Skovbrynet Skole  
 Sønderkov-Skolen  
 Sortedamskolen  
 SOSU Esbjerg  
 SOSU Nord  
 SOSU Syd  
 Store Magleby Skole  
 Strandskolen  
 Tech College  
 Tietgen Business  
 Toender Handelsskole  
 Tradium  
 U/Nord  
 Vesthimmerlands Gymnasium  
 Viden Djurs  
 VUC Storstroem  
 ZBC

## Финланд

Alppilan lukio  
 Björneborgs svenska samskola  
 Etäkoulu Kulkuri  
 Haapajärven lukio  
 Haapajärven yläaste  
 Helsingin kielilukio  
 Helsingin yliopiston Viikin normaalikoulu  
 Iisalmen lyseo  
 Jyväskylän kristillinen opisto  
 Jyväskylän Lyseon lukio  
 Jyväskylän normaaalikoulu  
 K. J. Ståhlbergin koulu  
 Kaitaan lukio  
 Kellon koulu

## Хавсралт

Kempeleen Kirkonkylän koulu  
Kilpisen yhtenäiskoulu  
Laanilan lukio  
Lapinlahden lukio ja kuvataidelukio  
Lyseonpuiston lukio  
Mäkelänrinteen lukio  
Oriveden lukio  
Oulun normaalikoulu  
Oulun normaalikoulu (yläkoulu)  
Oulun Suomalaisen Yhteiskoulun Lukio  
Putaan koulu  
Rauman normaalikoulu  
Saimaan ammattiopisto Sampo  
Suomalais-venäläinen koulu  
Tampereen yliopiston normaalikoulu  
Tikkalan koulu  
Tuusulan lukio  
Vaasan lyseon lukio

## Герман

Albert-Schweitzer-Schule Hofgeismar  
Edith-Stein-Schule Ravensburg & Aulendorf  
Freie Waldorfschule Karlsruhe  
Gesamtschule Bremen Mitte  
Gewerbliche und Hauswirtschaftlich-  
Sozialpflegerische Schulen Emmendingen  
Heinrich-Hertz-Schule Hamburg  
Illtal-Gymnasium Illingen  
Limesschule Idstein  
Max-Planck-Gymnasium Berlin  
Ostendorfer-Gymnasium Neumarkt  
Sophie-Scholl-Schule Berlin  
Städtische Realschule Heinsberg „Im Klevchen“  
Warndt-Gymnasium Völklingen

## Грек

1st Junior High School of Serres  
1st Senior High School of Ierapetra  
2nd Gerakas Senior High School  
2nd Junior High School of Geraka  
2nd Senior High School of Chania  
2nd Senior High School of Serres  
2nd Vocational Senior High School of Rethymno  
4th Junior High School of Maroussi  
4th Senior High School of Serres  
5th Junior High School of Agia Paraskevi  
American College Pierce  
Aristoteleio Junior High School of Serres  
Doukas Junior High School  
Experimental Junior High School of Rethymno  
Experimental Primary School of Serres  
Junior High School Athens College  
Junior High School of Koimisis, Serres  
Junior High School Psychiko College  
Music School of Serres  
Protypo Junior High School  
Protypo Junior High School of Anavryta  
Ralleio Junior High School of Piraeus  
Senior High School of Pentapoli, Serres  
Zagorianakos Junior High School

## Гватемал

Cooperativa Agro Industrial Nuevo Amanecer

## Гаити

Collège Cotubanama  
Collège de Côte-Plage

## Индонез

SMP Labshool Kebayoran

## Итал

ITCTS Vittorio Emanuele, Bergamo

## Япон

Amagi Junior High School

Amanohara Elementary School

Ginsui Elementary School

Hakko Junior High School

Hayamadai Elementary School

Hayame Elementary School

Hirabaru Elementary School

Kamiuchi Elementary School

Kunugi Junior High School

Kuranaga Elementary School

Matsubara Junior High School

Meiji Elementary School

Miike Elementary School

Minato Elementary School

Miyanohara Junior High School

Nakatomo Elementary School

Omuta Chuo Elementary School

Omuta Special Education School with special care

Shirakawa Elementary School

Tachibana Junior High School

Taisho Elementary School

Takatori Elementary School

Takuho Junior High School

Takuma Junior High School

Tamagawa Elementary School

Tegama Elementary School

Tenryo Elementary School

Yoshino Elementary School

## Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс

Collège Sisattanak

Collège Sisavad

École primaire Nahaidiao

École primaire Phonpapao

École primaire Phonphanao

École primaire Phonthan

École primaire Sokpalouang

École secondaire Champasak

École secondaire Phivat

Lycée Chanthabouly

Lycée Vientiane-Hochiminh

Vientiane Secondary School

## Ливан

Ahliah School

Al Kawthar Secondary School

Al Manar Modern School - Ras el Metn

Central College Jounieh

Collège de la Sainte Famille Française - Fanar

Collège des Soeurs des Saints Coeurs - Bauchrieh

Collège Notre Dame de Jamhour

Collège Protestant Français Montana - Dik el Mehdi

Collège Saint Grégoire - Beirut

Etablissement Sainte Anne de Besançon - Beirut

Greenfield College Beirut

Hajj Bahaa Eddine Hariri School - Saida

Imam Sadr Foundation-Rehab Al Zahraa School

Institut Moderne du Liban-Collège Père Michel  
Khalifé - Fanar

International College - Beirut

## Хавсралт

Les écoles de l'Association islamique  
philanthropique d'Amlieh

Les écoles de l'Ordre Libanais Maronite (OLM)

Makassed Ali Ben Taleb School - Beirut

Our Lady of Annunciation - Rmaich

Rafic Hariri High School Saida

Sagesse High School Ain Saadeh

## Мадагаскар

CEG Ambohimanarina

CEG Antanimena

CEG Nanisana

Collège privé ESSOR

Collège privé La Columba Ambatomainty

Collège privé Le Pétunia

Collège privé Palais des Princes

Ecole privée Pinocchio

EPP Ambatomanoina Lovasoa

EPP Ambohidroa 1

EPP Beravina

Lycée Andrianampoinimerina Sabotsy Namehana

Lycée Horace François Antalaha

Lycée J.J. RABEARIVÉLO

Lycée Miarinarivo Itasy

Lycée Nanisana

Lycée Naverson Fianarantsoa

Lycée privé La Chanterelle Sabotsy Namehana

Lycée privé Les Petits Chérubins

Lycée Talatamaty

## Мексик

Colegio Valle de Filadelfia

Instituto Alpes San Javier

PrepaTec Eugenio Garza Sada

## Норвеги

Steinerskolen i Tønsberg

## Пакистан

Karachi Grammar School

## Перу

Colegio Peruano Alemán Max Uhle

Institución Educativa Jorge Basadre, Junín

Instituto de Educación Superior Pedagógico Público  
Teodoro Peñaloza, Junín

## Португал

Agrupamento de Escolas D. Dinis, Quarteira

Agrupamento de Escolas da Batalha

Agrupamento de Escolas Sé, Lamego

Colégio Diocesano Nossa Senhora da Apresentação,  
Calvão

Escola EB/123 Bartolomeu Perestrelo, Funchal,  
Madeira

Escola Profissional do Montijo

Escola Secundária Aurélia de Sousa, Porto

Escola Secundária Filipa de Vilhena, Porto

Escola Secundária Jaime Moniz, Funchal, Madeira

Escola Superior de Educação Jean Piaget, Almada

Externato Frei Luís de Sousa, Almada

Instituto Duarte de Lemos, Águeda

## Бүгд Найрамдах Солонгос Улс

Chiak Elementary School

Chungnam Foreign Language High School

Chungryol Girls' High School

Daykey High School

Dongil Girls' High School

Hyoyang High School  
 Incheon International High School  
 Incheon Yeongjong High School  
 Jeonbuk Foreign Language High School  
 Jeonju Shinheung High School  
 Jeonnam Foreign Language High School  
 Kyungpook National University Attached  
 Elementary School  
 Masan Girls' High School  
 Munsan Sueok High School  
 Namsung Girls' High School  
 Osong High School  
 Sejong Global High School  
 Shin Nam High School  
 Shinseong Girls' High School  
 The Attached Elementary School of Gongju National  
 University of Education  
 Wonhwa Girls' High School  
 Yangcheong High School  
 Yeongjujeil High School

## Руанда

APADE Kicukiro  
 Collège Christ Roi de Nyanza  
 College Christ Roi/Nyanza  
 Collège de Gisenyi  
 College de Gisenyi (Inyemeramihigo)  
 College Saint André  
 Collège Saint André  
 Ecole Primaire Saint Joseph  
 Ecole Primaire Saint Joseph/Kicukiro  
 Ecole Primaire SOS  
 Ecole Primaire SOS Kacyiru  
 Ecole Technique SOS  
 Ecole Technique SOS Kigali

FAWE Girls School Kigali  
 FAWE Girls School Kigali  
 Groupe Scolaire Sainte Bernadette Save  
 Groupe Scolaire Maie Reine Rwanda  
 Groupe Scolaire Notre Dame de Lourdes/Byimana  
 Groupe Scolaire Nyanza/Kicukiro  
 GS Marie Reine Rwaza  
 GS Notre Dame de Lourdes Byimana  
 GS Nyanza/Kicukiro  
 GS Sainte Bernadette/Save  
 Lycée de Kigali  
 Lycée de Kigali  
 Lycée Notre Dame de Citeaux  
 Lycée Notre Dame de Citeaux  
 Teacher Training College Muhanga  
 TTC Muhanga

## Словени

Gimnazija Celje Center, Celje  
 Gimnazija Nova Gorica, Nova Gorica  
 Gimnazija Ptuj  
 IV. OŠ Celje  
 OŠ 16. december Mojstrana  
 OŠ Alojza Gradnika Dobovo  
 OŠ Bratov Polančičev, Maribor  
 OŠ Cirila Kosmača Piran  
 OŠ Cvetka Golarja Škofja Loka  
 OŠ dr. Jožeta Pučnika, Črešnjevce, Slovenska Bistrica  
 OŠ Dušana Flisa Hoče  
 OŠ Franceta Bevka Tolmin  
 OŠ Griže, Griže  
 OŠ in vrtec Sveta Trojica  
 OŠ Janka Padežnik Maribor  
 OŠ Kapela

**Хавсралт**

OŠ Kobilje  
OŠ Ledina Ljubljana  
OŠ Pesnica  
OŠ Poljane, Poljane nad Škofjo Loko  
OŠ Selnica ob Dravi  
OŠ Sveta Trojica  
OŠ Toneta Čufarja Jesenice  
Škofja Loka High School  
Šolski center Lava, Celje  
Šolski center Ptuj, Ekonomska šola  
Srednja gradbena šola in gimnazija Maribor  
Srednja zdravstvena in kozmetična šola Maribor  
Srednja zdravstvena šola Celje

**Испани**

Colegio Los Abetos  
Colegio Público de Hurchillo  
Colegio Sagrada Familia (Zaragoza)  
Colegio Trabenco  
IES Salvador Victoria (Monreal del Campo. Teruel)

**Их Британи**

Strathallan School

**Америкийн Нэгдсэн Улс**

Gunnison Middle School



unesco

Монголын  
Үндэсний комисс

## ИРЭЭДҮЙГЭЭ ХАМТДАА ДАХИН ТӨСӨӨЛӨХ НЬ Боловсролын нийгмийн шинэ гэрээ

Хүн төрөлхтний болон манай гарагийн харилцан сүлжилдсэн ирээдүй заналхийлэл дор байна. Загвараа өөрчилж, ирээдүйгээ дахин төсөөлөхийн тулд хамтдаа яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна. Эерэг өөрчлөлтийн хүчирхэг хүч гэдгээрээ эртнээс хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын салбарт шинэ, яаралтай, чухал хийх ажил бий. Хоёр жилийн турш бэлтгэгдэж, нэг сая орчим хүн оролцсон дэлхийн зөвлөлдөх үйл явцын мэдээллээр бүтсэн энэхүү илтгэлийг Боловсролын Ирээдүйн Олон улсын Комиссоос танилцуулж, хамтдаа болон бүх хүний төлөө энх тайван, шударга, тогтвортой ирээдүйг бүтээхэд туслах боловсролын шинэ нийгмийн гэрээг байгуулахад дэлхийн өнцөг булан бүрээс засгийн газар, институт, байгууллага, иргэдийг урьж байна. Энэ илтгэл нь өмнөх амлалтууд болон тодорхойгүй ирээдүйн хооронд боловсрол одоо хаана байгааг судалж, сурган хүмүүжүүлэх зүй, сургалтын хөтөлбөр, багшлахуй, сургууль, амьдралын бүхий л салбарт суралцах гэсэн таван хэмжигдэхүүний дагуу боловсролыг шинэчлэхийг нотлон харуулж, улмаар судалгаа, глобал эв санааны нэгдэл ба олон улсын хамтын ажиллагаанд уриалсан боловсролын нийгмийн шинэ гэрээг хурдасгахаар төгсөж байна. Суралцагчид, сурган хүмүүжүүлэгчид, боловсролын системийн менежерүүд болон төлөвлөгчид, судлаачид, засгийн газар болон иргэний нийгмийн ашиг сонирхлыг татахуйц энэхүү бүтээл нь дижитал технологи, цаг уурын өөрчлөлт, ардчилсан ухралт, нийгмийн туйлшрал, ажлын тодорхой бус ирээдүйн талаар гүнзгийрүүлэн харуулдаг. Энэхүү илтгэл нь хүн бүрд боловсролын тухай яриа нээж, сэтгэхүйг өдөөхийг зорьсон төдийгүй бидний хүн нэг бүрийг арга хэмжээ авахад түлхэц өгөхийг зорьсон юм. Энэ илтгэл нь юуны түрүүнд хувь хүний болон хамтын олон сая эр зориг, манлайлал, эсэргүүцэл, шинийг санаачлах, халамжлах үйлдлээр дамжуулан шударга, тэгш, тогтвортой ирээдүйг бий болгохын тулд бид чиглэлээ өөрчилж, боловсролыг хувиргах болно гэдгийг баталж байна.

